



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-15
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	16-125
<hr/>	
<i>1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	24-38
<i>2.Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан боловсруулсан, Засгийн газар 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	38-41
<i>3.Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	41-48
<i>4.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	41-48
<i>5.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	64-77
<i>6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	77-100
<i>7.Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	100-118
<i>8.“Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 2022.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	118-125

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, С.Батболд, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Болорчулуун, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энх-Амгалан, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Х.Нямбаатар, М.Оюунчимэг, Ш.Раднаасэд, Ц.Сэргэлэн, Ч.Ундрал, Н.Учрал;

Тасалсан: Н.Алтанхуяг, Д.Батлут, Ж.Батсуурь, Н.Ганибал;

Хоцорсон: Т.Аубакир-11 минут, Д.Бат-Эрдэнэ-2 цаг 31 минут, Д.Ганбат-43 минут, Ж.Мөнхбат-2 цаг 40 минут, Д.Өнөрболор-18 минут, Д.Цогтбаатар-49 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, Ш.Адъяаа, С.Ганбаатар, С.Чинзориг, О.Цогтгэрэл, Д.Бат-Эрдэнэ нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, Ш.Адъяаа, О.Цогтгэрэл, С.Чинзориг, С.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Даваасүрэн нар хэлэлцэх асуудлын 4 дүгээрт орсон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 35

Бүгд: 43

18.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Даваасүрэн нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 25

Бүгд: 43

41.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 12 дугаар сарын 30-ны өдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлд мэндчилгээ дэвшүүлэв.

Нэг.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулж, 2022.11.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн газрын шинжээч К.Гүлжан, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Х.Сүрэнхорол, Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн шинжээч Ш.Мөнгөнцэцэг, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, шинжээч Б.Төрбат нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Чинбүрэн, О.Цогтгэрэл, П.Анужин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгасан санал:

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гадна зар сурталчилгаа

9.1.Гадна зар сурталчилгаанд нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн

тусламжтайгаар байрлуулах зар сурталчилгаа хамаарна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.12-т заасны дагуу гадна зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрлийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар олгоно.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд гадна зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрлийн олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

9.3.Гадна зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл хүссэн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

9.3.1.гадна зар сурталчилгаа байрлуулах байршил, солилцлын цэг;

9.3.2.гадна зар сурталчилгааны байгууламжийн ангилал, төрөл, тоо, хэмжээ, ажлын зураг;

9.3.3.орон сууцны зориулалттай барилгын цонхгүй цул хана, дээвэрт сурталчилгааны байгууламж байрлуулах бол тухайн сурталчилгаа байрлуулах хэсэгт хамааралтай орон сууц өмчлөгчдийн энгийн олонх зөвшөөрснийг баталсан сууц өмчлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн хурлын тогтоол.

9.4.Гадна зар сурталчилгаа байрлуулахыг хориглох байршил, тухайн нутаг дэвсгэрт байрлуулах гадна зар сурталчилгааны өнгө, үзэмж, хэлбэр, аюулгүй ажиллагааны болон стандартын нийтлэг шаардлагыг тухайн шатны нутгийн өөрөө удирдах байгууллага тогтоож болно.

9.5.Энэ зүйлийн 9.1-д заасан зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 15

Бүгд: 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1 дэх хэсгийн “1.1, 1.21,” гэснийг хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.11 дэх заалтын “үйлчилгээ эрхлэх” гэсний дараа “зорилгоор талбай ашиглах” гэж нэмж, мөн зүйлийн 1 дэх заалтын “8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх” гэснийг мөн заалтын “5 дахь хэсгийн 5.1,” гэсний дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт болгох.

“Тайлбар: Энэ зүйлийн 4.1.2-т заасан “сонгон хэрэглэх баримт бичиг” гэж хүчин төгөлдөр стандартаас хэрэглэхэд тохирох стандартыг сонгохыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “21.1.11, 21.1.18, 21.1.20,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 6.2 дахь хэсгийн “14-20” гэснийг “15, 17, 18, 19, 20” гэж, мөн хэсгийн “21.1.8-21.1.21, 21.1.23-21.1.30, 21.1.32-21.1.38,” гэснийг “21.1.8, 21.1.9, 21.1.12, 21.1.13, 21.1.15, 21.1.16, 21.1.17, 21.1.24, 21.1.26, 21.1.27, 21.1.28, 21.1.30, 21.1.32, 21.1.33, 21.1.34, 21.1.35, 21.1.36, 21.1.37, 21.1.38,” гэж, мөн хэсгийн “27.2-27.5” гэснийг “27.3, 27.4, 27.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 21.1.21 дэх заалтын “эрх” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн “6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “30.2.2-30.2.6 дахь заалт, 30.3-30.5 дахь хэсэг” гэснийг,” гэснийг, мөн зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.1.38, 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.4,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгасан санал:

Нэг.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн “болон энэ хуулийн” гэсний өмнө “жагсаалт,” гэснийг “жагсаалт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 14

Бүгд: 44

68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2, 3, 9, 10, 11, 12, 13, 14 дахь заалтыг, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.1.20 дахь заалтыг, 10.2 дахь хэсгийг, мөн зүйлийн 5 дахь заалтын 11.1.28 дахь заалтын “болон үүсмэл орд ашиглах” гэснийг, 8 дахь заалтын 20.5.5 дахь заалтын “мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш заасан хугацаанд сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.3 дахь хэсгийн “18.1.7-д” гэснийг “4.1.30-д” гэж өөрчилж, мөн зүйлийн 8 дахь заалтын 20.5.3 дахь заалтын “шалгарсан” гэсний өмнө “геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын кадастрын асуудал хариуцсан нэгж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 15

Бүгд: 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “сонгон шалгаруулалтад оролцох” гэсний дараа “, үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн” гэж,” гэснийг, мөн зүйлийн “, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “эзэмшигч” гэсний дараа “, үүсмэл орд гэрээгээр ашиглагч хуулийн этгээд,” гэж” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 15

Бүгд: 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг, 5 дахь заалтын 20.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 20.1-д заасны дагуу” гэснийг, мөн зүйлийн 6 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 5 дахь заалтын 20.1.2 дахь заалтын “10.1.20-т” гэснийг “10.1.2-т” гэж, 20.2.1 дэх заалтын “10.2-т заасан маягтын” гэснийг “10.1.2-т заасан аргачлалын” гэж тус тус өөрчилж, 20.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.3.2.энэ хуулийн 20.3.1-д заасан үнэлгээг нэгтгэхэд хоёр болон түүнээс дээш оролцогчийн үнэлгээ тэнцсэн тохиолдолд илүү үнийн саналтай оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 15

Бүгд: 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагад” гэснийг “Засаг даргад” гэж,” гэснийг, мөн зүйлийн “53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Хайгуулын болон ашиглалтын” гэснийг “Хайгуул, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 16

Бүгд: 43

62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн “Цөмийн болон цацрагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 15

Бүгд: 43

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 20.2.5 дахь заалтыг, мөн төслийн 3 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 14

Бүгд: 43

67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9.6 дахь хэсгийн “6.7-д” гэснийг “5.2-г” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 4 дүгээр зүйлийн “15.4,” гэснийг хасаж, мөн зүйлийн “15.4 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж,” гэснийг “15.4 дэх хэсгийн “заасан эмэнд эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж гэснийг “заасан эмийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэх бөгөөд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж өөрчилж, мөн зүйлийн “мөн зүйлийн 15.5 дахь” гэсний өмнө “мөн хэсгийн “импортын лиценз” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан зөвшөөрлийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 13
Бүгд: 43
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл /Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, шинжээч Б.Төрбат нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооноос Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	20
Бүгд:	43

53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн дарга Б.Даваа-Эрдэнэ нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Зээлийн хэлэлцээрийг батлах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	21
Бүгд:	42

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 20

Бүгд: 41

51.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Зээлийн хэлэлцээрийг батлах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 19

Бүгд: 41

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийн төслийг соёрхон батлах хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Г.Гантулга, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн захирал Х.Алтай, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн Бизнесийн үйл ажиллагаа, хөгжлийн газрын захирал Б.Батсүрэн нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Чинзориг, Ц.Туваан, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр, Т.Аубакир

нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан даргалагчаас “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 10 минут үргэлжилж, 13 цаг 30 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Тав.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал Б.Эрдэнэхуяг, Монголбанкны Ерөнхийлөгчийн Эдийн засгийн зөвлөх Н.Батсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, С.Ганбаатар, Э.Батшугар, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага өгөв./14:20/

Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, мөн газрын Цахим худалдан авах ажиллагаа,

мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Цэрэнсамбуу, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн мэргэжилтэн Ц.Номингэрэл, Т.Энхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 15 цаг 20 минутаас 16 цаг 23 минутад хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Д.Өнөрболор, Ш.Адьяа, С.Ганбаатар, Д.Ганбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Бейсен, Д.Ганбат, Ш.Адьяа, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага өгөв./16:30/

Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан нарын 10 гишүүн 2022.06.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, мөн газрын Бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярболд, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Т.Аубакир, Т.Энхтүвшин, С.Чинзориг, Д.Ганбат, Ц.Сандаг-Очир, Б.Бейсен нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Бейсен нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл 2022.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, төслийн хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 23
Бүгд: 42
45.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /18:01/

Дагалдан гарсан:

2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /18:01/

3.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /18:02/

4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /18:02/

5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /18:02/

Дагалдан гарсан:

6.Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /18:03/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2022 оны сүүлийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд, ард иргэдэд хандан үг хэлж, шинэ оны мэндчилгээ дэвшүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 17 минут үргэлжилж, 76 гишүүнээс 49 гишүүн хүрэлцэн ирж, 64.5 хувийн ирцтэйгээр 18 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 20 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтгаж мэндчилье. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нийт 9 асуудлыг хэлэлцэнэ.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Зарчмын зөрүүтэй 16 саналтай.

Хоёрдугаарт, Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг явуулна.

Гуравдугаарт, Монгол Улс Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах,

Дөрөвдүгээрт, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан

анхны хэлэлцүүлэг, зарчмын дүрүүдтэй 4 саналтай юм байна,

Тавдугаарт, Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна,

Зургаад, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа. ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Долоод, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Наймд, Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлээс өргөн мэдүүлсэн,

Есдүгээрт, Нүүрсний экспорт, тээвэрлэлтэй холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагуудын тайлан мэдээлэлтэй танилцах,

Ерөнхий хяналтын сонсголын тайланг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т зааснаар саналаа бичгээр ирүүлсэн өнөөдрийн хэлэлцэх асуудлыг хойшлуулах, дараалал, өөрчлөх асуудал нэмэх горимын санал гаргаж үг хэлэхээр Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбандийн Адьшаа. Сайнхүүгийн Ганбаатар, Содномын Чинзориг, Одонгийн Цогтгэрэл, Даидэмбэрэлийн Бат-Эрдэнэ нараас албан бичгүүд ирүүлсэн байна.

Ингээд ирүүлсэн үгийн дагуу үгээ хэлцээнэ ээ.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн 11 дүгээр сарын 30-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх

тул зөвшөөрөл олгоно уу? Ингээд Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өглөөний амгаланг эрье.

Би өнөөдрийн хэлэлцэх асуудлаас тэр нөгөө биржийн тухай хуулийг дагаж гарах гэж байгаа тогтоолыг хойшлуулъя гэдэг саналтай байна. Энэ тогтоол дээр нэг ийм 2 заалт орчхоод байгаа юм. Иргэдийн 1072 хувьцааг эргэлтэд оруулах, Эрдэнэс Тавантолгой Хөрөнгийн биржид бүртгэх гээд. Энэ компани бүртгэлтэй. Хөрөнгийн биржийг сая хувьчилчихлаа шүү дээ. Ерөнхийдөө хувьчлал явж байна. Тэр гаргаж байгаа хувьцааны бараг 80 хувийг нь хэдхэн хүн стратегийн хөрөнгө оруулагч гээд авчхаж байгаа юм шиг байна лээ. Ингээд Хөрөнгийн биржийг нэг хэдэн хүн авч, тэгээд дээр нь Уул уурхайн биржийн тухай хууль гэж гаргаад уул уурхайн асуудлыг нэгтгээд авчхаж байгаа юм. Тэгээд юу хүсэж байна гэхээр Тавантолгойг хувьчлахыг хүсэж байгаа байхгүй юу. Харин би Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

Тэр Эрдэнэс Тавантолгойн хувьцааг эргэлтэд оруулах гэж байсан юмаа харин авч хаясан шиг байна лээ. Монголын экспортын 50 хувийг оруулж байгаа компанийг 1, 2 гэр бүл авч болохгүй шүү дээ. Энэ чинь яагаад ч байж болохгүй зүйл байхгүй юу. Тэгээд нэг ийм 2 асуудлыг шийдэх ёстой. Та бүхэн ой санамж байгаа бол санаж байна уу, үгүй юу. Энэ компани чинь ногдол ашиг 2018, 2019 онд гарсан. Иргэдэд 700 тэрбум төгрөг очих ёстой байсан. Тэр 700 тэрбум төгрөг нь иргэдээсээ асуухгүй, хаашаа хийсэн. Урд талын төмөр зам руу хийсэн байхгүй юу. Хэрвээ 1072-ыг эргэлтэд оруулна гэж ингэж байгаа бол тэр энэ хувьцааных нь тэр төмөр замд орсон хувийг бас шийдэх ёстой шүү дээ тэгвэл. 700 тэрбумыг нь өгөхгүй төмөр зам руу хийж хаячхаад тэрийг нь хувьчилна гээд сууж байгаа юм.

1072 биш 2016 оны сонгуулийн өмнөхөн 300-г нь иргэдэд өгч байсныг

санаж байна уу, үгүй юу? Манайхан ерөөсөө юм уншихгүй юм аа. Юм хэлэхээр попроод гээд байгаа юм. Өөрийгөө ухаантай гэж боддог бүсгүй надад тэгж хэлж байгаа юм. Ерөөсөө юм уншидаггүй байгаа байхгүй юу, гишүүн хүн л дээ. 2016 оны сонгуулийн өмнө 300-г нь мөнгөжүүлсэн. Ихэнх ядуу иргэд авсан. Одоо 1072-ыг эргэлтэд оруулбал бүгд зараад л ингээд л хөөрхий ядуу иргэд дуусна. Тэгэхээр ядуу, орлого багатай байсан иргэд 2016 онд бол 300-гаа мөнгөжүүлчихсэн байх. Тэгэхээр тэд нарынх бол нэг 772 хувьцаа л байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ бүх тооцоог хийх хэрэгтэй. Тэр ногдол ашиг нь хааччихсан юм. Хэд нь 772 хувьцаатай байгаа юм. Тэр 300-г төлж хэн авчихсан юм. Хувь хүн авчихсан юм уу, төр авчихсан юм уу, энэ Эрдэнэс Тавантолгойн хувьцаа ер нь яг юу болчхоод байгаа юм гэсэн ийм асуудлуудыг шийдэж байж хувьчлалын тухай, зүгээр менежментийг сайжруулах тухай ярих ёстой. Би намын дарга Ерөнхий сайдтай уулзсан. Би бол менежментийг нь сайжруулна, хувьчлахгүй гэж байна лээ.

Тийм учраас бид нар тогтоол гаргавал ямар тогтоол гаргах вэ гэвэл Эрдэнэс Тавантолгойн менежментийг сайжруулж оруулж ирэх үүргийг л Засгийн газарт өгөх хэрэгтэй. Үгүй ээ тэр хүнд үед би хэлээд байгаа шүү дээ. Хүнд үед энэ хүүхдийн мөнгийг хэн төлсөн юм? Эрдэнэс Тавантолгой. Түлшний мөнгөний 70 хувийн хөнгөлөлтийг хэн төлсөн юм? Эрдэнэс Тавантолгой. Гэрэл, цахилгааны мөнгийг хэн төлсөн юм? Эрдэнэт. Үгүй ээ энэ төрийн компаниуд чинь төлсөн байна шүү дээ. Ачааны хүндийг үүрсэн байна шүү дээ. Нөгөө үнэ цэнтэй ААН-үүдийг хувьчилж авсан компаниудаас чинь ковидын үед юм уу, хүнд үед хэн төлсөн юм. Хэн ард түмэндээ энэ зовлонг хуваалцсан хэн ч хуваалцахгүй.

Тийм учраас адаглаад энэ нэг иргэддээ энэ 2 компанийг нь гишүүд минь үлдээ ээ. Сонгуулиар очихоороо юу ярьдаг билээ дээ? Ёстой жинхэнэ попордог шүү дээ. Тийм учраас хүн энэ нэг улс орноо

бодъё, ингэе гэхээр попорч байна гэж. Тэр хүүхэн бол дандаа попордог юм шиг байна лээ. Аятайхан юм ярихаараа тэр гишүүн хүүхэн. Яагаад ард түмэнд та нар сонгуулиар явахаараа ард түмэндээ аймаар гоё гоё юм ярьдаг шүү дээ. Айн танай 2 бишээ биш. Тэгэхдээ би цаг нь ирэхээр зарлана. Тийм новишийн байж болохгүй. Ард түмний нүүр харахаараа попордог, тэгээд иргэдийнхээ төлөө дуугарах гэхээр попорлоо гэж үздэг. Эх орныхоо төлөө дуугарлаа гэхээр попорлоо гэж үздэг. Рио Тинто гэхээр хаихираад гүйдэг, дагаад гүйдэг. Иймэрхүү новишууд их байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ ард түмэндээ энэ Эрдэнэс Тавантолгойг үлдээчихье гэхээр попорлоо өгч байгаа юм. Үгүй ээ яагаад? Чи тэгвэл очоод тэр тойрог дээрээ очоод асууд аа, ард түмнээсээ, иргэдээсээ. Чадахгүй шүү дээ 2024 онд юу гээд явж байх бол доо? Би тэр үед чинь хэлнэ чамайг. Би яг зарлана, очиж байгаа тойрог дээр чинь.

Г.Занданшатар: Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Оны эцэс дээр энэ нүүрсний хулгайны шийдлийн асуудлаар тодорхой зүйл ярья гэж бодож байна. Нүүрсний 3 төрлийн хулгай байгаа. Нэгдүгээрт нь оффтейкийн хулгай байна. Тэгээд энэ оффтейк нууц байгаа гэрээнүүдийг ил болгох ажлыг яаралтай хийх хэрэгтэй.

Хоёрдугаарт нь Эрдэнэс Тавантолгой өнөөдрийн байдлаар 109 доллароор аман дээр нь нүүрсээ зарж байна. Энэ оффтейк гэрээнүүдийн үнийг 100 доллар руу хамгийн багадаа авчрах энэ ажлыг Засгийн газар маш яаралтай хийх ёстой шүү гэдгийг хэлье. Тэгээд 3 оффтейкийн төмөр замын оффтейктэй холбоотой гэрээнүүдийг зогсоо. Тэр төмөр зам нь ашиглалтад орохоор тэрүүгээрээ хамгийн түрүүнд тэвэрээ хийгээд авцгаана биз. Ашиглалтад ороогүй төмөр замын тэвэрийн оффтейкийн

төлбөр хийх бид нар өнөөдөр шаардлага байхгүй гэдгийг хэлье.

Хоёр дахь хулгай бол нүүрс худалдах, худалдан авахтай холбоотой, өөрөөр хэлбэл Их Хурлын гишүүд, дарга нар янз янзын хүмүүс очоод 100 мянга, 200 мянган гэрээ байна. Энэ дээр 2-5 доллар авах гэсэн юм. Энийг гэрээ зураад өгөөч гэдэг. Энэ бол далд явдаг. Тийм учраас энэ гэрээнийхээ асуудлыг ил болгох ажлыг Эрдэнэс Тавантолгой нэгдүгээрт хийх хэрэгтэй.

Хоёрдугаарт нь далд яваад байгаа тэр зүйлийг илрүүлэх ажлыг хууль хяналтын байгууллага хийх ёстой гэдгийг хэлье.

Гуравдугаарх нь түмний нүдэн дээр ил явж байгаа тэвэрийн хулгай байгаа. Хоосон машин хилээр гарч байгаа тухай асуудал яригдаад байдаг. Энэ дээр бол ирсэн шинэ машин болгон Монголд татвараа төлж орж ирчхээд буцаж Хятадын хил дээр очиж бүртгүүлдэг байхгүй юу даа. Хоосон машин хэдэн килограмм жинтэй, ямар ямар зохион байгуулалттай юм. Хаана нь юу юу байдаг юм. Бүгдийг нь ингэж шалгаж дараа нь автоматаар гаргахын тулд энэ хоосон машинуудыг гаргадаг. Энэ дээрээ бас ялгаж салгаж улс төрч нар зарим нь мэдлэггүй байх юм. Энийгээ бас бодож яриарай гэдгийг хэлье.

Тэвэрчид хэвлэлийн хурал хийгээд ер нь бол энэ бид 22000 жолооч нар хохирч байна гэж яриад байгаа. Энэ тэвэрчид 22000 тэвэрчдийг бас төлөөлөхгүй ээ. Богинын тэвэрт явсан жолооч нар. Эд нар бол нэг банк, бензинээрээ бензинээрээ 360 сая төгрөгийн тэвэр хийж, машиныхаа үнийг шууд олж байсан нөхдүүд өнөөдөр тэрүүгээрээ байна гэвэл эндүүрлээ. Энэ тэвэрийн чинь энэ үнэ ашиг дээр чинь Монголд орж ирэх ёстой тэр 1072 хувьцаа. Дээрээс нь Эрдэнэс Тавантолгойн дамжаад улсад орж айх ёстой тэр татварууд бүгдээрээ алга болсон гэдгийг бас хэлье.

Тийм учраас энэ холын тээвэрт явдаг жолооч нар бол яг энэ асуудал дээр чинь зүгээр чимээгүй хараад сууж байгаа. Энэ хүмүүс юу хүлээж байна вэ гэхээр ер нь жоохон шударга байгаасай, хол тээвэрт явдаг хүмүүс нь илүү мөнгө аваасай, дээрээс нь үнэ нь гол биш, хамгийн гол нь зохион байгуулалт нь зөв байгаасай л гэдгийг хараад хүлээгээд сууж байгаа гэдгээ хэлье. Эрдэнэс Тавантолгой нэг зүйлийг яаралтай хийх хэрэгтэй, тээвэр дээр. Нэг тонн богинын тээвэрт жишээ нэг тонн нүүрсийг 40000-аар гэрээ хийнэ гэх юм бол сард 3 удаа, 50000-аар гэрээ хийх юм бол сард 2 удаа, 60000-аар гэрээ гэх юм бол сард нэг удаа ингээд гардаг тэр сонголтыг нь гаргаж тээнгүүт нь тийшээ ороод 5 машинтай, 2 машинтай ч байсан, 50 машинтай ч байсан хамаагүй сонголтоороо дараад гэрээгээ онлайнаар хийчихдэг. Тэгээд нөгөө линк дээр дараад С зөвшөөрлөө авчихдаг ийм зүйлийг маш яаралтай хийх юм бол илүү үр дүнтэй. Одоо ингээд 40000-аас доошоо гэж ярьж байгаа тэр 40000-аас доошоо болох юм бол тэр 2 орны бас энэ чинь харилцаан дээр явагддаг энэ экспорт чинь шууд зогсох магадлалтай. Тодорхой тодорхой хугацаагаар доошлуулаад өдөр тутам багасгаад явах ийм нөхцөлийг нь хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Тавантолгой дээр С зөвшөөрлийн асуудал байгаа. Удахгүй Бямбацогт сайд аа хил хоорондын уулзалт болно. Энэ дээр нөгөө 5000 байж байгаад 6000 болсон. Тэр 6000 машинд С зөвшөөрөл өгнө гэхээр энэ дээр чинь бөөн хэл ам болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас энэ С зөвшөөрлийг тоог нь тоо тавихгүйгээр л энэ үсэнд нь өгдөг энэ хэлэлцээрт маш яаралтай орж, С зөвшөөрлийг байхгүй болгож байж л энэ хүнд суртал, авлига, хээл хахууль чинь байхгүй болох юм. Тэгээд энэ саналын дагуу тодорхой ажлуудыг ирэх оны энэ нэгдүгээр улиралд дотор багтаагаад хийх юм бол Монголын нүүрсний экспорт илүү сайжрах, илүү ил тод болох ийм боломж нь бүрдэнэ гэж

үзэж байна. Энэ дагуу ажлаараа мэдээж энэ нүүрсний хулгай гэдэг ийм муухай юманд МАН үнэхээр муухай холбогдлоо.

Тэгээд энэ дээрээ бас сайн ажил хийгээрэй гэж хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн алга байна. Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Тогтохсүрэн гишүүнээ жаахан чимээгүй байж байгаарай. Үг хэлчихье болох уу? Өнөөдөр энэ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх гэж байгаа энэ Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас авах гэж байгаа зээлтэй холбогдуулж энэ байр суурь илэрхийлэхгүй бол ер нь болохгүй байна. Энэ Монголчууд чинь 33 тэрбум америк долларын өрөнд орчихсон иймэрхүү нөхцөл байдалтай бид явж байна. Би тэгээд энэ парламент байгуулагдсанаас хойш энэ дэлхий нийтэд үүсээд байгаа нөхцөл байдалтай холбогдуулж бид Засгийн газраас авъя гэсэн зээлийг нь үг дуугүй баталж өгч байсан. Одоо бүр энэ хэтэрлээ. Монгол Улс чинь өрийн барьцаанд орлоо. Ковид чинь ингээд буурсан. Дайн ч бас үргэлжилж байгаа гэсэн ч энэ улс орноо өрөнд оруулдаг, гаднын банкнаас ямар ч хамаагүй юм бичээд ингэж ард түмнээ өрөнд оруулдаг. Энэ асуудалд цэг тавья Их Хурлын гишүүд ээ.

Өнөөдөр энэ Монгол Улсын Засгийн газраас замын засвар хийнэ, гүүр засна, махны зам барина гэдэг нэрийдлээр 110 сая долларын зээл авах ийм асуудлыг оруулж ирлээ. Өнөөдөр Монгол оронд энэ мах тээвэрлэдэг зам барина гэдэг ийм онигооны юм ярьж болох уу. Энэ барьсан замаараа махаа тээвэрлэхээр яадаг юм. Өнөөдөр Монгол Улсад энэ сүүлийн 2 жилд нэг ч тонн, түүхий мах гадаадад гаргаагүй шүү дээ. Ийм халхавчин дор төрийн мөнгийг угаах оролдлого хийдэг. Ард түмнийгээ ямар ч хамаагүй зээлийн

барьцаанд оруулдаг энэ асуудалдаа цэг тавья. Өнөөдөр ажлын байр бий болгох, ард түмнээ орлоготой болгох, экспортоо дэмжих энэ асуудлуудад зээл тусламжийг авъя гэвэл бид дэмжинэ. Гэтэл зам гүүрийн засвар хийнэ, махны зам барина гэдэг ийм юм оруулж ирж, 110 сая доллар чинь хэдэн төгрөг юм. 400, 500 тэрбум төгрөг шүү дээ. Энэ тэр жижиг, дунд орлоготой хүмүүсийг дэмжих, тэр юмны үнийг багасгах дээр яагаад зөрүүлж болдоггүй юм. Энэ Улсын Их Хурал, Засгийн газар чинь ард түмнийхээ амьдралыг, ард түмнийхээ сайн сайхны төлөө зүйл хийнэ гэж бид өнөөдөр төр барьж байгаа биз дээ. Гэтэл өнөөдөр ийм байдлаар энэ улсын мөнгө уйлдаггүй, Монгол Улс ямар ч юманд өр төлбөрт орсон хамаагүй гэдэг ийм байдлаар энэ эрх баригчид Засгийн газар ийм увайгүй, улс орноо зээлэнд өрөнд оруулдаг. Энэ асуудлаа зогсооё.

Хоёр банкнаас зээл авах гэж байна шүү дээ. Нэг нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн дэд бүтцийн банк. Үгүй ээ энэ зээл авахаас өөр юм алга уу. Энийг энэ Их Хурлын гишүүд та бүхэнд анхааралтай хандаарай. Энэ зээлийн хэлэлцээр, энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр ярьж байсан. Засгийн газрын хариуцсан яамнаас нь зөвшөөрөл авахгүйгээр ямар ч тооцоо судалгаагүй юманд зээл оруулж ирлээ гээд Болорчулуун сайд эсэргүүцэж байсан шүү дээ. Энэ Болорчулуун сайд хаачихсан юм. Тэгээд ийм юмыг өнөөдөр дахиад Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор оруулсан байна лээ. Үгүй ээ ингээд ийм улс орноо ингээд янз бүрийн юм яриад л, зээл аваад өөр зөндөө асуудал байна шүү дээ бид нар энэ. Үгүй ээ тэр төмөр замаа Гашуун сухайт, Ханги Мандлаа холбодог төмөр замдаа энэ зээлээ ав л даа. Ингэвэл бид дэмжинэ шүү дээ. Юун махны зээл вэ. Юу мах тээвэрлэдэг зээл вэ? Ийм юмыг бид өнөөдөр ярьж болохгүй ээ. Бид нар энэ өдөр ард түмний төлөөлөл, улс орныхоо эдийн засгийн асуудлыг шийдэхийн л төлөө байгаа болохоос биш ямар нэгэн зээл авч,

ямар нэгэн байдлаар энэ шаардлагагүй зүйлд ингэж улс орноо өрөнд оруулах энэ асуудалд бид цэг тавих ёстой шүү гэдгийг хариуцлагатай хэлье. Энийг энэ ард түмний төлөөлөл болсон та бүхэн энэ зээлийн хэлэлцээрүүдийг хэлэлцэхэд ямар байр суурьтай байж, хэн энэ зээлийг кноп дарсныг чинь ард түмэн харна шүү. Энийг бүр зориуд анхааруулж хэлье ээ.

Г.Занданишатар: Горимын саналаа тодорхой хойшлуулах санал гэж хэл.

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлыг хойшлуулъя гэж байгаа юм байна. Ингээд дараагийнх нь Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Саяын тав дахь, хагас, бүтэн сайн өдөр Д.Тогтохсүрэн, Г.Ганболд гишүүн бид 3 бол бас тойрогтоо нэг ажиллаад 5 сумаар иргэдтэйгээ уулзаад ирлээ. Хөдөө орон нутагт бол өвөлжилт жаахан хүндрэх янзтай байна. Цас ихтэй, өмнө орсон цас нь ер нь шуураагүй, хөдлөөгүй. Жаахан цас нэмбэл өвөлжилт хүндрэх нь гэсэн ийм одон янзтай иргэд бол байна. Иргэдтэй уулзаж байхад яах вэ энэ өнөөгийн нөхцөл байдлын нүүрсний хулгайтай холбоотой асуудал ярьж байна. Гэхдээ үүний зэрэгцээгээр энэ үнийн өсөлт чинь тэнгэрт хадлаа. Иргэдийн амьжиргааны түвшин маш дордож байна. Банкны зээл олдохоо больсон. Эм түлш, гурилын үнэ дийлдэхээ байлаа гэдэг ийм л зүйлийг маш их ярьж байна.

Тийм учраас би өнөөдөр үг авч байгаад 2 гишүүнээ төлөөлөөд бас ярьж байгаа юм. Иргэдийн бас ярьж байгаа асуудлыг өмнө нь Их Хурлын гаргасан шийдвэртэй холбоотой асуудлуудтай холбогдуулж бас ярихаас өөргүй л байна. Сүүлийн жил дараалан үнийн өсөлт энэ инфляцын төвшин 14.5 хувьтай байна. Буухгүй байна. Саяхан 11 сараас цахилгааны үнэ нэмэгдсэн ААН байгууллагуудын. Энэ чинь ч гэсэн бас ялангуяа тэр үйлдвэр эрхэлж байгаа иргэдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж

чиглэлд маш их сөргөөр нөлөөлж байна. Тийм учраас бол суурь үнэ нь нэмэгдсэн учраас цаашидаа ингээд ирэх онд ч гэсэн инфляцын түвшин 2 оронтой тооноос бууна гэдэг тийм зүйл бол харагдахгүй байх шиг байгаа юм.

Та бүхэн мэдэж байгаа байх. Статистикийн газраас би судалгаа авч үзлээ. Энэ үнийн өсөлтөөс чинь шалтгаалаад өрхийн бодит орлого маш их, агшиж байгаа юм байна. Агшиж байна өрхийн бодит орлого бол агшиж байна. Эм тарианы үнэ асар их өсөж байгаа юм байна. Зөвхөн эм тарианы үнэ гэхэд 40.6 хувиар өссөн гэсэн ийм дүнтэй байна, 1 жилийн хугацаанд. Би ганц нэг зүйл хэлье дээ хүүхдийн хэрэглэдэг фараденк хүүхдийн лаа гэхэд нэг ширхэг нь 2.5 дахин үнэ нь өссөн байна шүү дээ.

Тэгэхээр энэнтэй холбогдуулж юу хэлэх гээд байна вэ гэхээр Их Хурлаас чинь энэ эмийн чанар байдалд хяналт тавих түр хороо байгуулсан. Хугацаа нь дуусчихсан уу, яасан ч чимээгүй болчихлоо. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор энэ Түр хорооныхоо тайланг сонсож, Бид энэ эмийн үнийн асуудал, чанарын асуудал дээр яах вэ гэдгийг бас нэг яримаар байна. 2 дахь асуудал нь энэ би хөдөө дизелийн түлшний үнэ асар өндөр өсөж байгаа юм байна. Жилийн хугацаанд дизелийн түлш 35 хувиар өссөн байна. Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ 46.4 хувиар, зөвхөн гурилын үнэ гэхэд 50.8 хувиар өссөн байна. Энэ яг статистикийн мэдээ. Хөдөөд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийн өсөлт өсөөгүй учраас хөдөөгийн иргэд энэ үнийн өсөлт хамгийн их бас нэрвэгдэж байна гэж хэлж болохоор бол байна.

Тийм учраас бол Их Хурлаас энэ түлш гол нэрийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах нөөц бүрдүүлэх хууль баталсан. Мах, түлш, шатахуун, гурил гээд. Энэ 3 бүтээгдэхүүн дээр л үнийн өсөлтийг тогтворжуулъя, нөөц бүрдүүлье гэж бид хууль баталсан шүү дээ. Тэгээд энэ хуулийнхаа хэрэгжилтийг Их Хурал дээрээ яримаар байна дарга аа. Өнөөдөр

байдаг юм уу, амжихгүй бол он гарангуут ярьдаг юм уу, хууль баталчхаад тэгээд энэ хууль нь хэрэгжихгүй, тэгээд бид нар чинь хөдөө очихоор амаа таглуулаад байна шүү дээ. Нөгөө түлшний үнэ тогтвортой байх юм байна гэж үзсэн, хаана байна. Гурилын үнэ тогтвортой байх юм байна гэж үзсэн. Бид нар та нараас олон юм нэхэхгүй, ганц гурилын үнийг түлшний үнийг тогтвортой байлгаж чаддаггүй юм уу гээд ингээд.

Тийм учраас бол энэ хуулийнхаа хэрэгжилтийг ирэх 7 хоногт Их Хурал дээрээ ярьж үнэлэлт дүгнэлт өгч бид бас нэлээн яримаар байна. Цаашидаа энэ хөдөөгийн иргэдийг яаж орлоготой орлогыг нь нэмэгдүүлэх юм. Энэ МАА-н гаралтай бүтээгдэхүүний үнийн өсөлтийг яаж бий болгох вэ гэдэг дээр Их Хурал нэлээн онцгой анхаарал хандуулмаар байна. Хаврын чуулганаар Үйлдвэржилтийн байнгын хорооноос гаргасан тогтоолыг гишүүдийн ирц их муутай байсан, оролцоо муутай байж байгаад баталчихсан. Зөвхөн экспортод самнасан, ноолуур гаргана гэдэг угаасан ноолуур гаргана гэсэн ийм чиглэлийг баталж тогтоол болчихсон. Сая Засгийн газар сонсохноо, угаасан ноолуур гаргахгүй, бас зөвхөн самнасан ноолуур гаргана гэсэн ийм тогтоол гаргасан юм шиг байна. Тэгэхээр тэр Их Хурлаас Үйлдвэржилтийн байнгын хорооноос оруулсан, Их Хурлаас дэмжиж гаргасан тэр тогтоолыг ч гэсэн хүчингүй болгох асуудлыг Их Хурлаас яаралтай авч үзмээр байна. Энэнээс чинь болоод энэ хавар ноолуурын үнэ уначихвал яах юм. Хөдөөгийн иргэдийн орлого уначихвал яах юм бэ? Би бодитой зүйл л ярьж байна. Эдийн засгийн хөгжлийн яамнаас асуухаар чинь тийм самнах хүчин чадал манайд бол үндсэндээ алга байхгүй байна аа. Гаднаас энэ тоног төхөөрөмж нь орж ирнэ гэдэг асуудлууд яриад байна шүү дээ. Тэгэхээр энэ Их Хурлаас гаргасан 3 шийдвэртэй холбоотойгоор иргэдийн амьжиргааны түвшинтэй холбоотой, үнийн өсөлттэй холбоотой асуудлыг.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Эрх баригчид шүүмжлүүлэх, муулуулах их дургүй. Янз бүрийн хатуу хүтүү үг сонсохгүй байсаар байгаад ард түмэн та нарыг аймшигтайгаар үзэн ядаж байгаа. Өнөөдөр энэ парламентад бид нийгэмд болохгүй байгаа бухимдлуудыг ярих ёстой, парла гэж хэлэлцэх, ярих ёстой үг шүү дээ.

Энэ утгаараа би хэлэлцэх асуудлын 4-т орж байгаа энэ Биржийн тухай хуультай холбогдуулж байгаа энэ тогтоолыг хойшлуулах тухай санал оруулж байна аа. Өнгөрсөн чуулганаар биржийн тухай хуулийн эцэслэн батлах үед би бас энэ тухай ярьж байсан. Би хувь гишүүн яриагүй шүү дээ. Асуудал ярьж байхад өөдөөс миний хувийн тухай л ярьдаг. Харин 4 асуудлыг би тухайн үедээ арай дэндэж байна аа та нар бүр хулгай бүр гаарлаа гэж хэлчихсэн. 3-ыг нь өөрчлөөд, хамгийн гол юмыг нь бас дахиад оруулаад ирлээ даанч дээ.

Энэ дээр оруулж ирсэн заалтыг нь би ярьа л даа эзэн биегүй ярьж байгаа би асуудал ярьж байна. Энэ 2 дээр нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн гэж байгаа шүү. Иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг эргэлтэд оруулах гэж байгаа. Эзэмшүүлэхээ болино оо. Эзэмшлээс нь гаргана гэсэн үг. Хувьцааг эргэлтэд оруулна аа. Та нар сангийн аж ахуйг хувьчилж байхад хувьцааг эргэлтэд оруулна гэсэн. Өнөөдөр сангийн аж ахуй дээр хувьцаатай комбайнчин, ногоочин, тариаланч хэн ч байхгүй. Ганц 2 гэр бүлд л байгаа. Яг л та нар нийтийн өмчийг нэг хэсэг хүмүүст өгөх тухай л заалт оруулж ирчхээд байгаа байхгүй юу. Социал демократ нам шүү дээ та нар. Энийгээ эргэж хараач ээ. Энэ асуудлаа хойшлуулаач л гэж өнгөрсөн 7 хоногт хэлсэн. Өнөөдөр бас дахиад ярьж байна. Яг хэлэлцэх асуудалтай холбогдуулаад ярьж байна.

Та нар 1072 хувьцааг энэ буруу байхгүй. Та нарын тавьсан гүйцэтгэх захирал цөм цөм олон сая доллар хулгай хийсэн нь буруутай. Хувьцаа нь энэ 1072 хувьцааны эзэд хяналт тавиагүй, хяналт тавих боломжийг нь та нар олгоогүй энэ гүйцэтгэх захирлыг хариуцлага тооцох боломжийг олгоогүй. Энэ тогтоолд юу оруулаасай гэж би хүсэж байгаа вэ гэвэл 1072 хувьцаа эзэмшигчээс хувьцааг нь яаж хурааж авах тухай биш, энэ хувьцаанд нь яаж ашиг шимийг нь илүү өгөх вэ дээр нь нэмээд 1072 хувьцаа эзэмшигчийг тэр Тавантолгой компанийн эзнийг тэр компанийн тэр гүйцэтгэх захирлыг тавихад нь оролцуулдаг. Ажлаа хийхэд нь хяналт тавиулдаг. Бүр ингээд цөм цөм олон сая доллар хулгай хийгээд байвал хариуцлага тооцож хусдаг энэ эрхийг нь нээж өгөх тогтоол оруулж ирэх ёстой болохоос биш өмчийн эзэн болсон 1072 хувьцаа эзэмшигчээс хувьцааны эрхийг нь булааж авах тухай заалт оруулж болохгүй ээ. Энэ арай дэндэж байна аа. Одоо бол Монголын ард түмэн хувьцаанаасаа салчих юм бол Тавантолгой хувьцаанаасаа салчих юм бол гадаа жагсааж цуглаж гомдоллох ч эрхгүй болно. Бүр амар болно, амар хулгай хийх гэж байна л даа.

Ингээд МАН-ынхан аймшигтай алдаа хийж байгааг нь засаж залруулах гэж л сөрөг хүчин байдаг. Чимээгүйхэн шиг байж байгаа энэ тэнэг алдааг нь, дараа нь шархан дээр нь зовоох тухай би боддоггүй ээ. Энэ алдаагаа засаач ээ. Удахгүй чуулган завсарлана. Ард түмэн дээр очиход энийгээ тайлбарлах хэрэг гарна. Монголын ард түмэн зовж зүдэрч болохгүй ээ. Энэ тогтоолтой холбоотой 2 дугаар заалтад холбоотой тэр эргэлтэд оруулах гэдэг гоё нэртэй. Эргэлтэд оруулахын оронд ашиг шимийг нь ахиу өгөх, хувьцааны үр өгөөжийг ахин өгөх, хувьцаа эзэмшигчдийг хяналттай болгох, хариуцлага тооцох эрхийг нь нээх гэсэн ийм заалт орвол энэ бол ард түмний эрх ашигт нийцнэ гэж үзэж байна. Энэ хууль батлагдсантай холбогдуулан аргамжийн

тухай тогтоолыг хойшлуулж өгөөч гэсэн горимын санал гаргаж байна аа.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Өнөөдөр 2022 оны төгсгөлийн ажлын өдөр бид нар бас 1 цаг хугацаа дуусахад ажлаа бас дүгнэдэг. 2022 оны төгсгөл гэдэг чинь үндсэндээ энэ Их Хурлын циклийн дийлэнх олонх хугацаа нь ингээд өнгөрч байна. Өнгөрсөн хугацаанд энэ Их Хурал маань бас ямар ямар хууль, гол хуулиуд, тэр тусмаа 2022 онд ямар гол хуулиуд батлав аа. Үнэндээ бас олон хуулиуд баталсан. Гэхдээ цаана нь үнэхээр бас суурь хуулиуд, бид нар гар хөл хүрч чадахгүйгээр ингээд дийлэнх хугацаагаа өнгөрүүлж байна. Нийгмийн даатгалын багц хууль маань хаачив, Боловсролын хуулийн хэлэлцүүлгүүд маань хаачив? Худалдааг дэмжих худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой бодлого, шийдвэрүүд, худалдааны хууль хаачив. Экспорт, тэр тусмаа уул уурхайн бус экспорт дотор энэ парламент ямар бодлогын шийдэл гаргасан билээ. Үнэндээ юу ч байхгүй, гадаадын хөрөнгө оруулалт гэнэ гэдэг үндсэндээ Оюу толгойгоос бусад гадаадын хөрөнгө оруулалт гэдэг юм бараг 0. Энийг татах ямар бодлогын шийдэл гаргасан, үнэндээ тэр бодлогын шийдлүүд бас байхгүй. Эрчим хүч, агаарын тээврийн либералчлал гээд олон бодлогын шийдлүүд үндсэндээ ийм парламентад үндсэндээ дийлэнх олонх энэ хугацаанд гарахгүйгээр ингээд өнгөрч байна.

Яагаад гэвэл ирэх жилээс үндсэндээ сонгуулийн битүү эхлээд улс төрийн томоохон шийдвэрүүдийг гаргах энэ боломж бололцоогүй болно. Тэгээд саяын тэр том том шийдвэрүүд гарахад том том бодлогыг гаргахад одоо үндсэндээ эрх баригчдын тоо дутаагүй, Бараг энэний буруутан нь Үндсэн хуулийн өөрчлөлт Үндсэн хууль юм шиг энэ нөхцөл байдал руу орж байна. Тэгэхээр үндсэндээ энэ энэ 2022 онд бол томоохон энэ байж болох том өөрчлөлтүүдийг хийх ийм боломж, бололцоотой хугацааг бид бүгд,

ер нь эрх баригчид, сөрөг хүчин гэлгүй энэ парламент энэ боломжийг ашиглаж чадалгүй ингээд өнгөрүүлж байгаа нь харамсалтай байна.

Тэгээд ирэх жилд бас ирэх жил ирэх жилийн хаврын чуулган болоод энэн дээр эрх баригчид нь бас ард түмнээс мандат авсан нь энэ бодлого тодорхойлох эрх бүхий эрх баригчид та бүхэн бас энэ бодлогын томоохон суурь өөрчлөлтүүд рүүгээ хандсан хэлэлцэх асуудал болоод олон зүйл дээр энэ хуулиуд орж ирсэн ийм цаг хугацаа энэ жил ийм дараагийн чуулган байхыг л хүсэж байна.

Тэгэхээр үндсэндээ 2022 онд бол бид нар бодлогын том шийдвэр, өөрчлөлт гаргаж чадалгүй. 2022 оныг өндөрлөж байгаа нь бас харамсалтай байна аа.

Г.Занданишатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 12 дугаар сарын 31-нд Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Сүх-Очир Одон, Пагмын Цэгмид нарын тав дахь хүүхэд болж эхээс мэндэлжээ. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлдээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшиг ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд, Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөе.

Хэлэлцэх асуудалд оръё. Ингээд горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд сая хоёр санал гаргасан. Энэ Ширнэнбандийн Адьяа гишүүн Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт Хөгжлийн банкны. Энэ 3 дахь л асуудлыг хойшлуулъя гэсэн горимын саналыг Адьяа гишүүн гаргасан байна.

4 дэх асуудлыг хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол төслийг хойшлуулъя гэсэн саналыг Цэрэнпилийн

Даваасүрэн гишүүн. Сайнхүүгийн Ганбаатар нарын гишүүд гаргасан. Энүүгээр өнөөдөр хэлэлцэх асуудлаас хойшлуулъя гэсэн асуудлаар энэ 2 асуудлаар санал хураалт явуулна.

Энэ дотроо бол Байнгын хороон дээрээ сайн ойлголцоод Засгийн газарт чиглэл өгөөд л, эргэж орж ирж танилцуул гээд л менежментийг нь сайжруулах, тэгээд эргэлтэд оролцуулах гэдэг үг чинь буруу зөв ойлголт оруулаад байна шүү дээ. Тэрийгээ уул нь засаад оруулаад ирээрэй л гээд тэгээд байсан. Тэгээд нэг ойлгоцтой болохгүй болохоор ингээд буруу зөвөөр тайлбарлацгаагаад янз янзаараа ойлгоцгоогоод. Тэгээд энийгээ бол уул нь ажлын хэсэг, Бат эрдэнэ гишүүн эд нар уул нь тэгээд тэр амь оруулах, үр өгөөжтэй болгох энэ тэр гээд, тэгээд тэрийгээ судалж шийдвэрлэх гэж байна шүү дээ. Төгсгөлд нь судлаад оруулж ирж танилцуулах гээд л Засгийн газарт үүрэг өгсөн хэлбэртэй найруулга энэ тэр хийгээд явчихвал ойлголцоод явчихмаар байгаа юм.

Тэгээд энэ 2 асуудлаар санал хураалт явуулна. Дэгээрээ ийм байна.

Ингээд 3 дахь асуудал Ширнэнбандийн Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар Монгол Улсын Азийн дэд бүсийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийн санал хураалт явуулна.

Ширнэнбандийн Адьшаа гишүүний гаргасан саналаар Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлаас хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулна.

Эхлээд өнөөдрийн анхны санал хураалт учир бүртгэлийн санал хураалт явуулна.

Бүртгэлийн санал хураалт. Энэ гишүүд бүртгэлд ороогүй гишүүд

анхаараарай. Санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай Ширнэнбандийн Адьшаа гишүүний гаргасан горимын саналаар Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг хойшлуулъя гэсэн горимын саналаар Адьшаа гишүүний саналаар санал хураалт явуулъя.

Адьшаа гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй ээ. Энэ тухай асуудлыг хэлэлцэхдээ энэ асуудлыг мөн чанараар сайн судалж ярьцгаахыг хүсье ээ.

Дараагийн асуудлаар санал хураалт явуулна. Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг байгаа. Зарчмын зөрүүтэй 4 саналтай. Зарчмын зөрүүтэй санал дээрээ бас ярилцаж болно. Ингээд саналын дагуу энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Энэ санал дэмжигдсэнгүй. Энийгээ энэ хэлэлцүүлгийн явцад тэр үг үсгээ аятайхан болгочих л доо.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёо.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Ганхуяг гишүүнийг индэрт урж байна аа.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрлийн хуульд нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийж, эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг гүйцэтгэн боловсруулж, хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар санал хураалт явуулахгүйгээр нээлттэй үлдээж, Байнгын хороонд шилжүүлсний дагуу ажлын хэсгээс бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг үндэслэн санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулах үед санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд

оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг үндэслэн санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно оо.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол танилцуулгыг хамт Та бүхэнд хүргүүлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус

санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галын аюулгүй байдалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамигаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухайд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын генетикийн нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

орлуулах тухай, Музейн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архидаан согтууруулахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орох бол тухай, Ургамал хамгааллын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюулгүй бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон Амьтан, ургамал, тэдгээрийн

гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан ан организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье ээ.

Баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Пүрэв-Очирын Анужин гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Доржсүрэн Хорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах референт, Болдбаатарын Билгүүн Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, ХХАХҮ-ийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Стандарт хэмжил зүйн газрын Захиргаа удирдлагын газрын дарга Баярсайханы Ууганбаяр, ЭМЯ-ны Хуулийн хэлтсийн шинжээч Шижээгийн Мөнгөнцэцэг, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын шинжээч Кагватын Гулжан, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын шинжээч Бат-Эрдэнийн Төрбат.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Энэ Зөвшөөрлийн хуулийн би ажлын хэсэгт байгаа. Тэгэхээр энэ асуулт асуух нь зохимжгүй л дээ. Тэгэхдээ нөгөө энэ яамны болон зарим Их Хурлын гишүүдийн лоббигоор орж ирсэн нэг заалтаар бас ярихгүй болохгүй болчхоод байна. Амьтны тухай хууль байгаа. Тэгээд энэ агнуурын зөвшөөрөлтэй холбоотой энэ агнуурын зөвшөөрөл дээр хүн бүр орох боломжтой, гадаадын анчин ч оролцох боломжтой ийм заалт орж ирж байгаа юм. Энэ бол нэг тийм томоохон аж ахуй бүгдийг нь энэ зөвшөөрлийг авах ийм боломжоор л хангасан нэг энэ олон хувийн аж ахуйн нэгжүүдийг ан агнуурыг олон жил үйл ажиллагаа явуулсан тэр ААН-үүдийг боомлох ийм заалт орж ирж байгаа. Энэ бол маш хариуцлагагүй үйлдэл. Тэгэхээр ер нь бол хэн ч хамаагүй агнуурт оролцохоор гадаадын анчин ч гэсэн хамаагүй орох юм байна. Гадаадын анчин орох дээр тэр хүний чинь уул хадаар хамаа намаагүй

явдаг, тэрний хувийн аюулгүй байдлыг тэр мэргэшсэн байгууллага л хамгаалдаг байхгүй юу. Тэр эрсдэлд орчихно.

Хоёрдугаарт нь тэр ан агнуурын менежмент хийдэг ийм компаниуд байдаг. Тэд нар чинь яаж угалзаа, энэ тэхээ яаж өсгөх вэ. Яаж энэ ан амьтнаа бас ийм сайн, ан бий болгох уу гэдэг дээрээ л ер нь бол ингээд анхаарал тавиад явж байдаг. Тэр менежментийг нь тэр чигээр нь гадагш нь гаргаад ингээд хаячхаж байгаа юм. Тэгээд энэ хууль дотор чинь бас ингээд нэлээн олон ийм галзуу хүний өдрийн тэмдэглэл шиг ийм юмнууд орж ирээд байгаа юм л даа. Тэгээд Зөвшөөрлийн тухай хууль дээр мөн Монгол Улсын иргэний эрх зүйн чадамжтай этгээд татвар төлөгчид зөвшөөрөл олгоно гэж үндсэн шаардлага дээр нь бичсэн мөртөө гадаадын анчин оролцох боломжтой гээд заагаад өгчихсөн.

Дээрээс нь төсөл дотроо дуудлага худалдаагаар онлайнар цахимаар дуудлага худалдаа явуулна гэсэн мөртөө заавал гарын үсэг зурж байж тэр зөвшөөрнө, хүчинтэй болно хэрвээ гарын үсэг зурахгүй бол тэр дэнчин нь хүчингүй болно гэдэг ийм онлайнар болж байгаа юм бол тэр бүрэн онлайнараа явуулаад л дуусна биз дээ? Ийм нэг ийм яг нөгөө нэг томоохон ААН-д л бүх анг бүгдийг нь бага маржсантайгаар их өндөр үнэтэйгээр бүх анг аваачиж өгөх ийм зориулалттай л хууль батлагдаж байна шүү дээ. Энэ чинь I жилдээ ганц, хоёр уулз загнадаг тэр компаниудыг чинь бүгдийг нь энэ зах зээлээс нь хөөж гаргах үндэсний онцлогтой энэ ан агнуурын энэ салбарыг устгах ийм зүйлийг хийж байна шүү дээ. Энэ зарим нэгэн Их Хурлын гишүүд зарим бизнест дургүй байж болно. Зарим хувь хүнд дургүй байж болно. Тэрийгээ ингэж хууль болгож оруулдаг, энийг нь яам ингэж оруулж ирж, энэ өөрсдийнхөө нэг гараараа болохоор цахимаар явуулна гэхчээд заавал гарын үсэг зурна гэдэг ийм хачин хачин юм хийдэг, тэгээд өөрсдөө л нөгөө эрх мэдэл авчирдаг ийм зүйлүүдийг хийгээд байгаад харамсаж байна.

Тийм учраас энийг хэлэлцэх Дэгийн тухай хуулиар ямар боломж байна. Энийг буцааж засварлах, редакт дээр засварлах ямар боломжууд байна? Энэ тал дээр тодорхой хариулт өгнө үү?

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн ахлагч.

Х.Ганхуяг: Энэ ярьж байгаа асуудал дээр бол анх бол энэ зөвшөөрлийг нь сум, дүүргийн Засаг дарга олгодог байсан. Зөвшөөрлийг бол зүгээр зарладаг байсан. Энэ дээр Зөвшөөрлийн хуулиар бол энэ ярьж байгаа зөвшөөрлийг бол нэг бол дуудлага худалдаа, нэг бол сонгон шалгаруулалт хэлбэрээр явуул гээд хуулийн төсөлд орсон Зөвшөөрлийн хууль тэгж батлагдсан байгаа. Таны ярьж байгаа асуудлыг бол Засгийн газраас өргөн барьсан төсөл буюу салбарын яамнаас аймаг, нийслэлээс олгодог болж гэдэг л ийм байдлаар бид нар танилцуулагдсан. Тэгээд тэрүүгээрээ одоо явж байгаа. Тэгээд энэ таны ярьж байгаа асуудлаар Байгаль орчны яам хариулт өгөх үү?

Г.Занданшатар: 86. Байгаль орчны яам.

С.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Зөвшөөрлийн тухай хууль 2022 оны 6 дугаар сард батлагдахад тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах барихад тусгай зөвшөөрөл олгоно. Уг тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 5.6-д заасны дагуу дуудлага худалдаагаар олгоно оо гэдгийг бол заагаад Зөвшөөрлийн хууль батлагдчихсан. Үүний дагуу бол Зөвшөөрлийн хуульд Амьтны тухай хуулийг нийцүүлэх зорилгоор Амьтны тухай хуульд энэ дуудлага худалдаагаар явах процессыг оруулж өгөх шаардлагатай болсон. Амьтны тухай хуулийн төсөл дээр бол амьтан тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл дээр бол гадаадын анчинд тусгай зөвшөөрөл олгож болно гэсэн заалт бол байхгүй байгаа. Зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага дээр бол татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх гэдэг шаардлага байгаа. Тэгэхээр бол Монгол Улсад татвар төлөгчөөр бүртгүүлсэн этгээд бол энэ тусгай зөвшөөрлийг хүсэж байгаа дуудлага худалдаанд оролцох ийм зохицуулалттай байгаа.

Гарын үсгийн тухайд бол Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж боловсруулагдсан амьтны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дуудлага худалдааг цахимаар явуулж болно гэж байгаа. Тэгээд дуудлага худалдаа хүчин төгөлдөр болохын тулд дуудлага худалдааны явцад хийгдсэн тэмдэглэлд бол оролцогч нар гарын үсэг зурна гэж байгаа. Тэгэхээр тухайн этгээдүүд хэрвээ дуудлага худалдаанд газар дээрээс нь оролцож байгаа бол гарын үсгээ зураад онлайнаар өөр газраас оролцож байгаа бол цахим гарын үсэг хэрэглээд явах бүрэн боломжтой байгаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн 1 минут тодруулъя.

Б.Пүрэвдорж: Ингээд хуулиар хулгай хийж, бусдын бизнесийг дээрэмдэж болдгийн жишээг бол энэ Засгийн газар оруулж ирсэн энэ заалтаараа харуулж байгаа. Би энэ ажлын хэсгийн даргад, яг энэ хойтон болох энэ ан агнуурын зөвшөөрөл дээр хамгийн их зөвшөөрөл авах компанийг би бичээд яг дуудлага худалдаа болсны орой задлахаар Ганхуяг дарга би танд өгнө. Тэгээд нэг компанид зориулж нэг хоёрхон компанид зориулж энэ хууль батлагдаж байна шүү. Ингэж үндэсний аж үйлдвэр, үндэсний энэ хувийн хэвшлийн байгууллагуудаа ингэж буланд шахдаг ийм зүйлээ болих хэрэгтэй. Энэ бол Ганхуяг ажлын хэсгийн даргын ажил биш. Энэ бол тухайн яамных нь, дээрээс нь зарим нэгэн гишүүдийн лоббитой орж ирсэн зүйл. Би танд яг энэ компани.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн бичиж өгөөрэй, хяналт шалгалтыг бас хэрэгжүүлж болно.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Бүгдэд өглөөний мэнд хүргэе. Би бас Зөвшөөрлийн хуультай холбоотой 2 хуульд бас том өөрчлөлт орж байгаа. Энэ бол Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хууль 2 байгаа. Энэ дээр бол бид аль болохоор төрийн тогтолцооны бюрократ тогтолцоог илүү бага болгох, иргэдэд төвөггүй байлгах, ялангуяа манай Монгол Улсад тулгамдаж байгаа нэг асуудал бол энэ эрүүл мэндийн гол бүтээгдэхүүн болох эмийн асуудлыг энэ дээр бол онцгой ярих ёстой. Би ажлын хэсгийн даргаас бүр зориудаар 2 зүйлийг бүр асууя гэж бодож байна. Бид энэ зах зээл дээр байгаа эм, инфляцтай холбоотой үнэд ороод байдаг. Бид төрөөс барьж байгаа бодлого дээрээ бид бас энэ нэн шаардлагатай эмийг хөнгөлөөд улсаас хөнгөлөлт өгөөд төсвөө байнга нэмээд байдаг. Тэгтэл ард иргэд дээр нь эм нь үнэтэй байна гээд дөнгөж саяхан тэр нээлтийн үгэн дээр Чинзориг гишүүн бас ярилаа.

Тэгэхлээр энэ үнэтэй болоод байгаа зүйл бол энэ бюрократ тогтолцоо чинь өөрөө улам үнэтэй болгоод байгаа юм. Тэгэхээр бид аливаа зөвшөөрлөө авчихсан байхад нь дахиад тэрийг нь бүртгэл энэ тэрээр авдаг байдал нь өөрөө улам төвөгтэй болгож, хэн нэгэн хүмүүсээс заавал дахин дахин бичиг, эс үгүй бол зөвшөөрлийг дахин дахин авах нь улам эмийн үнийг үнэтэй болгох эсвэл цаг хугацаа алдах эсвэл хэн нэгэн эрх мэдэлтэнд авлигад өгдөг ийм муухай тогтолцоог өөхиүүлэх ийм байдал үүсэх гээд байна. Нэгэнт импортлох эм нь зөвшөөрөгдсөн лиценз авчихсан байхад түүнийг дахин бүртгэл болгох ямар хэрэг байгаа юм бэ? Энийг анхаараач ээ.

Энэ дээр надад хариулт өгөөч, заавал энэ лиценз гэснийг зүгээр зөвшөөрөл гээд байж болохгүй, заавал бүртгэл болгох гээд байгаа юм уу? Энэний ялгааг та нэг тайлбарлаж өгөөч? Ямар давуу тал байгаа юм?

Хоёр дахь асуудал нь биологийн нэмэлт бүтээгдэхүүн. Бид нарын нэрлэдгээр бол витаминууд байна. Витамин бол ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр шууд оруулна гээд тэгчих юм. Тэгэхээр энэ чинь хар аа витамин болгон өөрөө дандаа гаднаас орж ирэхэд сайн гэхгүй шүү дээ. Тэр доторх найрлага, агууламж дээрээс нь хүний эд эсэд яаж шимэгдэж орж байна вэ, хэдэн хувь нь шимэгддэг юм. Хэдэн хувь нь зүгээр баас шээс болоод гардаг юм. Тэгээд аягүй чухал асуудлууд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бүртгэлжүүлэхгүй шууд зөвшөөрөл олгоно гэхлээр чинь бас болохгүй байна шүү дээ. Ганхуяг дарга аа. Энэ дээр надад тайлбар өгөөч. Бид аль болохоор энэ зах зээл дээр байгаа эм, эмнэлгийн хэрэгслүүдээ хянадаг, чанарын тогтолцоог нь сайжруулахын төлөө хичээгээд байдаг. Эмийн агентлаг байгуулчихсан байдаг. Тэгээд мэргэжлийн байгууллагуудын дуу хоолой үгийг бас сонсмоор байна аа? Та яагаад тэгэх боломжгүй байгаа гэдгээ нэг тайлбар өгөөч?

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Яг энэ эрүүл мэндийн яам, салбар тэр тусмаа яг энэ эмийн хэрэгсэлтэй холбоотойгоор бол манайд эмийн импортлогч нарын мафи бий болчихсон. Аягүй олон давхар зөвшөөрөл авдаг байсан. Тухайлбал ганц эмийг оруулж ирэхийн тулд тэр эмийг бүртгэлд бүртгүүлнэ. Тэр эмийг Монгол Улсад хэрэглэж болно оо гэж яахын тулд шинжилгээнд оруулаад, бүртгэлд бүртгүүлээд дараад нь тэр эм нийтлүүлэгч компанитайгаа гэрээ хийсний үндсэн дээр эм импортлох зөвшөөрөл авна. Тэгээд 2 удаа зөвшөөрөл

авна. Тэгээд оруулж ирэх болгондоо хаана ямар боомтоор оруулж ирэх вэ хэдэн ширхэг ямар эм авах юм. Бүгдийг эм тус бүр дээр нь зөвшөөрөл авдаг байсан. Бүр ингээд яг майхан болчихсон. Яг энэ эмийн салбар руу шинэ тоглогч орох ямар ч боломж байхгүй, ийм тэрнээсээ үүдээд эмийн үнэ буурах ямар ч боломж байхгүй.

Дээрээс нь тэр зөвшөөрөл дээрээ үндэслэж хуурамч юм оруулж ирдэг. Бүр харин эсрэгээрээ Чинбүрэн эмчээ хуурамч юм оруулж ирдэг шүү. Яг тэр доз нь таардаггүй эм хүртэл орж ирдэг. Ийм асуудал байсан. Тэгээд ямар ч байсан энэ дээр нь бид нар нэг шатны зөвшөөрлийг нь байхгүй болгосон. Тэр нь юу вэ гэхээр тухай бүртээ оруулж ирэхдээ ширхэг бүр дээрээ авдаг зөвшөөрлийг нь бүртгэл болгож байгаа. Нэг ёсондоо эм импортлогч оруулж ирэхдээ хэдэн ширхэг ийм ийм эм, ийм боомтоор оруулж ирнэ гэдгийг зүгээр юу руу цахимаар л хүргүүлнэ гэсэн үг.

Тэгээд бол оо. Энэ олон давхар зөвшөөрөл чинь нэгдүгээрт авлигалыг өдөөж байна.

Хоёрдугаарт, эмийг үнэтэй болгож байна.

Гурав шударга өрсөлдөөний зарчим гэдэг юм чинь байхгүй болчихсон юм. Эмийн салбар бол яг эрүүл мэндийн салбар ерөөсөө мафи болчихсон байна лээ шүү. Би өөрөө компаниудын нэрийг нь ч дурдаад явахад бэлэн байна. Тэгэхээр энэ дээр бол таныг бол ойлгож байна. Та өөрөө эрүүл мэндийн салбарын хүн таныг хамгийн түрүүнд лоббидоно. Тэгээд энд сууж байгаа гишүүн болгон аль нэг салбартай холбоотой. Тэгээд гишүүн болгон лоббидож, энэ зөвшөөрлийн тоо чинь 1600 болчихсон байхгүй юу? Бид нар энийг чинь бууруулах гэж, энэ чинь салбар болгонтой яам болгонтой бид нар чинь хэлэлцээр хийдэг, судалгаа хийдэг, эрсдэлийн судалгаа хийдэг. Тэгэхээр та ажлын хэсгийн ажлыг битгий тэгж буруугаар

үнэлэлт дүгнэлт хийгээрэй л гэж би хүсмээр байна.

Хоёр дугаар асуудал энэ биологийн нэмэлт бүтээгдэхүүний зөвшөөрлийг яагаад хүчингүй болгож байна вэ гэхээр бүх дэлгүүрүүдээр витаминууд чинь ямар ч жоргүйгээр, хяналтгүйгээр зарагддаг. Хүн цүнхэндээ хийгээд 3 ширхэг ийм витамин оруулаад ирэхээр 2-оос илүүг нь буюу 3 дахиас нь авхуулаад зөвшөөрөл шаардлагатай гээд хурааж авдаг. Нэгэнт тэр жижиглэнгээр зарагдаж байхад нь хяналт тавихгүй байгаа тохиолдолд бол импорт дээр хяналт тавих шаардлагагүй гэж үзэж байгаа юм. Угаасаа хилээр орж ирэхэд нэмэлт бүтээгдэхүүн витамин хүнсний нэмэлт Мэргэжлийн хяналтын байгууллага тэр бүтээгдэхүүний эрүүл мэндийн эрүүл ахуй тал дээр нь шинжилгээ хийгээд үздэг. Тэгээд тэрний үндсэн дээр нь гаалийн бүрдүүлэлт хийгээд витаминаа оруулж ирдэг. Тэгээд саяын таны ярьсан асуудал дээр чинь л ийм хариулт өгмөөр байна.

Баярлалаа.

Г.Занданишатар: Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Та бас энэ эрүүл мэндийн салбарын гол хэрэглүүр болж байгаа эмийн чанарын асуудалд санаа зовж байгаад үнэхээр баярлаж байгаа. Олон зөвшөөрлүүд, олон төвөгтэй байдлууд нь энэ тогтсон үнийг нэмэгдүүлдэг, үнийг монополддог. Олигополи, монополи системийг устгахын төлөө бид бас ажиллаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол гишүүд лоббидоод энийг хийхгүй байгаа гэж хэлж байгаа бол тэр буруу шүү. Харин эсрэгээр үүний төлөө бид хамтдаа ажиллах ёстой. Тийм учраас олон төвөгтэй асуудлуудыг бууруулж байгаа нь сайн байна. Тэгэхдээ хамгийн эцсийн юун дээрээ нэг нь зөвшөөрөгдсөн, нэгэнт ороод ирчихсэн юмыг дахиад бүртгэлжүүлэх, мэдүүлэг болох хоёрын ялгааг л та надад сайн ялгаад хэлээд өгчихье л дөө.

Үнэхээр энэ хялбаршуулж байгаа юм уу, эс үгүй бол төвөгтэй болгож байгаа юм уу? Энийгээ нэг хэлээд өг.

Хоёр дахь асуудал. Витамины хэрэглээн дээр нэгэнт жижиглэнгийн худалдаан дээр хяналт тавихгүй, импортоор орж ирэхэд нь бол хяналт тавихгүй гэдэг чинь буруу. Энэ бол ялгаагүй хүний биед орж байгаа, шингээж байгаа бүтээгдэхүүн учраас бид.

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн ажлын хэсэг хариулъя.

Х.Ганхуяг: Чинбүрэн гишүүнтэй яг бүрэн санаа нийлж байгаа. Тийм учраас яг энэ өрсөлдөөнийг нь харин бүрдүүлж өгөх үүднээс энэ зөвшөөрлүүд дээр ийм байдлаар бид нар шийдлүүдийг гаргасан байгаа. Тэр салбарын яамнаас бол энгийн зөвшөөрөлтэй болох санал оруулж ирсэн. Нэг ёсондоо оруулж ирэх болгондоо эм тус бүр дээрээ тоо ширхэг үүр дээрээ зөвшөөрөл авдаг байсныг нь болиулаад бүртгэл болгож байгаа. Бүртгэл гэдэг маань ямар нэгэн зөвшөөрлийн шинж чанаргүй байна л гэж байгаа юм. Зөвшөөрлийн хуулиар угаасаа концепт нь тийм байгаа. Тэгэж орсон байгаа. Ямар нэгэн зөвшөөрлийн шинж чанартай бүртгэл, лиценз, мэдүүлэг байхгүй шүү гэдэг Зөвшөөрлийн хуульд орчихсон байгаа үндсэн концепт тийм. Тийм болохоор бүртгэл гэдэг маань ийм эм оруулж ирэгч нь тоо ширхгээ зүгээр тухайн салбарын тэр агентлагтай мэдэгдэл өгөр байдлаар хүргүүлнэ л гэсэн үг. Тийм хялбаршуулж байгаа гэсэн үг. Таны санаа зовж байгаа асуудал дээр чинь харин ч яг ийм шийдэлтэй орж ирж байгаа гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Витамин дээр бол угаасаа бид нар эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрүүл ахуйн шалгалт буюу тухайн эрүүл ахуйн хяналтын угаасаа хил дээр.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Шинээр батлагдаад хэрэгжиж эхлэх гэж байгаа Зөвшөөрлийн тухай хуулийг зарчмын хувьд бол маш ихээр дэмжиж байгаа. Энэ төрийн оролцоо, төрийн тэр хаалт, лиценз, олон зүйл, энэний цаана нуугдаж, бизнес эрхлэгчдийн боломжийг үндсэндээ дарамталж байгаа энэ зүйлүүд бол энэ зарчмын хувьд маш зөв хууль гэж ойлгож байгаа энэн дээр энэ ан агнуурын зөвшөөрөлтэй холбоотой мэргэжлийн оролцогчдоос нэг ийм санал ирснийг та нарт дамжуулах гээд. Тэр 291.2 гэсэн байх, 29.1 ч юм уу, энэ зүйл заалт дээр ан агнуурын зөвшөөрөл гаргахдаа 14 хоногийн дотор нийтэд мэдээлж, 30 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулна гэдэг нь энэ цахим хэлбэрээр нээлттэй гэдэг утга цаана нь явж байна уу? Цахим гээд тэрэн дотор шууд цахим хэлбэрээр зохион байгуулна гэхээр цахим мөртөө энэ чинь нэг хаалттай зүйл цаана нь болчих вий. Энэ яг тэр дуудлага худалдааны зарчим нь энд ил тод харагдахаар тусгаж өгөөч гэдэг тэр мэргэжлийн оролцогчдоос нэг ийм санал ирж байна лээ.

Ер нь бол цахим байна уу, цаас байна уу энэ чинь зүгээр нэг арга хэрэгсэл болохоос биш тэр зарчмын асуудал биш шүү дээ. Тэгэхээр энэний цаана энэ үгний цаана дахиад хаалттай гэдэг үг нь явчих вий гэдэг ийм болгоомж, энийг бас энэ хуулийн хэлэлцүүлгийн үеэр бас хэлж өгөөч гэдэг ийм санал ирж байсан. Тэгээд энэ зүйл заалтын цаана та нар тэр ажлын хэсгийнхэн 291.2 гэх шиг болсон шүү. Энэндээ тэр цахим хэлбэрээр гэдгийн цаана нээлттэй гэдэг утга агуулга нь явж байгаа юу. Энэн дээр бол та нар нэг тайлбар өгөөч.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Засгийн газарт өгөгдсөн тогтоол дээр бол угаасаа энэ шударга өрсөлдөөний зарчмаар явах ёстой шүү гэдэг байдлаар хууль батлагдсан

Зөвшөөрлийн хууль. Тийм ч учраас энэ дуудлага худалдаанаас бол нээлттэй дуудлага худалдаагаар явагдах ёстой. Орж ирсэн байгаа Аялал жуулчлалын хууль дээр түр операторуудад зөвшөөрлийн асуудал бас яригдсан байгаа. Түр Аялал жуулчлалын хуулийг дагалдуулаад бас энэ амьтны яг зөвшөөрөл олгох энэ дуудлага худалдаа явуулах, юу нь бас нарийвчлан орж ирсэн байгаа. Яах вэ тэр энэ 2 бол нийцэж байгаа. Энэ хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Улсын Их Хурлаас ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Хэрэгжилтийг хангахтай холбогдсон. Тусдаа ажлын хэсэг буюу тэгэхдээ энэ Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсгийн гишүүд бүгдээрээ орсон байгаа. Пүрэвдорж гишүүн бас яг энэ ажлын хэсэгт орчихсон байгаа.

Тиймээс одоо хэрэгжилтийн шатан дээр нь бид нар хяналтаа тавиад олон нийтэд нээлттэй явуулах байдлаар хяналтаа тавиад явах боломжтой байгаа. Ажлын хэсэг нэмээд хариулчих.

Г.Занданшатар: Байгаль орчны яам. Одоо нэг гишүүний асуулт хариултын дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. 16 саналтай.

86 товч тодорхой хариулаарай. Байгаль орчны яам.

С.Цогтгэрэл: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 29²-т заасан байгаа энэ хуульд заасан зөвшөөрлийн дуудлага худалдаа, мөн хуулийн 26.3-т заасны дагуу Засгийн газраас тусгай зориулалтаар агнуурын агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлж, 30 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулна гэсэн ийм заалт байгаа.

Тэгэхээр олон нийтэд нээлттэй гэдэг нь бол энэ дээр бүрэн туссан байгаа гэж ойлгож байгаа.

Г.Занданишатар: Өөрийгөө танилцуулж хариулж байгаарай, энэ протоколд тэмдэглэж үлдэх учраас нэр ус чинь дандаа.

С.Цогтгэрэл: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга С.Цогтгэрэл.

Г.Занданишатар: Сүхбаатарын Цогтгэрэл гэсэн байна.

Одоо Пүрэв-Очирын Анужин гишүүн асуулт асууна.

П.Анужин: Энэ салбарынхантай холбоотой асуудал байгаа. Тэгээд энэ дээр эргэлзээ нь тайлагдахгүйгээр мөн салбарынхны өгсөн саналыг харгалзаж үзэхгүйгээр оруулаад ирлээ гэж энэ юу вэ гэхээр Эм, эмнэлгийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан байгаа. Импорт, экспортын лиценз гэснийг мэдүүлэг гэж өөрчлөх гэдэг санал өгсөн байгаа. Тэгээд энэ бол утгаараа Чинбүрэн гишүүний асуугаад байсантай утга нэг асуултыг асууж байгаа юм. Тэгээд нэгэнтээ ороод ирсэн энэ эмэн дээр ахиад яагаад лицензийг шаардаж байгаа юм бэ? Зүгээр мэдүүлгээ өгөх нь өөрөө нөгөө эм импортлогчид чинь хамаагүй ажлыг энэ хуулийн мөн чанар болсон тэр ажлыг хөнгөвчлөхтэй нийцэх юм биш үү?

Тэгэхэд дахиад лиценз шаардана гэдэг бол энэ ажлыг маш хүндрүүлж байгаа. Энэ хуулийн бол гол мөн чанар оршихгүй байна аа. Тэгэхээр энд энэ салбарынхны өгсөн саналыг харгалзаж үзээч гэсэн ийм хүсэлтийг тавиад байгаа юм. Энэ дээр хариулт авъя аа.

Баярлалаа.

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Ганхуяг: Анужин гишүүн ээ. Та андуу хуураад байх шиг байна. Лицензийг харин болиулж байгаа юм. Лицензийг болиулж байгаа Зөвшөөрлийн хуулиар зөвшөөрлийн шинж чанартай ямар нэгэн мэдүүлэг, бүртгэл, лиценз юу байхгүй гэж орж байгаа юм. Тийм ч учраас салбарын хуулиуд, дээр нь лиценз гэж явсан зүйлийг нь бид нар наадах чинь бол зөвшөөрөл биш байна гэдгээр зүгээр бүртгэлийн үйл ажиллагаа л болгож байгаа гэсэн үг. Яах вэ тухайн орж ирэхдээ тухай бүртээ оруулж ирэхдээ бид нар ийм юм оруулж ирэх гэж байна гээд л тэр цахимаар салбарынхаа агентлаг руу л явуулна гэсэн үг. Тийм, тэгэхээр наадах чинь бол ажлыг хөнгөвчилж байгаа нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт бол бүртгэлтэй явна.

Гуравдугаарт болохоор зөвшөөрөл гэдэг байдлаар тэр авлигал байдаг юм уу, хүнд суртлуудыг тийм юмнаас ангижирч байна л гэж ойлгох хэрэгтэй.

Баярлалаа.

Г.Занданишатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн тодруулж асууя.

П.Анужин: Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд лиценз гэдгээрээ орчихсон байгаа гэж. Тэгэхээр энийг мэдүүлэг гэснээр оруулна гэсэн ийм л зүйлийг хэлсэн юм байна лээ шүү. Тэгэхээр бүртгэл гэдгээр орсон гэсэн үг үү? Лиценз биш бүртгэл гэдэг үгээр үү? тэ? Баярлалаа.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя. Энэ хооронд санал хураалт бэлтгэе.

Х.Ганхуяг: Тэгээд лиценз биш бүртгэл гэдгээр орж байгаа. Тийм, баярлалаа.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 16 саналын томъёолол байгаа.

Санал хураалт. Гишүүд асуулт асууж хариулт авч дууссан. Санал хураалт явуулна.

Яагаад санал хэлээгүй байхад юун санал явуулж байгаа юм? Асуулт асууж, үг хэлж дууслаа гээд алх цохидог. Тэгээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор 16 санал байгаа санал хураалт явуулна. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн саналуудаар санал галт явуулна.

Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал байна. Энэ бол Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Нэг.Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9 дүгээр зүйл.Гадна зар сурталчилгаа

9.1.Гадна зар сурталчилгаанд нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар байрлуулах зар сурталчилгаа хамаарна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.12-т заасны дагуу гадна зар

сурталчилгаа байрлуулах зөвшөөрлийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар олгоно.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд гадна зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрлийн олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

9.3.Гадна зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл хүссэн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

9.3.1.гадна зар сурталчилгаа байрлуулах байршил, солилцлын цэг;

9.3.2.гадна зар сурталчилгааны байгууламжийн ангилал, төрөл, тоо, хэмжээ, ажлын зураг;

9.3.3.орон сууцны зориулалттай барилгын цонхгүй цул хана, дээвэрт сурталчилгааны байгууламж байрлуулах бол тухайн сурталчилгаа байрлуулах хэсэгт хамааралтай орон сууц өмчлөгчдийн энгийн олонх зөвшөөрснийг баталсан сууц өмчлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн хурлын тогтоол.

9.4.Гадна зар сурталчилгаа байрлуулахыг хориглох байршил, тухайн нутаг дэвсгэрт байрлуулах гадна зар сурталчилгааны өнгө, үзэмж, хэлбэр, аюулгүй ажиллагааны болон стандартын нийтлэг шаардлагыг тухайн шатны нутгийн өөрөө удирдах байгууллага тогтоож болно.

9.5.Энэ зүйлийн 9.1-д заасан зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батална.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 1 дэх хэсгийн “1.1, 1.21,” гэснийг хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.11 дэх заалтын “үйлчилгээ эрхлэх” гэсний дараа “зорилгоор талбай ашиглах” гэж нэмж, мөн зүйлийн 1 дэх заалтын “8 дахь хэсгийн 8.14, 8.28, 8.29 дэх” гэснийг мөн заалтын “5 дахь хэсгийн 5.1,” гэсний дараа шилжүүлэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт болгох.

“Тайлбар: Энэ зүйлийн 4.1.2-т заасан “сонгон хэрэглэх баримт бичиг” гэж хүчин төгөлдөр стандартаас хэрэглэхэд тохирох стандартыг сонгохыг ойлгоно. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

Баримт бичиг гэж сонгохыг ойлгоно гэдэг чинь юу гэсэн үг. Баримт бичиг гэж сонгохыг ойлгохгүй баримт бичгийг л ойлгоно шүү дээ.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэний найруулгыг сайн хараарайдаа.

Дөрөв.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “21.1.11, 21.1.18, 21.1.20,” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

Ширнэнбандийн Адышаа гишүүн. Өдөржин ингээд л тойроод санал хураалт үймүүлээд хүмүүстэй уулзаад байх юм. Суудал дээрээ сууж болдоггүй юм уу?

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 6.2 дахь хэсгийн “14-20” гэснийг “15, 17, 18, 19, 20” гэж, мөн хэсгийн “21.1.8-21.1.21, 21.1.23-21.1.30, 21.1.32-21.1.38,” гэснийг “21.1.8, 21.1.9, 21.1.12, 21.1.13, 21.1.15, 21.1.16, 21.1.17, 21.1.24, 21.1.26, 21.1.27, 21.1.28, 21.1.30, 21.1.32, 21.1.33, 21.1.34, 21.1.35, 21.1.36, 21.1.37, 21.1.38,” гэж, мөн хэсгийн “27.2-27.5” гэснийг “27.3, 27.4, 27.5” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “мөн зүйлийн 21.1.21 дэх заалтын “эрх” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн “6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “30.2.2-30.2.6 дахь заалт, 30.3-30.5 дахь хэсэг” гэснийг,” гэснийг, мөн зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.1.38, 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.4,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгах санал:

Нэг.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “болон энэ хуулийн” гэсний өмнө “жагсаалт,” гэснийг “жагсаалт” гэж нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Энэ одоо юу гэсэн үг вэ? Жагсаалт гэснийг жагсаалт гэж нэмэх гэдэг чинь юу гэсэн үг вэ? Жагсаалт болон энэ хуулийн гэснийг жагсаалт болон энэ хуулийн гэж нэмэх гэж уншигдаад байна шүү дээ. Наадахаа шигтгээд уншиж үзвэл.

Эдийн засгийн байнгын хорооны гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2, 3, 9, 10, 11, 12, 13, 14 дахь заалтыг, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.1.20 дахь заалтыг, 10.2 дахь хэсгийг, мөн зүйлийн 5 дахь заалтын 11.1.28 дахь заалтын “болон үүсмэл орд ашиглах” гэснийг, 8 дахь заалтын 20.5.5 дахь заалтын “мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш заасан хугацаанд сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтын 10.3 дахь хэсгийн “18.1.7-д” гэснийг “4.1.30-д” гэж өөрчилж, мөн зүйлийн 8 дахь заалтын 20.5.3 дахь заалтын “шалгарсан” гэсний өмнө “геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын кадастрын

асуудал хариуцсан нэгж” гэж нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “сонгон шалгаруулалтад оролцох” гэсний дараа “, үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн” гэж,” гэснийг, мөн зүйлийн “, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “эзэмшигч” гэсний дараа “, үүсмэл орд гэрээгээр ашиглагч хуулийн этгээд;” гэж” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг, 5 дахь заалтын 20.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 20.1-д заасны дагуу” гэснийг, мөн зүйлийн 6 дахь заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 5 дахь заалтын 20.1.2 дахь заалтын “10.1.20-т” гэснийг “10.1.2-т” гэж, 20.2.1 дэх заалтын “10.2-т заасан маягтын” гэснийг “10.1.2-т заасан аргачлалын” гэж тус тус өөрчилж, 20.3.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.3.2.энэ хуулийн 20.3.1-д заасан үнэлгээг нэгтгэхэд хоёр болон түүнээс дээш оролцогчийн үнэлгээ тэнцсэн тохиолдолд илүү үнийн саналтай оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагад” гэснийг “Засаг даргад”

гээж,” гэснийг, мөн зүйлийн “53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Хайгуулын болон ашиглалтын” гэснийг “Хайгуул, ашиглалтын болон үүсмэл орд ашиглах” гээж,” гэснийг тус тус хасах . Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “Цөмийн болон цацрагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 20.2.5 дахь заалтыг, мөн төслийн 3 дугаар зүйлийг тус тус хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 9.6 дахь хэсгийн “6.7-д” гэснийг “5.2-т” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “15.4,” гэснийг хасаж, мөн зүйлийн “15.4 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж,” гэснийг “15.4 дэх хэсгийн “заасан эмэнд эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж гэснийг “заасан эмийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэх бөгөөд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж өөрчилж, мөн зүйлийн “мөн зүйлийн 15.5 дахь” гэсний өмнө “мөн хэсгийн “импортын лиценз” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан зөвшөөрлийг” гэж нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Санал хураалт.

69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

*Дараагийн асуудалд оръё.
Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх
журмын тухай хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг явуулна аа.*

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодез зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах тухай зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

батлагдах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байгаа тухайн хуулийн зөвшөөрлийн харилцааг зохицуулахаар тусган Зөвшөөрлийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39-дүгээр зүйлийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах, үе шаттай нэгтгэн явуулах тухай горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ. Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсээж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүд түрүүчийн хуультай холбогдуулан боловсруулсан учраас ажлын хэсэг бол адил байгаа байх гэж бодож байна.

Нэмэгдэж байгаа нь бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Галбаатар, АМТГ-ын Кадастрын хэлтсийн дарга Доржийн Батмагнай. Нэмэгдэж байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж.

Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Дашдондогийн Ганбат асуулт асууна.

Д.Ганбат: Ингээд ямар ч байсан нэг хууль гараас гарч байгаа юм байна. Энэ авлига энэ юм багасах уу, энэтэй холбогдуулаад ямар судалгаа байдаг юм. Тэгээд нөгөө хонх нь дуугарахаар дамар нь таг, дамар нь дуугарахаар хонх нь таг гэгчээр наад хууль чинь яг бусадтайгаа харьцаж нийлж үйлчилж чадах уу? Нөгөө хөрс сууриараа л ярихгүй бол бид бүхэн, тэгээд хоёрын хооронд юм хийчхээд л, тэрэндээ баясаад л, ард түмнийг хүлээлтэд оруулаад л ингээд явдаг. Иймэрхүү байдлаар өмнө нь баахан хууль гаргасан. Тэр нь цаасан дээр үлддэг. Амьдрал дээр хэрэгждэггүй. Тэр хуулийн чинь нэг хэсэг нь болчих юм биш биз дээ. Энэ тал дээр ямар байна. Өөр одоо саад бэрхшээл болж байгаа юм юу байна. Наадхыг чинь одоо зөвшөөрөл өгөхгүй байна гээд тэр авлига авсан, өгсөн хойно нь 2-улаа шийтгүүлдэг болохоор амьдрал дээр нэг их хэрэгжихгүй болов уу л гэж бодоод байх юм би.

Энэ тал дээр ямар байдаг юм бол оо? Нөгөө талаараа хуулиас давсан дүрэм журам гаргадаг аа. Нэг сайхан хууль гаргачихлаа гэдэг доор байгаа албан тушаалтнууд дуртай, дуртай, дүрэм журмаа гаргадаг тийм дүрэм журам гаргахыг нь хааж чадсан уу? Манай энд ийм л дүрэм байдаг юм. Энүүгээрээ л явна. Тэр хууль чинь ямар хамаатай юм гээд л дор бүрнээ тэгж ярьдаг л даа. Уул нь хуулиас давсан дүрэм журам үйлчлэх ёсгүй л юм байгаа юм. Тэгээд нэг зөвшөөрөл өгдөг, нэг авгай ургийн мод ургуулчихсан МАН-ынхан. Тийм маягаар л явдаг. Тэгээд энэ албан тушаалтантай хариуцлага тооцохгүйгээр ийм юм явахгүй байх аа. Өнөөдрийг болтол хэн ч албан тушаалтанд хариуцлага тооцож чадсангүй шүү дээ. Хариуцлагын асуудал ерөөсөө яригддаггүй. Тэгээд нөгөө л одоо

энэ яам. тамгынхны ярьдгаар МАН-ын үед улныхан болсон.

Монголын ард түмэн л хохироод л үлддэг. Улам л улныхан болж байгаа юм байна л даа. Би бас хөдөө орон нутгаар тойргоороо яваад ирлээ. Амьдрал бол их хүндэрсэн байна шүү. Одоо зөвшөөрөл энэ тэр гэлтгүй ямар ч бизнес явж байгаа юм алга. Бүгд л одоо энэ шинэ жилээр хэн нэг нь гарч ирээд хундагатай ямар юм чөлөөлчих болоо л гэж хүлээлтийн байдалтай л байна. Өрөндөө баригдсан байна. Амьдрал хүнд хэцүү байна. Мэдээж хэрэг энэ МАН-ын дарга нарын ширээ бол бялхах байх л даа. Шинэ жилээр бол ширээ дүүрэн идээ будаатай байх юм байгаа биз. Ард түмний амьдрал бол тиймгүй шүү. Бас шинэ жил юу ч гэдэг юм. Тэгээд нөгөө төрийн албан хаагчдын цалин чинь нэмэгдсэн юм ерөөсөө амьдрал дээр бол байхгүй юм шиг байна. Доллартой харьцуулбал нэг 500 байж байгаад 40, 8 хувь нь нэмэгдээд нэг 700 орчим болох юм байна. Баахан татвар татаад явчих юм байна гэх мэтчилэнгийн ийм асуудлууд байна. Тэгээд өөрсдөө бялхтал шинэ жил тэмдэглээд л, зугаалаад л баясаад байдаг.

Нөгөө төрийн албан хаагчид чинь бол зайлуул, ямар ч шинэ жил тэмдэглэж байгаа юм алга. Дайны үеийн байдалд байдгаас долоон дор байдалтай байна шүү дээ. Тэгээд нэг иймэрхүү юм хэлэлцээд сууж байдаг. Иймэрхүү юм яриад сууж байдаг. Энэ чинь хэлдэг, ярьдаг хүн байхгүй болчихсон юм уу? Энэ дотор чинь ийм л байх юм хүүхдүүдээ хүнд байна шүү, ард түмний амьдрал. Тэгээд баяр болохоороо илүү их мэдрэгддэг юм байна. Тэр нь хүмүүсийн амьдрал дээр. Та нар ч яах вэ гэр орондоо болж байгаа тэр нам дотороо болж байгаа.

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултад хариулна.

Х.Ганхуяг: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Ганбат гишүүн маш зөв зөв асуудлуудыг хөндөж байна. Ер нь бол энэ хуулийн концепц өөрөө яг таны яг санаа зовниж байгаа асуудлуудыг бол бас багагүйгээр шийдэх гэж оролцсон бид нар.

Нэгдүгээр асуудал бол энэ хууль батлагдсантай холбоотойгоор ямар нэгэн зөвшөөрлийн процессыг дүрэм, журам, тогтоол гаргахыг хориглосон байгаа. Бүртгэл явуулахыг зөвшөөрлийн шинж чанартай бүртгэл мэдүүлэг, дүрэм журам, тогтоол гаргахыг хориглочихсон байгаа. Энэ зөвшөөрлийг өргөдөл өгөхөөс авхуулаад өгөгдөх бүх тэр процессууд бол зөвхөн энэ хуулиар л явна. Мөн эсвэл салбарын хуулиар л явна гэсэн үг. Тийм болохоор дахиж энэ зөвшөөрлийн хууль дагуулаад юм уу, эсвэл энэ хууль давсан журам гарах боломжгүй болсон байгаа. Хаагдсан байгаа гэсэн үг.

Тийм ч учраас ийм олон хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа юм.

Хоёр дугаар асуудлаар та зардлын асуудлыг хөндлөө. Тэгээд зардалтай холбоотойгоор бол бид нар бас яг энэ хуулийг боловсруулж байх шатанд бол 15, 16 орны яг энэ зөвшөөрлийн хуулиудыг судалж үзсэн. Тэгээд үндсэндээ бол энэ сайн туршилага гэж хэлбэл би Гүрж улсын туршилагыг бас танд дурдчихмаар санагдаж байна. Яагаад гэхээр гарааны нөхцөл байдал ойролцоо байсан гэж хэлэх үү?

Гүрж улс бол 2002 онд яг энэ зөвшөөрлийн процессын хуулийг баталсан байдаг. Бас жагсаалттай, тэгээд эрх бүхий этгээдүүд нь хэн юм байх вэ гэдэг орчихсон байдаг. Тэгээд тухайн үед бол бизнесийн орчноороо 110-т байсан, авлигалын индексээр 130-д ордог байсан. Өнөөдөр Гүрж улс бол бизнесийн орчноороо 7-д орж байна. Бизнес эрхлэх ээлтэй орчин гэсэн шударга. Шударга өрсөлдөөний зарчим дээр суурилсан гэх мэтчилэн. Тэгээд тэрүүгээрээ 7-д орж байна. Авлигалын индекс өнөөдөр гучин хэдэд орж байгаа. Энэ Зөвшөөрлийн хууль

бол угаасаа бид нарын ерөөсөө гол тавьж байгаа зорилго юу вэ гэхээр нэгдүгээрт авлигал, хүнд суртлыг арилгах зорилго тавьж байгаа.

Хоёрдугаарт болохоор бизнесийн, эсвэл хувийн хэвилийн ажил хийх боломжийг нь олгоё гэж байгаа юм. Шударга өрсөлдөөний зарчмаар ажлаа хийг, аль нэг том компанид том том компани юм уу, ААН-ийн тэр өрсөлдөөнийг боомилсон тэр тэр арга хэрэгслүүдийг нь арилгаж байна л гэсэн үг. Тэгээд тийм зорилгоор батлагдаж байна. Тэгээд асуулт асуусанд баярлалаа Ганбат гишүүн ээ.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Ингээд хууль гарчихлаа. Энэнтэй холбогдоод энэ төрийн албан хаагчдын чинь цалин пүнлүү аягүй бага байна аа. Тэгээд энэ хүмүүс чинь авлига авахаас аргагүй, өөр байдалд орчхоод байдаг ямар нэгэн байдлаар. Тэрэнтэй холбогдоод ямар арга хэмжээ авах юм бэ? Тэгээд нэг их олон төрийн албан хаагчтай шүү дээ Монгол Улс чинь. 100 ямаанд 60 ухна гэгчээр. Энэ төрийн баахан зөвшөөрөл өгдөг баахан гарын үсэг зурдаг.

Энэ дарга нарын орон тоо чинь энэнтэй холбогдоод багасах юм уу? Өмнө нь одоо хэчнээн мянган зөвшөөрөл байсан юм. Одоо тэрийгээ багасгаад 600, 700 болгосон гэж ярьж байгаа амьдрал дээр.

Тэгээд энэ зөвшөөрөл өгдөг дарга нар чинь багасах уу, тоо нь багасах уу гэсэн ийм асуулт байгаа юм л даа?

Хууль дүрэмдээ тэгээд оруулчихдаг юм байна. Тэр яг нөхцөлийг нь бүрдүүлж чадсан уу? Олноос олны гарц цөөнөөс цөөнийн гарз гэдэг. Энэ олон авлигачид чинь төрийн нэрээр тэгээд ямар нэгэн байдлаар байж л байгаа шүү дээ. Тэгээд тийм цалин багатай хүнийг яаж ажиллуулах юм?

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Энэ Зөвшөөрлийн хуульд бас цахим нэгдсэн, платформын асуудал орсон байгаа юм. Нэг ёсондоо бүх энэ зөвшөөрлүүдийг цахимаар олгохоор бид нар хуульчилсан байгаа гэсэн үг. Мөн Нийтийн мэдээллийн тухай хууль болон Цахим гарын үсгийн хуулиудад бол холбож өгсөн байгаа гэсэн үг. Тэгэхээр нэг ёсондоо бол нэлээн олон шат дамжлагыг бууруулж байгаа гэсэн үг. Тэгээд нийтдээ 1600 гаруй жишигээлэл 362 болж байгаа. 363, 364 болж байна гэсэн үг. Тэгэхээр цаашидаа бол яг энэ цахим платформ бүрэн нэвтэрсний дараагаар бол тодорхой хэмжээний орон тоо бууруулах боломж бол бүрдэх байх гэж харж байгаа.

Хоёрдугаарт бол эдийн засаг өөрөө тэлээд эхлэхээр татварын бааз суурь бас нэмэгдэнэ ээ. Тэгснээрээ бол бас төрийн албан хаагчдын цалин урамшуулал нэмэгдэх боломж бас бүрдэнэ. Мөн судалгааны явцад бид нар энэ зардал болон цаг хэмнэлтэй холбоотойгоор бид нар судалгаа хийж үзсэн. Нийтдээ бол үндсэндээ бол зөвшөөрөл авах.

Г.Занданишатар: Энэ түгжрэл, хүнд суртал, бүх юмтай холбоотойгоор энэ төрийн ажлын 50 хувийг цахим хэлбэрт шилжүүлж мананд зайнаас ажилладаг. Санал хураалт явуулна гишүүд асуулт асууж хариулт авч дууссан.

Байнгын хороо Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах, үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал байхгүй, үг байхгүй.

Энэ нөгөө анхны хэлэлцүүлэг болохоор асуулт хариулт сая яваад дуусчихсан.

Санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай, санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт.

Ер нь бол хууль хэрэгжүүлэлтэндээ л хоног асуудал байгаа шүү. 53.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах, бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орохын өмнө Болдын Жавхлан сайд, Цогтгэрэл гишүүн хоёр нааш ир.

Дараагийн асуудал дээр Бат-Эрдэнэ гишүүн ээ, Даваасүрэн, Ганбаатар гишүүн та гурав 2 дахь заалтыг.

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Монгол Улс Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банктэй хамтран мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

БНХАУ-ын баримталж буй 0 ковид бодлогын улмаас тогтоосон хилний хязгаарлалт болон ОХУ, Украин улсуудын хямралт нөхцөл байдлаас шалтгаалан хүнс, эрчим хүчний үнэ огцом нэмэгдэж, нийлүүлэлтийн сүлжээний тасалдлыг бий болгосон. Түүнчлэн инфляц түвшин өсөж, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн хямрал улс орнуудын эдийн засагт хүндрэл учруулж байна аа.

Сүүлийн 40 жилд тохиолддог өндөр инфляцын түвшнийг тогтворжуулахаар улс орнууд Төв банкны бодлогын хүүгээ чангаруулж байгаа ба АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүг 2022 оны 11 дүгээр сарын хурлаар 6 дахь удаа эрс нэмэгдүүлсэн нь ам.долларын ханшийг голлох валютуудын эсрэг дахин өсгөж, хөгжиж буй орнуудад өрийн болон валютын ханшийн дарамтыг нэмэгдүүллээ.

Геополитикийн хурцадмал байдал болон гадаад орчны нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын төлбөрийн тэнцлийн алдагдал 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 1.4 тэрбум ам.долларт хүрсэн бол гадаад валютын албан нөөц 2021 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 1.4 тэрбум доллароор буурч, 2.9 тэрбум ам.доллар болоод байна аа. Түүнчлэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар энэ оны алдагдлыг 2 их наяд 387 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.1 хувиас хэтрэхгүй байхаар баталсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нэг их наяд 146 тэрбум төгрөг буюу ДНБ-ий хасах 2.4 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Төсөв ийнхүү алдагдалтай батлагдсанаар төсвийн орлого, зарлагын зөрүүг Засгийн газрын өр үүсгэж, санхүүжүүлэхээс санхүүжүүлэхээс өөр аргагүй байна аа. Энэ мэт мөчлөг сөрсөн санхүүжилтийн бодлогын арга хэмжээг дэмжиж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө. Энэхүү 100 сая ам. доллартой тэнцэх мөчлөг сөрсөн санхүүжилтийн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн

зээлийг авч ашиглахаар Азийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын банкттай зээлийн хэлэлцээрийг 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр хийсэн. Түүнчлэн зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах асуудлыг Улсын Их Хурлын Эдийн засаг, Төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжиж, зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгосны дагуу 2 тал 12 дугаар сарын 5-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулаад байна.

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас авч ашиглах 100 сая ам. долларын зээлийн хэлэлцээрийн зээлийн эх үүсвэр нь эхний 3 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, 7 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй бөгөөд баталгаатай овер найт санхүүжилтийн хүү болох сопер уг суурь хүү дээр 0.81 хувийн нэмэгдэлтэй болно оо. Энэхүү Азийн дэд бүтэц хөрөнгө оруулалтын банкны мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн Зээлийн хэлэлцээрийн хуулийн төслийг соёрхон баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдесламын Баделхан танилцуулна аа.

Индэрт урж байна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн өргөн мэдүүлсэн Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хооронд Зээлийн хэлэлцээр, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно оо.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, 70 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээр, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагч илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн.

Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Эдийн засгийн хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Батхишигийн Мөнх-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн дарга Батбаярын Даваа-Эрдэнэ, Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

Ц.Туваан: Энэ зээлийн хэлэлцээрийн асуудал орж ирж байна. Тэгээд энэ дээр Сангийн сайдаас бас тодорхой 2, 3 мэдээллийг бас нэмж хэлж өгөөч гэж ингэж хүсэж байна. Монгол Улсын өр ямар байгаа билээ? Дээрээс нь бас иргэдийн маань амьдрал, улс орны амьдрал бас хүнд хэцүү байгаа. Мэдээж зээл бол олон улсад хэрэглэгддэг ийм зах зээлийн хэрэглэгдэхүүн. Эдийн засаг нь хөгжсөн том улсууд ч гэсэн ДНБ-ээ давсан зээлүүдтэй л байдаг.

Тэгэхээр энэ дээр асуулт нь мөчлөг сөрсөн гэж байгаа. Энэ дотор чинь яг юу юу орж байгаа юм бэ? Энэ 100 сая долларын зээлийн зарцуулалт нь юунд зарцуулагдах вэ? Тэгээд ард түмний яг өнөөдрийн хүсэн хүлээгээд байгаа энэ юмны үнэ, өсөлт, инфляцын өсөлтөд ямар эерэг нөлөө үзүүлэх вэ гэсэн асуултууд асууя.

Г.Занданишатар: Болдын Жавхлан Сангийн сайд.

Б.Жавхлан: Туваан гишүүний асуултад хариулъя.

Бид нар яг эдийн засгийн хүнд нөхцөл байдал, ялангуяа төлбөрийн тэнцэл, төлбөрийн тэнцлийн алдагдлаас улбаатай Төв банкны валютын нөөцийн хомсдолын ийм богино хугацааны шоконд орсон ийм эдийн засаг маань ингээд явж байна. Яг ийм үед өндөр хүүтэй, богино хугацаатай арилжааны төсөл арга хэмжээ санхүүжүүлэх тийм зээл бид огт авахгүй гэдгийгээ дунд хугацааны стратегиараа Их Хурлаараа батлуулж аваад энэ хүрээндээ ажиллаад явж байгаа. Энэ зээл бол яг цэвэр мөчлөг сөрсөн буюу төсвийн дэмжлэг. Зарцуулалт нь мөчлөг сөрсөн гэдэг агуулга нь төлбөрийн тэнцэл дээр бидэнд валют нь юу юунаас хэрэгтэй байгаа юм?

Хэрвээ та бүхэн маань дэмжээд өнөөдөр ингээд соёрхон баталчихвал ер нь бид энэ ондоо багтаад гүйлгээгээ хийгээд авчихъя. Оны сүүлд гадаад валютын нөөц

дээрээ бас нэмэртэй байгаа учраас ингээж оруулж танилцуулж байгаа юм. Ингээд л ерөөсөө л зарцуулалт нь төгрөг нь төсөв дээр ороод ирнэ бид валютаа төв банкны валютын нөөц дээрээ аваачиж тушаах ийм л зарцуулалттай. Тэрнээс биш ямар нэгэн төсөл, арга хэмжээ, бондын эргэн төлөлт огтоос биш. Ийм юм байгаа юм. Тэгээд өнөөдөр нөгөө соёрхон батлах гэдэг маань хэд хэдэн бүх процессоор яваад урьд нь Их Хурлаар танилцуулагдаад, Байнгын хороодоор ороод өнөөдөр ингээд эцсийн соёрхон батлах шатандаа танилцуулж байна.

Баярлалаа.

Г.Занданшатар: Баагаагийн
Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банканд чинь манайх 2015 оноос эхлээд ингээд хамтарч ажиллаж байгаа. Урьд нь одоо миний ойлгож байгаагаар бол 100 сая доллар авсан. Ковид гээд. Дараа нь нэг 20 сая орчим ингээд 120 сая долларын зээл авчихсан ингээд явж байгаа. Энэ хэмжээгээр бол энэ мөнгө маань бол Төв банканд очсон. Монгол төгрөг болоод төсөв дээр ирээд ковидод зарцуулагдсан байх гэж ингээж ойлгож байна. Энэ сүүлийн үед янз бүрийн нэртэй энэ зээл маш их орж ирж байна л даа. Зарим нь харцуцсан шинэ, хуучин сайдын үед хийгдээд яачихсан. Шинэ сайд нь тэрийг нь хүлээн зөвшөөрөхгүй, Засгийн газар дотроо хоорондоо зөрчилтэй ийм юмнууд маш их орж ирж байгаа байхгүй юу. Энэ зээлдээ ер нь их болгоомжтой хандаач ээ. Зээл авах бол амархан.

Ялангуяа энэ Азийн хөгжлийн банк болно, эд нараас бол авахад бол нэг их тийм төвөгтэй биш юм шиг байгаа юм. Ав гэж шаардаад байгаа. Зарим нь ирээд шууд уулзаж байсан шүү дээ. Их Хурлын даргатай уулзаад шахаад та нар авахгүй бол дахиад санхүүжилт өгөхгүй гээд. Онож авахгүй л байгаад байна л даа. Өнөөдөр Монгол Улсад яг юу, ямар

салбарт зээл хэрэгтэй бүх юм нэг бизнесийн салбарт зээлэх хэрэгтэй. Энэ чинь нэг сопер дээр нэгхэн 0.8 гэхэд 4 орчим хувийн хүүтэй. Өнөөдөр бизнесийн салбарт 18 хувийн хүүтэй зээл ч олдохоо больчихлоо шүү дээ.

Төв банкны бодлогын хүү 13 хувь болчихсон, инфляц 14.5 хувь болчихсон. Ингээд ирэхээр зээл олгодог банк байхгүй. Тэгээд Төв банкны үнэт цаасаа худалдаж аваад л сууж байдаг л тийм л болчихсон байна шүү дээ. Энэ Монгол төгрөгийн хани гэдэг юм бол болохоо болилоо. Оны эхнээс хойш 21 хувиар уначхаад байна шүү дээ. Зөвхөн сүүлийн 7 хоногт л 5 нэгж, 5 төгрөгөөр, 7 хоногт л гэхэд 5 төгрөгөөр унаад байна шүү дээ.

Тэгээд бид нар ингээд зээл аваад өгөөд байдаг өгөөд байдаг, ер нь тэгээд цаашидаа яах юм бэ. Энэ ханины уналтыг. Монгол банкныхан нь алга байна. Тэгэхдээ энэ Сангийн сайдаас би бас асууя гэж бодож байгаа юм. Энэ ханитай холбоотой асуудал бол төсвийн бодлоготой бас холбоотой. Ер нь энэ ханшийн уналтыг цаашидаа яах вэ. Ингээд яваад байх уу? Энэ чинь энэ ард түмний бизнес эрхлэгчдийн бий болгосон энэ баялаг маань ингээд гоожиж байна шүү дээ. Үнэгүйдэж байна шүү дээ. Энийг ер нь яах юм бэ? Ер нь тэгээд төсөвт бол зээл, төсвийн дэмжлэг гэж гаднаас зээл авдаг бол байж болохгүй ээ. Ер нь цаашидаа бол. Өнөөдөр бол яах вэ дээ энэ бол энэ авч байгаа зээл маань 7 жилийн хугацаатай, тэгээд Төв банканд очоод валютын нөөц болоод Монгол төгрөг болоод төсөвтөө очоод ингээд явах л байх.

Цаашидаа бол юунд авах вэ? Эрчим хүчний салбартаа авмаар байна. Тэр хулгай нь нүүрлэчхээд байгаа 5 толгойд нь асар их хэмжээний эрчим хүчний нүүрс ингээд овоорчихсон байж байна шүү дээ. Үгүй ээ тэрэн дээрээ тэр цахилгаан станцаа барья л даа.

1 киловаттыг юу гэдэг юм 1 сая доллар гээд үзэх юм бол 1.5 сая гэх юм бол

нэг 700- 800 мянган доллароор тэр 500 мегаваттын эрчим хүчний станцыг бол барьчихмаар байгаа юм. Импортоор авч байгаа эрчим хүчнийхээ 70 хувийг Хятадаас, 20 хувийг нь Оросоос авч байна шүү дээ өнөөдөр. Тэгээд л энд нэг тийм янз бүрийн юм мөчлөг сөрсөн гээд л янз бүрийн нэртэй юм оруулж ирээд л ингээд. Энэ зээлийг яг бодит салбарт авмаар байна? Үр дүн гардаг салбарт. Энд хариулт өгөөч. Энэ ханшин дээр яах юм бэ? Энийг бас хэлж өгөөч ээ. Энэ төлбөрийн тэнцэл гэдэг юм бол ингээд ковид гээд л байгаа. Манайд бол энэ төлбөрийн тэнцлийн энэ алдагдал бол ковидоос гадна бол энэ хулгайтай холбоотой шүү. Мөнгө нь орж ирэхгүй байгаа шүү. Үр ашиггүй худалдаа хийж байгаа. Мөнгө нь орж ирэхгүй, оффтейк гэрээ гээд баахан юм хийчихсэн. Энэ тэрээсээ ер нь их хамаарал нь төлбөрийн тэнцлийг нь.

Г.Занданшатар: Болдын Жавхлан Сангийн сайдад хариулъя.

Б.Жавхлан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Ерөнхийдөө санал нийлж байна аа. Энэ өнөөдрийн бид нарын тулгамдаад байгаа энэ төлбөрийн тэнцлийн алдагдал, энэ макро тэнцвэрээ бид нар алдсан байдал бол олон жил үргэлжилж явж ирсэн. Ковид гээд дараа нь энэ дайн тулаан гээд бид ийм дараалсан 2 том шок дээр маш том сорилт дунд явж байна аа. Эндээс бид маш богино хугацаанд амжилттай гаргах хэрэгтэй байгаа юм. Засгийн газар талаасаа оролцож бид нарын хийж чадах зүйл нь бол төлбөрийн тэнцэл юм байгаа юм. Саяын таны асууж байгаа үнийн өсөлт бол дэлхий нийтээрээ тулгамдаж байгаа маш том ийм глобал асуудал болчихоод байгаа юм. Ялангуяа манайх шиг хэрэглээнийхээ 70 хувийг импортоор авдаг улс орнуудад энэ жижиг эдийн засагтай улс орнуудад маш хүнд тусаж байгаа юм. Өөрөөр хэлбэл гадна талдаа үнэ нь өсчихсөн тэр инфляцыг бид нар 70 хувь дээрээ импортлож авчраад байгаа юм. Энэ тохиолдолд төв банк

бодлогын хүүгээ өсгөөд мөнгөний бодлогоо чангаруулаад чаддаг арга хэмжээгээ зайлуул аваад л явж байна бидний зүгээс яг энэ төлбөрийн тэнцэл, энэ сувгаар гадаад худалдаа энэ валютын нөөцийг нь богино хугацаанд нэмэгдүүлэх ямар л арга хэмжээнд байна бүгдийг нь авахаас өөр арга байхгүй. Гэхдээ одоо бизнесийн орчныг дэмжинэ гээд бид богино хугацаатай, нөгөө айхтар өндөр хүүтэй төлбөр нь 1 жил нэг дор хийгддэг бондын зах зээл дээрээс бид нар мөнгө босгохгүй ээ. Энийгээ бол Их Хурлаар стратегиар бидэнд маш хатуу үүрэг өгсөн. Энэнийхээ хүрээнд явна. Харин урт хугацаатай, олон талт, энэ хөгжлийн түнш институтүүдээс бол харилцан тусламж авдаг, тэгээд гишүүн орны хувьд яг иймэрхүү зээлүүд нь яг энэ үед бидэнд маш чухал байгаа юм. Энийг бол та ойлгож дэмжинэ байх гэж би итгэж байна.

Тэгэхээр валютын нөөц нэмэгдэх тусмаа манай макро тэнцвэрийн энэ алдагдал багасаж ирнэ. Өөрөөр хэлбэл ханшийн савлагаа багасна. Ханшийн савлагаагаар одоо валютын ханшийн савлагаагаар дамжиж ирдэг үнийн өсөлтийн нөлөөлөл нь тэр хэмжээгээр буурна гэсэн үг. Тэгээд сайн мэдээнүүд бас байна аа. Сайн мэдээнүүд байна. Оны эцсээр бас төлбөрийн тэнцэл одоо алдагдал бидний төсөөлж байснаас харьцангуй бага гарах төлөвтэй байна. Төлбөрийн алдагдал ч гэсэндээ бид нарын төлөвлөж байснаар хуульчилснаас харьцангуй бага гарахаар байна. Төв банкны валютын нөөц тодорхой хэмжээнд нэмэгдэж гарахаар байна 1 сард урд хөрш маань хилээ нээнэ. Зорчих хөдөлгөөнөө нээнэ. Бүр Гашиун сухайт дээр одоо урдаас ковидын тест авахгүйгээр тээврээ үргэлжлүүлэхээр ийм хүртэл шийдвэрүүд гарсан байгаа нь ирэх онд манай гадаад худалдаа экспорт дээр эерэг нөлөө үзүүлж, бид богино хугацаанд төлбөрийн тэнцлээ сайжруулж, валютын нөөцөө нэмэгдүүлж богино хугацааны энэ шокноосоо гарах бид энд бас ийм боломж ирж байна гэж ингэж харж байгаа.

Баярлалаа.

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүн 1 минут тодруулж асууя.

Б.Баттөмөр: Ингээд Жавхлан сайдад баярлалаа.

Бас зөв хариулт байна. Санал нийлж байна аа. Энэ урд хөрш ингээд хэлээ нээх гэж байна аа. Энэ бол зүйтэй. Манай эдийн засагт бол чухал нөлөөтэй ийм арга хэмжээ болно гэж ойлгож байгаа. Тэгэхдээ яг хэлэгдсэний дараагаар манай Монгол Улсын эдийн засагт ямар эрсдэлүүд гарч болох вэ гэж. Зүгээр миний харж байгаагаар бол энэ Монгол төгрөгийн уналт улам нэмэгдэнэ. Валютын эрэлт нэмэгдэнэ. Валютын эрэлт нэмэгдэнэ гэдэг маань төгрөгийн ханиш унана гэсэн үг. Энэ дээр манай Сангийн яам, Монгол банк сая яам ер нь ямар бодолтой байна?

Хоёрдугаарт нь тэр эрчим хүчний төсөл гээд би сая ярьсан. Нүүрстэй мөртөө гаднаас эрчим хүч аваад байдаг ийм байж болохгүй л дээ. Бензинтэй мөртөө гаднаас бензин авдаг, алт баялагтай мөртөө гаднаас зээл авдаг. Энэ эрчим хүчний төслүүд дээр бол гаднын зээлийг.

Г.Занданишатар: Болдын Жавхлан сайд хариулна.

Б.Жавхлан: Эрчим хүч бол бидний шинэ сэргэлтийн бодлогын нэг тулгуур гол сэргэлтийн бодлого байгаа. Өнгөрсөн оны Улсын Их Хурлын 106 дугаар тогтоолоор бид эрчим хүчний багтаагаад бүтээн байгуулалтуудыг бүгдийг нь батлуулж авсан байгаа. Энэ дээр бол их сайн жагсаалт батлагдсан гэж ингэж бид харж байгаа юм. Ингээд эрчим хүчин дээр бол бид нар 2 чиглэлээр хөрөнгө оруулалтууд яригдаж байгаа. Эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний дамжуулах дэд бүтцүүд гээд. Одоо яг энэ жил бидний батлагдсан хэд хэдэн төслүүд

байгаа. Баруун аймагт болон Өмнийн говийн баригдах эрчим хүчний төслүүдээс төвийн шугамтай холбогдох, мөн эргээд төвийн шугамаас Өмнийн говийн болон замд нь дайран өнгөрөх аймгууд дээрх өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хангалтыг дэмжих, дамжуулах дэд станцууд дээр тэр тоонууд дээр ажлын хэсгээс хэлээдхээрэй.

Дэлхийн банкнаас бид хэд хэдэн төслүүд авч дамжуулах дэд станцуудаа ирдэг ээ.

Г.Занданишатар: Хэн хариулах юм? 85 ажлын хэсэг.

Б.Сүх-Очир: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжиж байгаа төслүүд болон ер нь шинээр хэрэгжих төслүүдийг бол ер нь шинэ сэргэлтийн бодлого руу чиглүүлж байгаа. Үүний хүрээнд эрчим хүчний салбарт бол одоогоор Эрдэнэбүрэнгийн УЦС болон тэрийг Хятадын зээлээр хэрэгжинэ. Тэрнээс Эрдэнэбүрэнгийн Мянгад Улайстайн цахилгаан дамжуулах дэд станцын төсөл бол Азийн хөгжлийн банктэй бид нар ярьж байгаа. 10 аймгийн төвийн дулааны станцыг барих төслийн хүрээнд бол бас яригдаад явж байна.

Чойр, Сайнишандын 230 километрийн агаарын шугам барих дэд бүтцийг бол бид нар зээлийн хэлэлцээрийг байгуулаад явж байна аа. Ер нь бол төслүүд бол урагштай явж байгаа.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, үг гэж дууслаа.

Байнгын хорооны саналаар төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зааснаар нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг

эцэслэн батлах бөгөөд нийт гишүүдийн олонх дэмжсэн бол эцэслэн батлагдана гэж заасан. Өөрөөр хэлбэл Байнгын хорооны саналаар хуулийн төслийг эцэслэн батлахын тулд.

Энэ ингээд жилийн эцсийн гүйлгээ учраас энэ хуулийн төсөл батлагдах юм бол өнөөдрийн байдлаар бол валютын нөөц нэг 3.2 тэрбум долларт хүрч байна. Энүүгээр нэмэгдэхэд бол нэг 3.4 тэрбум долларт оны эцсийн балансаар валютын нөөц бол өсөж гарах төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлт 11 сарын байдлаар 3.7 байсан бол эцсийн оны эцсийн байдлаар 4.4 хувьд хүрэх тооцоололтой байна. Ер нь бол сүүлийн 3, 4 сард нүүрсний экспорт бол 3, 4 дахин нэмэгдсэн. 30 сая тонныг давж байна. Энэ жил 6 сарын тэндэнцээрээ хандлагаараа бол нэг 14 сая тонн гарах уу, яах вэ гэж байсан бол 30 сая гаруй тонн оны эцсийн байдлаар экспортлох төлөвтэй байна. Нөөцийн байдал нэмэгдэх нь байна. Инфляц бол бусад улсуудын инфляц буурч байгаа хилийн хориг саадууд буурч байгаа тээвэр ложистикийн хүндрэлүүд шийдэгдэж байгаатай холбогдоод оны эхний инфляц бол 2 оронтой тоонд орох хүлээлт байна. Хил, гааль нээгдэж байгаа ковидын хязгаарлалтууд суларч байгаа нөхцөл байдлууд бол эдийн засагт эерэг нөлөө өгөх түүхий эдийн үнэд бас эергээр нөлөөлөх, ийм төлөв байдал бол бас нааштай төлөв байдлууд гарч байгаа. Тэгээд энэ үед бас энэ хэдийгээр богино хугацаанд төсвийн мөчлөг сорьсон зээл боловч ер нь богино хугацааны энэ валютын нөөцөө нэмэгдүүлэх ханиид эергээр нөлөөлөх, тэгээд цаашилаад урт хугацаандаа энэ экспортоо дэмжих цогц шийдэл бодлогуудыг хэрэгжүүлж байж энэ төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга маань төлбөрийн тэнцэл бол барааны урсгал данс эерэг болгоход, нэн ялангуяа зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай биш, малын гаралтай түүхий эд, хөдөө аж ахуйн гаралтай төв гэдэг тэр экспортыг нэмэгдүүлэх энэ

боломжийг бий болгох бол хамгийн чухал зорилт байх ёстой.

Ирэх онд Оюу толгойн далд уурхай ашиглалтад орно. Ингээд бүрэн хүчин чадалтай 2, 3 жил болох ч гэсэн энэ бол манай валютын экспортыг нэмэгдүүлэх нэлээн том нааштай үр дүн гарна. Тэгэхээр дунд хугацаанд бол манайх эдийн засгийн төлөв байдал бол сайжрах, энэ хэмжээгээр иргэдийн амьжиргаанд эергээр нөлөөлөх ийм бодит боломжууд бий. Энийгээ л бүрэн дүүрэн ашигладаг, тийм хулгай зэлгийгүй, авлигагүй, ил тод, шударга тийм эдийн засаг, нийгмийн тогтолцоог бүрдүүлэх асуудал бол бидний энэ ирэх жилийн эхний хамгийн том зорилтууд байх болно.

Нэг оронтой тоонд тийм инфляц ирэх оны хагас жилдээ нэг оронтой тоонд багтах, 14.5 хувьтай байгаа бол 10-аас доош хувьд буюу нэг оронтой тоонд инфляц болж орж зорилтот түвшинрүү дөхөх тийм бодит боломжууд байна.

Эцэслэн батлах санал хураалт биш энэ Байнгын хорооны саналаар ер нь хуулийн төслийг батлах санал хураалт явуулъя.

Дараа нь тэгээд эцэслэн батлах санал хураалтыг жич явуулна.

Байнгын хорооны саналаар зээлийн хэлэлцээрийг батлах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Бусад гишүүд орж ирье.

Б.Бат-Эрдэнэ: Горимын санал гаргая. Миний энэ санал өгсөн сая ажилласангүй.

Тийм учраас хүчингүй болгох санал хураалгаж өгөөч.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Энэ сайд нар яасан бэ

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Олонхын саналаар Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний гаргасан санал дэмжигдэж, саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Саяны санал хураалт хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулна. Зэрэгцэж яагаад Түр хороо хуралдуулаад байгаа юм.

Санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалт явуулъя. Гишүүдийн олонх дэмжсэн байна. Зарчмын хувьд хуулийн төсөл дэмжигдлээ. Ингээд хууль эцэслэн батлах шатыг дараа явуулна аа.

Дараагийн асуудалд оръё. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Телуханы Аубакир гишүүн танилцуулах уу? Бат-Эрдэнэ гишүүн яав.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Телуханы Аубакир гишүүн танилцуулна аа.

Т.Аубакир: *Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг баталсантай холбогдуулан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд экспортод гаргах нүүрсийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-аар цахим системээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, экспортод гаргах нүүрсний нээлттэй, цахим арилжаатай холбогдох харилцааг зохицуулсан журмыг баталж мөрдүүлэх, биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг баталж, шаардлагатай дэд бүтцийг бий болгох, биржийн үйл ажиллагааг цахимжуулах, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судлах, холбогдох арга хэмжээ авч авах зэрэг зохицуулалтыг тогтоолын төсөлд тусгалаа.

Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай болон Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэх, компанийн сайн засаглал, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээх зорилгоор Эрдэнэс Тавантолгой ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг эргэлтэд оруулах, Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй ХК болгох хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох

арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан.

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн тус Байнгын хороо санаачлан боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням тогтоолын төслийн 5 дахь дэд заалтад Эрдэнэс Тавантолгой ХК гэсний дараа 2023 оны 2 дугаар улиралд багтаан гэж нэмэх, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг тогтоолын төслийн 5 дахь дэд заалтад эзэмшиж байгаа 1072 хувьцааны ногдол ашгийг иргэдэд олгох, эсвэл Зүүнбаян төмөр зам болон Тавантолгой-Гашиун сухайт төмөр зам ХХК-г иргэдийн ногдол ашгаар хөрөнгө оруулсан хэмжээгээр хувьцаа эзэмшүүлэх гэж нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг тогтоолын төсөлд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТҮЗ-ийн гишүүдийг 2023 оны нийтийн сонсгол явуулж, сонгон шалгаруулалтаар томилох, компанийн цэвэр ашгийн 10-аас доошгүй хувийг жил бүр ногдол ашгаар хуваарилах гэж нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Эрдэнэс Тавантолгой ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцааг 34 хувиас доошгүй болгож нэмэгдүүлэх гэж нэмэх зарчмын зөрүүтэй саналуудыг гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт,

зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Туваан гишүүнээр тасаллаа.

Ер нь байна шүү дээ зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Тэгээд 4 саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөөд тэр 2 дахь заалт дээр хэл ам маргаан байгаа учраас 2 дахь заалтыг би Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Даваасүрэн, Ганбаатар гишүүн нар ажиллаад, ингээд 2 дахь заалтаа Засгийн газарт чиглэл өгөөд оруулж ирж танилцуулахыг чиглэл болгоод менежмент удирдлагыг нь сайжруулах тэр юмнуудаа хийгээд ингээд 2 дахь заалтаа маргаантай байгаа юмнуудаа буруу зөрүү ойлголт өгөхгүйн тулд гүйцээн боловсруулах чиглэл өгье гэсэн ийм зарчмын тохиролцоонд ажлын хэсэгтэй ярилцсан тийм ээ, Бат-Эрдэнэ гишүүнээ. Тэгээд явчихвал яасан юм бол гэж байгаа уул нь.

Хоёр дахь заалтаа боловсруулж байна. Энэ 4 заалт нь бол 4-үүлээ 2 дахь заалттай холбоотой учраас. Тэгэхээр бол бид нар энэ 4 санал бүгдээрээ л үндсэндээ 2, 3 дугаар бүлэгтэй холбоотой төсөл. Тэгээд эднүүсээ бүгдийг нь ахиж ер нь тогтоолоо гүйцээн боловсруулаад л ингээд л орж ир.

Гүйцээн боловсруулах гэсэн үг. Буцааж авах биш. Ажлын хэсгийн ахлагч дарга Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооноос хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай гээд санал орж ирж байгаа. С.Ганбаатар гишүүн, Даваасүрэн гишүүд бас саналууд хэлээд байгаа юм. Тэгээд бид уг нь бол нэг санал дээр тогтоод байгаа юм байхгүй юу даа.

Жишээ нь Ганбод энэ Даваасүрэн гишүүн өнөөдөр хэллээ шүү дээ. Эрдэнэс Тавантолгой компаниас ногдол ашиг иргэд ногдол ашиг хүртээх ёстой байсан, энэ мөнгийг төмөр зам руу оруулчихсан. Тэгэхээр энэ төмөр зам руу орчихсон мөнгийг буцаагаад иргэдэд нь өгөх арга хэмжээг аваач л гээд байгаа байхгүй юу.

Гэтэл бид нарын оруулж ирсэн зүйл дотор чинь бол жишээ нь сая орж ирж байгаа зүйлд бол төмөр замтай холбоотой төмөр замд оруулсан мөнгийг иргэдэд тодорхой хэмжээгээр ногдол ашиг өгье. Нийт орсон доо Эрдэнэс Тавантолгойн компанийн нийт ашгийн 10-аас доошгүй хувийг жил болгон ноогдол ашиг болгон энэ 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэддээ олгоё.

Дээрээс нь 2012 оны 4 сараас хойш төрсөн иргэддээ энэ чинь бараг сая орчим иргэн байгаа байхгүй юу. Шинээр төрсөн, тэгэхээр эдэндээ бас ноогдол ашиг нэмэгдэл болгож өгье. Ийм л зүйлүүд байгаа шүү дээ. Ер нь бол Даваасүрэн гишүүн хэлээд байх шиг байгаа юм. Энэ хөрөнгийн биржид бүртгэлтэй шүү дээ гээд. Үгүй байхгүй юу даа, бүртгэлгүй.

Тэгэхээр энэ чинь Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болгоод эргэлтэд оруулаад 1072 чинь эргэлтэд ороод ард иргэддээ ногдол ашгаа олгоод, ингээд бүх зүйлүүдийг нээлттэй болгоё гэсэн ийм зүйлийг л бид нар Монгол Улсын Засгийн газар буюу Л.Оюун-Эрдэнэ сайдад бас чиглэл болгож байж өгч байгаа байхгүй юу даа.

Энэтэй холбоотой асуудлуудыг энд тусгаад, ер нь бол буцаад Оюун-Эрдэнэ сайд бол оруулж ирж Улсын Их Хуралд танилцуулж байгаад тодорхой шийдвэрүүдийг гаргах ёстой.

Тэгэхээр бид бол энэ дээр эмзэглээд байх юм байхгүй. Тодорхой асуудлууд нь бол буцаж орж ирээд бид нар танилцуулагдаад алдаа оноогоо бол бас

засаад залаад явах нь ийм нээлттэй юм байгаа байхгүй юу даа.

Хамгийн гол нь Уул уурхайн биржийн тухай хуулиа дагалдуулаад энэ ард иргэд рүүгээ очсон, байгалийн баялгаа бол хүртэх ийм боломж бололцоог нь нээсэн Улсын Их Хурлын тогтоол гарч байгаа юм шүү дээ. Энэ бол бидний хувьд бол бас ард иргэд рүү гаргаж байгаа нэг том Улсын Их Хурлын гишүүдээс гаргаж байгаа том ололт гэж л харах гээд байгаа юм л даа.

Тэгэхээр Их Хурлын даргын өгсөн зөвлөмжийн дагуу Байнгын хороон дээр буцаж эргээд яах вэ бид нар томьёоллуудаа дахиад нэг зүгээр харчихъя. Утга агуулга бол нэг юм шүү. Утга агуулга бол Ганбаатар гишүүний ярьж байгаа асуудал, нэг. Даваасүрэн гишүүний ярьж байгаа асуудалд бид нарын орж ирж байгаа асуудал бол нэг юм байгаа шүү. Түрүүн Даваасүрэн гишүүн хэлсэн шүү дээ Байнгын хорооны гишүүд маань зөв зүйтэй саналууд оруулж ирлээ гээд тэгсэн. Энэ дээр бол яг л бид нарын ярьж байгаа зүйлүүд чинь ороод ирчихсэн та байхгүй юу?

Тэгэхээр даргын хэлдгээр Байнгын хорооныхоо анхны хэлэлцүүлэг рүү ороод тэгээд үг өгүүлбэр, юмнууд дээрээ бас жаахан буцаж эргэж харахад бол болохгүй зүйл байхгүй гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданишатар: Анхны хэлэлцүүлэгт буцаавал олонхын саналаар санал хурааж шийдвэрлэнэ. Гүйцээн боловсруулах чиглэл өгвөл эцсийн хэлэлцүүлэг дээрээ энгийн олонхын саналаар шийдээд л оруулаад ирнэ. Анхны хэлэлцүүлэг алга болохгүй л дээ. Үг үсгээ нээгээж орж ирэхгүй болохоор чинь наадах чинь нэг буруу ойлголт төрөөд байна. Найруулах л юм байна.

Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр яах аргагүй энэ Уул уурхайн биржийн тухай хууль батлагдаж гараад энэ уул уурхайн салбарыг тойрсон энэ үнийн асуудал, түүнтэй холбоотой энэ олон бүрхэг асуудлуудыг тодорхой болгоход нэлээн том хувь нэмэр оруулна. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулж энэ тогтоолын төсөл боловсрогдож орж ирж байна. Нийгмийн шаардлага ч байна үнэхээрийн энэ заяагдмал баялаг буюу энэ байгалийн баялгууд дээр тулгуурлагдсан, үнэ цэнтэй энэ аж ахуйн байгууллагуудаа сайн засаглалтай болгох, олон нийтийн оролцоотой болгох, хяналттай болгох энэ бүхий л үйл ажиллагааг бид зөв зохицуулалт хийх зайлиггүй шаардлага байгаад байгаа юм аа.

Тийм учраас энэ тогтоолоор энэ ил тод, нээлттэй байлгах, хариуцлагатай болгох, үр өгөөжийг дээшлүүлэх, хүртэх ёстой тэр Монголын ард түмэнд өгөөжийг нь хүртээх нөхцөлийг хангасан эрх зүйн орчин бүрдүүлэхтэй холбоотой олон заалтуудыг энүүнд тусгасан байгаа юм. Тэгэхдээ энүүгээр бүх юм шийдэгдэхгүй нь ойлгомжтой. Энэ тогтоолоор тодорхой судалгаа, бэлтгэлүүд хангагдаж, эргэж Улсын Их Хуралд танилцагдаж, зарим шийдвэрт тусгагдаж орох ёстой гэж ингэж л хараад байна л даа би бол.

Тийм учраас тэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тухай хууль гээд энэ хуулиудаар ер нь энд явж байгаа санаануудын суурь харилцаанууд зохицуулагдаж, схем их зөв болох ёстой л гэж ингэж хараад байгаа юм. Тэгээд энэ талаасаа бол бодох ёстой. Одоо энэ орж ирчхээд байгаа тогтоолын төслийн 5 дахь заалт дээр тэр 1072 хувьцааг үе шаттай эргэлтэд оруулах гэдгийг 1072 хувьцааны үр өгөөжийг нэмэгдүүлэх гэдэг үгээр солиод л, тэгээд тэр төгсгөл хэр дээр нь судалж шийдвэрлэх гэдгийг судалж, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд

танилцуулах гээд ингээд л оруулчих юм бол яригдаж байгаа бүхий л асуудлууд нэлээн нарийсгасан ийм судалгаа, дүгнэлт, тооцоололтой Их Хурал руу ирээд танилцагдчих юм байна. Тэрнийх нь хүрээнд бид асуудлаа яриад холбогдох чиглэлүүдээ өгчих ийм бололцоо, боломж нь бүрдэх юм байна л гэж ингэж л харагдаж байна л даа.

Тийм учраас би түрүүн энэ тогтоолын төслийг хойшлуулах асуудал яригдахаар нь зэрэг дэмжээгүй юм. Яагаад дэмжээгүй вэ гэхээр дэмжихгүй, орхичихоор зэрэг олон олон шаардлагатай заалтууд цаг хугацаа хойшилчих гээд байгаа учраас дэмжээгүй юм. Хэлэлцэж байгаад харин тухайлсан тэр онож болохгүй байгаад байгаа үгнүүдийг нь онодог үгээр нь сайжруулж аваад ингээд энэ тогтоолыг дэмжээд гаргачих нь зөв л гэж л ингэж л бодоод байна л даа. Ингэж байж бид нар энэ байж байгаа байдал, нөхцөлөө арилгах, тэгээд энэ хулгай зэлгийн элдэв бус юмнаасаа холдох, тэгээд энэ байгалийн баялгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хүртэх ёстой тэр иргэд олон түмэнд хүртдэг, боломж бололцоог нь бүрдүүлж өгөхөд ихээхэн нааштай зүйл болсон л гэж л ингэж л хараад байна даа.

Тэрнээс хий хоосон 2 тал руугаа саваад хэрэггүй л дээ. Нэг хэсэг нь юм сайжруулах гээд ч байгаа юм шиг, нэг хэсэг нь тэрийг бас давхар хардалт өгөөд зогсоох гээд ч байгаа юм шиг ингээд баймгүй байна. Аль болохоор ярилцаад хамгийн зөв, тэгээд энэ цаг үедээ тохирсон тийм зөв шийдлээ гаргаж авах тухай л асуудал бидэнд байгаа л гэж ингэж харж байна.

Тийм учраас би тогтоолын төслийг дэмжье ээ.

Ингэж энэ үгнүүдийг өөрчлөөд найруулчих бололцоо боломж байна уу гэдгийг асууж байна аа?

Г.Занданшатар: Бололцоо боломж байна уу? Тэгэхгүй бол заавал

анхны хэлэлцүүлэгт буцааж энэ Пүрэвдорж гишүүнтэй яахаар биш гүйцээн боловсруулах чиглэлийг өгөөд тэр эзэмшүүлсэн 1072 хувьцааг үе шаттай эргэлтэд оруулах гэдэг чинь эзэмшүүлсэн юмыг авах гээд байна гэж нийгэмд ойлгогдоод, ойлгуулаад яриад байна шүү дээ. Тэрнийгээ л үр өгөөжтэй болгоно гэдгийг өөрчлөх гүйцээн боловсруулах чиглэлийг бол ингээд явчихвал эцсийн хэлэлцүүлэгтээ бэлдээд л орж ирээд тэртээ тэргүй шилжүүлээд орох юм чинь. Тэр хамгийн л зөв чиглэлээ.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа юм. Ер нь бол бид нарын буцаад тодорхой асуудлыг шийдвэрлэх гээд, тэгээд тэрнийхээ ар дээр танилцуулга эргэн танилцуулах гэдэг үгийг нэмчихээд л улам бүр итгэл үнэмшилээр хардлагагүй л болчих юм л даа. Тэгвэл тийм үг үүсгээд ганц үг оруулчихъя.

Хоёрдугаарт даргын хэлдэгчлэн тэр эргэлтэд оруулах гэдэг үгээ бүр, эсвэл заалт болж байгаад бүр тодруулсан ч болж байна.

Ер нь бол яах вэ зүгээр арай л дэндүү зүгээр эргэлтэд оруулах гэдэг бид нар хуулийнх нь тэр үг үсэг юмнуудыг урд талынх нь тогтоол шийдвэрүүдийг харж байж тэр үг үсгийг оруулсан юм л даа. Тэгээд энэний цаана юу гэж ойлгох вэ гээд энэ биржийнхэнтэй хамт ярьсан. Асуудлуудыг нь ярьсан. Тэгж байж ийм үсэг байх юм гэсэн. Хэрвээ тэрийг шаардлагатай бол даргын хэлсэнчлэн дахиад боловсруулаад арай ондоо үг үсгээр ингээд орлуулаад тэгээд ороод ирэхэд бололцоотой гэж хэлээд байна. Баярлалаа.

Өгөөжийг нэмэгдүүлэх болно, өгөөжийг нэмэгдүүлэх.

Хоёрдугаарт энэ чинь ер нь бол нээлттэй компани болгох гээд байгаа шүү

дээ. Нээлттэй компани болгоно гэхээр манайх нөгөө төрийн өмчийнхөө хэдэн хувийг л зарчих юм шиг л юм бодоод байгаа үгүй байхгүй юу даа. Нээлттэй компани болно гэдгээрээ энэ чинь яг биржид ном ёсоороо үйл ажиллагаа явуулах бололцоо нь нээгдэх юм. Одоо бол хаалттай компани байгаад байгаа шүү дээ. Хаалттай компани байгаад байгаа юм.

Хоёрдугаарт, 1072 хувьцааг эзэмших, иргэд хяналт тавих боломж бололцоо чинь бүр хуулийнхаа дагуу тэр системийнхээ дагуу ороод ирэх байхгүй юу. 1072 хувьцаа эзэмшигч Монгол иргэд энэ компанийн менежмент дээр хяналт тавих боломж нь бол нээгдээд ороод ирэх юм. Тийм бирж дээр гарч байж.

Баярлалаа. Тэгж үг үсгээ нь засаж болно.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн. Үг тасалсан.

С.Чинзориг: Тэгэхээр энэ хууль батлагдсантай холбоотой авах арга хэмжээн дэх Их Хурлын тогтоол байгаа юм уу? Энэ 1072 хувьцаатай холбоотой асуудалд бас анхнаас нь би 2010 оноос оролцоод бас нэлээн Засгийн газрын шийдвэр гарахад нэлээн оролцож байсан. Нэлээн бас ойлголт, мэдээлэлтэй л дээ. Энэ иргэд, гишүүд юун дээр болгоомжлоод байна вэ гэхлээр 2 юм байгаад байх шиг байгаа юм. Тэрийг нь яах вэ нэгийг нь ажлын хэсэгт авчихсан юм байна.

Тавантолгойг нээлттэй компани болгох гэхлээр эдийн засаг амаргүй, иргэдийн 30 хувь нь ядуу, орлого муутай байгаа ийм цагт, тэгээд нэг орлоготой цөөхөн хэсэг нь л энэ хувьцааг чинь аваад ингээд цөөн хэсэгт л энэ орлого хуримтлагдчихна шүү дээ гэж гишүүд яриад байгаа юм. Би энийг бас нэг буруу ч гэж үзэхгүй л байгаа юм. Тэгэхдээ энийг нь бол авчихсан юм байна. Уг нь болдог бол энэ 1072 хувьцааг эргэлтэд оруулах, амь оруулах асуудал их чухал байгаа юм. Энэ чинь эдийн засгийн эргэлтэд орохгүй, амь

орохгүй байгаа учраас бол бид нар иргэд ногдол ашиг авч чадахгүй байна. Ноогдол ашгаа авч байж чадахгүй байна.

Хоёрдугаарт, энэ компанийнхаа үйл ажиллагаанд хяналт тавьж чадахгүй байна. Удирдлага зохион байгуулалтад нь орж чадахгүй байгаа юм. Гэхдээ бас нөгөө талдаа манайхны энэ нөгөө үнэт цаасны зах зээлийн үнэт цаастай холбоотой асуудлаар нэлээн ойлголт их багатай байгаа учраас нөгөө 1990 оных шиг ягаан, цэнхэр тасалбар шигээ эдийн засгийн эргэлтэд 1072 хувьцааг оруулчихаар бас зарж үрээд юухан хээхнээр зараад хямдхан зараад ингээд цөөхөн хэсэгт буцаад энэ 1072 хувьцаа чинь хуримтлагдчихсан биш биз дээ? Одоо цаг үе нь мөн үү, биш үү гэж эргэлзээд байгаа юм байна гэж би бол ойлгож байгаа юм.

Тийм учраас бол гишүүдийн яриад байгаа тэр үр өгөөжийг нь дээшлүүлэх иргэддээ ядаж хаалттай компани байгаа ч гэсэн тэр иргэддээ ногдол ашгийг нь жил тутам олгодог байх ийм чиглэлээр уг нь бид нарын тогтоол заалт бол оруулчихмаар байгаа юм.

2 асуулт бол байгаа юм. Одоо ингээд 2012 оны 4 сарын 1-нээс хойш төрсөн хүүхдүүд гэхлээр хэчнээн хүнд энэ ногдол ашгийг чинь эзэмшвэл болж байгаа юм 1072. Хэчнээн хүнд, хэдэн хүнд, хэчнээн мянган хүнд эзэмшүүлэх юм бол үндсэндээ иргэд чинь Тавантолгой хувьцааны 1072 хувьцаа эзэмшээд компанийн бараг нэг 18.5 хувийг л эзэмшиж байгаа гээд байгаа юм. Тэгээд энэ 2012 оны 4 сарын 11-нээс хойш төрсөн иргэдэд хүүхдүүдэд хувьцаа олгохоор энэ компанийн чинь хэдэн хувь нь энэ иргэдэд бол очих гээд байгаа юм бэ гэж.

Хоёр дахь асуудал хаалттай компани гээд үнэлгээ дахин хийгээгүй байгаа юм. Уг нь бол дахиж үнэлгээ хийгээд анх 2011 онд энэ иргэдэд 1072 хувьцаа эзэмшүүлэхэд чинь нэгж хувьцааны үнэ 933 төгрөг гэж байсан санагдаад байна. Тэгээд дахин үнэлгээ

хийх хэрэгтэй. Дахин үнэлгээгээр энэ 1072 хувьцааны чинь нэгж хувьцааны үнэ нь хэдэн төгрөг болж байгаа юм бэ гэдгийг бас нэлээн тодорхой болгомоор байгаа юм.

Хоёр дахь асуудал нь энэ 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдэд дээр нь ноогдол ашиг өгөх юм уу, өгөхгүй юм уу? Бид нарт чинь 1 сая 500 мянгыг өгсөн, 300000-ыг өгсөн. Тэгээд өөр юм өгөөгүй. Хэзээ ер нь энэ иргэддээ хэдийгээр хаалттай компани ч гэсэн энэ ноогдол ашгийг нь өгөх юм бэ? Ноогдол ашгийг нь жил болгон өгдөг болгомоор байна.

Гурав дугаар асуудал. Энэ иргэдийн чинь эзэмшиж байгаа ногдол 1072 хувьцааны ноогдол ашгаар бид нар энэ бүтээн байгуулалтын ажил хийнэ гээд 2 төмөр замд хөрөнгө оруулчихсан шүү дээ. Эсвэл ногдол ашгийг нь өг, хэрвээ ногдол ашгийг нь бэлэн өгч чадахгүй гэж байгаа бол тэр Тавантолгой Гашуун сухайт, Тавантолгой Зүүнбаян төмөр замд энэ иргэдийн 1072 хувьцааны ногдол ашгаар хөрөнгө оруулсан учраас энд нь оногдох тэр 2 төмөр замын хувьцааг нь эзэмшүүлэх асуудлыг бид бас шийдмээр байгаа юм. Ийм боломж байна уу, үгүй юу? Өмнө нь тэр 2 төмөр замын чинь нэг 16 орчим хувийг нь.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Байнгын хороон дарга хариулъя.

Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Чинзориг гишүүний эхний асуултад хариулчихъя.

Дараагийн асуултуудыг нь ажлын хэсгээс хариулаарай. Эхнийх нь тэр 2012 оны 4 сарын 11-нээс хойш төрсөн бол сая гаран хүүхэд болчихоод байгаа тийм ээ. Тоо сая ямар ч байсан сая гаран байгаа юм. Тэгэхээр энэ хүүхдүүддээ бид нар хувьцаа олгоход бид нар нэг зарчим барих ёстой. Энэ бол шинээр хувьцаа гаргаж, одоо энэ хувьцаа эзэмшиж байгаа иргэдийнхээ хувьцааг үнэгүйдүүлж, шингэрүүлж

болохгүй ээ. Тийм учраас бол энэ хүүхдүүддээ хувьцаа олгохдоо өнөөдөр төр эзэмшиж байгаа хувьцаанаас нь шилжүүлж өгөх ёстой. Энэ дээр бол тийм зарчимтай байна. Энэ бас ийм ард нь байгаа агуулгыг нь энүүгээр ойлгож явах ёстой.

Дээрээс нь нэг нэмээд саяын Чинзориг гишүүний асуулгатай шууд холбоотой биш, ер нь энэ өнөөдөр энэ асуудал яригдаад, ингэхээр энийг энэ тогтоолын төсөл ярихаар зэрэг нэг хувьчлах гэж байгаа, төрийн өмчтэй үлдсэн ганц нэг компанийг хувьчлах гэж байгаа юм шиг юм ойлгоод байх юм аа. Энэ хувьчлах гэж байгаа гэдэг нэг ийм ойлголтоо бид нар хувьчлах гэж байгаа юм уу, огт хувьчлагдаагүй компанийн тухай яриад байгаа юм уу? Хувьчилна гэж юу гээд яриад байгаа юм. Нэг ойлголттой болчих хэрэгтэй.

Нэгдүгээрт, бид нар энэ ард түмэнд нь хувьцаа эзэмшигч, бүх ард түмэн хувьцаа эзэмшдэг компанийн тухай ярьж байгаа юм. Тэгээд хувьцаа эзэмшигчид маань хувьцаагаа өөрийнхөө хөрөнгийг удирдах, хяналт тавих, тэр хөрөнгийг нь удирдаж байгаа компанийнх нь үйл ажиллагаанд оролцох, энэ боломжийг нь бид нар нээж өгөх гээд л энэ дээр л яваад байгаа юм л даа.

Тэрнээс өнөөдөр огт төрийн 100 хувийн өмчтэй компанийг бид нар хувьчлах тухай ерөөсөө яриагүй юм. Тэгэхээр хувьчлал явагдах явагдахгүй тухай яриа биш шүү. Өнөөдөр зүгээр ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийнхээ бас нэг бага хэмжээний ААН-үүд байдаг юм байна лээ. Энэ хэдийнхээ компанийнхаа үйл ажиллагаанд оролцох тэр эрхийг нь нээж өгье. Өнөөдөр тэр компани нь өөрөө ногдол ашиг авах ёстой байсан бол тэр ноогдол ашгийг нь өөрсдөөс нь асуух ч гүй аваачаад л төмөр зам руу хийчихсэн байгаа шүү дээ. 2 төмөр зам руу. Жишээлбэл энэнийхээ асуудалд оролцдог болгоё. Энэ боломжуудыг нь нээж өгье

гэж байгаад л асуудал ярьж байгаа юм шүү. Ингээд ажлын хэсгээс хариулъя.

Г.Занданиатар: Хэн хариулах юм 83.

Б.Дөлгөөн: Чинзориг гишүүний асуултад хариулъя.

СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Дөлгөөн. Эрдэнэс Тавантолгой компани бол одоогоор Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй ХК биш, яг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр хувьцаа нь хадгалагддаг хаалттай ХК хэлбэртэй байдаг. Нээлттэй ХК болсон тохиолдолд бол зах зээл дээр үнэ ханиш тогтох боломжтой буюу 2 дахь зах зээлийн арилжаа эхэлснээр тухайн компанийн зах зээлийн үнэлгээ ямар байхтай холбогдсон ханшийн үнэлгээ бол тогтоож явж байгаа. Яг одоогийн байдлаар бол хаалттай ХК хэлбэртэй байгаа учраас анх дүрмийн санд оролцож байсан нэгж хувьцаа 933 төгрөг гэдэг ханиш бол хэвээрээ байгаа. Үүнийг бол мэдээж Компанийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу дахин үнэлгээ бол хийх бүрэн боломжтой. Энийг бол бид нар Засгийн газраар шийдвэрлэж явах ёстой байх.

Одоогийн байдлаар бол нийтдээ 12 тэрбум ширхэг хувьцааг бол энгийн хувьцаа хэлбэртэй гаргасан. Үүнээс 0.06 хувийг Эрдэнэс Тавантолгой компани дээр ААН-үүд эзэмшиж байгаа. Иргэдийн хувьд бол 18.44 хувь, төрийн эзэмшил бол 81.5 хувийн хувьцаа эзэмшилтэй гэсэн мэдээлэл байгаа. Үүнээс гадна 3 тэрбум ширхэг хувьцааг бол зарласан хувьцаагаар бол бас бүртгэлтэй байгаа.

Г.Занданиатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн. Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя гэнэ ээ.

С.Чинзориг: Асуултад ерөөсөө хариулт өгөхгүй байна л даа. Одоо тэгээд бид яах юм ногдол ашиг өгөх юм уу, өгөхгүй юм уу? 1072 хувьцааны. Хэрвээ

ногдол ашиг мөнгөөр өгч чадахгүй гэж байгаа бол тэр иргэдийн эзэмшиж байгаа хувьцааны ногдол ашгаар бүтээн байгуулалт хийгээд 2 төмөр зам барьчихсан. Эсвэл бүр бэлэн мөнгө өгч чадахгүй бол тэр 2 төмөр замынхаа иргэдийнхээ тэр хувьцааныхаа ноогдол ашгаар оруулсан хувь хэмжээгээр тэр 2 төмөр замынхаа ногдол ашгийг хувьцааг нь эзэмшигч болох юм уу? Энэ асуудлыг чинь би бид бол нэг шийдэл гаргамаар байна шүү дээ.

Хоёр дахь асуудал нь ер нь дахин үнэлгээ хийх хэрэгтэй. Дахин үнэлгээ хийж байж тэр эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал ярихгүй бол дахин үнэлгээ хийхгүйгээр ийм хуучны тэр 2010 оны үнэлгээгээр эдийн засгийн эргэлтэд оруулна гэдэг асуудал ярьж болохгүй. Ингээж олон түмний өмчийг үнэгүйдүүлж болохгүй. Тийм учраас дахин үнэлгээ хийх хэрэгтэй. Энэ чиглэлээр ажлын хэсэг энэ тогтоол дээр бас заалт оруул.

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ тогтоолын төсөл дээр нэг санал орж ирж байгаа. Энийг бол Чинзориг гишүүн өөрөө оруулж ирсэн. Энэ бас нэлээн зөв зүйтэй санал орж ирж байгаа. Энийг бол дэмжээд явж байгаа шүү дээ. Энд бол жишээ нь 2023 онд 1072 хувьцааны ногдол ашгийг олгох гэж байгаа юм. Эсвэл Зүүнбаян төмөр зам болон Тавантолгой Гашуун сухайтын төмөр зам ХХК-д иргэдийн ногдол ашгаар хөрөнгө оруулсан хэмжээгээр хувьцаа эзэмшүүлэх гэж орж ирж байгаа. Тэгэхээр таны санаа зовоод байгаа зүйлийг бид нар бол ийшээ оруулчхаж байгаа шүү дээ. Ер нь бол иргэдэд очих байсан мөнгийг л төмөр зам руу оруулчхад байгаа. Энд бол санал нэг байж байгаа. Тийм болохоор энэ хэлэлцүүлгийн явцад бол энэ дэмжигдэх байх гэж бүрэн ойлгож байгаа. Тэгээд тэрүүгээрээ бол тодорхой хэмжээний хувьцаа. Цаашиаад бол жилийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг жил

болгон олгож байя гэсэн ийм тогтоолын төсөл орж ирж байгаа шүү. Ногдол ашиг олгоно оо гээд.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Тэгээд энэ Эрдэнэс Тавантолгойн хувьцаатай холбоотой асуудал болохоор Монгол Улсын иргэн бүртэй холбоотой ийм асуудал учраас нэлээн нухацтай ярих ёстой гэж бодож байна. Тэгээд 12 тэрбум ширхэг хувьцаа байдаг юм байна. Тэгээд эндээс бас иргэд 18.4 хувийг нь Монгол Улсын иргэд эзэмшдэг юм байна. Энэ дээр бас тодорхой нэг хариулт авъя. 2012 оны 4 сарын 11 гэж яриад байх юм. Би санахад 2011 оны 3 сарын 31 гэдэг нэг хугацаа байдаг санаад байх юм.

Энэ дээр яг энэ ажлын хэсэг хэлээдэх дээ Энд 1 жил орчмын алдаа байна уу? Эсвэл яагаад тэр юу яагаад байгаа юм? 2011 оны 3 сарын 31-нээс өмнө төрсөн хүүхдүүдэд эзэмшүүлж байсан санагдаад байгаа юм. Энийг ажлын хэсэг тодруулаад өгчих. Тэгээд энэ ер нь концепц нь яаж явж байгаа юм бэ? Цаашиаа Монгол Улсад өнөөдрөөс цааш энэ тогтоол батлагдсанаас цааш ч гэдэг юм уу, төрж байгаа хүүхдүүд дээр ер нь ямар бодлого барих юм бэ? Тэд нар төрөөд л Монгол улсын иргэн. Тэгээд иргэн бүрд гээд байгаа юм чинь тэрийг ямар бодлого бодлогоор цаашиаа ингээж барьж явах юм? Тэгээд ер нь бол энэ нэг хувьцааны асуудал чинь ингээд төмөр зам руу орчихсон, 1072 нь байгаа.

Дээрээс нь тэр хувьцаанаас нь 300000 төгрөгийнхөө хувьцааг иргэд зарчихсан энэ тэр гээд. Энэ чинь ерөөсөө нэг тийм бүрхэг байгаад байгаа байхгүй юу. Тодорхойгүй. Тэгэхээр иргэдийн дунд юу яригдаж байна гэхлээр яг энэ 1072 хувьцаа чинь иргэн болгон дээр яг бүртгэлтэй байгаа юу? Хөрөнгийн бирж дээр. Нэг зүүгээр нэг тийм бүртгэлийн маягтай юм уу бичилтийн маягтай л байгаад байгаа гэсэн ийм юм яригдаад

байгаа шүү дээ. Тэгэхээр чинь л энэ асуудал чинь ингээд яг иргэний өөрийн хувьцааны асуудлууд, ноогдол ашгаа заавал авах уу, авахгүй юу гэдэг ийм бүрхээг асуудал руу ороод байгаа байхгүй юу. Тэгэхээр яг иргэн болгон энэ хувьцааныхаа эзэн гэдэг нь юугаар яаж батлагдаж байгаа вэ гэсэн асуултыг асууя.

Дараагийн асуулт нь болохоор энэ 300000 төгрөг аваад иргэд маань ойролцоогоор 1 сая 400 гаруй мянган иргэн хувьцаагаа зарсан. 2016 онд Даваасүрэн гишүүн өглөө хэлээд байна лээ. Энэ хүмүүсийн хувьцааны хасалт нь яг хийгдсэн үү? Хаана ийм хасалт хийгдсэн юм бэ? Хасалт хийгдсэн юм байдаг юм уу? Эсвэл ер нь ноогдол ашиг болчихсон юм уу? Тэгээд тэр хасалт нь хэрвээ хийгдсэн бол энүүгээр авсан хувьцаа яг тэр төрийн хувьцааны төрийн мэдлийн хувьцаан дээр нэмэгдэж орсон уу гэдэг нэг ийм асуултыг асууя.

Тэгээд иргэд маань ингээд төмөр замд энэ авах ёстой ногдол ашгаас нь энэ төмөр зам руу оруулчихсан гээд ингээд ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр бас зарим гишүүд төмөр зам руу хувьцаа эзэмшүүлье энэ тэр гээд.

Тэгэхээр ер нь бол энэ иргэдийнхээ энэ хувьцаа эзэмшигчдийнхээ саналыг тов тодорхой авч байж л асуудлыг нь шийдэхгүй бол үнэхээр 1072 хувьцаатай иргэн бол төмөр зам руу оруулахгүй байвал яах юм? Би ногдол ашгаа авна аа. Төмөр зам руу орохыг чинь би зөвшөөрөхгүй байна гэж хэлбэл бас бид нар ямар хариулт асуудал өгөх юм?

Тэгэхээр энэ асуудлыг л тодруулж асууя.

Дээрээс нь энэ ер нь бол бид нар чинь энэ Тавантолгой чинь бид нарт Монголчуудад бурхнаас өгсөн бэлэг. Энийг бид нар ямар ч нэмэлт юм хийхгүй байгаа. Бид нар боловсруулахгүй байгаа. Их хүнд үйлдвэрийн процесс явуулахгүй байгаа. Зөвхөн л оператор хийж байгаа шүү дээ.

Тэгэхээр энийгээ бид нар экскаватороор ухаад л вагонд юм уу, машинд ачаад л зарж байгаа асуудал шүү дээ. Тэгэхээр энэний хувьцааг тэр эргэлтэд оруулна гээд гишүүд эмзэглээд байгаа чинь бол зөв гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр Байнгын хорооны дарга болон энэ ажлын хэсгийнхэн энэ хувьцаа эргэлтэд оруулах гэдэг үг чинь хардлага дагуулаад байна аа. Тэгэхээр энэ асуудлыг яг яаж шийдэхийг тодорхой хариулж өгнө үү? Өглөөнөөс хойш нэг тийм хоёрдмол утгатай.

Г.Занданишатар: Байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэр яагаад 2011 он, 2012 он байгаа юм бэ? 2011 он байсан биш үү? гээд асууж байгаа. Ажлын хэсгийнхэн сайн тодорхой хариулаарай шалтгааныг нь.

Туваан гишүүний сая нэг асуулт асууж байна. Яагаад энэ хувьцаа эзэмшигч энэ 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэд маань тэр төмөр зам руу хөрөнгө оруулалт оруулахгүй гэж шийдвэл яах юм? Яагаад тэд нараасаа саналыг нь авах вэ гэж байна? Үгүй ээ угаасаа энэ компанийг чинь нээлттэй болгож өгч байж л тэр хүмүүс чинь тэр компани дээрээ л бид нарт энэ жил ийм ашиг гарлаа, ийм хөрөнгө оруулалт хийх боломж байна. Энийгээ та нар хөрөнгө оруулалтаар энэ рүү хийх юм уу? Энийг ашигтай гэж үзэж байна уу? Эсвэл двидентээр ингээд бэлэн мөнгөөр аваад энэ хэлбэрээр ингээд авах юм уу, үгүй юу гэдгийг чинь компани дээр шийдэж байх ёстой байхгүй юу. Тэгтэл энэ компани дээр шийдэх ёстой энэ компани чинь тэр ХК-ийнхаа дүрмээр ингээд ажиллах ёстой юмыг нь өнөөдөр бид нар нээж өгөхгүй болохоор зэрэг энэ дээр тэр хэн авчраад хэдэн саяын бээлийг хүртэл нийлүүлье гээд гэрээ хийгээд байж байгааг бид нар энэ хувьцаа эзэмшигч энэ ард иргэд чинь мэдэхгүй байна шүү дээ.

Өнөөдөр ХК дээрээ очоод тэр хувь компанийн хувьцаа эзэмшигч эзэн нь юм бол компаниасаа мэдээлэл авах боломжгүй байна шүү дээ.

Дээрээс нь өнөөдөр энэ хугацаанд чинь өчнөөн энэ хүмүүс нас барсан эд нарыг чинь өөрийнх нь хөрөнгийн бол өнөөдөр үр хүүхэд нь энийг чинь өвлөж авах эрх нь байхгүй. Тэгэхээр энийг л нээж өгье гээд байгаа юм л даа. Тэгэхээр зэрэг тэр сая сүүлд нь асууж байна. Энэ чинь ингээд зүгээр л таны зүгээр нөгөө талаас нь би өөрийн ойлгосноор хэлбэл таны ийм их хямдхан өртөгтэй ингээд өндөр үнэтэй зарагдах ашиг өндөртэй ийм бизнес байхад чинь энийг тэр хувьцаа хэлбэрээр эзэмшигчид нь хувьцаа зараад ингээд бөөгнөрчихвий гэж айгаад байгаа юм биш үү гэж. Үгүй ээ тэгвэл наад эзэд хувьцаа эзэмшигч нь очоод миний компани ийм их ашигтай юм байна. Иймхэн өртгөөр 30, 40 долларын өртөгтэй гаргаад зуун доллароор зарчихдаг юм байна. 60 долларын ийм ашигтай юм байна гээд хувьцаагаа бүр л зарахгүй шүү дээ. Үгүй тэгээд энэ мэдээлэл чинь өнөөдөр хоёулаа хувьцаа эзэмшигчдээ очихгүй байна.

Энэ дээр энэ компани бүртгэлгүй хөрөнгийн биржид бүртгэлгүй компани. Өнөөдөр энийг бүртгүүлье л гэж байгаа юм. Бүртгэлгүй юм чинь хаалттай ХК нэртэй ингээд эзэд нь эрхийг нь нээж өгөхгүй ингээд хаачихсан. Тэгэхээр бүртгэж энийг нээж өгье гэж байгаа юм. Энийг тэр хувьцаа зарах эрсдэл байвал байна шүү дээ өнөөдөр буцаад энэ чинь Их Хурлаар орж ирнэ. Засгийн газарт бүрэн эрх нь байна. Өнөөдөр нийт хувьцаа эзэмшигчид жилд хувьцааныхаа байг гэхэд жишээ хэлье.

15 хувиас хэтрүүлж зарж болохгүй. 2 дахь зах зээл дээр зарж болохгүй гээд л шийдвэр гаргаад л болоо шүү дээ. Ингээд л хамгаалчих юм бол энэ их тэгж сүр дуулиан болгоод анхааруулж, ард түмнээ ингээд нэг ингэж нэг тийш нь ингэж буруу ойлголт өгөөд, тэгээд нэг тийш нь бөөгнөрүүлээд хуйлуулаад энд

байж байгаа эдэн нөхдүүд хуйвалдаж байгаад энэ компанийн хувьцааг нь тэнд хуурч байгаад ард түмнээс авч ирэх гээд байгаа юм шиг яриад ингэж улс төржүүлэх ерөөсөө ямар ч шаардлагагүй байхгүй юу.

Харин ийм нөхдүүдийг би ингэж яриад байгаа хүмүүсийг цаана нь өөр ашиг сонирхол байна гэж хараад байна. Энэ хүмүүс өнөөдөр ингэж яг хаалттай хэлбэрээр нь та нар эзэн нь мөн гэгчхээд тэгээд энэ ХК-ийг нь хаалттай хэлбэрээр энд улсын хөрөнгийн биржээр бүртгүүлэхгүй ингэж барьчхаад тэгээд эндээс нь өөрсдөө ТУЗ-даа аваачаад өөрсдөө хүмүүсээ оруулаад ТУЗ-өөр нь дамжуулаад энэ компаниудын худалдан авалтыг нь удирдаад байгаа байхгүй юу.

Хөрс хуулалтыг нь хэн хийх юм. Ямар эд бараа худалдаж авах юм? Үгүй ээ энэ чинь буцаад баригдахгүй шүү дээ. Өнөө жинхэнэ баригдахгүй, өчнөөн жил 30 жил ингэж төрийн өмчтэй компаниудаар хийгдэж ирсэн хулгай шүү дээ. Эрдэнэт дээр яригддаг. Эрдэнэтийн тэр хэдэн их наядын худалдан авалтыг хэн хэн хийдэг юм?

Өнөөдөр Тавантолгой дээр хийсэн тэр их ажил үйлчилгээг худалдан авалтуудыг нь хэн хэн хийж байгаа юм? Өнөөдөр бид нарт тэр мэдээлэл хэрэгтэй байна шүү дээ. Тийм л энэ ард түмэн тэгэхээр энд хүрч чадахгүй байна. Тэгвэл энэ гишүүдэд нь юу, хувьцаа эзэмшигчдэд нь эздэд нь энэ.

Г.Занданшатар: Хүрэлбаатар Булгантуяа.

Х.Булгантуяа: Иргэдийн бухимдлыг далимдуулж нэг хэсэг хүмүүс ч үнэхээр попордог.

Үнэхээр тууштай сайн хийх юм аа. Уг нь энэ хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байна гэдэг чинь бид нар нээлттэй, ил тод, тайлангаа ил тод, олон нийтэд тайлагнадаг 1072 хувьцаа

эзэмшигч буюу энэ Эрдэнэс Тавантолгойн 18 орчим хувьцааг эзэмшиж байгаа иргэд өөрсдийнхөө төлөөллийг ёстой жинхэнэ өөрсдийнхөө төлөөллийг хараат бус гэдэг, ТУЗ-ийн гишүүдийг нь томилдог, хэн нэгэн Улсын Их Хурлын гишүүдийн байдаг юм уу хэн нэгний ах дүү, хамаатан садан томилогддоггүй. Дээрээс нь нэмээд иргэд өөрсдөө ноогдол ашгаа авдаг ийм компанийг л бий болгоё гэж оролдоод байгаа юм. Хөрөнгийн биржид бүртгэлтэй боллоо гээд нэмж хувьцаа гаргах уу, үгүй юу гэдгийг энэ чинь компанийн наад захын нь засаглал мэддэг хүмүүс байвал мэдэж байгаа шүү дээ. ТУЗ эсвэл энэ стратегийн орд учраас Улсын Их Хурал шийднэ. Нэмж компани гаргах уу, үгүй юу гээд. Би иргэдээс асуумаар байгаа юм. Танд 2011, 2012 онд 933 төгрөгөөр үнэлж Хөрөнгийн бирж дээр жишээ энэ 1072 хувьцааг үнэлж өгчээ. Өнөөдөр энэ хувьцааны үнэ унасан уу, 200 төгрөг болтлоо унасан уу, 2000 төгрөг болтлоо өссөн үү гэдгийг иргэн та мэдэж байгаа юу?

Та мэдэхгүй байгаа учраас энэ компани аягүй бол үнэгүйдээд өнөөдөр зарахад магадгүй хэн ч авахад хэцүү ч байж болтол нь муу засаглачихсан байж магадгүй учраас бид нар ил тод болгоё л гээд байгаа юм. 1072 хувьцааг эргэлтэд оруулья гэдэг нь 2011, 2012 оноос хойш зарим өнөөдөр хувьцаа эзэмшигч иргэд нас барсан. Үр хүүхдүүд нь хувьцааг нь өвлөж авч чадахгүй байгаа. Тэрнээс хойш сая орчим хүнээр Монголын иргэд бас олихирсон. Байгалийнхаа баялгийг эзэмшиж чадахгүй байгаа. Энэ бүгдийг л нээлттэй болгоё, иргэнийг үнэхээр нь баялагт нь эзэн болгоё гэхээр хувьчилж авчих гээд байна гээд ингээд худлаа яриад байх юм. Ард түмнийг бухимдуулаад л, уурлуулаад л, хооронд нь талцуулаад л, алацуулаад л нэг хэсгийг нь жагсаагаад л байвал нэг хэсгийнх нь улс төрийн карьер их хол явдаг юм шиг байгаа юм тэ.

10 гаруй жил өнөөдөр Улсын Их Хуралд суучхаад хамгийн том ТӨК-аа хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үгүйгээ

мэдэхгүй байна шүү дээ. Эрдэнэс Тавантолгой гэдэг компани Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй. Иргэд та бүхэн хэрвээ тэрийг гайхаж байгаа бол тас.тп гээд хөрөнгийн бирж дээр ороод шалгаарай. Орон нутгийн жижигхэн дулааны компаниуд бүртгэлтэй, харин. Тэгсэн мөртөө 1072 гэдэг хувьцаанууд бол иргэд бидний хувьцаа өнөөдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр бүртгэлтэй. Бид нар энэ бүгдийг хийхгүйгээр өнөөдөр яг өнөөдрийнхөөрөө явна. Ахиад 10 жилийн дараа 5 жилийн дараа ахиад л хэдүүлээ Сүхбаатарынхаа талбай дээр жагсана. Яагаад гэвэл бид нар гүйцэтгэх захирлаас нь авхуулаад тайлан балансаас нь авхуулаад 7.5 их наяд төгрөгийн худалдан авалтыг бид нар захиран зарцуулж чадахгүй байна. Ил тод биш байна гээд иргэд бухимдаад байхад яг энэ чигээрээ явъя гээд нэг хэсэг нь уурлаад байх юм.

Би тэгээд ерөөсөө ойлгохгүй байна. Энэ бол үнэнийг хэлэхэд 1072-оосоо иргэд зарах уу, үгүй юу гэдгийг бид нар Улсын Их Хурал дээр шийдэж болно. Зарим нэг настай хүмүүс бол жишээлбэл би 70 хүрсэн хүн. Энэ Эрдэнэс Тавантолгойн хувьцаагаа бид нар би үнэд хүрэхийг хүлээж чадахгүй байна аа зармаар байна гэдэг хүмүүс байдаг юм байна лээ. Миний аав өвөө ингээд өнгөрсөн. Би хувьцааг нь авмаар байна гэдэг хүмүүс байдаг юм байна лээ. Тэгэхээр энүүнийг нь л нээж өгье гэж байгаа юм. Тэгээд тэрнээс хойшоо 1072-оосоо 2-ыг нь заруулах юм уу, далыг нь заруулах юм уу? Мянгууланг нь заруулах юм уу гэдгийг Улсын Их Хурал дээр хэдүүлээ ярьж байгаад шийдэж болох байх аа? Тэгээд жинхэнэ эзэн болгоныг иргэдээ баялагт нь эзэн болгоё гэвэл нэг сая хүүхдийг яах юм. Иргэдээ баялагтаа эзэн болгоё гэвэл энэ компанийн үнэлгээг яах юм.

Иргэдээ энэ жинхэнэ баялагтаа эзэн болгоё гэвэл энэ хэдэн попчдын гараар эс үгүй бол нэг улс төрөөр томилогдсон хэдэн хүмүүсийн гараар энэ байгалийнхаа баялгийг угаалгаад яваад байх юм уу гэдэг

ийм л шийдвэр дээр тулж ирчхээд байхад яг одоогоороо явна гээд байгааг бол ойлгохгүй байна. Ерөөсөө ойлгохгүй байна. Тэгээд энэ мэргэжлийн хүмүүс нь шийдэх байлгүй дээ. Энд олон улсын хөрөнгийн бирж дээр ажиллаж байсан хүмүүс Уул уурхайн дэд сайдаар ажиллаж байна. СЗХ, Хөрөнгийн биржийнхэн та бүхэн маань энэ бүгдийг энэ иргэдийн оролцоо, хяналт дор байж байж л энэ бүхэн луйвар, авлигал, албан тушаалын хэрэг зогсоно гэдгийг та бүхэн маань бас эрх биш мэдэж байгаа байлгүй дээ. Бид нарыг улс төржлөө гэж харж байгаа бол.

Г.Занданишатар: Ажлын хэсэг хэнээс юу? Хэн хариулах юм? Баагаагийн Баттөмөр гишүүн. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр одоо тодруулна аа.

Туваан гишүүн нэг минут.

Ц.Туваан: Булгантуяа гишүүн юугаа асуултдаа сайн, миний асуултыг сайн бүгдийг нь ойлгож байж яагаарай, тэр попорно уу, байна уу миний эрхийн асуудал шүү. Тэгээд та хэд хоорондох асуудлаа ярьж байгаа бол тэрийгээ тодорхой яриарай.

Хоёрдугаарх нь тэр миний хэлээд байгаа асуултад тодорхой хариул л даа. 3 сарын 31-нээс тэр 1 жил арван хэдэн оны хүүхдийг яагаад орхиж байгаа юм бэ? Гэж тодорхой асуулт асуусан шүү дээ.

Дээрээс нь тэр 300 мянгын хувьцаа 1400000 гаруй иргэн зарчихсан юм бол тэрний хасалт хаана хийгдсэн юм бэ? Хасалт хийгдсэн хувьцаа нь юу гэдэг юм. Төр дээр байгаа юм уу, хаана байгаа юм бэ гэдгийг хоёрдугаарт нь асуусан юм.

Гуравдугаарт нь яг энэ иргэн Ц.Тувааны нэр дээр байгаа 1072 хувьцаагаа би ер нь хаанаас яг яаж харах юм? Одоо яг бүх юм чинь ийм будилаантай, бүрхэг байгаа учраас тодорхойгүй яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм 3 асуултад ажлын хэсэгт

тодорхой хариул л даа. Та нар ажлын хэсэг гэж орж ирсэн юм бол.

83 хариулъя.

Б.Дөлгөөн: Туваан гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгээс 1072 хувьцаатай холбоотой хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой Засгийн газраас 2011 оны 98 тоот, 2012 оны 116 тоот, 2012 оны 181 тоот гээд тус тус тогтоолууд гарсан. Туваан гишүүнтэй яг асууж байгаагаар холбоотой тогтоол бол 2011 оны 3 сарын 31-ний 98 дугаар тогтоол дээр Эрдэнэс Тавантолгой компанийн нийт хувьцааны 10 хувийг 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэнд эзэмшүүлсүгэй гэж гарсан. Түүний дараа 2012 оны 4 сарын 11-ний 116 дугаар тоот тогтоолоор үүнийг бол 2011 оны 4 сарын 1-нээс 2012 оны.

Г.Занданишатар: 83 гүйцээгээд хариулчих. 2012 оны 116 дугаар тогтоол дээр 2011 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр болон түүнээс өмнө шинээр төрсөн иргэнд 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх тухай тогтоол гарсан. Хамгийн сүүлд 2012 оны 181 дүгээр Засгийн газрын тогтоолоор нэгж хувьцааг яг тогтоосон байгаа. Өөрөө 1072 хувьцааг нэг сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосугай гэсэн ийм тогтоолууд гарсан. Тэгээд энэ тогтоолуудын дагуу бол 2012 оны 4 сарын 11-ний өдрөөс өмнөх төрсөн хүмүүст 1072 хувьцааг бол эзэмшүүлсэн байгаа. 2016 оны холбогдох тогтоолоор 334 дүгээр тогтоолын дагуу бол сайн хувьцаа хөтөлбөр буюу иргэнээс 300 ширхэг хүртэл хувьцааг буцааж худалдаж авах, Засгийн газар буцааж худалдан авах ийм тогтоол гарсан. Үүний хүрээнд бол нийтдээ 1.2 сая ширхэг иргэдийн хувьцаа бол буцаагдсан. Энэ нийт үнийн дүнгээрээ бол 360.4 тэрбум төгрөгийн хувьцааг бол

буцааж Засгийн газар худалдаж авсан байгаа. Иргэнээс хасагдчихсан байгаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ тогтоолд их чухал чухал асуудлууд орж ирсэн байна. Тухайлбал, энэ лабораторийн асуудал. Лабораторийн асуудлыг оруулж ирсэн байна. Манайх чинь лаборатори байхгүй, Оюутолгой танайд гаргаж байгаа. Танайхаас гаргаж байгаа танай баялаг 1.9 тэрбум доллароос 300 сая долларын алтыг бид авдаг юм шүү гэхээр бид за гээд л явж байгаа. Энэ уул уурхайн бүтээгдэхүүнүүд дээр бол гадагш гарахдаа лаборатори байх ёстой. Юу юу ямар бүрэлдэхүүнтэй, ямар бүтэцтэй бүтээгдэхүүн гаргаж байгааг бид мэдэхгүй шүү дээ. Тэгээд энд энийг оруулж ирсэн нь сайн байна.

Дараагийн асуудал миний маш их олон жил ярьсан энэ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. Энэ уурхайн эзэд гээд яриад байгаа улсууд чинь лицензээр л түр эзэмшиж байгаа улсууд шүү дээ. Тэгэхээр юу ард түмний энэ баялаг ямар үнэтэй, юу гаргасан юм. Ямар ашиг олсон юм. Тэгээд юу худалдаж авч байгаа юм. Энэ болгон нь бол ил тод байх ёстой. Энэ ингээд 2 гол асуудал орж ирж байгаад би баяртай байна. Дэмжиж байна.

Энэ ажлын хэсгээс нэг юм асуугаадахъя. 12 тэрбум хувьцаа байгаа юм байна. Энэний миний ойлгож байгаагаар бол нэг 16.4 гээд энэ зарим улсууд бол 18 гээд байгаа юм. Иргэдэд эзэмшиж байгаа. Бас ААН нэгж дээр 0.5 хувийг нь эзэмшидэг юм шиг байгаа юм.

2021 оны 12 дугаар сарын 31-ний жилийн эцсийн балансаар яг хувьцаануудын тоог хэлээдхээч. Төрд хэчнээн байна яг тоогоор нь, хувиар нь хэлээд өгөөч, нэг дэх асуудал.

Дараагийн асуудал юу вэ гэхээр энд хардах юм гаргаад байгаа учраас л хүмүүс хардаад байгаа юм л даа. Хардах юм гаргахгүйгээр ажиллах ёстой. Энэ дээр миний ойлгож байгаагаар бол 1072 хувьцааг үе шаттайгаар эргэлтэд оруулах. Энэ дээр л одоо хардлага яваад байна л даа. Нөгөө ядуу нийт хүн амын 42.5 хувь нь ядуу болон ядуурах магадлалд орчихсон гээд тогтоочихсон байгаа шүү дээ. Тэгээд энэ хүмүүс чинь ингээд яг хувьцаагаа зарах болонгуут зараад, тэгээд энэ чинь нөгөө ард түмний мэдэлд байдаг биш, цөөхөн хэдхэн хүмүүсийн гарт ороод нөгөө ядуурал гэдэг юм маань улам нэмэгдээд байх юм. Энэ хувьцаа бол Монголын ард түмнийг энэ ядуурлаас гаргах бас нэг үндсэн нэг арга хэрэгсэл энэ юм байгаа юм шүү дээ. Энэ хувьцаагаар дамжуулж мөнгөжүүлэх. Энэ тэр юмнуудаа их зөв үг үсгийн юуг нь зөв гаргахад бол болохгүй юм байхгүй гэж ингэж ойлгож байгаа юм. Сүүлийн үед энэ төрийн өмчийг их хувьчилж байна, зүйтэй.

Төрийн банк хувьчлагдсан. Тэрний ямар хэчнээн хувь, ямар компани яаж эзэмшсэнийг зарлаж болох уу? Ийм нууц юм уу, эсвэл мэдмээр байна шүү дээ энэ ард түмэн. Энэ төрийн өмчийг хувьчлахдаа бол энэ ард түмэнд ер нь ямархуу мөнгө байна гэдгийг ер нь тооцоолдог юм уу? Би 100000 төгрөгтэй дэлгүүрт ороод 100000 төгрөгтэй л худалдаа хийнэ шүү дээ. Тэгэхээр ингээд замбараагүй ингээд л хувьчлаад хувьчилна гээд л яваад байдаг. Нөгөө ард түмний эзэн баялаг эзэмшидэг энэ ард түмэн чинь худалдаж авч чаддаггүй нэг цөөхөн хэдэн хүмүүс, нөгөө нэг хулгайн нүүрс, нүүрсний хулгай янз бүрийн хулгайлаад байгаа тэр мөнгө чинь энд орж ирээд ингээд энэ өмчийг ингэж аваад энэ чинь мөнгө угаалт байхгүй юу. Хууль бусаар олсон мөнгийг хууль ёсны эргэлтэд оруулахыг мөнгө угаах гэдэг ийм юм яваад байгаа юм биш биз дээ? Энэ юмнуудаа та нар үзээч ээ. Энэ хүүхдүүдэд өгөх юм байна.

Ертөнцийн мөнх бусыг үзсэн улсуудыг яах юм. Үр хүүхдүүд нь өвлөж явах юм уу, эсвэл хасагдаад явах юм уу? Энэ тэр 2 төмөр замд оруулсан юмыг яаж эзэмшүүлэх юм. Маш их олон асуудлууд байна шүү дээ. Ер нь бол энэ ард түмнээ ядуурлаас гаргах үндсэн гол аргуудын нэг нь бол энэ төрийн өмч, энэ баялгийн менежментийг маш сайн хийж, ард түмнийхээ ядуурлаас гарах нэг гол арга энд байгаа шүү.

Г.Занданишатар: 83.

Б.Дөлгөөн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Яг одоогийн байдлаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигчийн тухайд ААН нийтдээ дотоодын ААН 486 ААН-ийн нийт 7065038 ширхэг хувьцаа энэ нь бол тухайн компанийн 0.06 хувьтай тэнцэж байна. Иргэний хувьд нийт 2512771 иргэн нийт 2213063202 ширхэг хувьцаа эзэмшиж байна. Энэ нь бол 18.44 хувьтай тэнцэнэ ээ. Эрдэнэс Монгол компани одоогийн байдлаар үлдсэн хувь буюу төрийн эзэмшлийн хувийг эзэмшиж байна. Нийтдээ 9779000871760 ширхэг хувьцаа энэ нь 81.5 хувьтай тэнцэж байна аа тухайн байгууллагын. Ингээд нийтдээ арван хоёр тэрбум ширхэг хувьцаа байгаа.

Төрийн банкны тухайд бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу аливаа хөрөнгийн бирж дээр нээлттэй ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдүүлдэг байгаа. Арилжаа эрхлэх байгууллага буюу Монголын хөрөнгийн биржийн веб сайтаар гарах ёстой. Төрийн банкны хувьд бол 5 хувиа олон нийтэд санал болгосон. Энэ бол Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигч 5 хувь болон түүнээс дээш хувиас эхэлж байгаа. Ингэхээр нийтдээ Төрийн банкн дээр 7306 иргэн, ААН бол хувьцаа эзэмшиж байгаа. Эдгээрийн хэн нь ч нөлөө бүхий хувьцаа

эзэмшигч биш учраас бол өөрөөр хэлбэл тухайн компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох ийм боломжгүй байгаа. Ингэхээр бол нээлттэй мэдээлэх мэдээлэлд бол байхгүй байгаа.

Шаардлагатай гэвэл нэг хувь болон түүнээс дээших мэдээллийг бол гаргаж өгдөг. Гэхдээ энэ бол бас хувь хүн болон хувьцаа эзэмшигчтэй холбоотой мэдээлэл учраас олон нийтэд нээлттэй тэрүүгээр гаргах нь бол хүндрэлтэй байгаа хуулийн дагуу бол. Үнэлгээний хувьд бол мэдээж компанийн үнэлгээг бол тухайн хөрөнгө оруулалт гэж үзээд тухайн хөрөнгө оруулалтын тухайд ирээдүйд олох ашиг болоод ирэх жилүүдийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн үзүүлэлт, мөнгөн урсгалын тооцоолол дээр холбогдуулж тодорхой үнэлгээний олон улсын стандартад нийцсэн тодорхой аргуудаар бол гаргадаг.

Тэгэхээр энэ үнэлгээнд бол нийцүүлж суурь, компанийн үнэлгээ бол гарч байгаа. Энэ компанийн үнэлгээг эцсийн дүндээ компанийн ТУЗ-өөс тогтоож олон нийтэд санал болгодог байгаа. Зарим тохиолдолд бол захиалгын бүртгэлийн арга буюу биют бюлдинг гэдэг аргыг ашиглах замаар олон нийтэд санал болгох замаар тухайн үнэлгээ бас тогтох ийм бас үнэлгээний бас аргачлал олон нийтэд санал болгох ийм аргачлал бас байгаа.

Г.Занданишатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Баттөмөр гишүүнтэй санал нэгдээд нэг байгаад байгаа юм аа. Тэр үе шаттайгаар гээд байгаа шүү дээ. Үе шаттайгаар гэж байгаа нь бол ер нь яах вэ 18 хувийг гараад бирж дээр гарлаа гээд тэгэхэд ард иргэд бүгдээрээ 18-ыгаа ингээд нэг дор бүгдийг нь зарчих уу, үгүй юу. Мэдээж одоо иргэдээс нэн тэргүүнд шаардлагатай ч гэдэг юм уу, хэрэгцээтэй байгаа зарлаа гээд бодоход 10 хувийг зарлаа гэж бодоход энэ чинь 1.8 хувь л болчих гээд байгаа

байхгүй юу, нийт. Тэгэхээр сая бас хэллээ. Таваас дээш хувьтай болж байж нөлөө бүхий хувь эзэмшигч болчих гээд байгаа юм.

Тэгэхээр яах вэ зүгээр үе шаттайгаар гэж энэ үсгийг оруулж байгаа маань ер нь нийт иргэдийн хувьцааны 10 хувийг эхлээд зарах тийм боломжийг нь нээгээч ээ. Үе шаттайгаар нээгээч л гэж байгаа юм. Тэгэхгүй бол панк гээд 18 хувийг нэг дор нээчихнэ гэсэн үг биш байгаад байгаа юм.

Хоёрдугаарт, бид Засгийн газрын өмнөөс ингээд хариулах гээд байгаа байхгүй юу. Засгийн газрын өмнөөс хариулаад Засгийн газар дээр яг яаж хийгдэх нь бол бид нар тодорхой биш байхад өмнөөс нь хариулж болохгүй. Хамгийн гол нь Засгийн газар яг энэ үүслийн дагуу хийхийн тулд бид нар энэ үг үсэгтэй удирдамжийг Их Хурлын тогтоолыг гаргаж өгөөд байгаа байхгүй юу. Тийм болохоор 1072 хувьцаагаа эргэлтэд оруулах нэг, хоёрдугаарт энэний үе шаттайгаар гэдэг үг оруулаад. Магадгүй зүгээр үр өгөөжийг нь сайжруулах гэдэг үг Байнгын хороон дээр дахиж орж ирээд нэмэгдүүлээд өөрчлөөд яваад байхад бол болохгүй зүйлгүй байгаа юм аа.

Хоёрдугаарт, төрийн өмчийн хувьцаан дээр бол хувьчилчих байх гэсэн манайхны санаа зовоод байгаа юм. Улсын Их Хурал төрийнхөө ТӨК-уудынхаа төрийнхөө асуудлуудыг Улсын Их Хурал мэддэг шүү дээ. Жишээ нь бид нар Эрдэнэтийн 51 хувийг алдчихлаа эд нар гээд л янз янзын юм ярьж байсан юм. Яагаад Улсын Их Хурал дээр ирж шийдээгүй юм бэ гэдэг асуудлуудыг бид нар ярьсан шүү дээ. Тэрэнтэй адилхан хүссэн хүсээгүй жишээ нь 80 гаруй хувийг бол хэрвээ биржээр худалдах дээр шийдвэл Засгийн газар хүрч байж энэ танилцуулах ёстой. Тэгж байж Улсын Их Хурал шийдвэр гаргах ёстой. Тийм болохоор энд бас Их Хурлын даргын ч удирдамж байж байгаа. Иргэнд танилцуулах гэдэг үг

үсгийг оруулчихъя. Тэгвэл ерөөсөө буцаад бид нар танилцуулаад тэрэн дээр нь ёстой харин хэдүүлээ Засгийн газрын тэргүүнээсээ Засгийн газраас бид нар хариултыг нь бүрэн дүүрэн авъя гэж бодож байгаа шүү. Тийм болохоор танилцуулъя гээд орчхож байгаа юм.

Г.Занданшатар: Телуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ тогтоолыг бол дэмжиж байгаа юм гишүүд санаа зовоод ярьж байгаа нь зөв. Ганбаатар гишүүн, Даваасүрэн гишүүн, Баттөмөр гишүүн тэр санаа зовж байгаа нь зөв өө. Яах арга байхгүй энэ баялгийн тэгш хуваарилалттай холбоотой Монголын төр тодорхой хэмжээний шийдвэр гаргаад 1072 хувьцааг нийт Монголын бүх ард түмэнд эзэмшүүлсэн. Энэ бол дэвшилттэй бодлого байсан. Ингэхийн явцад тухайн компани дээр очсон удирдлагуудын үндсэндээ алдаанаас болоод 1072 хувьцаа ногдол ашиг гээд ногдол ашиг өгөх боломж гаргадаггүй. Компания ашиггүй ажиллуулдаг. Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр энд тэнд хөрөнгө оруулалт хийж, төмөр зам зам барьдаг. Энэ бүх асуудалд цэг тавихын тулд л үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв билүү тэрэн дээр байгаа компанийг Хөрөнгийн бирж дээр бүртгэе гэсэн ийм шийдвэр гаргаж байгаа юм.

Хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэнээр тухайн хувьцаа эзэмшигчид энэ компанийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж нээгдэж байгаа юм. Хаалттай компани учраас хэдэн төгрөгийн орлого олж байгаа. Хэдэн төгрөгийн зарлага гарч байгаа дээр хяналт тавих, олон нийтийн хяналт тавих боломжгүй байгаа. Энэний гаргалгаа болгож энэ Эрдэнэс Тавантолгой компанийн хөрөнгийн бирж дээр авч ирж бүртгэе. Ногдол ашигийг нь хуваарилъя. Энэ хувьцааг нь өвлүүлдэг болгоё. Одоо үндсэндээ ингээд хувьцаа эзэмшиж байгаад нас барсан хүмүүсийн

хувьцааг бол өвлүүлэх боломж нээгдэхгүй байгаад байна шүү дээ, эрх зүйн орчин нээгдэхгүй байгаа.

Хөрөнгийн бирж дээр ирэх юм бол тэр хүний нэрийн данс нээгдээд тэр хүний хувьцаа нь байж байх юм. Энэ бүх гаргалгаануудыг гаргахын тулд энэ Эрдэнэс Тавантолгойг бирж дээр авчирч нээлттэй компани болгоё оо л гэж байгаа юм. Энэ асуудлыг бол дэмжиж байгаа.

Энэ дээр Баттөмөр гишүүн бас сая асуулаа. Энэ 1072 хувьцааг үе шаттайгаар эргэлтэд оруулах гэдэг маань бас л яах вэ? Би СЗХ-ны нөхдүүдтэй бас уулзсан. Яг энэ үгний цаад утга нь бас тийм биш юм аа. Энийг амь оруулъя гэсэн ийм агуулгатайгаар орж ирсэн юм гэж магадгүй үгний сонголт буруу болчихсон байж магадгүй. Яг одоо 1072 хувьцааг эргэлтэд оруулаад арилжаалдаг болгочих юм бол яг манай Монгол Улсын нийгэм эдийн засгийн нөхцөл бас бэлэн биш юм шиг л надад санагддаг юм. Ингээд нөгөө талдаа хэдэн олигархууд нь энэ компанийн ихэнх хувийг нь эзэмшээд үлдчих юм биш үү? Одоо энэ санхүүгийн асуудалтай байгаа ийм үед иргэд маань хувьцааныхаа үнийг бууруулаад эргээд нөгөө яг гол утга агуулга буюу энэ баялгийн тэгш хуваарилалтын гэдэг энэ агуулга нь алдагдчих юм биш үү гэсэн ийм хардалт яваад байгааг бол үгүйсгэхгүй. Тийм учраас энэ 1072 хувьцааг үе шаттайгаар эргэлтэд оруулах гэдэг үгээ хэдүүлээ бас эргэж харах нь зөв байх. Яагаад гэвэл яг энэ бичиг дээрээ шууд Засгийн газар дээр үүрэг болоод чиглэл болоод оччих учраас энийг яаж ч мушгиж болохоор л харагдаж байгаа юм л даа.

Миний бодлоор бол ард иргэд энэ Эрдэнэс Тавантолгой компаниас ногдол ашгаа авах, ногдол ашгаа авахын тулд олон нийтийн хяналтыг тэнд бий болгох нь чухал гэж би үзэж байгаа юм л даа. Тэр хувьцаагаа арилжаалах бол нэгдүгээр зорилго бол биш, ард иргэдийн. Нэгэнт одоо гишүүд маань нэлээн заяагдмал эрх гэж нэгэнт энэ Монгол Улсад төрсөн юм

бол Монгол Улсын энэ газар доорх баялгаас хувь хүртэх ёстой гэсэн үндсэн зарчмаа бид нар бариад, та бол хувьцаагаа бол одоохондоо арилжаанд оруулах бол болоогүй шүү. Ноогдол ашгаа л аваад явж бай гэдэг эрх зүйн зохицуулалтыг манай ажлын хэсгийг олж гаргах хэрэгтэй. Ногдол ашгаа бүрэн авах дээр энэ Монгол Улсын иргэдийн эрхийг л хангах, эрх зүйн орчин гаргалгааг та бүхэн олох ёстой л доо.

Тийм учраас энэ тогтоолыг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ саяын миний хэлсэн үе шаттайгаар эргэлтэд оруулах гэдгийгээ эргээд харна биз. Тэгээд энэ яг өнөөдөр бид нар энэ асуудлыг энд хэлэлцээд сууж байгаа нь.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд үг байхгүй. Энэ Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж хариулт авлаа. Тэгээд нийт гишүүдийн олонх нь Жигжидийн Батжаргал гишүүнээс эхлээд сая Телуханы Аубакир гишүүн хүртэл энэ иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үе шаттай эргэлтэд оруулах гэдгийг бол буруу зөрүү ойлгогдох, тэгээд энийг хэрэгжүүлэх шатандаа зөрчил дутагдал гарах, энийг тэгээд бас хувьчлах гэж байгаа юм шиг ойлголт нийгэмд өгөх ийм эрсдэлүүд байгаа учраас энийг тэр удирдлага, менежмент, хяналтын тогтолцоог сайжруулах. Энэ чинь угаасаа л олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх гэдэг дотор энэ агуулга яваад. Тэгээд газрын хэвлэлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд хүртээмжтэй болгох хүртээмжтэй эдийн засаг гээд байгаа шүү дээ. Хүртээмжтэй эдийн засаг болгох ийм зарчмын саналуудаар бүх гишүүд үг хэлсэн учраас энэ 1, 2, 3, 4 дүгээр асуудал дээр бол ямарваа нэгэн санал шүүмжлэл өрнөсөнгүй.

Ингээд бас Сайнхүүгийн Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн нарын гишүүн ч гэсэн энийг өглөө бас

санал шүүмжлэл өрнүүлсэн. Энэ бүхнийг харгалзан үзээд ингээд энийгээ бол шийдэл өгөх гэж байгаа юм шиг чиглэл биш Засгийн газар, Улсын Их Хуралд нэгдүгээр улирлын дотор оруулж ирж танилцуулж шийдвэрлүүлэх гэсэн хугацаатай болгоод төрийн эзэмшлийн хувьцаа энэ тэрийнхээ юмыг үг хэллэг, хууль зүйн зөрчлүүдийг арилгаад ингээд гүйцээн боловсруулах чиглэл өгч байна аа.

Энэ 4 санал хураалтыг дөрвүүлэнгий нь 5 дугаар заалттай холбоотой учраас ингээд 5 дугаар заалттай холбоотойгоор болон бусад асуудлуудыг санал хураалт явуулах юу ч алга байна. Цайны цаг болсон байна. Ингээд гүйцээн боловсруулж эцсийн хэлэлцүүлэг дээрээ гүйцээн боловсруулаад ингээд эцэслэн баталъя аа.

Чуулган завсарлалаа. Үдээс өмнөх чуулган завсарлалаа.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн үдээс үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Дараагийн асуудалдаа оръё. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Гишүүд ажлын хэсгийг бэлтгэе. Гишүүд ажлын хэсгийг бэлтгээд эргэж мэдэгдээрэй. Хууль санаачлагчийн илтгэл.

Асуудалдаа оръё. Хөрөнгө оруулалтын Банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хороо санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн танилцуулна.

Ц.Цэрэнпунцаг: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүнээс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ. Тус Байнгын хороо 2021 оны 3 дугаар сарын 31-ний 08 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагаар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Бат-Эрдэнэ О.Цогтгэрэл, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, ажиллууллаа.

Байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн зарим зохицуулалтыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрийг төрөлжсөн болгож тодорхойлох зэрэг чиглэлээр зарчмын зөрүүтэй нийт 33 саналын томъёолол бэлтгэгдсэн болно оо.

Үүнд:

Хөрөнгө оруулалтын банк нь дунд, урт хугацааны тогтвортой эх үүсвэрээр

төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа явуулах төрөлжсөн банк байхаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснээр хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Банкны тухай хууль хуулиар үйл ажиллагааг нь зохицуулах банк болон Хөрөнгө оруулалтын банкны хуулиар үйл ажиллагааг нь зохицуулагдах, хөрөнгө оруулалт оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааг давхардуулан эрхлэхгүй байх тухай зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Мөн гадаад улсын төрийн өмчит хуулийн этгээд, хөрөнгө оруулалтын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 33 ба түүнээс дээш хувийг эзэмших тохиолдолд Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан зөвшөөрлийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас авах хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол банк, СЗХ хамтран банкны тухай хууль тогтоомж, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн хүрээнд тус тусын бүрэн эрхийн хүрээнд олгохоор зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хориглох үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, мөнгөн хадгаламж, хүү төлөх нөхцөлтэй харилцах данс нээх, түүнтэй адилтгах байдлаар хөрөнгийн эх үүсвэр төвлөрүүлэх, салбар, хараат болон охин компани байгуулах, Монгол Улсын банк, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахыг хориглох. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл, Хөрөнгө

оруулалтын банкны дүрмийн сан таван зуун тэрбум төгрөгөөс доошгүй байна гэсэн 5.2 дахь хэсэг нэмэх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөх өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Энхбаярын Батшугар гишүүнээр тасаллаа.

Ширнэнбандийн Адьяаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяаа: Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийг оруулж ирж байна.

Энэ ямар учраас ингэж оруулж ирж байна. Энэ Хөгжлийн банкныхаа асуудлыг шийдээгүй байж дахиад ямар банк оруулж ирж байгаа юм бэ?

Хөгжлийн банк чинь тийм том төсөл хөтөлбөрүүдийг шийднэ. Том мега

төслүүдийг санхүүжүүлнэ гэдэг асуудал яригдаад өнөөдөр ямар үр дүн гараад юу болчихоод байгаа билээ. Гэтэл өнөөдөр энэ хөрөнгө оруулалтын банк гээд энэ банкийг байгуулаад энэ том төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх тухай энэ танилцуулга дээр байна л даа. Үгүй ээ тэр Хөгжлийн банкаараа яагаад энийг шийдэж болдоггүй юм. Заавал нэг банк оруулж ирэх сан, зорилго нь юу байна аа. ямар зорилго байна Дахиад энэ чинь нэг хөрөнгө оруулалтын банк гээд Хөгжлийн банкттай адилхан хэмжээний ийм үйл ажиллагаа явуулах гээд байгаа юм уу, нэг бол Хөгжлийн банкаа татан буулгах гээд байгаа юм уу гэдэг талаар тодорхой хариулт авмаар байна.

Энэ Хөгжлийн банкаа татан буулгаад тэр өр төлбөр, бусад асуудлыг нь ингэж залгамж чанарыг нь хадгалуулах юм уу, дахиад өнөөдөр ингээд хөрөнгө оруулалт нэрээр энэ улс төрчид, энэ хамаарал бүхий компаниар дамжуулаад дахиад ийм эрсдэлтэй, ийм ард иргэдийн боломжийг хулгайлсан ийм үйл ажиллагааг зохион байгуулах юм уу, энийг огт дэмжихгүй байна би. Түүний оронд өнөөдөр гаднын банкийг оруулж ирэх, өнөөдөр энэ арилжааны банканд барьцаалагдсан Монголын эдийн засгийг чөлөөлөх асуудал дээр оруулж ирвэл бид дэмжинэ. Гэтэл өнөөдөр Хөгжлийн банкны асуудлыг цэгцэлчхээд дараа нь энэ Хөрөнгө оруулалтын гэдэг банк гэдэг сайхан нэртэй энэ хуулиа оруулж ир ээ. Энэ дээр бол ингэж амь аргацаасан ч юм уу, аль эсвэл ямар нэгэн бодлогоор ийм юмыг оруулж ирэхээ боль оо. Энийг огт дэмжихгүй байгаа.

Дээрх 2 асуултад би хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Эхлээд Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Адъяаа гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, энэ хууль 2016 онд өргөн баригдсан ийм хууль, Тэгээд олон удаа ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд энэ удаан, энэ Их Хурал дээр байсан. Энийг бол заавал бид нар хэлэлцэх шаардлагатай байгаа юм.

Таны яриад байгаа Хөгжлийн банк бол өөрөө хуультай. Хөгжлийнхөө банкны хуулиар явна. Энэ бол хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хууль гэж хууль. Энэ бидэнд өнөөдөр энэ дотоод бид нарын энэ хөрөнгө оруулалтын чиглэлээр арилжааны банкнууд дээр хөрөнгө оруулалтын энэ хэлбэрээр Голомт, жишээлбэл, Худалдаа хөгжил дээр нэг хөрөнгө оруулалтын ийм өөрийнхөө сантай болсон. Энэ эрэлт хэрэгцээ бий болж байна. Нөгөө талаасаа бол гадаадын банкнууд орж ирж, энэ Монгол Улсын эдийн засаг, энэ эдийн засаг Монгол Улсын эдийн засаг томорч байна. Өсөж байна.

Дээрээс нь энэ төсөл хэрэгжиж байгаа энэ хувийн хэвшлийн ч бай, төрийн ч бай төсвийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн маань овор хэмжээ томорч байна. Энэнийхээ хэрээр санхүүжилт том их хэмжээтэй санхүүжилт шаардлагатай болж байгаа юм. Тэгэхээр зэрэг өнөөдөр энэ том төсөл хөтөлбөрүүдийг явуулахын тулд бол гарцаа байхгүй энэ хөрөнгө оруулалтын чиглэлээр дагнасан ийм л гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх эрх зүйн хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх ийм бодит практик шаардлага бас амьдралд гарч ирж байгаа юм аа. Таны сая хэлээд байгаа гадаадын банкийг л оруулж ирвэл би зөвшөөрч байна. Гадаадын банкны хууль гэж байна. Энэ хууль бол одоо энэ арилжааны банкнаас Хөгжлийн банкны хуулиар зохицуулагдаж байгаагаас гадна шинээр үүсэж бий болж байгаа энэ шинэ зах зээл, маркетыг эрх зүйн орчныг нь бүрдүүлэх шаардлагатай болж байна.

Энд өнөөдөр энэ хөрөнгө оруулалтын банкнууд орж ирснээр төслүүд хэрэгжинэ. Энэ төслүүд бол өнөөдөр арилжааны банкнууд маань

хэмжээ багатай зээл гаргаж байгаа юм. Тийм учраас бол нэг Тавантолгой гэхэд л зээл авахад манай 3 том системийн 3 том банк нийлж байж зээл гаргасан шүү дээ. Өнгөрсөн жил Тавантолгой зээл авахад. Удаан хугацаатай одоо 2, 3 жилээс дээш, ингээд урт дунд хугацаанд өгөөжөө өгч эхлэх энэ төслүүд дээр бол урт хугацаатай ийм эх үүсвэрүүд шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэ эх үүсвэрийг бүрдүүлэх ийм зайлшгүй практик шаардлага гарч байгаа юм.

Дээрээс нь энэ банкнуудын нэг арилжааны банкнуудыг бол та мэдэж байгаа тийм ээ. Энэ хадгаламж эзэмшигчдийн мөнгийг хадгалж буцааж зээл хэлбэртэй гаргадаг. Энд зээлүүд бол хугацаа богинотой, заавал хадгаламжийн хүү өндөр байгаа учраас бол хүү өндөр байдаг. Энэ хөрөнгө оруулалтын банкнууд орж ирснээр бол энэ зээлийн хугацаа уртсах, хүү багатай энэ зээлийн эх үүсвэр, санхүүжилтийн эх үүсвэр бий болох юм аа. Таны тэр болгоомжлоод байгаа тэр түрүүн хэлсэн Хөгжлийн банктэй та энийг андуурч болохгүй. Энэ хөрөнгө оруулалтын банк бол 100 хувь хөрөнгө оруулагч өөрийнхөө хөрөнгийн эх үүсвэрээр энэ банкны эх үүсвэр бүрдэх учраас ямар нэгэн энэ хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эрсдэлд оруулах ийм эрсдэл байхгүй. Төрийн оролцоо байхгүй ийм л банкууд байх юм шүү.

Г.Занданшатар: Ингээд ажлын хэсгээс Энхтайван хэдэн номер байна. 83 номер.

Г.Энхтайван: Адьшаа гишүүний асуултад нэмж тодруулъя.

2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд өөрчлөлт оруулсан байгаад байгаа Улсын Их Хурлаар. 2021 оны энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр банкны салбарт баримтлах бодлогыг Улсын Их Хурал баталсан юм аа. Энэ бодлогоор тус хуулийн 4.1 дээр банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр

төрийн хувийн болон холимог үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нь нийтлэг ба төрөлжсөн байж болно гээд. Үйл ажиллагааных нь хэлбэрээр нь бол төрөлжсөн банк байх эрх зүйн үндсийг нь бол нээгээд өгчихсөн юм. Яг энэ хүрээнд 2017 онд Банкны тухай хууль тухайн үед гарсны дараа Төв банкнаас Хөгжлийн банканд төрийн өмчийн төрөлжсөн банкны гэрчилгээ олгосон байгаад байгаа. Хөгжлийн банк нь өөрөө дунд болон урт хугацааны санхүүжилтээр нийгэм, эдийн засагт үр нөлөөтэй төслүүдийг санхүүжүүлэх үндсэн зорилготой төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд байгаа.

Тэгэхээр яг ийм чиг үүрэгтэй гэхдээ хувийн хэвшлийн яг энэ чиглэлд нь ажиллах эрх зүйн боломжийг нь нээж өгөх үүднээс энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн Банкны тухай хуулийг оруулж ирж байгаа юм. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь урт болон дунд хугацааны санхүүжилтийн эх үүсвэрээр төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ ээ. Дотоодын банкны салбарт бол өрсөлдөхгүй иргэдийн банкны үйл ажиллагаа явуулахгүй. Зээлийн хэмжээн дээр нь хязгаарлалт тавьж байгаа. Мөн дотоод зах зээл дээрээс ямар нэгэн хэлбэрээр эх үүсвэр татахыг нь бол хориглож байгаа. Адьшаа гишүүний тодруулаад байгаа тэр гадаадын банкныг оруулж ирэх тухай зохицуулалт бол Банкны тухай хуулийн 22 дугаар зүйл дээр гадаадын банк, гадаадын хөрөнгө оруулалттай банк нь салбар төлөөлөгчийн газраа хэрхэн байгуулах, тухайн зөвшөөрлийг яаж авах, ямар шаардлага хангах тухай зохицуулалтыг Банкны тухай хуулийн 22 дээр дэлгэрэнгүй тайлбарлаад өгчихсөн байгаад байгаа. Яг одоогийн байдлаар Төв банканд гадаадын аль нэгэн банк салбар төлөөлөгчийн газар байгуулах хүсэлтээ ирүүлээгүй байгаад байгаа юм.

Ер нь бол энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль байхгүйгээс болоод гадаадын банк Монголд орж ирэхгүй байгаа юм шиг ийм

буруу ойлголт ард нийтийн дунд ч гэсэн яваад байгаа юм. Тэгэхээр энийг бол хольж ойлгож бол ерөөсөө болохгүй. Энэ бол төрөлжсөн банкны тухай хууль орж ирж байгаа юм энүүгээр.

Г.Занданиатар: Ширнэнбандийн Адьшаа 1 минут тодруулна.

Ш.Адьшаа: Цэрэнпунцаг дарга аа би бас нэг жоохон юм гадарлахтайгаа байгаа шүү. Өнөөдрийн Хөгжлийн банкны үйл ажиллагаатай гэж л нэг л юм байна шүү дээ. За яах вэ та нарын ярьж байгаагаар төрөөс тодорхой хэмжээний мөнгө төгрөг олгохгүй, төр энд оролцохгүй юм гэдэг ийм л юм ярьж байна. Тэгэхдээ цаг хугацаа харуулна аа. Эхний тэр төрийн нэрээр байгуулсан тэр Хөгжлийн банкныхаа асуудлыг чинь бүгд энэ та нарын энэ үзэл баримтлалууд чинь адилхан байгаа шүү дээ. Том төслүүдийг хэрэгжүүлнэ гэж байгаа. Тэгээд бусад зээл олгоно гэж байгаа. Энд ямар схем зөрчөөд байна аа? Би хардаж байгаа. Өнөөдөр Тавантолгойн хувьчлалын асуудал явагдаж байна. Ай фондын асуудал явагдаж байна. Гэтэл энд энэнтэй зэрэгцүүлээд хөрөнгө оруулалтын банк гэдэг ийм юм оруулж ирээд юм ойлгохтойгоо байгаа шүү, Цэрэнпунцаг аа би бол.

Г.Занданиатар: Цэрэнпунцаг гишүүн, Байнгын хороон дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Энхтайван танд бүр тодорхой хариулсан шүү дээ энэ чинь энд ерөөсөө төрийн өмчтэй ийм хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулахгүй. Энэ бол хувийн хэвшлийнхний гадна дотнын хөрөнгө оруулагчдад энэ хөрөнгө оруулалтын чиглэлээр энэ төрөлжсөн баг явуулах үйл ажиллагааных нь тэр хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгч байгаа юм Адьшаа гишүүн ээ та энэ дээр итгэлтэй байж болно. Тэгээд энэ хууль гараад явахаар зэрэг тэгээд та түрүүн хэллээ харна биз.

Сая энэтэй холбоогүй бас таны яриад байгаа хувьчлал гээд байх юм. Тавантолгойн хувьчлал гэж яриад байх юм. Тэгээд энэ үгийг ингээж Тавантолгой чинь ХК шүү дээ. ХК өнөөдөр зүгээр нэг ХК-ийг хаалттай байгааг л нээлттэй болгох гэж байгаа юмыг ингээд л ард түмнийг, ард түмнийг ингээд толгойг нь эргүүлээд л хувьчлал болох гэж байгаа төрийн өмчтэй компанийг хувьчлах гэж байгаа юм шиг юм яриад яваад байх юм.

Г.Занданиатар: Болдын Жавхлан Сангийн сайд.

Б.Жавхлан: Адьшаа гишүүний асуултад нэмж хариулъя аа.

Адьшаа гишүүн ээ та материалаа нэмээд нэг сайн тухтай нэг харчихвал уг нь нэлээн ойлгомжтой байгаа л даа. Та сая 2, 3 юм ярьж байгаад би яг нэг ийм юм бол би дэмжинэ шүү гээд нэг тодорхойлоо шүү дээ. Яг тэр тодорхойлж байгаа тэр банкны зохицуулалт тань л орж ирж байгаа юм биш үү? Ер нь бол банкны зах зээл дээр нэг ийм үйлчилгээ хэрэгтэй байна гэж 30 жил ярьсан асуудал юм байгаа юм. 30 жил ярьсан шүү. Өөрөөр хэлбэл банкнаас манай санхүүгийн салбар маань ерөнхийдөө нэг банк гэдэг ганц тоглогчтой энэ монолоо задалъя гэж байгаад л ийм зохицуулалт юм байгаа юм. Энэ хуулийг 2016 онд өргөн барьснаас хойш 7 дахь ажлын хэсэг нь байгуулагдаж байна 7 дахь. 7 удаа ажлын хэсэг байгуулагдсан, 7 удаа дарга нь солигдсон, 7 удаа ажлын хэсгийнхний бүрэлдэхүүн солигдсон байдаг юм.

Тэр хаанаас хэн дургүйцээд байгаа нь маш ойлгомжтой. Энэ бол өрсөлдөөнийг л дэмжих гэж байгаа юм. Энэ өрсөлдөөнөөс хэн хожих вэ? Банкны үйлчлүүлэгч хожно. Зээлдэгч нар хожих юм байгаа юм.

Г.Занданиатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой юм асуу. Юмаа унш.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ хуулийг орж ирж байгаа нь зөв өө зөв. Манай төв 5 банк гэж яриад байгаа Монголын үндэсний нэртэй банкнууд бол зүгээр даварчихсан байгаа шүү дээ. Бүр ард түмнийг бол зүгээр л бүр Монгол оронд мөнгө хамгийн үнэтэй зуун төгрөгийг 120 төгрөгөөс дээш зардаг. Монголд ийм үнэтэй мөнгө зардаг, яагаад гэвэл банкнууд дундаас нь иддэг. Монголбанк ч гэсэн дээ зуун төгрөгийг 115 төгрөгөөр зардаг эдийн засгийн ойлголтоор бол. Бодлогын хүү 13 хувь байна гэдэг бол зуун төгрөгийг арилжааны банкнуудад 113 төгрөгөөр өгдөг, нөгөөдүүл нь ченжлээд зуун төгрөгийг 113-аар авчхаад 120-127 төгрөгөөр зардаг.

Тэгэхээр миний тодруулж асуух зүйл гэвэл арилжааны 14 банкны 8 банк гадаадын хөрөнгө оруулалттай гэж байгаа аль хэзээний хөрөнгө оруулалттай. Хэдэн хувь байгаа вэ? Ямар 8 банк байгаа вэ? Хадгаламж эзэмшигчдийн өмнөөс би энийг асууж байна. Энэ мэргэжлийн улсууд нь тодорхой хэлж өгнө үү? Эдгээрээс 3 банк нь гадаадын банкны хувьцаа эзэмшигчтэй гэж байгаа юм. Хэдэн хувь нь хувьцаа эзэмшдэг вэ? аль 3 банк вэ? Энэ нууц биш ээ. Энэ хадгаламж эзэмшигчдэд мэдээлэх ёстой зүйлийг би асууж байна.

2 дугаар зүйл, Зээлийн бодлого гэж юм байдаг аа. Зээл бол бас яг нарийн яривал зүгээр л мөнгө олгох, ашиг олгох ажил биш шүү. Энэ бас стратегийн зүйл шүү. Би Хаан банканд ажиллаж байхад бас Япончуудад өгнө гээд л ингээд л ярьж байхад зээлийн бодлогыг нь асуудаг байсан. Зээлийн бодлого, Хөдөө аж ахуйн зээл өглөө гэхэд чинь зүгээр л бодлогоор дандаа ямаанд зээл өгөөд байвал давуу нөхцөлтэйгөөр өгөөд байвал Хөдөө аж ахуйн салбар унах вий гэдэг ийм асуудлыг л би санаагаа ойлгуулах үүднээс асууж байна шүү.

Социализмын үед бол үхэр хонинд зээлийн бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, санхүүгийн бодлогоор дэмжлэгтэй байдаг байсан. Тэгэхээр энэ гадаадаас орж ирж байгаа банкнууд дээр яг энэ зээлийн бодлого, стратегийн тодорхой Үндсэн хуулийн 5.4-т чинь төрөөс эдийн засгийг зохицуулна гэж заасан байгаа шүү. Төрөөс эдийн засагт менежмент нь оролцоно гэсэн үг биш зохицуулалт хийнэ. Регулешин. Тэгэхээр энэ дээр тодорхой саналууд байгаа юу? Би эндээс юу ч олж уншиж чадсангүй. Миний 2 дугаар асуулт энэ.

Гурав дугаар асуулт, ер нь зүгээр, миний саяын асуулт ашиг багатай ч гэсэн дээ. Улс орны эрх ашгийн төлөө тодорхой стратегийн зарим салбаруудад санхүүгийн хямд эх үүсвэрээр үйлчлэх үүрэг бас байдаг. Энэ банканд тэрийгээ та нар тодорхой энд бичээгүй байна. Тодруулж өгөөч ээ.

Гурав дугаар миний асуулт. Энэ гадаадынхан орж ирэхлээр л гоё болно оо л гэсэн заалт байна. Хуудас нь энэ дээр бичээгүй байна. Энэ Монголын үндэсний энэ том банкнууд хүүгээ буулгахгүй энэ гадаадын банк орж ирснээрээ.

Бүр иргэд хадгаламж эзэмшигчийн тухай ярихгүй байлаа гэхэд жижиг дунд үйлдвэрлэгчид зээлийн хүү буух уу. Төгрөг Монгол мөнгө үнэ нь хямдрах уу? Маши ойлгомжтой асуулт би асуулаа.

Тэгэхээр энэ хямд эх үүсвэрээр хангах зорилгоор энэ байгаа гэж би ойлгож байгаа. Шинэ технологи орж ирэх нь яах вэ? Бидэнтэй бидэнгүй орж ирнэ.

Тэгэхээр 4 дүгээр асуулт стратегийн томоохон Оюу толгойн томоохон энэ уул уурхайнуудад зээл өгөх гээд байдаг эд нар. Жижиг, дунд үйлдвэрлэгч нарт зээл өгөхөд багц нь хэдэн хувь байх вэ гэдэг дээр та нар тодорхой судалгаа шинжилгээ, тодорхой зохицуулалт байгаа юу? Би 4 асуулт

асуулаа. Надад тодорхой хариулж өгвөл би маш их баярлана.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн 83.

Г.Энхтайван: Ганбаатар гишүүний асуултад сүүлийнх нь асуултаас нь эхлээд хариулаад явчихъя.

Энэхүү хууль маань бол хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааг явуулж байгаа. Зээл олгох та төслийн 7 дугаар зүйл дээр зээл олгох үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан заалт байгаад байгаа. Төсөлд олгох зээлийн хэмжээ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг банкны системд нөлөө бүхий банкнаас хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээ бусад хүчин зүйлсийг хамааран харгалзан СЗХ хороо, Монголбанк тогтооно гээд заачихсан байгаа.

Тэгэхээр зээлийн үйл ажиллагаа ямар хэлбэрээр явагдах юм. Энэ дээр ямар ямар шалгуур тавигдах зээлийн доод хэмжээ хэд байхыг бол СЗХ, Монгол банк хамтраад тогтоочихно. Жижиг дунд үйлдвэрлэл болон иргэдийн зээл олгохгүй ээ. Яагаад гэхээр энэ дээр иргэдийн бид бүхэн энэ хөрөнгө оруулалтын банкиг томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ гэж оруулсан байгаад байгаа юм. Хөрөнгө оруулалтын банк. Тэгэхээр дотоодын арилжааны банкнууд тэртээ тэргүй зах зээл дээрээ ажиллаж байгаа тохиолдолд яг банкнуудын өрсөлдөгч бол үйл зээл олгохгүй. Гэхдээ таны асуугаад байгаа тэр хүү буурна. Гадаадын хөрөнгө оруулалттай хөрөнгө оруулалтын банк орж ирснээр. Томоохон хэмжээний зээл, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд явахаар одоо манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкнууд дээрх эх үүсвэр суларна.

Тэгэхээр эх үүсвэр суларснаар иргэдэд болон таны асуугаад байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт

очих санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэнэ. Эх үүсвэр нь нэмэгдэхээр зээлийн хүү буурна. Зээлийн хүү, ер нь бол цаашидаа дан ганц ямар нэгэн хууль батлаад ч юм уу л ингээд буухгүй ээ. Зээлийн хүү бол зөвхөн эх үүсвэр нэмэгдэж байж хуримтлал нэмэгдэж байж эх үүсвэрийн төлөө банкууд өрсөлддөггүй, эх үүсвэр хангалттай болсон тохиолдолд л зээлийн хүү буурна. Инфляц тогтворжсоны хүрээнд бол буурна. Хэдэн банк гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаа эзэмшигчтэй байна вэ гэсэн асуулт байна.

Төв банкнаас системийн нөлөө бүхий банкнуудын үйл ажиллагаа, цар хүрээ, банкны системд эзэлж байгаа жингээр нь тодорхойлно. Системийн нөлөө бүхий 5 банк гэж одоогоор бол тодорхойлоод байгаа. Эдгээр 5 банкнаас төрийн өмчийн эзэмшилд байгаа төрийн банкнаас бусад нь ямар нэг хэлбэрээр гадаад улсын хувьцаа эзэмшигчтэй байгаад байгаа юм. Арилжааны банк Банкны тухай хуулиар олгогдсон эрх үүргийнхээ дагуу өөрийнхөө хувьцаа эзэмшигчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтаараа олон нийтэд бол тавьж байгаа. Энэ дээр бол Монголбанк хяналтаа тавиад явж байгаа. Төсөл хөтөлбөр гэдэг дээр бид бүхэн энэ хуулийн 4 дүгээр зүйл дээр хуулийн нэр томъёо гэдэг дээр байгаад байгаа юм. Төсөл гэж яг юу юм бэ гэдэг дээр санхүүгийн хөрөнгийн дунд, урт хугацаатай эх үүсвэр шаардлагатай, уг эх үүсвэрийг орлогоороо нөхөх боломжтой эдийн засгийн үйл ажиллагаа гэж бид бүхэн тодорхойлсон байгаа. Энэ төсөл хөтөлбөр гэдэг яг энэ төсөл гэдэг энэ нэр томъёог бид бүхэн ОУВС болон бусад холбогдох байгууллагуудтай нэлээн удаан ярилцсаны үндсэн дээрээс бол яг энэ хууль дээр төсөл гэдэг үгийг яг ингээж тодорхойлж гэж оруулж ирсэн байгаа.

Энэ бол яг олон улсын жишиг стандартын дагуу тодорхойлсон байгаад байгаа. Та түрүүн тэр зээлийн хэмжээ асуугаад байх шиг байна. Яг одоогийн

байдлаар Банкны тухай хуульд тавьсан шаардлагын дагуу манай хамгийн том өөрийн хөрөнгөтэй банк Хаан банк өөрөө хөрөнгийнхөө 20 хувьд зээл олгох боломжтой байгаад байгаа юм. Нэг зээлдэгчид тэр бол гурван зуун тэрбум төгрөг. Манай арилжааны банкны нэг зээлдэгчид дангаараа гаргаж байгаа зээлийн максимум хэмжээ 300 тэрбум л байгаад байгаа юм.

Тэгэхээр томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх энэ төрөлжсөн банк орж ирснээр ийм хэмжээний зээл, энэнээс илүү гарч байгаа зээлийг дангаараа санхүүжүүлээд явах, эсвэл дотоодын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудтайгаа, эсвэл Хөрөнгө оруулалтын банктэй хамтраад Ко Финанс хийгээд банкны синдикат хэлбэрээр зээл олгоод явах.

Г.Занданшатар: Энхбаярын Батиугар гишүүн асууна.

Э.Батиугар: Баярлалаа. Энэ төрөлжсөн хөрөнгө оруулалтын банкны хуулийг дэмжиж байгаа юм аа. Ямар ч улсын эдийн засгийн үндсэн судас нь цус нь бол санхүүгийн сектор нь өөрөө эзэлдэг. Энэ утгаараа Монгол Улсын эдийн засгийг цаашид хэлэхэд ч гэсэн бас санхүүгийн салбараа либералчлах хэрэгтэй. Энэ хуулийг оруулж ирснээрээ тодорхой хэмжээний алхмууд хийгдэж байна гэж ойлгож байгаа юм. Тэгээд өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн тулгамдаж байгаа асуудлын хамгийн нэг том нь бол гадаадын шуудан, валютын урсгал. Үүнээс шалтгаалаад манай төгрөгийн хани сулраад долларын хани чангараад импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт гэх мэтчилэн зүйл явагдаж байгаа.

Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын банкны хууль баталснаар бол шууд гадаадын хөрөнгө оруулалттай банкнуудыг их хэмжээний урт хугацааны эх үүсвэрээр тордох бололцоо нээгдэж

байна гэж харж байгаа юм. Ингэснээр давуу тал нь бол түрүүн бас Энхтайван ерөнхийлөгч ярьж байгаа. Манай нэг банк бол 300 тэрбумаас өөр илүү санхүүжих бололцоогүй байдаг. Өнөөдөр яригдаад байгаа шинэ сэргэлтийн бодлого болон бусад том хөгжлийн төслүүд бол бараг 300 тэрбум биш, 300 сая доллар 400 сая доллароор яригдах тийм төслүүд байгаад байгаа юм.

Эд нарыг гадаадын хөрөнгө оруулалтын банкаар л шийдвэрлэх бололцоотой. Өөр бололцоо байхгүй, ингэснээр Монгол Улс цаашаагаа том том аж үйлдвэрээ хөгжүүлэх болон эдийн засгаа ажиглах бололцоо нээгдэнэ.

Дээрээс нь нэмээд их хэмжээний урт хугацааны валют орж ирснээр манай хани эргэж чангарах тийм бололцоо нээгдэнэ. Эцсийн үр дүндээ бол бид нар бусад улс орнуудын бас кэйсийг харах ёстой. Тэгээд Вьетнам улс бол нэг санхүүгийн сектороо либералчлаад, тэгээд өнөөдрийн 2022 оны байдлаар бол дотоодын бүтээгдэхүүн 8 хувиар өснө гэсэн тийм покус гарчихсан байгаа юм.

Тэгээд энэ жил харахад бол Тайландын Кайси конексон банк Вьетнамд үйл ажиллагаа нээгээд ирэх жил 500 сая доллар оруулж ирнэ гэсэн байна. Бид нарын мэдсэнээр Кэй Ди би Кореан деблбмент банк бол ирэх жил бас салбараа нээгээд тэгээд том том дэд бүтцийн төслүүддээ хөрөнгө оруулалт хийнэ гээд бас зарлачихлаа. Мөн Bank of America ч гэсэн тэнд өөрсдийнхөө салбарын тэгээд явж байгаа юм. тэгээд энэний үр дүнд бол эдийн засаг нь өнөөдөр бол 2022 оны байдлаар бол 8 хувиар өсөж байгаа юм. Энэ бол бүсдээ бол хамгийн том өсөлт гэж та бүхэн ойлгож болно. Энэ цэвэр санхүүгийн сектор нь либерал болсон гадаадын хөрөнгө оруулалт татсан дээрээс нь том том хөгжлийн төслүүддээ бол бүрэн явуулах бололцоо нь нээгдсэн улс орон юм. Манайх ч гэсэн яг энэ кэйсийг бас тодорхой зөв хэсгүүд нь дагаж бас дуурайж явах нь зүйтэй ингээж

байж л улс орон болоод хөгжинө шүү дээ. Үүнтэй холбоотойгоор ахиад нэг заавал ярих ёстой зүйл нь бол энэ баялгийн сан яримаар байгаа юм аа. Манай Монгол улс чинь бол зэс, төмрийн хүдэр. Дээрээс нь нэмж жонш, алт гэх мэтчилэн маш олон, уул уурхайн баялагтай. Энэ баялгийн сан байгуулж, энэ уул уурхайн баялгаа зөв менежмент хийж байж Монгол Улс одоо, ирээдүй хойч хүүхдүүддээ бид нар үлдэнэ шүү дээ. Газар доор байгаа баялаг чинь өөрөө хэзээ 1 цагт дуусна.

Тэгэхээр өнөөдөр бүгдийг хэрэглээд, тэгээд дараа нь үр хүүхдүүддээ юу ч үлдээхгүй хоцорч болохгүй. Монгол Улсын иргэн бүр энэ тухайн баялгаас хүртэх хүртэх ёстой хамгийн зөв нь Баялгийн сангийн хууль юм аа. Энийгээ л аль болохоор яаравчлуулж явмаар байна. Тэгээд зөв кэйсүүдийг бас яривал Темасенк гээд Сингапурын баялгийн сан. Энэ бол сүүлийн 40 жилд маш үр дүнтэй үйл ажиллагаа явуулсан. Жил болгон дундаж өсөлтийг нь л 12 хувиар баялгийн санхүү өсгөсөн юм. 12 хувьд чинь ямархуу тоо байна гэж яривал 40 жилийн өмнө 100 долларыг байршуулаад жил болгон 12 хувиар өсгөвөл өнөөдөр тэгээд зуун доллар нь 9300 доллар болчих тийм бололцоотой. Энэ бол жил болгон ямар нэгэн байдлаар нэмэгдүүлэхгүй цэвэр өөрөө геометрийн прогрессоор нэмэгдсэн хувилбар. Тэгэхээр ийм том том боломжууд байгаад байгаа. Эд нарыгаа бид нар өнөөдөр л хэрэгжүүлэх нь хамгийн зүйтэй. Тэгээд буцаад эргэж хөрөнгө оруулалтын банктэй ярихад бол та бүхэн мэдэж байгаа байх. Өнөөдөр бол яг Монгол Улсад том том аж үйлдвэр болон эдийн засгаа сэргээх тийм нөхцөл байдал үүсчихсэн байна. Үйлдвэр технологийн парк.

Г.Занданишатар: Хариулт хангалтгүй бол нэмнэ. Хэн хариулах вэ? 83.

Г.Энхтайван: Батиугар гишүүний тавьсан саналыг бол хуулийн дэд ажлын хэсгийнхэн бол тухай бүрдээ ярилцаад гишүүнтэй бол нэг саналтай байгаад байгаа. Хуулийн 15.4 дээр төрөлжсөн

банкны хувь нийлүүлсэн хөрөнгө үйл ажиллагаа эрхлэх эх үүсвэр нь эдийн засгийн харьяат бус этгээдээс гаралтай гадаад валют байна гээд тодорхой зааж өгсөн нь бол энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь өөрсдөө гадаад валютаар буюу Монголбанкны нөөцийн валютаар дүрмийн сан болон эх үүсвэрээ бүрдүүлнэ. Энэ хэрээр гадаад валютын Монгол Улсад орж ирж байгаа урсгал нэмэгдэнэ. Энэ нь эргээд манай Монгол Улсын валютын нөөцөд маш эерэг үр дүнтэй. Банк хоорондын зах дээр ханиш тогтворжих, арилжааны банкнууд, энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банктэй хамтран төсөл хөтөлбөр санхүүжүүлэх, гадаад валютаар гадаад валютын менежментийн хувьд удирдах хүрээнд бол маш их томоохон ахиц дэвшил гарна гэж үзэж байгаа.

Тэгээд гишүүнтэй бол энэ дээр зуун хувь санал нэгтэй байгаа.

Г.Занданишатар: Батиугар гишүүн.

Э.Батиугар: Түрүүн бас хэлж байсан. Үйлдвэр технологийн паркийн хууль батлагдчихсан байгаа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хууль яригдаж байна. Дээрээс нь нэмээд сая 11 сарын Ерөнхийлөгчийн айлчлалаар талын зам болон бүс, зам төсөл хөтөлбөрийг интеграцад оруулсан гэсэн юм яригдаж байгаа. Тэгэхээр бол яг энэ санхүүжилт үндсэн механизм нь болох юм аа. Гэхдээ одоо дүрмийн сангаа яг ямархуу байдлаар бүрдүүлнэ. Ямар барометр индикатораар тогтоох вэ гэдэг л асуулт байна л даа.

Г.Занданишатар: Болчихсон уу?

Э.Батиугар: Болчихсон. Дүрмийн сангаа хэдээр бүрдүүлэх вэ? Ямар индекатар болон барометр харж бүрдүүлэх вэ? Тэр хязгаараа тогтоох уу?

Г.Энхтайван: Батиугар гишүүний асуултад тодруулъя. Өргөн барьсан

хуулийн төслийн 5.2 дээр төрөлжсөн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг юу, юуг харгалзан Монголбанк тогтоох тухай бол дэлгэрэнгүй оруулсан байгаа. Үүнд бол үндэсний аюулгүй эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын түвшинд төлбөрийн тэнцлийн үзүүлэлт, төгрөгийн ханшийн өөрчлөлт, банкны төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалтын банкны эрхлэх үйл ажиллагааны онцлог, мөн дотоодын банкны салбар дахь төслийн санхүүжилтийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан Монголбанк тогтооно гэж заасан байгаад байгаа юм.

Тэгэхээр яг энэ хуулийн 5.2-оор дамжуулаад Монголбанк энэ дээр тухай бүрд нь шинэчлээд явах тийм деликац авч байгаа. Өмнөх бүр анх 2016 онд өргөн баригдсан, 7 жилийн өмнөх хувилбар дээр бол тухайн үедээ 500 тэрбум төгрөг гэдэг заалтыг тавьж өгсөн байсан. Тэгээд ажлын хэсэг дээрээ бол энийг ярилцаад яг тийм хатуу тоо тавих нь бас байнга хувьсан өөрчлөгдөж байгаа эдийн засгийн нөхцөл байдлын хувьд бол бас тохиромжгүй юм. Байн байн хуулиа өөрчлөх шаардлагатай болох юм гээд яг энэ 5.2 гэдэг заалтаар.

Г.Занданшатар: Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр, ер нь бол Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг бол би дэмжиж байгаа. Тэгэхдээ бас нэг хэд хэдэн зайлиггүй асуух ёстой асуулт байна. Нэгдүгээр асуулт бол өөрийн хөрөнгө болон санхүүгийн эх үүсвэрээ зөвхөн гадаад улсад үнэт цаас гаргах зарчмаар оруулж ирэх, дотоодын зах зээлд өрсөлдөхгүй байх энэ заалтыг яаж тусгасан бэ? Өөрөөр хэлбэл дотоодоос эх үүсвэрээ бүрдүүлнэ гээд явчих юм бол нөгөө дотоодын банктайгаа адилхан болчихно шүү дээ. Тийм учраас энэ тал дээр ямар асуудал байгаа вэ?

Хоёрдугаарх нь 2016 оны анхны өргөн барилтаар бол 500 тэрбум

төгрөгийн дүрмийн сантай байна гэсэн. Энэ бол тухайн үеийн валютын ханшаар бол нэг 200000000 доллар байсан юм байна лээ л дээ. Одоо ингээд хани унаад 150 сая доллар болчихлоо, 500 тэрбум гэдэг чинь. Тэгэхээр би энийг санал гаргаад 500 болгох санал гаргачихсан байж байгаа. Тэгээд энэ Монголбанканд энэ эрхийг өгчихөөр, тэгээд энэ 500-аас доош болгочих юм биш биз дээ? Энэ дээр ямар саналтай байна? Тэгэхээр энэ дотоодын банкнууд бол мега төслүүдэд орж байгаа. Жишээ нь Голомт банк гэхэд нэг их наяд 2 их наяд, бараг хэдэн их наядын юунд орж байна шүү дээ. Тэгэхээр эд нар яаж санхүүжүүлж байна вэ гэхээр өөрийн хөрөнгө нь бол нэг 200 тэрбум гаргалаа гэхэд нэлээн хэд хэдэн компаниудад зээл олгох замаар тэр компанийнхаа юуг нэг санхүүжилтэд олон олон компанид өгөх замаар зээл олгох замаар ингээд хөрөнгө оруулалт хийгээд яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ ялангуяа мега төслүүд санхүүжигдэх тэр прожект финанс аль эсвэл одоо төслийн дутагдал хэрэгтэй байгаа бриж финанс энэ тэр дээр ямар шалгуур яаж тавих юм. Олон компанид олгох компанид олгох замаар ингээд шийдээд явчих юм биш биз дээ гэдэг асуулт байна. Дотоодын банкны салбарт банк санхүүгийн салбарт оруулах энэ хувь хэмжээ энэ дээр байгаа юу? Энэ чинь бас нөгөө нэг тодорхой хэмжээгээр Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд хэр нийцэж байгаа вэ гэдэг энэ дээр хязгаар тавьсан уу?

Дөрөв дэх асуулт нь екюти финанс буюу компанийн өөрийн хөрөнгөд дутагдал болчихсон, тэрний 49 хувьд хүртэл нь олгоно гэж байгаа юм. Тэгээд энүүгээрээ ингээд нөгөө уул уурхайн ч болон бусад компаниудын 49 хувийг авах замаар нөгөө компани чинь тухайн улсын бодлогыг хэрэгжүүлээд энэ Монголын энэ эдийн засагт хэтэрхий өндөр хувьтай ороод ирэх ийм нөхцөл байдал бий болох юм биш биз дээ гэдэг энэ дээр ямар хариулт байгаа вэ?

Мэдээж энэ дээр нэг асуудал гараад байна шүү дээ. Жишээ нь алтны уурхайтай нэг компани эрсдэлд орлоо. Тэгэнгүүт тэр компанид энэ хөрөнгө оруулалтын банк чинь зээл олгочихсон байж байдаг. Гэтэл тэрийгээ компанийнх нь 49 хувьд хөрөнгө оруулах замаар буцаад нөгөө нэг өөрийнхөө орны компани ч юм уу, ААН-д зарчихдаг. Үүнээс нь болоод газрын доорх баялаг ашиглах тухай асуудал, энэ тэр янз янзын асуудлууд гарч ирээд байгаа. Энэ дээр нэг улсын харьяа хараат болох тэр асуудал чинь энэ ялангуяа нэг том банкны бүрэн санхүүжилтээр бүх асуудлаа шийддэг ийм хараат болох нөхцөл байдал чинь хэр зэрэг хязгаарлалттай хэр зэрэг зохицуулалттай байгаа вэ гэсэн ийм асуу асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ?
83.

Г.Энхтайван: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Хуулийн төслийн 15.4 дээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагаа эрхлэх эх үүсвэр нь эдийн засгийн харьяат бус этгээдийн гарал үүсэлтэй гадаад валют байх бөгөөд тухайн этгээд эзэмшиж буй Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэг дээр бүрдүүлээгүй байна гээд заачихсан байгаа. Тэгэхээр энэ бол эх үүсвэр дээр тавьж байгаа зохицуулалт бол энэ 15 дугаар зүйл 15.3, 15.4 дээр бол бүрэн тусаж байгаа. Тэгэхээр яг эдийн засгийн харьяат бус нь гадаад улсын мөнгөн тэмдэгтээр буюу Монголбанкны нөөцийн валютаар эх үүсвэр дүрмийн сангаа бүрдүүлж оруулж ирнэ. Энийг бол хууль дээр бол нарийвчлан зааж өгсөн байгаа. 500 тэрбум төгрөгийн дүрмийн сангийн хэмжээг яагаад ингээд аваад хаячхав гэж байх шиг байна. Нөхцөл байдал бол та бидний бодож байгаагаас маш хурдан өөрчлөгдөж байгаа. Эдийн засгийн хэмжээ болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, олон улсад тулгарч байгаа үнийн өсөлт гэх мэтчилэн, нийгэм, эдийн

засагт үүсэж байгаа энэ геополитикийн шок гээд. Эдийн засгийн нөхцөл байдал та бидний ингээд бодож байгаагаас маш хурдан тааварлашгүй байдлаар өөрчлөгдөж байгаа юм.

Тэгэхээр яг хууль дээрээ хадмал тоо шууд 500 юм уу, эсвэл 300 ч юм уу тавиад өгнө гэдэг нь өөрөө нэг талаасаа маш зохимжгүй байгаа. Бас одоо та Монголбанк 500-г бууруулчих уу энэ тэр гээд байна. Ер нь бол гадаадын хөрөнгө оруулалтыг бид бүхэн нэмэгдүүлэх, Гадаадын хөрөнгө оруулагчыг Монгол Улсад урьж ажиллуулах шаардлагатай гадаад эх үүсвэрийг оруулж ирэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх бол манай үндэсний аюулгүй байдал, тэр дундаа эдийн засгийн тогтвортой байдалд учирч байгаа хамгийн том асуудал. Хамгийн том асуудал. Тэгэхээр бид бүхэн бол аль болохоор зах зээлээ нээлттэй, Гадаадын хөрөнгө оруулагч орж ирж ажиллах боломжийг нь л нээх үүрэгтэй.

Тийм учраас яг хатуу тоо тавих нь нэг талаасаа маш зохимжгүй. Нөгөө талаасаа аягүй ойлгомжгүй байдалд хүргэнэ ээ. Хувьцааны асуудал дээр одоо энэ та түрүүн дотоодын банк, санхүүгийн байгууллага хувь эзэмшээд явчих уу энэ тэр гээд тодруулаад байсан. Хуулиараа бол бид бүхэн энэ дээр төрөлжсөн банк бол дотоодын банк, санхүүгийн байгууллага ч ямар ч хувьцаа эзэмшихгүй. Энийг бол хорьж байгаа. Тэр 49 хувь гэж яриад байна. Холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 49 хувьд. Энийг бид бүхэн ажлын хэсэг дээрээ яриад 49-өө 20 болгоод бууруулаад Байнгын хорооны хуралдаанаар 20 хувь гээд ороод ирсэн байгаад байгаа юм.

Тэгэхээр төрөлжсөн банк нь холбогдох этгээдийнхээ хувьцааны 20 хүртэлх хувийг 5 хүртэл жилийн хугацаатай эзэмшинэ. Мөн тухайн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна гэж байгаа юм. Тэгэхээр яг одоогийн нөхцөл байдалд арилжааны банкнууд маш олон төрлийн компанийн

хувьцаа эзэмшээд, тэдгээрийнхээ бизнесийн үйл ажиллагаанд оролцоод хуулиар олгогдсон банкны үйл ажиллагаагаа эрхлэхгүй, бусад төрлийн машин зараад ч юм уу, төмөр зам бариад эсвэл юу гэдэг юм сүүлдээ бараг ууц чанаад яваад байна шүү дээ. Тэгэхээр энэ бүгдийг тодорхой хэмжээнд нь зохицуулж, хуулиар олгогдсон төрөлжсөн банкныхаа л үйл ажиллагааг эрхэлье гэж байгаа юм.

Мэдээж хөрөнгө оруулалтын зах зээл дээр ажиллах боломжийг нь нээх үүднээс хөрөнгө оруулж байгаа тухайн төсөл нь хэрвээ санхүүжилт дутагдаж байгаа тохиолдолд тодорхой хэмжээний екюти файнэнс хийгээд хорь хүртэлх хувийг нь, тэгэхдээ хугацаатайгаар 5 хүртэл жилийн хугацаатайгаар эзэмшээд, тэгэхдээ үйл ажиллагаа нь менежментийн түвшинд нь оролцохгүй, саналын эрхгүй байдлаар эзэмшээд явдаг тийм зохицуулалтыг энэ хуулийн 10.4.5 дээр бол оруулж өгч байгаа. Мөн та түрүүн тэр алтны ААН-тэй холбоотой нэг асуудал хөндлөө. Яг энэ хууль дээр бол бид бүхэн 7.4 дээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь барьцаалсан ашигт малтмалынхаа тусгай зөвшөөрлийг хэрхэн бусдад шилжүүлэх тухай дуудлага худалдан авах тухай, Ашигт малтмалын тухай хуулийн 7.1-д заасан этгээдэд шилжүүлнэ гээд маш нарийн зохицуулаад заагаад өгчихсөн байгаад байгаа юм. Тэгэхээр яг энэ бүх үйл ажиллагаа бол банкны тухай хуулиараа ч зохицуулна.

Г.Занданиатар: Байнгын хорооны дарга Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Түрүүн 4 асуултын нэг нь дээр нь Энхтайван бас хариулж байгаад дутуу нэг юм орхичихсоныг гүйцээгээд хариулчихъя. 500 тэрбум гээд ингээд таны оруулж ирсэн санал байгааг ингээд тавьчихаар нэгдүгээрт ийм хатуу тоо уян хатан байх хэрэгтэй, бас нөхцөл байдал янз бүр байна гээд хэллээ.

Дээрээс нь бол энэ хууль бол зөвхөн Гадаадын хөрөнгө оруулагчдад биш бас дотоодод өөрийнхөө банкиг би суурь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк болгож явуулъя гэх юм бол бид энэ хэддээ бас өндөр тоо тавьчихвал энэ нь бас тэд нарт маань өндөр босго болчих, бас энэ үйл ажиллагаа явуулахад нь бас нэг хатуу өндөрдсөн шаардлага болчих байх гэж энэ тоон дээр ингэж хандаж байгаа шүү. Та тэрэн дээр анхаараарай.

Дээрээс нь тэр компаниудад хувьцаа эзэмших нь бол түрүүн Энхтайван тодорхой хэлсэн. Тэр компани нь ямар нэгэн төрлийн өөр төрлийн бизнес хийдэг бай, тэндээсээ банк нь хамгийн гол нь ашиг олох биш, тэр компанийнхаа тэр зээл өгчихсөн байж байгаа компанийнхаа 20 хүртэлх хувийг аваад тэнд саналын эрхгүй оролцоод, тэр компанийн бүрэн мэдээлэлд хүрэх ийм л давуу талыг үүсгэх хэрэгтэй байна. Компани дотор эрсдэл байна уу, үгүй юу, үйл ажиллагаа нь сайн байна уу? Засаглал нь ямар байна гэдгийг хянаж энэ өөрийнхөө зээлийн эрсдэлийг багасгаж байгаа учраас, жишээлбэл нөгөө төсөлд хөрөнгө оруулах оруулахдаа заавал зээлдэгчээс өндөр шаардлага тавиад эрсдэлийн энэ нэмэгдлүүд нэмэгдээд байхгүй байх талаас нь зээл бага хүүтэй гарах, ийм бас их хэмжээтэй гарах бололцоог нь бүрдүүлэхийн тулд энэ заалтууд оруулж өгсөн ийм байгаа юм шүү.

Г.Занданиатар: Эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Туваан гишүүн ээ.

О.Цогтгэрэл: Энэ Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль орж ирж байгаа. Энэ хуулийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Яагаад гэвэл ер нь аливаа бизнес аливаа салбар хөгжин дэвшинэ гэдэг чинь төрөлжиж, тодорхой сегмент сегмент рүү ялгарахыг хэлж байгаа юм. Гэтэл яг энэ Хөрөнгө оруулалтын банкны 2016 онд өргөн баригдсан энэ хууль чинь өөрөө яг томоохон төсөл хөтөлбөр рүү чиглэсэн урт хугацаатай санхүүжилт. Тэр тусмаа

өнөөдөр манай Монгол Улсад тулгараад байгаа гадаадын эх үүсвэр татах, тэр дотоодын жижиг зах зээл дээр өрсөлдөхгүй байх гээд маш олон давуу талуудыг бий болгож байгаа. Энэ хуулийн төслөөр. Ийм болохоор энэ хуулийн төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэний цаана дахиад бид нарт гарч байгаа нөгөө Хөгжлийн банкны үндсэн асуудлуудыг чинь бараг төрийн оролцоогүйгээр шахуу том төслүүдийг явуулах бүрэн бүрэн дүүрэн Хөгжлийн банкн дээр нэг ингээд шуугиад өнгөрөх биш гарц, гаргалгаа талдаа энэ бол их том бодлогын шийдэл гэж бас ойлгож байгаа.

Харин энэ дээр нэг асуулт байгаа нь үнэхээр энэ бол Монгол Улсад маш их ашигтай зүйл. Гэтэл нөгөө талаасаа бид нар хэчнээн ингэж батлаад тэр том актив хөрөнгөтэй, гадаад эх үүсвэр татчихсан валютаар оруулж ирээд монгол төгрөгөөр зээл өгөх хэмжээний энэ ААН-үүд банк үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч чинь харин олдож байгаа юм уу, үгүй юм уу. Тэр бүхэн чинь харин үнэхээр олдвол бүрэн дүүрэн, бид нар алгаа дэлгээд хүлээж авах ёстой л ийм бодлогын өөрчлөлт л гэж үзэж байгаа.

Тэгэхээр тэр яг гадаадын хөрөнгө оруулагчид байгаа юм уу, үгүй юм уу. Яг энэ хууль батлагдлаа гээд энэний чинь дагуу орж ирэх юм уу, төгрөгөөр зээл өгөх юм уу?

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. 83 Энхтайван ерөнхийлөгч Монгол банкны.

Г.Энхтайван: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Төв банкны зүгээс хууль, эрх зүйн орчныг нь тодорхой болгоод өгчихье. Гадаадын хөрөнгө оруулагч энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн боломжийг нь нээлттэй болгоод өгье гэсэн тийм бодлогын хүрээнд бол энэ хуулийг оруулж ирж байгаа. Мөн бид бүхэн энэ хуулийн

драфтыг хийж байх явцад хэд хэдэн удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Монголын бизнесийн болон Худалдааны танхимууд, банкны холбоо гэх мэтчилэн байгууллагуудыг оролцуулж. Энэ хүрээнд бол мэдээж манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын банкууд, Японы MUFG болон Сумитомо, Мицүй, Банк об Чайна, ICBC энэ тэр бол бүгдээрээ оролцсон. Тодорхой хэмжээнд бол хууль хэрхэн батлагдахыг бол тухайн ААН-үүд бол ажиглаж байгаа гэдэг бол мэдээлэл байгаа. Яг одоогийн нөхцөл байдалд бол энэ төлөөлөгчийн газраараа дамжуулаад гадаадын банкууд бол зээл олгож байгаа. Зээлийн хэмжээ бас их өндөр биш байгаа. Гэхдээ яг одоогийн байдлаар бол 240 орчим сая долларын зээлийг төлөөлөгчийн газраараа дамжуулаад олгогчоод байгаа гэдэг нь нэг талаасаа манай зах зээл дээр ажиллах сонирхлоо илэрхийлээд байгаагийн нэг хэлбэр юм болов уу гэж үзэж байгаа.

Хууль батлагдсаны дараа бол Төв банкны зүгээс гадаадын хөрөнгө оруулалттай ч юм уу, эс үгүй бол энэ дотоодынх ч байсан болно энэ төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх боломжийг нь нээж, энэ журмуудыг хурдан хугацаанд баталж өгсний үндсэн дээр бол хууль эрх зүйн орчин бүр бүрэн утгаараа нээлттэй болно оо л гэж ойлгож байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна зарчмын зөрүүтэй санал байгаа. Асуулт хариултын цаг дууссан учир гишүүд чуулганы танхимд цуглаж санал хураалтад бэлтгэнэ үү.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль бол их чухал хууль. Улсын Их Хурал 2016

онд хэлэлцсэн. Тэгээд тэрнээс хойш бол ингээд Их Хурал дээр байсаар байгаад сая харин ажлын хэсэг олон удаа өөрчлөгдсөөр байгаад ажилдаа ороод явж байгаа ийм хууль байгаа. Нөгөө 2 парламент дамжиж хэлэлцэгдэж байгаа хууль учраас бас нэг бүлгээр ярьж, саналыг нь нэгтгэх ийм шаардлага байгаа учраас Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиуд дээр МАН-ын бүлэг ажлын 3 хоногийн завсарлага авъя гэсэн хүсэлтийг гаргаж байна аа.

Баярлалаа.

Г.Занданшатар: МАН-ын бүлгийн даргын саналаар ирэх 4 дэх өдрийн 10 цаг хүртэл завсарлага өглөө. 3 хоног.

Асуулт хариулт дууссан. Тэгээд 34 саналаар санал хураалт явуулъя.

Дараагийн асуудалд орно оо. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. индэрт урьж байна. Жавхлан сайдыг индэрт урьж байна.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг анх 2000 онд хуулиар зохицуулж эхэлсэн бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийг 2005 онд баталсан ба тус хуульд 32 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр, 2020 оны 24 дүгээр тогтоолоор

батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгах, мэдээллийн ил тод байдал, худалдан авах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, гэрээ шууд байгууллагын аргачлал, шалгуурыг тодорхой болгох, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх зэрэг зорилтуудыг хангуулах, хууль эрх зүйн орчныг шинэчлэх шаардлага үүссэн.

Түүнчлэн тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр хуулийг шинэчлэн найруулах тухай зөвлөмж гарсан бөгөөд Улсын Их Хурлаас шинэ сэргэлтийн бодлого баталсантай холбогдуулан шинэ сэргэлтийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн шинэчилсэн найруулга гэж тусгагдсан байна аа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын хүрээнд тендер шалгаруулалт дахь хүний оролцоог бууруулах, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эх оронч худалдан авалтыг дэмжих, тендер шалгаруулалтыг түргэн шуурхай зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог шинэчлэх гэсэн үндсэн агуулгыг тусгаж, хуулийн төслийг боловсрууллаа.

Нэг. Технологийн дэвшилд тулгуурлан тендер шалгаруулалт дахь

хүний оролцоог бууруулна. Засгийн газраас худалдан авах ажиллагааг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2011 оноос эхлэн тасралтгүй хийж байгаа боловч тендер шалгаруулалтыг цахим технологид тулгуурлан бүрэн шилжүүлэх шаардлага байсаар байна аа. Одоогийн байдлаар тендерт оролцогчдын бүрдүүлдэг материалаас зөвхөн 18 хувийг цахим хэлбэрээр төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн сангаас татан авч, тендерийн үнэлгээнд харгалзан үзэж байгаа бол үүнийг 70 хувьд хүртэлх агуулгаар, хүргэх агуулгаар хуулийн төсөлд тусгалаа.

Ингэснээр худалдан авах ажиллагаан дахь хүний оролцоог 60 хүртэл хувиар бууруулна гэж үзэж байна аа. Түүнчлэн тендер шалгаруулалтын үнэлгээнд төрийн байгууллагуудын мэдээллийн салбарын өгөгдлийг ашиглаж, ингэснээр хүний нөөц, машин механизмын чадавх зэрэг бусад иргэн, ААН-ээр нэгжгийн мэдээлэл, өгөгдөл зэргийг хууль бусаар ашиглаж тендерт шалгарч, гэрээ байгуулж буй цүнхний гэх компаниудыг өрсөлдөөнөөс шахан гаргаж, тендер шалгаруулалтад шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

2.Худалдан авах ажиллагааг төлөвлөх шатнаас эхлэн гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлийг хянах хүртэл үе шатыг цахим системээр зохион байгуулна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 2778 захиалагч байгууллагаас 15792 тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж байна.

Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д нийт 16780 хуулийн этгээд бүртгүүлэн тогтмол тендер шалгаруулалтад оролцож байна. Улсын хэмжээнд бүх шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах бөгөөд захиалагч байгууллагын өдөр тутмын хэрэгцээт бараа, ажил, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авах оролцоход

хялбар, богино хугацаанд тендер шалгаруулж, зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхээр зорьж байна. Энэ хүрээнд бүртгэлийн тогтолцоог захиалагч, ААН бараа, үйлчилгээ зэргээр төрөлжүүлж бүрдүүлнэ.

3.Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ ээ. Тендер шалгаруулалтын бүх үе шатыг ил тод болгож, тендерт оролцогчид шалгарсан оролцогчийн ирүүлсэн материал болон тендерийн үнэлгээний үе шаттай танилцах боломжийг олгоно оо.

Мөн иргэд, олон нийт болон эцсийн хэрэглэгч аливаа худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтийн талаар санал, хүсэлт гаргах, санал хүсэлтийн дагуу гэрээний үүргийг хянах эрх зүйн орчныг бий болгоно оо.

Нөгөөтэйгүүр гэрээний мэдээллийн санг ил тод болгож, аль компани ямар ажлыг хийж байгаа тухай гэрээний гүйцэтгэл, санхүүжилтийг олон нийтэд нээлттэй мэдээлэх зохицуулалтыг шинээр тусгалаа.

4.Монгол Улс энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан эх оронч худалдан авалтыг дэмжих зорилтыг хэрэгжүүлэх зохицуулалтуудыг хуулийн заалтад орууллаа. Дотоодын үйлдвэрлэл, ААН-үүдийг дэмжих, одоогийн хуулийн сайн зохицуулалтуудыг бүрэн хадгалж, давуу эрхийн зөрүү тооцох аргачлалыг боловсронгуй болголоо. Мөн дотоодын барааг импортын бараатай өрсөлдүүлэхгүй байх ба зөвхөн Монгол бараа үйлдвэрлэгч хоорондоо өрсөлдөнө. Засгийн газар чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталж, чанартай, стандартад нийцсэн дотоодын барааг цахим дэлгүүрт байршуулж, төрийн байгууллагууд тогтмол нийлүүлэх боломжийг хуулиар бий болголоо.

5.Худалдан авах ажиллагаанд оролцогч болон шийдвэр гаргах этгээдийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтийг тусгалаа.

Сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор захиалагч тендерийн баримт бичиг боловсруулах болон тендерийг үнэлэх ажлын хэсгийг тус тусад нь байгуулах хууль бус шийдвэр гаргасан, захиалагч үнэлгээний хороонд зайлишгүй хариуцлага хүлээлгэх, хариуцлагатай, чанартай компанийг дэмжихийн тулд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, хуурамч материал бүрдүүлэн тендер шалгаруулалтад оролцдог хариуцлагагүй ААН-үүдийг хар жагсаалтад үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн мэдээллээр бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлж байна.

Тендерийн баримт бичигт тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, ингэснээр өрсөлдөөнийг хязгаарлаж, бусдад давуу байдал олгох боломжийг багасгаж, ач холбогдолгүй баримт, материал, ирүүлэхийг тендерт оролцогчдоос шаардлагыг хязгаарлаж зогсоож, зохицуулалтыг бий болгохоор хуулийн төсөлд төсөлд тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын дарга,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцууллаа.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна аа. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөр өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тендер шалгаруулах, хүний оролцоог багасгах, мэдээллийн ил тод байдал, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан тендер шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, гэрээ шууд байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх нь зүйтэй гэж үзэж хуулийн төслүүдийн төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин тендер шалгаруулалттай холбоотой гомдол, маргаан болон шууд гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалт, мөн тендерийн баталгааны нөхцөлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд хуулийн үйлчлэх хүрээ нэг эх үүсвэрээс худалдан авах болон шууд гэрээ байгуулах нөхцөлд хариуцлагын асуудлыг хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Баделхан тендер шалгаруулалтын үнийн дүн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал Улсын нууцад хамаарах үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт болон гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар, 2023 оны төсвийн хуулиар

баталсан сүүлийн 2 жилийн магадлал хийсэн хөрөнгө оруулалтын тендерт хамруулах өөрчлөлтийг тусгасан талаар, гүйцэтгэгчийн болон хариуцагчийн гүйцэтгэсэн ажилд орон нутгийн байгууллагын хяналт тавих боломжийг бүрдүүлсэн эсэх, мөн дотоодын ААН-ийн нэгжүүдэд давуу байдал олгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, тайлагналтын талаар ТӨК-уудын албан тушаалтны сахилга хариуцлага, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх хариуцлагыг тусгасан талаар Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир тендерийн ажлын чанар, үнийн дүнтэй холбоотой асуудлаар тендер цахим болсноор хэдэн компани оролцох оролцоог хянах боломжтой эсэх, мөн тендерийн нэмэлт санхүүжилтийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох талаар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Улсын Их Хурлын гишүүн Баделхан дотоодын ААН нэгжийг хуулиар дэмжихэд онцгой анхаарах, мөн тендерийн хамгийн бага үнийн санал гэдгээр хязгаарласан асуудлыг халж, Монгол Улсад нэвтрээгүй шинэ техник технологийн бүхий ажлыг гадаадын компани гүйцэтгүүлэх асуудлыг хэлэлцүүлгийн шатанд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авч байгаа энэ нөхцөлд хууль бус үйл ажиллагааг хаах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй. Мөн хуулийн өөрчлөлтөөр авлига, албан тушаалын хэргийн ял өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тендерт оролцогч компаниуд болон төрийн албан хаагчдад хууль сурталчлах, мэдээ, мэдээлэл хангалтгүйгээс болж эрсдэл үүсэхээс болгоомжлох. Цаашид хэлэлцүүлгийн шатанд олон нийт, компани, хувийн хэвшлийн ААН-үүдийн саналыг төсөлд тусгах талаар анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно оо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсэг Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Худалдан авах ажилгааны бодлогын хэлтсийн дарга Ганболдын Гийхнаран төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагаа Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Нүрэнзэдгомбын Цэрэнсамбуу.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Товчлоод хэлэх юм бол Тендерийн тухай хууль гэдэг бол татвар төлөгчдийн мөнгийг хэрхэн үр бүтээлтэй зарцуулах вэ л гэдэг л ийм хууль. Тийм учраас энэ хуультай, шинэчилсэн найруулга оруулж ирж байгаатай холбогдуулаад нэг 3 асуулт байгаа юм. Нэгдүгээрт энэ гүйцэтгэлийн баталгаа гаргаад хугацаандаа хийнэ гээд ингээд гэрээ байгуулчихсан хэрнээ олигтой хийж чаддаггүй компаниуд маш их байдаг аа. Маш их байдаг. Тэгээд энэ хүмүүсийг орон нутагт яадаг вэ гэхээр хар жагсаалтад оруулна шүү л гэдэг л юм ярьдаг. Хар жагсаалт руу саналаа явуулдаг, орсон юм байдаггүй. Ингээд дараа дараагийн худалдан авалтад ороод л нөгөө завааруулдаг завааруулаад л, ингээд л явдаг л ийм л зарчимтай байгаад байгаа юм.

Тэгэхээр энийг яг энэ шинэ хууль дээр бүр дорвитой өөрчлөлт оруулаад чадахгүй байгаа том амласан хэрнээ чадахгүй байгаа тэр компаниуд дээр яг ямар хариуцлага тооцох том заалт орсон бэ? Хуучин хууль дээр одоо мөрдөгдөж байгаа хууль дээр ч гэсэн энэ хар жагсаалтын асуудал байдаг хэрнээ тэр ер нь мөрдөгдөхгүй яваад байдаг шүү. Тэгэхээр энэ дээр зүгээр тийм нэг өнгөлөн далдлалт бүхий тийм заалт биш, үнэхээр чаддаг бол чаддагаа хэлээд чадахгүй бол чаддаггүйг нь ялгаад тавьчихдаг ийм л зохицуулалт нэн чухал хэрэгтэй байгаа гэж ингэж харж байгаа юм.

Дараагийнх нь энэ орон нутагт янз янзын компаниуд очоод туслан гүйцэтгэгчээр нэг баахан хувь хүнийг ААН-ийг авчихдаг. Эргээд ингээд нэг юм улсын комисст өгөөд мөнгөө авъя гэхээр мөнгө нь орж ирээгүй гэж хугацаа хожиж байгаад ингээд байхгүй болдог.

Тэгээд эргээд мөнгөө олж чадахгүй хүмүүс тэр ард нь маш их үлддэг ээ. Тэр ААН-үүд, хувь хүмүүс ийм кэйс бол улс орон даяар байгаа. Энэ хуулийг одоо яригдаж эхэлнэ гэх цагаас авхуулаад л

олон хүмүүс над руу энэ хүсэлтээ явуулаад байгаа. Энэ тал дээр онцгой анхаарч өгөөд энийг нь судлаад үзэхээр Улаанбаатарт байгаа ААН орон нутагт очоод юм хийгээд ингээд олон хүнийг хохироогоод буцчихад тэр хүмүүс араас нь гомдол мэдүүлэхийн тулд заавал Улаанбаатар руу ирж, баахан өргөдөл гомдол болгодог. Нөгөө шүүх хурал нь баахан хойшилдог гээд ийм олон хүндрэлүүд байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ нэмэлт энэ дагаж орж ирж байгаа хуулиуд дээр энэ талын зохицуулалтууд би бол бас байхгүй, яг л бахь байдгаараа байх юм байна гэсэн ийм нэг ойлголт байгаад байгаа юм. Энэ дээр нэг хариулт авъя.

Гуравдугаарт нь одоо мөрдөгдөж байгаа хууль дээр шүүд гэрээ байгуулах асуудал байгаа. Бараа, ажил үйлчилгээ бол 30 сая байгаа шиг санаж байна. Энийг бол би тавин сая болгож өгөөч гэдэг хүсэлтээ энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байх үед ч ярьж байсан, албан бичгээр ч хүргүүлсэн. Яагаад энийг 50 сая болгох ийм шаардлага байгаа гэж ингэж үзээд байгаа юм бэ гэхээр энэ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө гээд улсын төсвийн хөрөнгөнөөс 300-гаад тэрбум төгрөг орон нутгууд руу хуваарилагддаг. Энэ 330 сум руу хуваарилагддаг. Энэ хөрөнгүүд чинь ихэнх нь одоо тэр орон нутагт шаардлагатай байгаа зүйлүүдийг хийдэг. Үгүй ээ тэгээд энэ ажлуудыг ингээд нэг 20 саяас дээш давсан ажлуудыг үндсэндээ хэн аваад байна гэвэл цаасны компаниуд л аваад байгаа байхгүй юу. Тэнд хүн байхгүй, тэр битгий хэл хүрз ч байхгүй. Тэгээд л нэг тусгай зөвшөөрөл, нэг ААН гэсэн нэртэй нэг А4-ийн цаастай, тэгээд л нөгөө хорин хэдэн сая төгрөгийн ажил түүгээд л явдаг. Тэгээд яг цагаа тулахаар татвараа төлдөг ч юм уу, үгүй ч юм уу, тэр орон нутагт байгаа залуучуудыг нэг ажиллуулсан болоод цалинг нь өгөхгүй ийм байдалтай л яг орон нутагт байгаад байгаа юм.

Энэ 330 сумын асуудал шүү. Тэгэхээр энийг нэг ядаж 50 сая болгочих юм бол олон залуучууд нэгдээд нягтраад энэ компани болох эх үндсээ тавиад эхнийхээ ажлыг хийгээд урам зориг аваад ингээд явах бас бололцоо байгаа. Яах вэ нөгөө талдаа ах дүү нартаа өгнө гэсэн ийм хардлага бас яваад байдаг юм байна лээ. Эрүүгийн хуулиар тийм байдал үүсгэх юм бол ямархуу өндөр хариуцлага тооцогдох вэ? Ямархуу хатуу болсон гэдгийг та бид бэлхнээ мэдэж байгаа юм. Тэгэхээр би энэ 3 асуудал дээр энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуульд ямар өөрчлөлт орж байгаа вэ гэдэг дээр асууя.

С.Одонтуяа: Идэрбат гишүүний асуултад хэн хариулах уу? Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Зөв асуудал хөндлөө. Энэ хуулиар бид ер нь нэг 5 чиглэлээр томоохон өөрчлөлт оруулж байгаа гэдгийгээ түрүүнд би танилцуулгадаа дурдсан. Тэрний нэг гол хэсэг нь энэ хариуцлагажуулах асуудал юм байгаа юм. Оролцогч талаасаа ч тэр тендер зохион байгуулж байгаа талаасаа ч тэр аль аль талаасаа хариуцлагыг өндөржүүлэх, ил тод болгох, цахим болгох гээд эдгээр асуудлуудыг хуулиар нь маш нарийн зохицуулж өгсөн байгаа. Та яг оролцогч талаас нь хэллээ. Одоо бол хар жагсаалтад оруулах зохицуулалт бол одооны хуульд байгаа. Тэгэхдээ үндсэндээ нэг компанийнх нь нэр нь орж ирдэг. Хар жагсаалтад бүртгүүлэх процесс нь өөрөө захиалагч, төрийн институци, яам орон нутгаасаа бас их хамааралтай байгаа учраас хар жагсаалтад оруулахгүй авч үлдэх дарж нуух ч гэдэг юм уу, энэ дээр бас л хариуцлага тооцно. Ийм заалт нэмэлтээр орж ирж байгаа.

Дээрээс нь хар жагсаалтад орох шаардлага хангасан компанийг зөвхөн компаниар нь биш тухайн үеийн тендер шалгаруулалтад оролцож байх үеийн

гүйцэтгэх захирал болон эцсийн өмчлөгчөөр нь тэр түвшинд нь мэдээллийг нь оруулах эцсийн өмчлөгчийн түвшинд оруулчихаар нэг компани биш, өөр олон компаниуд эзэмшдэг бол эзэмшигчдээрээ дамжаад тэр компаниуд нь ч гэсэн тендерт оролцохгүй байх, оролцох боломжгүй болж байгаа ийм хариуцлагын өндөр түвшинд гарч ирж байгаа. Тэр шууд худалдан авах доод хэмжээг тэр 20 сая байгааг 50 сая болгох нь энэ бол нөгөө хуулиар зохицуулагддаггүй асуудал байгаа. Засгийн газрын тогтоолоор тухайн үед эдийн засгийн объём худалдан авалтын хэмжээ ямар байх нь вэ. Шаардлага ямар байх нь вэ гээд ингээд өөрчлөөд явдаг. Та санаж байгаа байх жилийн өмнө энэ 10 сая байсан шүү дээ.

Арван сая байсныг бид нар 2 дахин нэмээд, ингээд хорин сая болсон. 50 сая бол яг одоохондоо бид нар ингэж өөрчлөлт оруулна. Тэгш бусыг нь бүр 2.5 дахин нэмнэ гэж би хэлж чадамгүй байна. Нэг зүйл судалъя. Энийг бас хэт хавтгайруулах бас их эрсдэлтэй. Энэ 20 сая төгрөг болголоо. Бид нар 1 жил ч нүүр үзээгүй байна энүүгээр яваад. Тэгээд ямар эрсдэл гарах нь вэ манай хэмжээнд болж байна уу, болохгүй байна уу, ёс зүйн хэм хэмжээ маань аль хэмжээнд байна гэдгийгээ бас амьдрал дээр нэг хараадахъя. Тэгж байж болох нь зүйтэй байх.

С.Одонтуяа: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Шууд гэрээг хийхэд эрсдэл байгаа юу гэвэл байгаа. Тэгэхдээ эрсдэл хаана үүсэх вэ гэхээр албан тушаалтнуудаас л үүснэ шүү дээ. Тэгэхээр ер нь бол яах вэ саяын тодруулга дээрээс харж байхад тэр хар жагсаалтад оруулах асуудлууд хэрвээ тэр компанийг буруу шалгаруулсан бол тухайн холбогдох албан тушаалтнууд бол маш өндөр эрүүгийн хариуцлагад орохоор болчихсон. Нөгөө талдаа эцсийн тэр өмчлөгчийг нь тодорхойлно гэдэг бол би сайн зүйл гэж ингэж харж байгаа. Нэг асуулт дутуу явчихсан нь юу вэ гэхээр энэ араас нь гарах

гомдлын асуудал дээр тэр харьяаллын дагуу шүүхэд хандана гэдэг энэ зүйл чинь олон хүний хад мөргүүлж байгаа энэ дагалдах хуулиуд дээрээ энийг оруулаад ирэх бололцоо байна уу?

Дараагийн нэг санал нь юу вэ гэхээр 50 сая болгоход эрсдэл байгаа. Гэхдээ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгүүд энэ 330 сум дээр хэдэн ажил дээр яаж хуваарилагдаад, тэр нь яаж тендер сонгон шалгаруулалт явж байна вэ гэдгийг нэг анализ хийгээд үзэх юм бол бас арай өөр дүр зураг анзаарагдана. 20 сая төгрөгөөс дээшээ гарсан, тэрнээс бага ажил.

С.Одонтуяа: Ажлын хэсгээс хэн хариулах уу? 82 дугаар микрофон. Нэрээ байгууллагатайгаа хэлээд.

З.Энхболд: Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Энхболд. Идэрбат гишүүний туслан гүйцэтгэгчтэй байгуулаад түүн дээр гэрээний асуудлаар маргааныг яах вэ гээд туслан гүйцэтгэгч болон үндсэн гүйцэтгэгч хоорондын байгуулагдаж байгаа гэрээ бол 2 байгууллагын хүсэл зоригоор хийгдэж байгаа цэвэр иргэний эрх зүйн харилцаа учраас энэ зүйлтэй бол хамааралгүй гэж бид хэд үзэж байгаа юм аа. Тийм учраас холбогдох харьяаллын дагуу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийнхаа дагуу явна гэж үзэж байгаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууя.

Д.Өнөрболор: Та бүгдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байна. Байнгын хороон дээр хуулийн энэ хуулийн хэд хэдэн зүйл заалт дээр бас тодруулга авахын тулд бас асуулт тавьсан. Тэр дотроо бол энэ 34 дүгээр зүйл дээр бол бас 3 асуудал

ярьсан юм уул нь. Тэгээд энэ тухайлбал энэ Сангийн яамны энэ хуулийн төсөлд тусгасан яаралтай горимоор шууд гэрээ байгуулах гээд энэ амбицыг Улсын Их Хурлын гишүүд үнэхээр дийлэхгүй юм байна лээ гээд үнэн байдлыг нь би хэлсэн юм.

Тэгээд баахан доромж амссан. Энэ Байнгын хороон дээр хэлэлцэх үед бол ер нь бараг бүх гишүүд л энэ асуудлыг бол тойрч ярьсан даа. Тэгээд энэ зарим гишүүдийн ер нь хэлж байгаагаар яг үүнээс л том хулгай үүсдэг юм байна гэдэг асуудлыг бол ярьж байна лээ. Тэгээд өмнө нь бол миний хувьд бизнесийн салбарт ажиллаж байхдаа бол үнэхээр энэ төрийн тендерт оролцож үзээгүй болохоор би тэр нарийн ширийн энэ процессын үйл ажиллагааг нь үнэхээр мэдэхгүй юм гэтэл Жавхлан сайд бол энэ асуудлыг бол ААН байгууллагуудын энэ хар жагсаалтад оруулна л гэсэн л асуудлыг бол ингээд тайлбарлаад байгаатай бол би бол санал нийлэхгүй байна гэдгийгээ илэрхийлээд байгаа юм.

Яагаад гэхээр энэ худалдан авах, ажиллагаа бол төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах энэ процесс чинь өөрөө нээлттэй биш байна аа. Энэ албан тушаалтны хариуцлагагүй байдлаас болж энэ хулгай луйвар хийгдэж байна. Ард иргэд хохирч байна гэсэн шүүмжлэлийг л байнга хийж байгаа хүмүүс. Тэгэхээр өнөөдөр иргэдийн орлого бас хумигдаж байна. ААН-үүд үүд хаалгаа барьж байна. Тэгэхээр улс орны эдийн засгийг авч яваа сангийн асуудлыг хариуцаж байгаа хүний хувиар бол зөв бодлогоор ААН-үүдээ дэмжих ёстой, ард иргэдийнхээ орлогыг тэтгэх ёстой. Энэ авч явах энэ олон нийтийг тэнцвэртэй мэдээллээр хангах, дүгнэлт гаргах нь бол таны үүрэг гэж бол би бодож байгаа. Үүнтэй холбоотойгоор энэ Эрдэнэс Тавантолгой компанид хийсэн аудитын тайлангаар шаардлагагүй ашиглагддаггүй, маш их өндөр өртөгтэй их хэмжээний үхмэл хөрөнгийг бол авсан байдаг юм байна лээ. Тэгээд энэ компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилт өнөөдөр 34 хувьтай байхад худалдан авсан бараа

ажил үйлчилгээний зардал нь бол 7.5 их наяд төгрөг болсон юм байна лээ. Тэгээд зөвхөн энэ 2 тоог л харьцуулахад бол энэ компани дээр бол маш том эрсдэл үүсчихсэн байсан юм байна лээ. Тэгээд энэ аудитын тайлан бол таныг сайд байх үед бол гарсан. Тэгээд энэ төрийн өмч, сангийн хөрөнгөнд байнга хяналт тавих Сангийн сайд түүний харьяа байгууллагууд болох татвар, гааль зэрэг байгууллагуудын үндсэн үүрэг гэж бол би бодох юм. Тэгээд таны хувьд бол шүгэл хүлээх хангалттай хугацаа байсан боловчиг бол энэ ажлыг бол хийж чадсангүй гэж бол бодож байна.

Энэ ТӨК-удын сахилга хариуцлагыг нэмэгдүүлсэн ер нь ямар зохицуулалтуудыг энэ хуульд тусгасан юм бэ? Олон нийтийн энэ хяналтыг ер нь хэрхэн хангахаар тусгасан байгаа вэ? Энэ талаараа бас тодорхой хариулт авчихмаар байна. Байнгын хороон дээр бол тэгээд нэг шүүх хурлын талаар ярьсаар байгаад л тэгээд дууссан. Энэ хууль дээр бол эх оронч худалдан авалтын талаар бол нэлээн их, бас дурдаж тусгасан гэж тайлбарлаж байх шиг байна. Гэхдээ яг энэ худалдан авалтаар жижиг, дунд үйлдвэрлэгчдээ яаж дэмжиж байгаа талаар бол энэ хууль дээрээс бол харагдахгүй байна. Өнгөрсөн хугацаанд бол жижиг, дунд үйлдвэрлэлийг нийтдээ бараг нэг их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон юм байна лээ. Тэгээд өнөөдөр жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, нийт экспортын 2.4-хөн хувийг эзэлж байгаа нь бол маш чамлалттай тоо бол байгаа. Тэгээд энэ эдийн засаг гэх яг ийм хүнд үед бол энэ жижиг дунд бизнес эрхлэгчдэд бол төрийн захиалгыг авна гэдэг бол тэдний үйл ажиллагаанд бол маш том бодитой дэмжлэг гэж үзэж байна.

Тийм учраас энд чиглэсэн бодлого зохицуулалт ер нь байна уу? Энэ хуулийн төслөөс бол би бас үнэхээр харахгүй байна. Гадаад улс орны туршилагыг ингээд авч үзэхэд бол жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нь худалдан авах, энэ зах зээлийг хөхүүлэн дэмжих.

С.Одонтуяа: Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя.

Энэ шууд гэрээ хийх энэ нөхцөл байдал, үр дагавар бол маш их шүүмжлэл дагуулдаг. Тийм учраас энэ удаагийн хуулийн шинэчилсэн найруулга дээр бид агуулгын хувьд энэ зүйл, энэ бүлэг дээр нь маш том дэвшилт гаргаж байгаа шүү. Бид энэ төрийн болон орон нутгийн өмч бараа материал, үйлчилгээ худалдаж авах энэ хууль маань 2000 онд ажиллаж эхэлснээс хойш 2005 онд нэг удаа шинэчилсэн найруулгаар өөрчлөлт хийгээд, ингээд нийтдээ анх бол 5 шууд гэрээний нөхцөл байсан. Сүүлд нь ингээд өөр бусад салбар хуулиудаар нэмэгдсээр байгаад 11 ийм нөхцөлөөр шууд гэрээ хийгддэг болчихсон байгаа юм одоо ажиллаж байгаа хуулиараа. Тэгвэл салбар хуулиудаас нь хасаад эргүүлээд 11.6 болгож энэ хууль руугаа тодорхой болгож оруулж ирж байгаа гэсэн үг. Шинээр шууд худалдан авах гэрээ тийм нөхцөл бол энэ хуулиар байхгүй, хумьж байгаа гэсэн үг.

Тэр битгий хэл одоо байгаа хууль дээр ингэдэг шүү дээ. Бид нар 2 удаа тендер зарлаад шалгаруулалт байхгүй. Оролцогч байхгүй бол шууд гэрээ хийх нөхцөл үүсдэг. Тэрийг ч хүртэл зогсоож байгаа. Тэгэхгүй бол захиалагч, институт нь өөрөө одоо энэ гэрээ тендер шалгаруулалтыг амжилттай болгох тийм мотиваци байхгүй болчихдог. 2 удаа хийе, дараа нь тэгээд шууд гэрээгээр нэг нь дуудаж авчраад л хийчих юм чинь гээд энэ зохицуулалтыг бүр болиулсан, зогсоосон. Гэх мэт энэ шууд гэрээ хийх зүйлүүдийг хязгаарласан. Нөгөө талаар шууд гэрээний үед бүх юм ил тод цахимаар ингэж явдгийг илүү нарийвчилж зааж оруулсан байгаа.

Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд Өнөрболор гишүүний хэлж байгаа зүйлүүдтэй бол 100 хувь санал нийлж

байна. Тийм ч учраас Засгийн газар энэ компани дээр онцгой төлбөр тогтоосон. Сангийн яамны ТНБД давхар бүрэн эрхт төлөөлөгч хийгээд явж байгаа. Манай Засгийн газрын хувьд ч тэр, манайхаас өмнө ч тэр хэд хэдэн удаа шалгалтууд хийгдсэн. Шалгалтын мөрөөр харамсалтай нь сайн арга хэмжээнүүд авагдаагүй явсаар бид удаа дараа энэ арга хэмжээг авъя гээд сая ингээд 10 сард онцгой төлбөр тогтоож байна. Одоо ингээд энэ байгаа асуудлуудыг гаргаж ирж тавьж байна. Харин эдгээр асуудлуудтай холбоотойгоор бид цаашаа өөрсдийн эдгээр хуулиуд дээрээ нарийн чангалж өгөх, өөрчилж өгөх зүйлүүдийг ээ энэ удаа хууль дээрээ хэдүүлээ ингээд хийгээд явъя. Энэ хууль бол бүх түвшний төрийн байгууллагууд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрууд 50 хувиас дээш. Эдгээр ААН-үүдэд бүрэн хамрагдах ёстой үйлчлэх ёстой ийм хууль болно. Тэр эх оронч худалдан авалтын талаар манай Батзул дарга тодруулаад ярь даа. Бүр заалтуудаа дурдаж байгаад.

С.Одонтуяа: 83 дугаар микрофон.

Ц.Батзул: Өнөрболор гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгийн гишүүн, Төрийн худалдан авах, ажиллагааны газрын дарга Батзул. Эх оронч худалдан авалтын хүрээнд бол одоо байгаа заалтуудыг нь бол бүгдийг нь сайжруулаад оруулсан байгаа. Эхний заалт нь бол Монгол Улсад үйлдвэрлэж байгаа чанар, стандартын барааны жагсаалтыг нь Засгийн газар батална. Уг жагсаалтад багтсан барааг бол зөвхөн дотоодын үйлдвэрлэгчээс нь авна. Хэрвээ энэ жагсаалтад бараг төрийн байгууллагад хэрэгтэй болох юм бол импортын бараа авахгүй байхаар бүр хуульд заасан байгаа. Энэ статистикийг харах юм бол 2018 онд нийт 92.5 тэрбум төгрөгийг дотоодын үйлдвэрлэгчээс авч байсан бол 2021 онд энэ 332 тэрбум төгрөг ингээд жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Жишээ нь бол жанжин штаб бүх

цэргүүдээ бол дотоодод үйлдвэрлэсэн гутал хэрэглэж байгаа. Бүх аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд бол нормын хувцас хангалт хэрэгслүүдээ бол бүгдийг нь дотоодын үйлдвэрлэлээр авч байгаа.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаад хуулийн төсөл дээр одоо мөрдөж байгаа хуульд орсон заалтуудыг нь мөн аваад явж байгаа. Жижиг дунд үйлдвэрлэгчийн үйлдвэрлэж байгаа бараанд бол 15 хувийн нэмэлт давуу эрх олгохоор хуулийн төслийн 8.6-д нь заасан. Харин Монгол Улсад үйлдвэрлэсэн барааны хувьд бол 10 хувийн давуу эрх зөрүү тооцохоор байгаа. Мөн тухайн орон нутагт ажил гүйцэтгэж байгаа ААН-үүдэд бол нэмэлтээр 5 хувийн давуу эрх олгож, тендерийн үнэлгээнд нь тооцохоор хийсвэрээр тооцохоор хуулийн төслийн 8.7-д бол заасан байгаа.

С.Одонтуяа: Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Одоо байгаа хуулиар тендерт оролцогч нар, ялангуяа дотоод, гадаад гэж ялгаад нэг босго дүн тавьчхаад байгаа юм. Үйлчилгээн дээр 100 сая байшин барилга энэ томоохон тендерүүд дээр 10 тэрбум гээд. Тэр 10 тэрбумаас дээш, зөвхөн гадаадын компаниуд орж болно. 10 тэрбумаас доош бол дотоодын компаниуд. Тэгээд бол эдийн засаг чинь нэлээн өсөлтөө дотоодын компанийн хүчин чадал нэмэгдсэн. Энэ босгыг 30 тэрбум болгож байгаа юм. Өөрөөр хэлбэл 34 төгрөг хүртэл дотоодын компаниуд ороод гаднын компаниуд орохгүй үед зах зээлийг нь хамгаалж өгч байгаа юм. Бараа материал үйлчилгээн дээр жишээ нь зуун сая төгрөг гэж байдаг юм. Тэрийг нь 300 сая болгож байгаа юм. Гэх мэт яг дотоодын үйлдвэрлэгч талаасаа тендерт оролцох энэ боломж хязгааруудыг нь нэмж өгч зах зээлийг нь хамгаалсан гэсэн үг. Түрүүн Батзул бас цухас дурдлаа.

Энэ дотоодын үйлдвэрлэлүүдээс бид сүүлийн жилүүдэд маш сайн худалдан авалтууд хийж байгаа. 2018 онд 92 тэрбум, 2019 онд 151 тэрбум 2020 онд 332 тэрбум төгрөгийн худалдан авалтыг дотоодоосоо хийсэн байгаа юм. Түрүүн дурдсан тэр Засгийн газраас батлах тэр жагсаалтад одоогоор 14 бүлгийн 155 нэрийн бараа бүтээгдэхүүн жагсаалтад орсон байгаа. Энэнтэй ижил төрлийн импортын барааны тендер шалгаруулалт хийгээд импортын бараа шалгарсан бол манайхаас тендер нь шууд зогсоож байгаа. Зогсоогоод энэ жагсаалтад батлагдсан ижил төрлийн ийм бараа материал дотооддоо байна аа. Эндээс та нар худалдаж ав гээд ийм зохицуулалтууд одоо орсон байдаг. Энийгээ бол хадгалаад явна.

Нэмж хэлж байгаа юм шүү.

С.Одонтуяа: Одоо Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьшаа: Энэ татвар төлөгчдийн мөнгөөр худалдан авах ажиллагааг явуулдаг. Хөрөнгө оруулалт нэрээр татвар төлөгчдийн мөнгийг завидаг, хулгайлдаг ийм том схем өнөөдрийн гуч гаруй жилийн хугацаанд үйлчилж ирсэн. Энийг засаж залруулахын төлөө үе үеийн Засгийн газар олон зүйлийг ярьдаг гэсэн ч энийг шийдэж чадахгүй ирсэн. Өнөөдрийн энэ хуулиар бас энэ асуудлыг зохицуулах шийдэл гаргалгаа гаргах, нэн ялангуяа цахимжуулах талаар бас шинэчлэлийн зүйл оруулж ирсэнд бас энд бас тодорхой хэмжээгээр эрэл хайгуул хийж, энэ булхай луйврыг энэ төрийн мөнгө төгрөгийг хамгаалах талаар бас анхаарсан гэдэг ийм бодолтой байна. Гэсэн хэдий ч энэ хуулиар зохицуулах шаардлагатай олон зүйлүүд орхигдсон гэсэн ийм бодолтой байна аа. Ялангуяа энэ захиалагчийн эрх, үүргийн талаар энэ тодорхой зүйл алга байна. Энэ захиалагч гэдэг энэ байгууллага сүүлийн жилүүдэд авсан мэдээ, судалгаагаар ямар ч үүрэг хариуцлага хүлээдэггүй.

Жил бүхэн улсын төсөв дээр хөрөнгө мөнгө тавиад тэр барилга, объектыг тухайн гүйцэтгэгч компани ерөөсөө ажлаа хийдэггүй, тухайн ондоо багтсан зүйлээ хийдэггүй. Ингээд л жил бүхэн төсвөө нэмэгдүүлээд л яваад байдаг. Энэ чинь ямар вэ? Энэ талаар ямар зохицуулалт хийсэн. Дээр нь одоо тендер шалгаруулалтад хэд хэдэн компани бэлдчихдэг ийм схем бий болсон. Тэгээд л нөгөө шалгарангуут нөгөө шалгарсан компанийн алдаа дутагдлыг хайгаад л бүхэл бүтэн хуулийн баг ажиллуулдаг. Тэгээд л нэг жижигхэн алдаа олж аваад л нөгөө ялсан компани дээрээ очиж янз бүрийн шантааж хийдэг, мөнгө нэхдэг, тэгээд энэний нь бол нэг 20000000 төгрөг гэдэг ийм доод босго тавьдаг. Тэрнээс илүү мөнгө нэхдэг энэ хүмүүсийн ийм бусармаг үйл ажиллагааг таслан зогсоохын тулд Эрүүгийн хууль, бусад хуульд ямар заалт оруулсан бэ? Энэ талаар асууя.

Дээр нь өнөөдөр энэ үндэсний аюулгүй байдлын асуудал төрийн нууц гэдэг нэрээр өнөөдөр энэ цэрэг, цагдаагийн байгууллагын хөрөнгө оруулалт нууц байна аа. Өнөөдөр хууль шүүхийн өмнө бүгд тэгш байх ёстой. Гэтэл жинхэнэ тэнд чинь өнөөдөр тэр хууль зөрчсөн, чанаргүй аливаа асуудал тэнд явагдаж байна шүү дээ. Энэ хуулиар энийг яаж оруулсан юм. Энэ талаар нэг тодорхой мэдээлэл авъя.

Дээр нь өнөөдөр энэ тендерт шалгарсан компаниуд бичиг баримтаа бүрдүүлээд тодорхой тендер авдаг. Гэтэл энд ажлаа хийдэггүй, туслан гүйцэтгэгч гээд нэг хэдэн хүн бэлдэж авдаг. Орон нутагт ийм юм маш их байгаа. Гэтэл өнөөдөр тэрэнтэй тооцох хариуцлага ч байхгүй. Тэр хар дансанд бүртгэнэ гэдэг чинь худлаа байгаа шүү. Өнөөдөр бол би энийг Ховд аймгийн хэмжээнд энэ сүүлийн авсан судалгаа хийж үзэхэд зөндөө ийм асуудал байна шүү дээ. Тэгээд ямар ч тэрэнтэй тэмцэх юм байхгүй, хариуцлага хүлээх юм байхгүй, худлаа л хар дансанд бүртгэнэ гэдэг ийм юм ярьдаг. Энэ нэг

ажил хэрэг болох талаар энэ хууль санаачлагчид энэ дээр бас тодорхой энэ хууль эрх зүйн хувьд энийг шийдэх ийм гарц гаргалгааг нь тодорхой оруулж өгмөөр байна гэдэг ийм санал хэлье. Тэгээд тэр асуусан асуултад хариулт авъя.

С.Одонтуяа: Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Ер нь баярлалаа. Манай яг хуулийн үзэл баримтлал, агуулгыг л ер нь хэлчихлээ дээ. Хэдүүлээ хэлэлцэх шатандаа ажлын хэсэг байгуулагдаад ингээд явна. Засаж залруулах, нэмж хийх зүйлүүдийг хэдүүлээ ярилцаад явъя. Зуун хувь төгс төгөлдөр болоод явж байна гэж яаж хэлэх вэ? Гэхдээ саяын таны хэлсэн энэ 4 чиглэлээр бол бид тодорхой хэмжээний шинэлэг, бас нэг шийдчих юмсан гэсэн зохицуулалтуудыг бол хийсэн юм шүү. Тэр сунгаад яваад байдаг гэж байна. Тэр бол яг үнэн. Үндсэндээ бараг ингээд нэг төрийн худалдан авах ажиллагааны ийм бараг хонгил үүсчихсэн байхгүй юу. Хонгил үүсчихсэн.

Тэгэхээр төрийн худалдан авах энэ нийт процесс маань ерөөсөө бэлтгэл ажлаасаа эхэлдэг. ТЭЗҮ-ээсээ эхэлнэ. Бэлтгэл ажлаа хийнэ. Магадлангаар оруулна. Тэгээд төсөвтөө тусгана. Тэгээд төсөв батлагдсанаас хойш худалдан авах процесс нь эхэлдэг. Ингээд гэрээ нь хийгдээд гүйцэлтийн шатандаа хяналт тавина. Ингээд ашиглалт гээд ийм урт процесс явдаг. Энэ хууль маань бол төсөв батлагдсанаас хойш сонгон шалгаруулалт хийх, гэрээ хийх тэр хоорондхыг зохицуулж байгаа юм. Таны хэлж байгаа үнэхээр яг тэр хонгил үүсдэг шат нь бол бүр бэлтгэлээсээ эхэлчхээд байгаа юм. ТЭЗҮ нь дутуу. Хуучин зургаар магадлал нь бүр хэдэн жилийн өмнө хийгдчихсэн, ийм зүйлүүдийг төсөвт тусгаж оруулахаас болоод шинэ төсөв шаардлагатай болдог.

Дахиж шинээр тэнд шалгаруулалт хийх болдог гээд ийм зүйлүүд үүсээд

байгаа юм. Харин сүүлийн жилүүдэд бид төсвийн шинэчлэлийн хүрээнд, энийг бас засаж янзлах, зураг төсөвгүй ганц ч төсөл оруулахгүйгээр тусгахгүй байх тал дээр бол онцгой анхаарч ажилласны үр дүнд жишээ нь энэ жил төсөв хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 81 хувьтай гарч байна. Энэ бол өмнө нь байгаагүй ийм өндөр гүйцэтгэлийн тоо хэмжээ. Тийм учраас энэ дээр бол бид нэлээд хэдэн ийм заалтуудыг төсвийн хууль дээр нь ч оруулсан энэ худалдан авалтынхаа ажиллагааны хууль дээрээ ч зохицуулалтууд нь маш сайн орж явж байгаа. Энэ бол өөрөө түрүүн миний хэлдэг тэр 5 бүлэг чиглэл дээрээ ил тод болгох, хариуцлагажуулах бүхий л шатанд нь ингэж орсон байгаа. Тухайлбал тэр цүнхний компаниудыг хэллээ.

Цүнхний компаниудыг одоо бол ер нь маш шахагдаж байгаа шүү, маш шахагдаж байгаа. Жишээ нь тендерт орох гэхээр тендерт орж байгаа компани чинь өөрөө л тусгай зөвшөөрөлтэй байх ёстой, барилгын тусгай зөвшөөрөлтэй, замын тусгай зөвшөөрөлтэй. Тусгай зөвшөөрөл авах процесс маань өөрөө бараг тендерт шалгарахаас өндөр босготой байх ёстой. Тусгай мэргэжлийн өндөр дипломтой өндөр, ийм үнэмлэхтэй тийм юм мэргэжилтэн инженерүүдийг оруулж байгаад тусгай зөвшөөрлөө авчихдаг. Гэтэл тендер шалгаруулалт дээр очихоороо нөгөөдүүл нь солигдчихсон тэр хүмүүс нь тэндээ ажилладаггүй байх жишээтэй.

Одоо энэ хуулиар яаж зохицуулагдаж байгаа вэ гэхээр нэг арай өндөр мэргэжлийн барилгын инженер хүн байлаа гэхэд утсан дээр нь мессеж ирж байгаа юм та ийм дипломтой, ийм мэргэжлийн хүн байна. Таных ийм ийм тендерт та оролцож байгаа юм байна шүү гээд мессежээр нотликэйшин нь ирж байгаа. Зарим үед тэр хүн тэр мессежийг аваад өөрөө тэр тендерт орж байгаагаа мэдэж байх жишээтэй. Одоо жишээ нь барилгын тендерт орж байгаа компаниуд, манай дээр тийм техник эзэмидэг, ийм

тийм мундаг техниктэй л ингээд л бас ордог. Энийг бол манай төрийн мэдээллийн систем дээр бол бид нар 16 эх үүсвэрээс нэгдсэн ийм маш сайн системтэй болж ирсэн байгаа юм.

Тийм учраас энэ дээр бол маш сайн зохицуулалтууд хийж, энэ цүнхний компаниудыг шахах ийм эрх зүйн зохицуулалт бол сайн болсон. Энэ нууц гэж байна. Харамсалтай нь энэ нууц бол төрийн нууцын хуулиар тусдаа ингээд энэ хуулиар зохицуулагдахгүй ингээд явна. Нууцаас гадуур төрийн худалдан авах бүх түвшний ажлыг бид нар энэ хуулиараа зохицуулаад явна. Ажлаа хийдэггүй нөхдүүд дээр хариуцлага тооцно гэхээр цаашдаа ажлаа хийдэггүй компаниудыг шалгаруулах биш. Тийм компаниуд тендер шалгаруулалтад оролцох боломжгүй болгох ийм эрх зүйн зохицуулалт нь бол хамгийн шударга, ил тод, тэгээд ёстой л таны хэлж байгаагаар төрийн мөнгөөр нэг төгрөг болгон байгаа онох ажлаа хийх ёстой гэдэг ийм зарчмаар зохицуулалт хийгдэнэ.

С.Одонтуяа: Батзул Төрийн Худалдан авах ажиллагааны газрын дарга хариулна. 83 дугаар микрофон.

Ц.Батзул: Хуулийн төсөлд бол хариуцлага тооцох зохицуулалтыг 61 дүгээр зүйлд тодорхой заасан байгаа. Бид нарын оруулж ирсэн нэг шинэ зохицуулалт юу вэ гэхээр мөрдөж байгаа хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны хуулиар хариуцлага хүлээнэ гэгчихсэн байдаг. Гэтэл энэ хуулийн дагуу захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж байгаа Төрийн албаны хуулийн үйлчлэлд хамаардаггүй олон албан хаагч нар байдаг. Жишээ нь төрийн өмчит үйлдвэрийн газрууд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хувьд хөдөлмөрийн гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байдаг. Тэгээд төрийн албаны хуулиар нь хариуцлага тооцох гэхээр энэ зохицуулалтад ордоггүй учраас бас хариуцлагын асуудал дээр дутагдал байсныг нь эргэж хараад Хөдөлмөрийн

хуулийг нь мөн нэмж оруулж ирсэн байгаа. Тэгээд гүйцэтгэх захиралтай хийж байгаа ТУЗ-ийн гэрээнд нь бол энийг нь тусгахаар хуулийн зохицуулалтад нь тодорхой зааж өгсөн байгаа.

Нөгөө талдаа бас захиалагчийн гаргах шийдвэрийг нь хугацаатай нь хамт тодорхой зааж өгсөн. Хэрвээ захиалагч өөрөө хуулийн хугацаанд эс үйлдэхүй хийгээд гаргаад, тэгээд хуульд заасан шийдвэрийг хуулийн хугацаанд гаргаагүй бол хариуцлага тооцохоор бас нарийн зохицуулалтуудыг оруулсан байгаа.

С.Одонтуяа: Адьшаа гишүүн тодруулъя 1 минут.

Ш.Адьяа: Энэ төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга байгаа учраас нэг зүйлийг би тодруулчихъя. Энэ Ховд аймагт гэхэд би удаа дараа асуудал тавиад байгаа юм. Тэр нэг сургуулийн барилгын тендер авсан нэг компани ерөөсөө 2 сар шалгарчихаад 11 сард хүртэл ажлаа хийгээгүй. Гэтэл тэр 2, 3 газар тендер аваад одоог хүртэл явж байгаа. Гэтэл энийг сонгон шалгаруулалтыг зарлая гэж танайд өгсөн. Гэтэл шүүх дээр өгсөн ч юм уу, өгөөгүй гэдэг байдлаар өнөөдрийг хүртэл гацааж байгаа. Энэний нэг хариулт авъя. Би энийг олон сайд, дарга нар ч хэлсэн, өөртэй чинь ч утсаар ярьсан. Гэтэл энд ямар сонирхол байна аа? Энэ талаар хариулт авмаар байна.

С.Одонтуяа: 83 Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Батзул.

Ц.Батзул: Адьяа гишүүний асуултад хариулъя.

Анх 2021 оны 12 дугаар сард энэ Боловсрол шинжлэх ухааны сайдын багцаас санхүүжих 160 суудалтай Мөнххайрхан сумын сургуулийн барилгын тендер зарлаад Вива зон гэдэг компани тендерт шалгараад гэрээ байгуулсан байсан. Тэгээд Боловсролын ерөнхий газраас гэрээний үүргээ зөрчсөн гэдэг

асуудлаар 9 сард гэрээг нь цуцалсан. Үүнтэй холбоотойгоор бас шүүхэд маргаан гаргасан талаар бол Захиргааны хэргийн шүүхээс манай газарт бол 12 сарын есний өдөр бол мэдэгдсэн. Гэхдээ шүүхээс бол тендер шалгаруулалтын процессыг нь зогсоохыг даалгаагүй учраас бид дараагийн шатны тендер шалгаруулалтыг нь 11 сарын 10-ны өдөр зарлаад түр хугацаанд завсарлахсан байж байгаад буцаагаад нээгээд энэ 1 сарын 23-ны өдөр тендер хүлээж авахаар бол зарлахсан явж байгаа. Тэгэхээр ямар нэгэн байдлаар бол сонгон шалгаруулалт.

С.Одонтуяа: Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууна.

С.Ганбаатар: Энэ Монголын улс төрчдийн энэ 76-гийн хамгийн гол анхаарах л ёстой асуудал л даа. Энэ хулгай нүүрлэсэн, төрөөс хулгайг нь бууруулахын тулд энэ тендертэй холбоотой энэ хуульд л анхаарах ёстой гэж би ойлгож байна. Тэгээд улсын мөнгөөр барилга байшин барина, сургууль, цэцэрлэг барина, эмнэлэг барина, тоног төхөөрөмж оруулж ирнэ гэж хэлчээд л худлаа байдаг ар нь түүз биш байдаг. Дандаа худлаа ярина. Тэгээд энэ бүр мэргэшичхсэн, би санаж байна. Өмнө нь гишүүн байхад Хан-Уулын нэг эмнэлэг л байнга л яригддаг байсан. Анх 4 тэрбумаар орж ирээд л, дараа нь 7 тэрбум. Сүүлдээ бүр 24 болчихсон явж байсан. Тэгээд бүр барих нь гол биш, зүгээр жил болгон сунгаад л, мөнгө идээд л явж байдаг тийм бүр бүлэг болчихсон юм шиг.

Харин энэ Сарангэрэл сайд, Эрүүл мэндийн сайд байхдаа тэрийг ёстой нэг зүтгэж байгаад нэг оруулчихсан байна лээ. Тэгэхээр иймэрхүү бэрхиээлүүд их байдаг. Энэ хууль дээр бүгд анхаарах ёстой. Миний нэгдүгээр асуулт төслийн 14.3, 42.3.3 хоёр заалт дээр энэ тендерийн ба гүйцэтгэлийн баталгаанд зөвхөн Монгол Улсын даатгалын байгууллага даатгуулах эрх олгосон ийм байгууллага байна гээд заачихсан байгаа. Даатгалтай юм байна. Энэ даатгалын энэ заалт дээр

тендер ингээд авчхаад тооцоо дутуу, гүйцэтгэл чанар муу гээд худлаа үнэн яриад ингээд сунжирдаг энэ муухай юм байхгүй болно гэж би ойлгож болох уу? Даатгалын компани бол арыг нь дааж байгаа гэж ойлгож болох уу? Иншиуренс гэдэг чинь ар нь түүз гэсэн үг шүү дээ. Энэ ярьж байгаа бэрхиээлүүд байхгүй болно гэдэг би энэ дээр хариулт авмаар байна. Өөрөөр хэлбэл тендерт оролцож байгаа компаниуд хариуцлагагүй тэр хар жагсаалт жагсаалд олон жил ярилаа шүү дээ. Хэрэгжихгүй байгаа. Хариуцлагагүй байгаа. Энэ заалтаар хариуцлагатай болох уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, би зарчмын юм ярья.

Ер нь энэ тендер ярихлаар чанар үнэ 2 л ярьдаг л даа. Хамгийн сайн, гайгүй үнэ өгсөн хамгийн сайн чанартай санал өгсөн компанийг л шалгаруулдаг. Яг энэ үзүүлэлтээрээ бол MCS юм уу эсвэл хэдэн олигарх компаниуд л шалгарна. Хамгийн гайгүй үнэ уг нь хамгийн чанартай тэд ажил хийж сурсан. Гэтэл татварын мөнгөөр улсын мөнгөөр ажлын байр бий болгох дөнгөж хөлөө олж ядаж байгаа жижиг, дунд үйлдвэрлэгчийг дэмжинэ гэсэн ойлголт хуульд байдаг шүү. Энэ олон улс дээр ч гэсэн байдаг. Тэгэхээр Америкт бол бүр шинэ бүтээл, оновчтой санал гэдэг компанийг дэмжинэ гэж байгаа шүү дээ? Ай фад анх гарч ирэхэд хамгийн анхны худалдан авалтыг дэлхийгээр тарахаас нь өмнө Америкийн Засгийн газрын мөнгөөр Засгийн газар худалдаж авдаг ийм ойлголтууд байдаг аа? Тэгэхээр жижиг, дунд үйлдвэрлэгчийг дэмжих, энэ зорилгоор салбарын бизнес эрхлэгчдийн төлөөллийн байгууллагуудтай хэлэлцээрт ордог, шалгаруулдаг тийм зүйл заалт энд хүчтэй харагдахгүй байна. Энийг би олон жил ярьж байгаа юм. Тэгэхгүй зүгээр сайд юм уу, эсвэл улс төржссөн дээр тавигдсан нэг дарга нэг компанийг сонгон шалгаруулна гэдэг гоё байж магадгүй. Тэгэхээр тэр төлөөллийн байгууллагуудтай ярьдаг энэ механизм дээр та нар яаж анхаарсан, хэд хэддүгээр

заалтад орсон бэ? Би олигтой хүчтэй заалт олж харахгүй байна.

Гуравдугаарт 14.3, 42.3 дээр энэ дандаа гадаадаас, бид сонгон шалгаруулалт бас их хийдэг гадаадаас тоног төхөөрөмж авдаг, гадаадын даатгалын байгууллагуудыг оруулж ирсэн тохиолдлууд Оросын хууль дээр Казахстаны хууль эрс байдаг юм байна лээ. Ганцхан Монголын гэж яагаад заасан юм бэ?

Дөрөвдүгээрт, тэр эмзэг мэдээлэл гэж 22.5 дээр байх юм. Эмзэг мэдээлэл гэж ер нь юуг хэлээд байгаа юм бэ? Хүний эмзэг мэдээллийг тараахгүй гэсэн нэг ийм үг томъёолол яваад байх юм. Тэгээд би энэ 4 асуулт дээр хариулт авъя.

С.Одонтуяа: 83 Батзул дарга хариуллаа.

Ц.Батзул: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Мөрдөж байгаа хуулийн хүрээнд бол гүйцэтгэлийн баталгааг арилжааны банкны баталгаагаар гаргадаг. Энэ маань сая хавар өөрчлөлт ороод өмнө нь бол нийт төсөвт өртгийг нь 5 хувиар гаргадаг байсныг нь өөрчилж, тухайн онд санхүүжих дүнгийн 3 хувийг гаргах бол ийм зохицуулалтыг оруулж өгсөн байгаа.

Нөгөө талдаа сая 12 сард Их Хурлаар хэлэлцээд энэ гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа, тендерийн баталгааг нь даатгалын баталгаагаар гаргахаар хуулийн төсөлд нэмэлт орсон байгаа.

Тэгэхээр яг таны үзэж байгаагаар гүйцэтгэлийг бол даатгалын баталгаагаар давхар баталгаажуулж байгаа энэ шинэ зохицуулалт бол орсон. Үүнийгээ бол тендертээ хадгалаад, шинэчилсэн найруулгадаа бол хадгалаад явна. Хуулийн төслийн 8 дугаар зүйлд бол энэ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих давуу эрхийн зөрүү тооцох

зохицуулалтуудыг нь оруулсан байгаа. 8.4.4 дээр Инновацын тухай хуулийн 3.1.4-т заасан инновацын бүтээгдэхүүнд бол давуу эрх олгоно гээд мөн жижиг, дунд үйлдвэрлэгч эрхлэгчийн бараанд бол 15 хувийн давуу эрх олгоно гэдгийг нь 8.6 дугаар зүйлд бол заасан байгаа. Мөн зөвхөн Засгийн газраас баталж байгаа жагсаалтад орсон дотоодын бараа байх юм бол энийг нь бол импортын бараатай өрсөлдүүлэхгүй цахим дэлгүүрт оруулна гэж заасан байгаа.

Хуулийн яг үндсэн концепц юу болж байна гэхээр мөрдөж байгаа хуулийн харилцаа маань цаасан суурьтай буюу цаасан харилцаан дээр үндэслэж хийгдсэн байгаа. Энэ үед бол нөгөө тендерт оролцогчдын бүрдүүлдэг материал нь маш их хэмжээгээр байдаг. Одоо бол үндсэндээ бид нар Сангийн яамнаас судалгаа хийгээд нэг тендерт бол дунджаар нэг 200 хуудас цаас скайнердаж тендерт оролцдог, шинэчилсэн найруулгаар бол ер нь төр өөртөө байгаа мэдээллийг ААН эсвэл хуулийн этгээдээр ингээд дамжуулж нэг хүнээс нөгөө газар лавладгаа болиод төр өөрийнхөө байгаа мэдээллийг өөрөөсөө лавладаг болдог. Ийм зохицуулалтыг бол тусгаж хийсэн байгаа. Тэгэхээр та хэдэн онд байгуулагдсан компани вэ гэдгийг нь бол компаниас нь асуугаад байх хэрэггүй. Хуулийн этгээдийн бүртгэлээс асууж байна. Та өмнө нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ямар ямар ажил хийсэн бэ гэдгийг нь нөгөө компаниасаа асуугаад байх хэрэггүй.

Төсвийн хөрөнгө оруулалтын газраас нь нэгдсэн мэдээллийн сангаас нь үзээд тэгээд тэр газрынх нь комисс нь ажиллаад чанартай хийгдсэн юм уу, чанаргүй хийгдсэн юм уу үүнээс хойш ямар асуудал үүссэн юм гэдэг бүх мэдээлэл дээр нь үндэслээд тендерийн үнэлгээ хийнэ гэсэн үндсэн концепцод орж ирсэн байгаа. Тэгэхээр нөгөө энд тэнд очиж давхар ажил эрхэлдэг, эсвэл өөрийнх нь хүчин чадал нь хүрэхгүй байхад нэмж гэрээ авдаг энэ асуудал маань тодорхой хэмжээнд бол цэгцэрнэ гэж үзэж байгаа.

Эмзэг мэдээллийн хувьд бол Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулиар хувь хүний эрүүл мэндийн байдал, хувийн мэдээлэл нь бол нууцад байхаар заасан байгаа. Тэгэхээр тендерт бол тусгайлан хүний энэ эмзэг мэдээлэлтэй холбоотой мэдээллийг бол ашиглахгүй. Зөвхөн тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаа чадавх, нөөц бололцоог нь тогтоох зорилгоор төрийн байгууллагаас мэдээллийг нь лавлана гэж зохицуулсан учраас энийг нь хуулийн төсөлд тусгайлан зааж оруулсан байгаа.

Тэгэхээс биш хувь хүний нууцын тухай хуулиар бол эмзэг мэдээлэл нь угаасаа тухайн хүний зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах нь хориотой байдаг учраас. Энэ хуулийн зохицуулалтын дагуу хуулийн төсөлд бол яг энэ зарчмынхаа дагуу орсон байгаа.

С.Одонтуяа: Ганбаатар гишүүн тодруулъя, 1 минут.

С.Ганбаатар: Давхардаад зарим юм арай дутуу л хариулчхаад байх юм.

Тэр нөгөө тендер авчхаад ингээд луу унжаад төрийг зовоогоод арчаагүйтээд яваад байдаг юм зогсоно гэж би ойлгож болох уу? Энэ комплет зогсоно гэж. Та нарын үг чинь бас чухал шүү дээ. Тэрийгээ хэлчих ээ. Яагаад гэвэл хариуцлагын даатгал гэдэг ийм шинэ зохицуулалт орж ирсэн учраас би бас итгэл төрж байна шүү дээ надад.

Хоёр дугаар асуулт гэвэл тэр жишээ нь Тавантолгой ТУЗ гэж байсан. Бүх сайд дарга нар энэ төрийн нарийнууд байсан. Одоо энэ бэт бүрэн эрхт төлөөлөгч гэсэн тэр ТУЗ-д байсан. Энэ хүмүүс энэ янз бүрийн тендер худалдан авах, энэ төрийн өмчийн энэ янз бүрийн худалдан авах энэ үйл ажиллагаанууд дээр хариуцлага үүрэх үү? Энэ чинь зөв, зүгээр шагналын албан тушаал юм уу? Энэ дээр ер нь надад тодруулж хэлэх болов уу гэж би дотроо бодоод байсан. Бид чинь энэ

улсын мөнгөөр ажил, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ авчхаад хулгай луйвар хийхийг л зогсоох гээд л улс даяараа шалдлаад.

С.Одонтуяа: 83 дугаар микрофон Батзул дарга.

Ц.Батзул: Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулъя.

Түрүүн би нөгөө гүйцэтгэлийн баталгаа биш ээ. Тендерийн баталгааг даатгалын сертификатаар зөвхөн Монгол Улсын даатгал гэдэг энд нь хариулахад дутуу хариулж. Давхар даатгагчийн гэрээ байгуулахыг нь бол тухайн даатгалын байгууллага нь өөрийнхөө хүрээнд бол гэрээ байгуулаад явах нь бол нээлттэй байгаа. Таны хэлж байгаа нөгөө байгуулсан гэрээнийхээ үнийг нэмэгдүүлээд л байдаг асуудал маань үндсэндээ түрүүн Жавхлан сайдын хариулсантай яг адилхан хуучирсан зураг төсөв магадлал хийгдээгүй бүр он удаан жилийн өмнөх төсвөөр хийчихээр л яг ийм асуудал үүсээд. Дунд нь бас зургийн алдаатай байдлаас болоод төсөвт тусгагдаагүй ажлууд нэмж гарч ирдэгтэй холбоотойгоор бас ингэж төсвийн төлөвлөсөн хугацаандаа хийгдэхгүй байх дутагдалтай тал байсныг нь сая Их Хурлаас Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад Төсвийн тухай хуулийн 29.².2-т сүүлийн 2 жилд баталгаажсан. Магадлалаар баталгаажсан төсөвтэй байх төсөл арга хэмжээнд бол мөнгө тавина.

Мөн дээрээс нь Төрийн хяналтын хуулиар нь бас энэнтэй холбоотой.

С.Одонтуяа: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Яах вэ дээ бид нар нэг асуусан болоод л та нар нэг хариулсан болоод л нэг иймэрхүү маягтай л явж байна л даа. Үгүй тэгээд энэ Тендерийн тухай хууль бараа бүтээгдэхүүн худалдан авах энэ хууль чинь хэдэн удаа өөрчлөгдөж байгаа юм бэ? Тэгээд өөрчлөгдөх тусмаа

сайжирч байна уу? муудаж байна уу? Тэрэн дээр дүн шинжилгээ хийсэн юм байна уу? Энэ бол нэг косметик чанартай л өөрчлөлт орж ирж л гэж бодож байна. Тийм нөгөө нэг музейгээ барьдаг Нөгөө л түүх юу билээ хөшөө дурсгалаа барьдаг. Нөгөө бурхны хөшөөгөө мөнгө төгрөг оруулдаг тэгээд орон нутагт бол жижиг нь жижиг, том нь том. Бүгд л хулгай хийж байгаа шүү дээ. Энэ тендер гэдэгт чинь итгэдэг хүн ганц ч байхгүй болчихсон. Үгүй ээ энэ дээр санхүүгийн хяналт шалгалт ордог юм уу? Аудит ордог юм уу? Энэнтэй холбогдуулаад ямар нэгэн хүн шийтгэл хүлээсэн үү, хариуцлага хүлээсэн үү? Хэдэн хүн хариуцлага хүлээсэн, ямар ямар шийтгэл авсан юм. Тэгээд ажил нь яаж сайжирсан юм? Үгүй ээ яах вэ шинэ оны сүүлийн өдрүүдэд бас нэг иймэрхүү юм яриад байх хэцүү л байна л даа.

Тэгээд тэр барьж босгосон юм нь хэрэглэгчдийн сэтгэл ханамж нь ямар байдаг юм. Эцсийн хэрэглэгч нь тэгээд ард түмэн л байгаа шүү дээ. Иргэд л байгаа шүү дээ. Тэр иргэдээс нь татварыг нь авч байгаа. Тэд нарт зориулаад барьж өгч байгаа юм нь тэд нарын шаардлагыг хангасан ийм байдаг уу, тэр сэтгэл ханамжийг нь авсан тэр маань асуудаг уу, хачин хачин л юм барьчихсан. Тэгээд их л баяжсан улсууд байдаг шүү дээ. Сүүлийн 5, 6 жил бол 9911 утас, Ланд круйзер 300 машин бол буунгуутаа л үнэд ороод л бүгд л худалдаж авч байгаа шүү дээ. Дандаа л МАН-ын угшилтай том жижиг дарга нар бүгдээрээ л авдаг. Нүдэн дээр л ингээд л голийгоод байдаг. Тэгээд ард түмний амьдрал улам л хүнд хэцүү болж байдаг. Ийм л байгаа шүү дээ. Та нарт тийм хүсэл зориг байгаа юм уу? Энэ ажлыг сайжруулах төрийн оролцоотой энэ юм чинь Монгол Улсын эдийн засгийн 40, 60 хувийг эзэлчихлээ. Нэг иймэрхүү маягаар яваад байвал наадах чинь ямар ч үр дүн гарахгүй ээ. Сангийн сайдаа, Засгийн газраа наадахаа уг угшлаар нь сайжруул. Муу нэртэй, луу данстай АН байхад наадах чинь 28, 29, 30 хувийн төр мэддэг барьдаг байсан юм. Тэрийг нь багасгадаг

байсан юм. Хаашаа яваад байгаа юм та нар.

Тэр Хойд Солонгосыг байгуулах гээд байгаа юм уу? Юугаа байгуулах гээд байгаа юм. Үнэхээр хэцүү байна шүү дээ. Энэ ард түмэн чинь. Одоо та нарын барьж байгаа, босгож байгаа юманд итгэдгээ байчихсан. Тэр нефтийн үйлдвэр чинь яасан, хаана байгаа юм. Бүтнэ босгоно бүтээнэ гээд байсан. Тэгээд Тавантолгой чинь бөөн л өөр л байгаа шүү дээ. Ер нь ямар ямар хүн шийтгүүлсэн юм бэ? Хариуцлага ярихгүйгээр энэ юм чинь сайжрахгүй шүү дээ. Тэгсэн мөртөө төр дээрээ баахан мөнгө овоолоод татвар төлөгчөө цуглуулаад олигтой компаниуд наана чинь орох ч үгүй. Та нарын хэдэн компаниуд ордог. Тэр концессын гэрээ гэж байсан Концессын хууль гэж байсан. Нэрийг нь өөрчлөөд л төр хувийн хэвшлийн түншилэл гээд л тэрүүгээр баахан мөнгө цохисон шүү дээ, дээгүүрээ. Нэг иймэрхүү маягтай л нэг косметик чанартай өөрчлөлт оруулж ирээд л ингээд байгаа та нар.

Одоо наадахад чинь итгэдэг, барьдаг хүн байхгүй ээ. Хэдэн хүн шийтгүүлсэн юм. Ямар хариуцлага үүрсэн юм? Санхүүгийн хяналт, шалгалт гэж ордог юм уу? Аудитын дүгнэлт гэж байна уу? Орон нутагт бол нөгөө ялдаг хэдэн компаниуд л ялдаг. Хэдэн дарга нарын. Тэгээд МАН нь тэрнээс нь татвар авдаг юм гэсэн. Тэгээд юу ч дуугарч чаддаггүй. АТГ бол тэрэн дээр бол ажилладаггүй.

С.Одонтуяа: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Ийм ерөнхий хуулийн үзэл баримтлалтай холбоотой асуулт асуулаа. Энэ хуулийн орчин ер нь 2000 оноос бид ийм эрх зүйн зохицуулалттай болсон. Үүнээс хойш 2005 онд нэг удаа шинэчилсэн найруулга ороод, тэрнээс хойш үндсэндээ 17 жилийн дараа өнөөдөр анх удаа 70 хувь

дээр нь өөрчлөлт орж байгаа шинэчилсэн найруулга орж байна гэсэн үг. Таны ярьж байгаа энэ тендер худалдан авах үйл ажиллагааны гарсан зөрчил муу үр дагавар бид нар хойшдоо анхаарах зүйлүүдтэй санал нийлж байна уу?

Нийлж байна. Үнэхээр нийлж байна. Харин энийг цаашид засаж янзлах төрийн төсвийн нэг төгрөг болгон төрийн үйлчилгээг илүү чанартай үзүүлдэг, төсвийн хөрөнгө оруулалтыг илүү чанартай, үр өгөөжтэй байлгах тал дээр л бид нар зорилт тавьж ингэж ажиллаж байгаа. Та сая тэр музейн эд нар гээд ярилаа. Энэ хууль маань бол музей барих уу, үгүй юу гэдгийг шийддэг хууль бол биш. Музей барих эсэхийг бол бид нар Төсвийн хуулиараа шийднэ нэгэнт Төсвийн хууль батлагдаад жагсаалт гарсан хойно тэрийг чанартай, ил тод, шударга ийм худалдан авалт хийх тэр процессыг энэ хуулиар зохицуулдаг ийм байгаа юм.

Тэгэхээр 17 жил шинэчилсэн найруулга хийгдээгүй хууль дээр бол бид маш хатуу дорвитой бөгөөд цаашидаа их дунд, урт хугацаанд олон жилийн настай, сайн үр дагавартай байх ийм хуулийг л бид нар батлах ёстой ийм хариуцлагатай цаг үе мөн юм аа. Та нэгэнт их ерөнхий агуулгаар үзэл баримтлал дээр нь орж ирж байгаа учраас ер нь таныг бас би энэ ажлын хэсэгт нь орж ажиллаасай гэж хүсэж байна. Таны нүдээр харах нэг өөр бид нарын нүдээр харах бас нэг өөр. Ингээд хамтраад ажиллацгаая л гэж уриалж байна.

С.Одонтуяа: Тэр хариуцлага хүн хүлээсэн юм уу, энэ тендерийн будилаанууд дээр ер нь хэн хэзээ хариуцлага хүлээсэн юм бэ гээд асуугаад байсан юм бэ гэж асуугаад байсан.

Б.Жавхлан: Энэ хууль маань өөрөө бол энэ Эрүүгийн байцаан шийтгэх хууль биш шүү дээ. Энүүгээр бол хуулиар шийтгэл хүлээлгэдэггүй. Энэ дээр бол хариуцлага тооцох захиргааны бид нар хязгаарлалтууд авна. Захиргааны арга

хэмжээнүүд авна. Тендер дахиж орохгүй байх. Тэнд орохыг нь оролцохыг нь зогсоох, оролцож байх шатанд нь хасах, хар жагсаалтад оруулах гээд. Тууль шүүхийн байгууллага руу шилжүүлэх асуудлууд бол байлгүй яах вэ. Тэр нь Эрүүгийн хуулиараа тусдаа ингээд шийдэгдээд явдаг. Энэ дээр би нэг юу билээ статистик хэлье. Жилдээ бид ингээд төрийн болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүд, төсвийн хуулиа нийтдээ нэг 22000 ийм худалдан авах ажиллагаа хийж байна. Гэрээ байгуулагдаж байгаа юм. 2018 онд үүнтэй холбоотой 21 хувь дээр нь маргаан гардаг байсан. 2018 онд хэдхэн жилийн өмнө 4 жилийн өмнө. 2022 онд 3 хувь болсон. 3 хувь болтлоо буурсан гэсэн үг.

Өөрөөр хэлбэл, тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагаа маань бас илүү чанартай явж ирж байна гэсэн үг. Хариуцлагатай болж ирж байна гэсэн үг. Эндээс нэг хүрэхгүй хувь нь шүүхийн шат руугаа очиж байгаа. Тендерт холбоотойгоор ийм статистик хэлье. Энхболд дарга хэлээдэх, яг тендертэй холбоотой, ялангуяа захиалагч талаасаа шүү, төрийн оролцоо талаасаа төрийг төлөөлж оролцож байгаа улсуудаас сахилга хариуцлага ялангуяа шүүхээр эрүүгийн хариуцлага хүлээсэн хэдэн тийм тоо байна вэ? Тэрийг хэлээдэх.

С.Одонтуяа: Хэн хариулах юм. Юугаа өргөдөө 82 дугаар микрофон.

3.Энхболд: Тендерийн хуулийг зөрчсөн талаар бол АТГ-аас бол Сангийн яаманд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тайлбар, зөвлөмжийг бол Сангийн яам гаргаж өгч ажилладаг тодорхой эрүүгийн хэрэг дээр. Яг хэчнээн тэр тухайн эрүүгийн хэрэг дээр шалгагдаад шүүхээр хэчнээн хүн ял шийтгэл авсан асуудлыг бол танд АТГ болон шүүхийн судалгаанаас авч байгаад танд жич хариу мэдэгдье ээ.

С.Одонтуяа: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тэгээд хууль өргөн бариад хууль хэлэлцээд явж байхад нэг иймэрхүү л байна шүү дээ. Тэр ул сууриар нь яриа гээд би та нарт хэлээд байна шүү дээ. Хэдэн хүн шийтгүүлсэн юм. Ямар байсан юм. Юун дээр нь анхаарах ёстой юм. Тэрийгээ мэдэхгүй байж байж л дээ. Тэндээс асуу эндээс асууя гээд энд цоорхой шанага шиг байгаа татвар төлөгчдийн мөнгийг улсын мөнгийг ингээж урсаж байгаа юмыг хаах, боох хүсэл ерөөсөө үнэхээр байхгүй юм.

Тендерт байнга шалгардаг хэдэн компаниуд л байдаг шүү дээ. Хөдөө орон нутагт бол бүгдээрээ л бие биеэ мэднэ шүү дээ. Миний ярьж байгаа ч гэсэн бүгд сонсоод сууж байгаа байх. Тэгээд инээд нь хүрч байгаа байх. Та нарын ярьж байгааг сонсоод, тэгэхээр ийм судалгаагүй ийм цаанаасаа системтэй хийгээгүй ийм хуулиа тэгээд л ингээд баталчихдаг энэ хууль нь ингээд гарчихлаа. Тэгэхээр сайн сайхан болёо гээд горьдоод байх юм юу ч алга шүү дээ. Энэ дээрээ анхаармаар байна шүү энэ ажлын хэсэгт байж байгаа хүн юу мэдэж байна? Яаж байна.

С.Одонтуяа: Дараагийн асуулт асуух гишүүн байхгүй байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх дэмжсэн 3 хүртэл дэмжээгүй 3 гишүүнийг бүртгэе. Ганбат гишүүнээр тасаллаа. Нанзадын Наранбаатар гишүүн үг хэлнэ.

Н.Наранбаатар: Тендерийн хуулийг бол ер нь шинэчлэх цаг нь бол болсон л доо. Өнгөрсөн хугацаанд бас л зөндөө л алдаатай оноотой асуудлууд гарсан. Чанаргүй олон ажлууд хийгдсэн. Хугацаандаа дуусаагүй өнөөдрийг хүртэл ингээд сунжраад явж байгаа. Цаашиа хэзээ дуусах нь мэдэгдэхгүй асуудал гарсан олон хүмүүс бас тендер шалгаруулалттай холбоотой. Хууль хяналтын байгууллага руу шилжсэн, төсвийн мөнгө үр ашиггүй зарцуулагдсан гээд олон асуудлууд байгаа.

Тийм учраас энэ дээр харин хуулийг шинэчилсэн найруулгаа хийхдээ нэлээн бас судалгаа ялангуяа энэ орон нутагт энэ худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа улсууд. Энэ төрийн албан хаагчид ийм хүмүүсээс нэлээн сайн хэлэлцүүлэг хийж, саналыг нь сайн авч байж энийгээ амьдралд нийцсэн юм хийхгүй бол болохгүй шүү. Энэ тендер орон нутгийн өмчөөр тендер шалгаруулж ч бараа ажил үйлчилгээ авч байгаа энэ үйл ажиллагаанд бол хэд хэдэн бас гажуудлууд өнгөрсөн хугацаанд гарсан.

Тухайлах юм бол энэ цүнхний компаниуд ингээд тендерийн ажил аваад хийхгүй. Би чадна гээд доороо туслан гүйцэтгэгч аваад тэр нь ажлыг нь ингээд алдуулдаг. Өөрөө ажил хийдэггүй хүн ч байхгүй, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж байхгүй ийм асуудлууд маш их гардаг. Мөн шууд гэрээ байгуулах заалтыг ашиглаж аваад ингээд шууд гэрээ рүү оруулаад үүнээсээ болоод чадваргүй компаниуд шалгаруулах ийм асуудлууд маш их гардаг.

Мөн гүйцэтгэлийн баталгааг сайн хийж өгөөгүйгээс болоод энэ тендерийн ажил дууссаны дараа жил болохгүй, чанар байдал нь танигдаж, борооны ус гоожихоос авхуулаад ингээд чанаргүй ажлууд их хийгддэг учраас энэ дээрээ маш сайн анхаарч чанаргүй ажил хийгдсэн бол эргээд тэр хөрөнгөөс нь засуулдаг, тэр компанид нь хариуцлага тооцдог, эргээд чанартай хийлгэдэг, ийм бай зүйлүүдийг бас нарийн тусгаж өгөх шаардлагатай. Мөн жил бүхэн хийгддэг зам засварын болон бусад орон нутгийн байнгын хийгддэг ажлууд дээр бас энэ тендер шалгаруулалтыг бас зөв зохион байгуулж бас тогтвортой чадвартай компаниар нь цаашид ажлыг нь хийлгэдэг байх бас зохицуулалт хэрэгтэй. Маргаан гаргадаг асуудал тендерт ялагдсан компани маргаан гаргаад ингээд хугацаа алдуулаад ингээд хамаг ажил гацаадаг, үнийг нь өсгөдөг ийм зохисгүй асуудлууд гарч ирдэг.

Хар жагсаалтад бүртгэхгүй бол аймаг, аймаг, сум, суманд очоод ингээд ажил аваад хийхгүй ажил ингээд хаяад яваад байдаг ийм бас зохисгүй асуудлууд байдаг. Мөн одоо энэ төрийн үйлчилгээ цахимжисан мэдээллийн бааз дата харьцангуй сайтай болчихсон нөхцөлд бол энэ тендерийг зарлах хугацаа, шалгаруулах хугацаа энэ бүх зүйлүүдээ бас эргээж харж аль болохоор богинохон хугацаанд чанартай, тухайн жилд нь багтааж энэ ажлыг хийлгэж дуусгадаг байх дээр бас анхаарах шаардлагатай. Мөн энэ үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, эх оронч худалдан авалтыг дэмжих тал дээр дорвитой бус зүйлүүдийг тусгаж өгөх хэрэгтэй. Бас нөгөө талаар тодорхой нэг үйлдвэрлэгчээс чанартай бараа бүтээгдэхүүнийг дунд нь ямар нэгэн үнийн өсөлт хийлгүйгээр ченж зуучлагч оруулалгүйгээр үйлдвэрээс нь ийм худалдан авалтыг хийх ийм боломжийг бас нээж өгөх шаардлагатай байгаа нь бас амьдрал дээрээ харагддаг. Мөн энэ ТӨК-уудын энэ тендер худалдан авалтыг өөрсдөө бас зохион байгуулаад байгаа юм.

Тийм учраас энэ ТӨК-уудын худалдан авалтыг бол энэ худалдан авах ажиллагааны газраар дамжуулж зохион байгуулдаг ийм хэлбэр рүү бас орох нь зүйтэй. Ингээгүйгээс болоод л маш олон асуудлууд гараад ингээд явж байгаа нь бол харагддаг аа.

Тэгэхээр цаашидаа бол та бүхэн энэ зүйлүүд дээрээ бас нэлээн анхаарч аль болохоор энэ төсвийн хөрөнгө, татвар төлөгчдийн хөрөнгийг бол зөв зохистой, чанартай, үр ашигтай зарцуулах дээр энэ хуулиа хэлэлцүүлгийн шатандаа нэлээд анхаарч тооцоо судалгаа амьдрал дээр бий болдог бодит туршилагыг бас нэлээн сайн үзэж, энэ хуулиа бол цаашид улам боловсронгуй болгох шаардлагатай гэсэн санал хэлье. Ингээд хэлэлцэх эсэхийг бол дэмжиж байна.

С.Одонтуяа: Дэмжиж үг хэллээ. Одоо Буланы Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа нь өөрчлөх цаг нь ч болсон. Тэгэхдээ учир дутагдалтай юм их байна. Энэ төрийн худалдан авах ажиллагааны агентлагууд одоо муу ажилласны улмаас 2023 оны бүтээн байгуулалтын төсвийг урьд жилүүдийн дуусгаагүй ажлыг дуусахад ингээд тавьсан. Энэний цаана бас тухайн салбарт ажиллаж байгаа улсуудын хариуцлага, хяналт сул бай харуулж байгаа л даа. Жишээлбэл Баян-Өлгий аймагт барилга цэцэрлэг, сургууль, эмнэлэг барьж байгаа юмнаас болоод Хотгор багийн эмнэлэг татан буугдсан. Бас дутуу барьчхаад нэг компани ингээд алга болсон. Энэ гол нь аймгийн ИТХ аль эсвэл намын харьяаллын дагуу ингээд тендер олгодог. Нөгөөдүүл нь чанаргүй, юм хийдэг, дутуу ингээд үлдээгээд явдаг. Нэг компани түрүүн Адышаа гишүүний ярьдгаар олон тендер авдаг, гүйцэтгэж чаддаггүй ийм юм байж байгаа л даа.

Ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбар дээр нодлин би багш нар 9 сургуульд компьютер, канон ухаалаг самбар тавьсан. Ухаалаг самбарыг нь өгөөгүй. Мөн аймгууд төвд бас ингээд юунууд тавьсан эмнэлэг өрхийн эмнэлгүүд дээр. Мөн адилхан юм дутагдалтай тавьсан. Аль эсвэл чанаргүй юм аваачаад чихдэг. Эрүүл мэнд, Боловсролын яамныхан энд авч үзэж байгаа. Яамны хэмжээний чанартай юм нийлүүлэхгүй бол нөгөө ИТХ-аар ингээд шагналаар авсан юун дээр тендер дээр нь тогложоод байна. Энэ дээр та бүгд 1 онцгой анхаарахгүй юу. Би энэ агентлагийн даргад очоод энэ энийг хот руу авч үзээрэй гээд бас саналаа хэлсэн байсан. Гэтэл сая очоод үзсэн чинь нөгөө 3, 4 хэмнэлт тавьсан тоног төхөөрөмжийг нь нэг б сар урвалж бодистой нь гэсэн. Урвалж бодис байхгүй хоосон аппаратууд байж байх юм. Энийг бас хамтдаа шийдээд сургалтын асуудлыг хамтдаа шийдээд бүрэн боломж байгаа л даа тендер авсан компаниуд. Энэ дээр ялангуяа онцгой анхаараад ажиллахгүй бол болохгүй байна. Аймгийн худалдан авах ажиллагаан

дээр аймгийн тэр орлогч дарга нь хариуцдаг, тэгээд л юмаа чихдэг.

Өөрийнхөө хамаарал бүхий этгээдээр тендер авдаг ийм ноцтой асуудал гарч байгаа. Энэ дээр танайх агентлагийн зүгээс хяналт шалгалт хийхгүй бол цаана чинь улсын төлөө ажиллаж байгаа ер нь албан хаагч бол цөөхөн байна шүү. Үүний цаана авлига бага гэж ойлгож байгаа ерөөсөө. Тийм учраас энэ дээр нэг анхаарч ажиллах нь зөв байх гэж бодож байна. Нөгөө талаар Жавхаа сайдаа одоо энэ худалдан авах ажиллагаан дээр энэ жил зарим сумд 3, 4 жил машингүй явж байна Засаг дарга нар нь. Одоо зудтай сумууд дээр чинь унаа өгөхгүй бол тэгээд төрийг бас хүчгүйдүүлж байна. Энэ Засаг дарга унаагүй, байнга унаа гуйж явдаг гэдэг ийм асуудал байж байна. Энэ дээр та нэг анхаарч ажиллаад нэг алслагдсан тэр Булган сум цастай байна. Алтай сум байна. Цэнгэл сум байна. Цас зудтай сумд. Энэ ногоон нуур сум байна. Энэ дээр нэг анхаарч ажиллаад худалдан авах ажиллагаан дээр нь бас Сангийн сайд нь бол хяналт тавьж ажиллахыг би танаас хүсэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: 2 гишүүн дэмжлээ. Одоо Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Ер нь бол учир дутагдалтай байгаа юм аа. Энэ хуулиа бол нэлээн тийм судалгаан дээр бас тооцоон дээр л оруулж ирмээр байгаа юм л даа. Тэгээд дутуу дулимаг юм хийчхээд л тэгээд болж байна, бүтэж байна гээд явахаар хийхгүй байснаасаа л дор юм болчхож байгаа байхгүй юу. Бусад хуулиудтайгаа уялдаад улс орныхоо нөхцөл байдалтай уялдуулаад ингээд явах ёстой. Тухайлбал татвар төлөгчдийн мөнгөөр авсан зүгээр жирийн нэг жишээ татъя л даа би. Багш нарт компьютер авч өгч байна аа. Улс орон даяар нөт бүүк зөөврийн нөт бүүк тарааж өгч байх шиг

байна. Үгүй ээ ямар муу компьютер авчихсан юм бэ тэрийг нь. Ямар үнэтэй юм бэ? Тэгээд багш нарт тараагаад яваад байх юм. Хувиасаа өгч байгаа юм шиг. Энэ Улсын Их Хурлын гишүүд нь ч бай, орон нутагт байгаа удирдлага дарга нар ч бай. Яах вэ дээ хөдөө орон нутгийн зарим нэг хүн бол тийм байна, ийм байна их ажил хийж байна гээд л хууртдаг л байх. Үгүй шүү дээ энэ чинь тийм биш л байгаа байхгүй юу? Үгүй ээ тэр мөнгийг нь багш нарт нь өгч л дөө.

Тэр хүн өөрөө ямар компьютер худалдаж авахаа өөрөө мэдэгч дээ. Чадна шүү дээ тийм ямар хэрэгцээтэй байдаг юм. Ямар компьютер авдаг юм. Хэд дахин хямд хүн компьютер авчхаж чадна. Эсвэл тэр мөнгөөр маш сайн компьютерыг олоод авчхаж чадна. Нэг иймэрхүү багш нартаа итгэдэггүй, иргэддээ итгэдэггүй, дундаас нь цавчаа хийсэн ийм ажлуудыг л хийгээд байх юм. Энэ дээрээ бас анхаармаар байна. Нөгөө талаар энэ тендер юу ч биш ээ. Тэр концесс, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа гээд л. Зарим нь бол тендерт хэн ч ордоггүй гээд л нууцалж байгаад л баахан гэрээ авчихсан. Тэр хулгай нь дуусаагүй, бараг би буяны ажил хийчихсэн гээд л явж байна шүү дээ. Харин нөгөө талаараа нэг их туйлширалгүй бас тухайн орон нутгийн удирдлага нь Засаг дарга нь бараг шууд гэрээ хийж байвал зүгээр байх. Тэгвэл эзэнтэй юм. Хэн нь авсан юм, хэн нь өгсөн юм. Тэр нь ажил нь ямар байсан юм түрүүн би нэлээн хэдэн асуулт асуулаа л даа. Тэгэхэд хариулж байгаа хүн ерөөсөө алга. Тэр санхүүгийн шалгалт ордог юм уу, хэчнээн хүн ял шийтгэл хүлээсэн юм. ямар хариуцлага тооцсон юм.

Энэ хуулиараа ямар болох юм гэх мэтчилэнгийн асуултууд асуугаад байхад л бол ерөөсөө хариулт өгөхгүй юм. Нэг иймэрхүү маягтай бид нар Улсын Их Хурлын цаг хугацааг үрссэн ийм л ажил хийгээд яваад байна л даа гэж би бодох юм. Тэгээд энэ тендер итгэдэг хүн байхгүй болчихсон шүү дээ. Тендер шалгаруулалтын нэр хүнд бол үнэхээр

унасан. Эсвэл нэг чанаргүй юм шахдаг эсвэл дандаа тэр МАН-ын дарга нарын компаниуд ялж байдаг. Эсвэл орон нутагтаа нөгөөдөх нь намдаа нэг хэдэн төгрөг өгдөг. Тэгээд ял зэмээс мултарч байдаг. АТГ нь бол авлига аваад баригдчихлаа. Яасан авлига өгөөд л мултарчихлаа л гэсэн, иймэрхүү байдалтай л юманд хандаж байгаа шүү дээ. Энэ юмыг хагархай цоорхойг бүрэн хаасан, ийм хууль хийж чадахгүй л бол бараг хийснээсээ хийгээгүй нь дээрдээ. Улаар наад юмаа шийдээч ээ. Ард түмэн олных болчихоод байдаг. Бид нарын хийж байгаа ажил ард түмнийг улам л олных болгох юм яриад байна. Тэгээд хариулт байхгүй. Асуултад хариулдаггүй. Бүрэн гүйцэд мэдээлэл өгдөггүй.

Ийм байхаар чинь энэ юм чинь яаж авах юм бэ. Ямар тендер сайхан болоод юу болсон юм өнөөдөр. Бараг л тэрэг хийх гэж байгаад модон тэрэг хийх гэж байгаад сүүлд нь нэг шүдний чигчлээс шиг юм болоод л дуусдаг шүү дээ. Ер нь тендер шалгаруулалт бол тийм болоод л дуусдаг. Тэгж явдаг санхүүгийн хяналт шалгалт гэж алга. Аудит оруулж байгаа юм алга. Ийм юмнуудаа хийхгүй байж хэн хариуцлага хүлээх нь алга. Тендер шалгаруулж байгаад ингээд комисс томилчихдог. Тэр комисс нь нийтэд нь ял заагаад л, хууль нь ийм чинь би хуульд нь тохируулаад л хийсэн шүү дээ. Тэгээд мултраад гараад явчихдаг, эзэн биегүй ийм үл үлдэж байгаа байхгүй юу? Үгүй ээ үгүй эзэн биегүй ч гэж дээ. Энэ төрийн мөнгө, татвар төлөгчийн мөнгө бол энэ хэдэн дарга нарын л мөнгө болчихсон. Аль болохоор өөр дээрээ их овоолно, тэр тусмаа тэгж баяжна, үндэслэлгүйгээр. Тэгээд одоо тэр хөнгөвчилсөн нөхцөлөөр эрүүгийн хэрэг шийдлийг нь байхгүй болгочихсон. Ямар ч авлига гарч ирэхгүй, цаашдаа бол.

С.Одонтуяа: Ширнэнбандийн Адьшаа гишүүн үг хэлнэ.

Ш.Адьяа: Энэ хуулийн төслийг бол ер нь зарчмын хувьд дэмжиж байгаа.

тэгэхдээ энийг бол маш сайн хэлэлцэх хэрэгтэй. Энэ сүүлийн жилүүдэд 30 жилд энэ татвар төлөгчдийн мөнгөөр бизнес хийдэг, мөнгө угаадаг ийм хэрэгсэл болсон энэ нүүрсний хулгайтай чинь тэмцэх хэмжээний асуудал бол өнөөдрийн энэ төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах энэ тендер шалгаруулалт байгаа. Энд бас Сангийн яам бас зоригтой бас зарчимч байр суурь илэрхийлж, бас тодорхой шийдэл гаргахын төлөө зорьж байгаа нь сайн хэрэг ээ, сайн хэрэг. Өнөөдөр энэ булхай луйвартай тэмцье. Хулгайчтай тэмцье, ил тод болгоё, сахилга хариуцлагыг дээшлүүлье гэж байгаа энэ цаг үед бас ийм зүйл хийсэн нь бас энэ сайн хэрэг гэж хэлэх ёстой гэж үзэж байгаа юм.

Гэхдээ өнөөдөр энэ хуулийн төслөөр бол зарим асуудлыг шийдэх шийдэл тодорхой бус байна. Энэ тендер шалгаруулалтын үед хэд хэдэн компани нийлж аваад бүр тодорхой хуульчдаа, тодорхой бүр тийм хэрэг эрхлэх албатай ингэж оролцож байгаа. Тэгээд ингээд заргалдах системийг бий болгодог. Эхлээд Сангийн яаманд заргалддаг, дараа нь шүүх заргалддаг, тэгээд шүүх нь бол хүлээж авдаг. Хүлээж аваад 2, 3 шатны шүүх дамждаг. Эхлээд энэ 2, 3 сар хүлээлгэдэг нотлох баримт цуглуулж байна гээд тэгээд дараа нь нэг шийдвэр гардаг. Давж заалддаг давж заалдахын шатны шүүх, Хяналтын шатны шүүх гэсээр байтал 6, 7 сар болдог энэнээс үүссэн хариуцлагыг яах юм.

Энийг тодорхой болгочих ёстой. Төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ гэдэг чинь тухайн жилд төрийн бодлогыг хэрэгжүүлэх энэ төрийн ажил чинь гацаадаг аа. Энэ гацааснаас гарах үр дагаврыг энэ хуулиар тодорхой болгож өгье. Тэр Эрүүгийн хуульд оруулъя, Зөрчлийн хуульд оруулъя. Тэгээд одоо нэг 20 сая төгрөгийн ийм дэнчин тавиад л, тэгээд ялагдсан ч 20 сая төгрөгөө алдах юмгүй байгаа шүү дээ. Энийг тодорхой болгохгүйгээр цаашаа явахгүй ээ.

Дээр нь энэ цүнх баригч компаниуд гэж байгаа юм. Тэр цүнх баригч компаниудын гаргах хохирол, үр дагаврыг тодорхой болгоё. Захиалагчийн хяналттай холбоотой асуудлыг тодорхой болгоё. Энийг сайжруулъя. Энэ засаглалыг сайжруулах яах ёстой юм. Хууль, эрх зүйн орчин дээр нь тодорхой болгоё. Энэ хуулийн төслийг бол ингээд ийм байдлаар явбал энэ гаргасан энэ ужиг үр дагаврыг чинь бид засаж чадахгүй ээ.

Энэ дээр манай энэ Сангийн яамны нөхдүүд байж байна энд хууль, эрх зүйн газрын урдах дарга нь ингээд худалдан авах ажиллагааны дарга болсон. Дараагийн дарга нь ингээд энд онцгой анхаарах ёстой. Энийг бид тал талаас нь ярьж хэлэлцэж, маш сайн хэлэлцэж байж энэ сайн үр дүн гаргах сайн. Засаглал бий болгох, ил тод бий болгох асуудлыг шийднэ ээ. Ийм учраас энэ хуулийн хэлэлцүүлгийг иргэд, олон нийтэд нээлттэй болгох ёстой. Иргэдийн яаран сандран энийг баталж болохгүй ээ. Энийг нээлттэй, ил тод олон хэлэлцүүлэг хийж байж хэн хэнийхээ эрх ашгийг тусгах, энэ хууль дээдлэх зарчим энэ өнөөдөр энэ Их Хурлын удирдлагуудаас яриад байгаа тэр хулгай, луйвартай тэмцэх асуудал энэ хуулийг яаж батлахаас шалтгаална шүү, яаж батлахаас шалтгаална. Өнөөдөр энэ төрийн өмчөөр бараа үйлчилгээ хийж байгаагаас гарсан энэ хулгай луйвар чинь тэр нүүрсний хулгайтай ч тэнцэх хэмжээний асуудал байгаа шүү.

Энэ дээр бол олон Улсын Их Хурлын гишүүд, захиалгаар өнөөдөр барилга объект бариулдаг. Хамаарал бүхий компани оруулдаг. Тэгээд энийг чинь ашиглалтад авдаггүй жил бүхэн өнөөдөр ингээд л төсөв хөрөнгийг нь нэмсээр байгаад л 10 жил болсон юм бол сая судалгаагаар гарч ирж байна шүү дээ. Төсвийн хууль хэлэлцэх үед. Энийг ингэж цэгцлэх нь Өнөөдөр Монгол Улсын төрийн үүрэг, төрд итгэх итгэл, өнөөдөр хулгай луйвартай тэмцэх тэмцлийн чинь ажил, хууль дээдлэх зарчим энд чинь шийднэ шүү. Ийм учраас энэ асуудлыг маш сайн, олон

талаас нь, урт удаан хугацаанд хэлэлцэх ёстой. Яаран сандран энийг шийдэж болохгүй. Тийм учраас би Их Хурлын гишүүний хувьд энэ ажлын хэсэгт орох бүр саналтай байна.

Энэ дээр бол тодорхой энэ шийдлүүдийг гаргах, энэ дээр өөрийн дуу хоолойгоо энэ ард иргэдийн захиа шиг энд би биелүүлэх ийм шаардлага.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

3 дэмжсэн үг хэлчихсэн.

Ц.Идэрбат: Ер нь яах вэ энэ хууль бол бас дэвшилттэй болж байна гэж ингэж харж байгаа.

Нэгдүгээрт, цахим болж байна. Хүнээс хараат бус, мөн төрийн цахим нэгдсэн системээс олон мэдээллүүдээ авдаг нь бизнес эрхлэгчдэд ч гэсэн маш хөнгөлөлттэй ийм хялбар нөхцөл үүсэж байгаа. Захиалагчийн талаас хариуцлага бол мэдээж маш чангарчихсан, энэ хууль дээр ч байна. Дээр нь Эрүүгийн хууль дээр ямар нэгэн байдлаар бусдад давуу эрх олгосон бол ямархуу заалт байгаа билээ та бид бүхэн мэдэж байгаа. Гол нэг заалт бол энэ гүйцэтгэгчийн хариуцлагын асуудлыг маш сайн тусгаж өгч бид нар хар жагсаалт гэдэг нэг юм л яриад л байдаг болохоос биш огт хэрэгжихэд маш магадлал багатай. Нэг ёсондоо бол нөгөө шүдгүй арслан гэдэг шиг ийм л байдалтай байсан бол хар жагсаалтад оруулаагүйн улмаас тухайн төрийн албан хаагчид ч гэсэн өөрөө бас нэлээн асуудалд орох ийм л юм орж байгаа юм байна гэж ингэж бас харж байгаа.

Энэ дээр 2, 3 бас юм байгаа юм.

Нэгдүгээрт энэ шууд гэрээг өсгөх тал дээр Сангийн яам бас энэ дээр нэг уяатай байж үзээч ээ. Хараач ээ. Ялангуяа миний хэлээд байгаа энэ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгүүд чинь бүгд бүх сумдууд дээр хуваарилагдаж байгаа.

Тэрийг том чадалтай компаниуд авдаггүй юм аа. Хэн авдаг вэ гэхээр ёстой цаасны компани хүн хүч ч байхгүй, техник тоног төхөөрөмж ч байхгүй, ажлыг нь авчхаад орон нутгийнхнаар хийлгэдэг нэг ийм нугалаа байгаа юм. Энийг та хэд маань бас нэг эргээд нэг хараач гэж ингэж бодоод байгаа юм. Энэ бол олон залуучуудад цаашидаа бизнес эрхлэх, магадгүй ААН болоод цаашаа хөгжиж дэвжээд явах ийм л үүд хаалгыг нээсэн ийм зүйл болно.

Дараагийнх нь нэг юм бол энэ гомдол гаргах процесс дээр тэр Сангийн яамныхны тайлбар бол дэндүү тийм бас хөндий байна л даа. 2 хүний хоорондох асуудал энэ тэр гэж өөр тийш нь чиглүүлээд орхиод байгаа юм. Яг та ингээд судлаад үзэх юм бол та наад хуулаа өшөө бас нэг чанартай болгоё, хүнд ээлтэй хууль болгоё гэж бодож байгаа бол тэгж хөндий биш наадхаа өөр цааш нь нэг судлаад үзээч ээ. Гарц гаргалгаа хайгаач ээ. Ялангуяа хар жагсаалтад оруулах ч нэг шалтгааны нэг нь наадах чинь байж болно шүү дээ. Хэдүүлээ нийлээд л баг болж ороод л 20, 30 сая төгрөгөө луйвардуулаад л авч чадахгүй, гомдол гаргана гэхээр заавал Улаанбаатар хотын тэр дүүрэг рүү явах болдог гээд л нэг бөөн зовлон байдаг шүү дээ. Яг энэ ганц юу гэдэг юм ганц нэг тохиолдол яриад байгаа юм биш. Улсын хэмжээнд байгаа тохиолдлыг би бас яриад байгаа юм шүү. Тэгэхээр та ингэж хөндий биш, энэнийхээ гүн рүү ороорой гэж ингэж би бас хэлэх гээд байгаа юм.

Дараагийн нэг зүйл бол орон нутгийн удирдлагууд гэрээ цуцалдаг, үнэхээр хийж чадахгүй байгаа нөхдүүдтэй гэрээ цуцалдаг, баахан шүүхддэг. Шүүх процесс жил гаран явдаг. Энэ бол бүр бодитой жишээ байна шүү дээ. Та бүхэн бараг мэдэх байх Сангийн яамныхан. Хэнтий аймгийн Хан Хэнтий чуулгын барилга гэж 11 жил болж байгаа энэ барилга гүйцэтгэж чадахгүй байгаа компанитай Засаг дарга байхдаа гэрээг нь цуцалчихаар жил гаруйн хугацаанд Дээд

шүүх хүртлээ энэ процесс яваад тэгээд энэ хооронд тэр барилга гацаж байгаа юм. Энэ хооронд энэ юмны үнэ хэд дахин өсчхөж байгаа юм. Тэгээд тэрний хохирлыг хэн төлөх юм бүү мэд, ингээд л татвар төлөгчдийн мөнгөөр одоо энэ нэг салдаггүй компаниас нь салгасан, нэг юм дуусгах гээд явж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хувь хүнтэй холбоотой гомдол гаргах энэ процесс, энэ гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан энэ процесс энэ дээр бас нэг энэ хуулийнхаа агуулгын хүрээнд тэр олон талын хүний эрх, тэр шүүгдэх эрх мэдэл, тэр эрх үүрэг бүх юмыг нь хангаад нэг энэ хууль дээр бас нэг юм оруулаад өгөх бололцоо байна уу?

Энэ дагалдах хууль гээд хэдэн 5, 6 хууль бас орж ирж байна шүү дээ. Энэ дээр бас Хууль зүйн яамтайгаа ярьж байгаад энэ саяын процесс тэр хувь хүнийг хохироодог, барьдаг, энэ зүйлүүдийг цэгцлээд явчих юм бол энэ захиалагч талдаа буюу татвар төлөгчдийн мөнгө үр ашигтай болно. Ажил чанартай гүйцэтгэгдэнэ. тэнд юм хийсэн хүмүүс цалин хөлсөө авч чадахгүй байх энэ процесс бас давхар хаагдчихаасай. Энэ зүйл чинь л орхигдчихоод байгаа юм биш үү гэдэг ийм л зүйлийг бас хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль гээд шинэчилсэн найруулга маш чухал хуулийн хэлэлцүүлэг явагдаж байна аа.

Хэлэлцэх эсэх нь энэ хууль бол өөрөө бас маш олон оролцогч талын харилцааг шийдчихсэн, урьд өмнө бас асар олон тийм их хэл ам дагуулдаг, иргэдийн болоод

бизнес эрхлэгчдийн итгэл уначихсан ийм их чухал хууль. Мөн бас яг энэ өдрүүдэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль бас ороод Их хурлаар хэлэлцэгдэж байгаа. Тэгээд бас манай бүлгийн гишүүд ч бас янз бүрийн байр сууриудтай байна. Ийм болохоор энэ хууль дээр АН-ын бүлгээс 3 хоногийн завсарлага авъя.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу АН-ын бүлэгт ажлын 3 хоногийн завсарлага, ирэх 4 дэх өдрийн өглөө хүртэл завсарлага өглөө.

Дараагийн асуудалд орно.

Төрөөс олгох урамшуулаас Нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутгах суутган төлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан танилцуулна.

Ц.Туваан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, А.Адъяасүрэн, Д.Батлут, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Н.Ганибал, Н.Наранбаатар Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар нараас төрөөс олгох урамшуулаас Нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 6 сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслийн зорилт нь төрөөс олгох, ноосны сүүний, арьс ширний улаан буудайн урамшуулал авах эрх үүссэн иргэний төлбөл зохих НДШ, ЭМД-ын шимтгэлийг тус урамшуулаас нь суутган төлөх замаар нийгмийн даатгал болон эрүүл мэндийн үйлчилгээг авах эрхийг нь бүрдүүлэх билээ.

Монгол Улсын Засгийн газраас 2009 оны 39 дүгээр тогтоолоор Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын баримт бичиг батлагдсан. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилго нь малчин хүнийг өөрийг нь хөгжүүлэх замаар малчин өрхийн ашиг орлогыг нэмэгдүүлэн амьдралын түвшинг дээшлүүлэх бөгөөд малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүйн эдийн засгийн орчныг бүрдүүлэх юм. Улсын Их Хурлаас малчид, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол, Засгийн газраас боловсруулах үйлдвэрт оруулах арьс шир бэлтгэн тушаасан холбооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох, хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулах олгох журмыг тус тус батлан хэрэгжүүлж байна аа. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль тогтоомжийн дагуу төрөөс олгох ноосны сүүний, арьс ширний улаан буудайн урамшууллыг жил бүр төсөвт суулган шаардлага хангасан ААН, иргэдэд олгож байгаа.

Тухайлбал, 2020 онд 46828 малчинд ноосны урамшуулал 19.4 тэрбум, 2021 онд 91977 малчинд 31.7 тэрбум төгрөг олгосон.

2. 2020 оноос шийдвэр гарч, сүүний урамшуулал олгож эхэлсэн бөгөөд салбарын яам сүүний урамшууллыг литр тутамд 500 төгрөгөөр тооцож олгосон, 2020 оны 11 дүгээр сараас эхлээд 2021 оны 3 дугаар сар хүртэл 8.5 сая литр сүүгээ нийлүүлж тушаасан нийт 6516 малчин,

мал бүхий этгээдэд 4.3 тэрбум төгрөгийн урамшууллыг тооцож олгосон байна.

3.Тариалангийн тухай хууль хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт Засгийн газрын 2020 оны мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 2020 онд 797 иргэн, ААН-д 22.4 тэрбум төгрөг, 2021 онд 767 иргэн, ААН-д 22.7 тэрбум төгрөг олгосон.

4.Арьс, ширний урамшуулалд 2020 онд 37825000 малчин, мал бүхий иргэдэд 9.9 тэрбум төгрөг олгосон байдаг. Дээрх төрөөс олгож байгаа урамшуулалд хамрагдаж байгаа малчин, мал бүхий иргэд, тариаланчдын дийлэнх нь нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэлээ сайн дурын үндсэн дээр төлдөг боловч байнгын орлогогүй байдлаасаа шалтгаалж нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл төлөлт тасалдах, төлөхгүй байх зэрэг асуудал үүсдэг ээ.

Төрийн зүгээс нэгэнт жил бүр төсөвт урамшуулал олгох хөрөнгийг суулгаад олгож байгаа тул нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэлээ тухай бүр нь тогтмол төлж чадахгүй байгаа, зарим боломжгүй иргэдэд нэгэнт олгох урамшууллаас нь суутган тооцоод олгох нь олон талын ач холбогдолтой. Нэн ялангуяа малчдын хувьд гар дээрээсээ шимтгэл төлөхгүйгээр ирээдүйн амьдралын баталгаа болох тэтгэвэр авах эрх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд даатгалаараа хамрагдах боломж үүсэх олон талын ач холбогдолтой. Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төсөл нь 5 зүйлтэй төрөөс олгох, ноосны сүүний арьс ширний улаан буудайн урамшуулал авах эрх үүссэн, иргэний төлбөл зохих НДШ-ийг урамшууллаас нь суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд зохих журамд заасан шаардлага хангаж, урамшуулал авах болзол хангасан иргэд энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, А.Адъяасүрэн, Д.Батлут, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Н.Ганибал, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Л.Мөнхбаатар нараас төрөөс олгох урамшууллаас Нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагчид баярлалаа.

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна аа. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Д.Батлут, Г.Тэмүүлэн нарын 10 гишүүнээс 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч төрөөс олгох ноосны сүүний, арьс ширний улаан буудайн урамшуулал авах эрх үүссэн иргэдийн нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэлийг тус урамшууллаас нь суутган төлөх зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар малчин, саальчин, мал бүхий иргэд, тариаланчид зэрэг иргэдэд нийгэм, эдийн засгийн олон талын ач холбогдолтой улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг *Dparliament.mn* цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг хуулийн төслийн нэрийг төрөөс олгох зарим төрлийн урамшууллаас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай гэж засах болон малчдын нийгмийн даатгалд хамрагдалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил уг асуудлыг бие даасан хуулиар зохицуулахаар оруулсан нь оновчтой эсэх талаар, мөн хуулийн төсөлд тусгагдсан сайн дураар төлөх гэрээг хэрхэн байгуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн малчдын ЭМД-ын хамрагдалт болон малчдыг даатгалд хамруулахад ямар хөшүүрэг, арга хэмжээг ЭМД-ын Ерөнхий газраас авч хэрэгжүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг бие даасан хуулиар биш Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах замаар тусгах, түүнчлэн урамшуулал авах, иргэд өөрөө зөвшөөрсөн тохиолдолд нийгмийн болон ЭМД-д хамрагдах боломжтой гэдгийг тодорхой тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир малчид, тариаланчид зэрэг төрөөс урамшуулал авдаг иргэдийн тухайн жилийн урамшуулал дараа жилд нь дамнаж ордог тул нийгмийн даатгалын болон ЭМД-ын үйлчилгээ авч чадахгүй нөхцөл байдал үүсдэг асуудал болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан туслах, малчдын даатгалд хамрагдах боломжийг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлээгүй бөгөөд төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр буюу 100 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданишатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Цэндийн Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Туваан нарын гишүүний өргөн барьсан төрөөс олгож байгаа урамшууллыг нийгмийн болон ЭМД-ын даатгалд шимтгэл төлөх энэ хуулийг нь дэмжиж байгаа. Тэгэхээр сайн дурын үндсэн дээр гэдэг нь бол хамгийн чухал. Өөрөөр хэлбэл тухайн иргэн хүн өөрөө эндээс төлж болно гэх юм бол төлж болно. Төлж болохгүй ээ би өөрөө энэ орлогоо өөрөө авч зарцуулна гэх юм бол тэр нь тэр хүний хувийн асуудал болж хувирч байна. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжүүлснээр Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн нийгмийн даатгалын санд хэдэн төгрөгийн ихэнх нь сайн дураар даатгуулаад байгаа. Зарим нь бол огт даатгуулдаггүй. Тэгэхээр ер нь хэр зэрэг даатгуулагчийн хувь нэмэгдэх вэ гэдэг энэ асуултыг хууль санаачлагчаас асууя.

Хоёрдугаарх нь ЭМД, нийгмийн даатгалын төлбөрийг хөдөөгүүр явж

байхад бол малчид жилд нэг удаа аваад байна. Тэгэхээр бид нарт их хэцүү байна аа. Тэгэхээр сая бол энэ албаны хүмүүсээс асуухад анхнаасаа гэрээ хийхдээ сараар ч төлж болно, хуваарилаад хэдэн ч удаа төлж болно гэж жилд хэдэн ч удаа төлж болно гэж хариулж байна л даа. Тэгэхээр энийг олон нийтэд хамгийн гол нь хүргэх нь би миний хувьд чухал байгаа. Тийм учраас нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэлийг малчид бол 1 жилдээ 2 хувааж төлөх сонирхолтой байгаа. Ялангуяа ноолуур гарах, ноос ноолуур гарах үеэр шимтгэлээ төлчихмөөр байна. Яагаад гэвэл орлого нэлээн орж ирдэг учраас ирээдүйнхээ энэ тэтгэврийн асуудлыг бодолцоод эрүүл мэндийн үйлчилгээний асуудлыг бодолцоод энийгээ төлөх сонирхолтой байгаа. Нөгөө хэсэг төлбөрийг нь мал борлуулах үеэр буюу 10, 11 сард энэ төлбөрөө төлөх ийм сонирхолтой байдаг юм.

Тийм учраас нэгэнт л сар сард ч хуваадаг юм уу, жилд хэдэн удаа ч хуваах тийм анхнаасаа гэрээ байгуулж байгаа тохиолдолд хөдөө байгаа тэр нийгмийн даатгалын байцаагч нар, ЭМД-ын байцаагч нартай, ер нь бол хэдэн ч удаа хувааж болдог шүү гэдэг тийм ойлголтыг сайн өгөх нь энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад маш чухал байгаа. Энэ дээр тэгээд энэ ялангуяа энэ санд төвлөрүүлж байгаа албан тушаалтнууд энэ дээр малчдад тодорхой мэдээллийг өгөөч гэж хүсэж байна. баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагч Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултад хариулна.

Ц.Туваан: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Энэ хуулийн концепц дотор бол иргэд өөрсдөө зөвшөөрсний үндсэн дээр буюу сайн дурын үндсэн дээр энэ суутган тооцох асуудал яригдана гэдгийг энэ даширамд хэлье. Өнөөдрийн байдлаар манай хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, хөдөө аж ахуйн салбарт

эрхлэгчид ер нь ЭМД-д хамрагдах, нийгмийн даатгалд хамрагдах хувь бол нэлээн бага байгаад байгаа юм. Монгол Улсын хуулиар ЭМД-ын шимтгэл бол албан журмын даатгал байгаа. Тэгэхээр Монгол Улсын иргэн болгон ЭМД-д албан журмаар хамрагдах ёстой болчхож байгаа юм. НДШ нь бол 2 янз буюу албан журмын даатгалд даатгуулах, сайн дурын үндсэн дээр НДШ төлөх гээд ингээд ийм байдалтай байгаа.

Тэгэхээр энэ ЭМД-ын хамрагдалт малчдын жишээн дээр авч үзэхэд 30-36 хувьтай гэсэн ийм тоо гарч ирж байгаа юм. Өнөөдрийн байдлаар. Тэгэхээр 3 малчин хүн тутмын нэг нь ЭМД-д хамрагдсан, хамрагдсан байгаа ийм статистик байгаа. НДШ төлөлт бол сайн дураар, төлж байгаа малчид маань бол 20 орчим хувьтай. Өөрөөр хэлбэл 5 малчин тутмын нэг нь НДШ-ээ сайн дураар төлж байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр эндээс энэ малчид маань жилдээ 2 удаа бөөн орлого буюу бэлэн мөнгөний орлого олдог. Энэ нь хаврын цагт ноолуур тушаагаад намар мал махаа борлуулсны дараа ийм орлого олдог. Тэгэхээр энэ үед нь бас НДШ-ийг хуваан тооцож болдог, өөрөөр хэлбэл сараар, 3 сараар, хагас жилээр төлж болдог хууль эрх зүйн зохицуулалт байгаа ч гэсэн энэ эрүүл мэнд, НДШ-д хамрагдах хувь маань бол төдийлөн өсөхгүй байгаа.

Тэгэхээр энэ хуулийн бас үндсэн зорилго бол сумын төвөөс хол мэдээллээс хол, ийм малчдад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр хуулийн дагуу олгож байгаа урамшууллаас нь өөрсдөө сайн дураар зөвшөөрвөл шимтгэлүүд нь автоматаар төлөгдөөд явчихдаг байвал энэ хамрагдах хувь бол огцом өснө өө гэж ингэж харж байгаа. НДШ төлөлт бол 50 хувиас дээшээ гарна гэж харж байгаа. ЭМД-д хамрагдах, хамрагдалт бол 80 хувиас дээш гарна гэсэн ийм тооцоололтой байгаа гэдгийг нь хэлье.

Тэр сая хэлсэн нөгөө хувааж төлдөг буюу ялангуяа энэ малчдын хувьд бол сумынхаа нийгмийн даатгалын

байцаагчтай гэрээ байгуулаад хувааж НДШ-ээ сайн дурын үндсэн дээр төлж болж байгаа. Тэгэхдээ энэ бол нэг их сайн хөшүүрэг болж өгөхгүй байгаа юм. Сая бид нар энэ 1 жилийн хууль батлаад өөрөөр хэлбэл НДШ-ээ нөхөн бөөнөөр нь төлөөд тэтгэвэрт гарах энэ нөхцөлтэй хууль баталсан. Иргэдийн саналаар 1 жил дахин сунгасан боловч ойролцоогоор 2 орчим хувиар нэмэгдээд илүү хамрагдалт өсөхгүй байгаа. Тэгэхээр энэ хамрагдах хувийг л ер нь нэмнэ гэсэн ийм гол концепц байгаа гэдгийг энд хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Телуханы Аубакир гишүүн.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Нэмээд танилцуулчихъя. Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга. Басангийн Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн бодлогын хэрэгслийг зохицуулах газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга. Мэндбаярын Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгслийг зохицуулах газрын дарга, Ламжавын Бямбасүрэн ЭМД-ын Ерөнхий газрын дарга, Бүдрагчаагийн Баярболд, ЭМД-ын Ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр болон гүйцэтгэгч, Чойжоогийн Гантөмөр ЭМД-ын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга.

Хэн хариулах вэ ажлын хэсгээс. 84 Хишигбаяр.

Б.Батжаргал: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Батжаргал. Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын тухай хуулийн энэ 16 дугаар зүйлийн 6-д зааснаар

сайн дурын даатгуулагч буюу малчин даатгуулагч, НДШ-ээ сар, улирал, хагас жил, жилээр гэрээний дагуу төлнө өө гэсэн ийм хуулийн зохицуулалттай. Энэ зохицуулалтын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яамтай хамтраад сайн дурын даатгалын гэрээний маягтыг баталсан. Тэгээд энэ баталсан маягаараа бид нар бүх 330 сумынхаа Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагчдаа хүргүүлээд сурталчилгаагаа бас энэ чиглэл рүүгээ сайн явуул гэсэн үүрэг өгдөг. Гэхдээ малчид бол таны хэлдгээр энэ голчлон улирал, эсвэл хас жилээр жилд 2 удаа төлье гэсэн ийм сонголтыг хийж гэрээ байгуулж ажиллаж байгаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Тодруулъя. Бөхчулууны Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Дарга хариуллаа. Тэгэхээр ер нь бол сараар, улирлаар жилээр, хагас жилээр гэж байгаа юм байна. Тэгэхээр нэг доор танай албан тушаалтнууд чинь ажлаа хөнгөвчлөөд жилд нэг удаа нөгөө малчидтайгаа уулзах гээд, тэгээд энэ нөгөө малчдыг жилд нэг удаа төл гээд ингээд яваад байгаа байж магадгүй шүү. Яагаад гэвэл нэлээн хэдэн удаа надаас бид нар 2 удаа, жилд 2 удаа орлоготой болдог. 2 удаа орлоготой болохдоо л төлбөрөө төлчихмөөр байна гэж. Сараар гэж асуугаагүй. Ноолуур гарах үеэр малаа борлуулах үеэр ингээд 2 төлчихмөөр байна л гэж ярьж байгаа.

Тийм учраас та нөгөө доодох нөгөө нэг албан тушаалдаа ялангуяа Аюурсайхан сайд сууж байна. Тэр хүмүүсийгээ тэр ажлаа хөнгөвчлөөд жилд нэг удаа хүний төлбөрийг авах тухай ярих биш, ядаж 2 удаа болох тухай асуудал дээр бас нэг жоохон анхаараарай гэж зөвлөх байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Санал хэллээ. Телуханы Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ хуулийг санал санаачилгынх нь хүрээнд бол

дэмжиж байгаа юм. Яах арга байхгүй, малчид гэдэг бол энэ нийгмийн даатгал, ЭМД-ын даатгалаа төлөх бололцоо хомс, ялангуяа залуу малчид бол энэ асуудлаас ер нь бүрэн хаягдаж байгаа юм. Сая Туваан гишүүн хэлж байна. хамрагдалт бол энэ гучаас 36 хувь гэдэг бол маш хангалтгүй байгаа. Эргээд тэр малчид маань, ялангуяа залуу малчид маань нас өндөр болоод тэтгэвэрт гарах нийгмээс авах үйлчилгээгээ эрхээ хязгаарлуулчихсан байдалтай, ЭМД, нийгмийн даатгал, ялангуяа ЭМД бол сайн дурынх. Энэ дээр өөрсдөө оролцоо, идэвх бас нэг талдаа тааруухан. Энэ урамшуулуудаасаа даатгалуудад хамрагдуулж байгаа нь өөрөө эргээд хэдэн жилийн дараа үзүүлэх нөлөө нь өндөр л дөө. Энэ урамшууллаас мөнгө ороод ирэхээр, энэ бол нийгмийн даатгал буюу ЭМД-ын санд бол хүндрэл болж очихгүй. Энэ утгаараа энэ малчдынхаа бас энэ хамрагдалтын нь хувьд миний хувьд бол дэмжиж байгаа юм.

Сая орон нутгаар явж байхад жишээлбэл Улаан-Уул сумын 11 дүгээр багийн иргэн Корнеш гуай жишээлбэл хэлж байна лээ. Бид нар энэ малын тоо толгойн татвараа төлье өө. Энэ төлж байгаа мөнгөнөөс бид нар ЭМД манай гэр бүлд 5, 6 залуучууд байна аа. ЭМД, нийгмийн даатгалд хамрагдаагүй ээ. Энэ татвараасаа төлүүлэх бололцоо бий юу гэж хүртэл асууж байсан.

Тийм учраас Туваан гишүүн Наранбаатар нарын гишүүд энэ бас зөв санал санаачилга оруулж ирж байгааг хувьдаа бол дэмжиж байна. Арьс ширний урамшуулал, сүүний урамшуулал, ноосны урамшуулал, дээрээс нь магадгүй малын тоо толгойн татварын асуудал нэмээд ч байдаг ч юм уу? Тийм ээ ингээд зохицуулах гаргалгааг харж орж ирж байгаа зүйл гэж бодож байна. Гэхдээ яг одоо нөгөө талдаа бусад хуулиудаа зөрчихгүй биз дээ?

Сая Пүрэвдорж гэсэн асууж байна л даа. Сайн дурын гэж. ЭМД бол угаасаа сайн дурынх, тийм ээ угаасаа сайн дур

шүү дээ. Тийм учраас бусад хууль янз бүрийн юмнуудаа зөрчдөггүй. Бид нар чинь хэдий урамшуулал боловч төсвөөс орж байгаа мөнгө. Тэр мөнгийг нь бид нар хувь хүний хувь иргэний ЭМД-ын шимтгэл хэлбэрээр шилжүүлээд сууж байх нь хэр зохимжтой юм. Энэ тэр хууль зүйн гаргалгаа энэ тэрээ зөв олоод гаргах юм бол миний хувьд бол дэмжиж байна. Яах арга байхгүй одоо хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүний хувьд малчдын маань тавьдаг, санаа зовж явдаг энэ ЭМД эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо руу шилжсэнтэй холбоотой, эргээд эрүүл мэндийнхээ үйлчилгээг үнэгүй авчих, хямдхан авчих бололцоо бүрдэж байгаа дээр бид нар бол малчдаа дэмжээд явах нь зөв гэж бодож байгаа юм.

Тийм учраас яг хууль эрх зүйн хувьд гаргалгаа нь болж байгаа юу? Манай энэ НДЕГ-аас хүн байна уу? НДЕГ эсвэл ЭМД-ын ерөнхий газраас хариулаад өгөөч. Бусад хууль тогтоомжуудаа бид нар зөрчихгүй биз дээ гэсэн ганц асуулт байна?

Ер нь бол дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн хариулъя.

Ц.Туваан: Тэгээд Аубакир гишүүний асуултад хариулъя аа.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу ЭМД-ын хуулийн дагуу шимтгэл төлөлт бол албан журмынх байгаа. Тэгэхээр бид бүхэн 2020 оны парламент байгуулагдаад хамгийн анх ээлжит бус чуулган хийгээд төсвийн тодотголоос гадна хэлэлцсэн нэг хууль бол энэ Эрүүл мэндийн тухай, ЭМД-ын тухай хууль хэлэлцэж баталсан. Энэ гол хуулийн гол концепц бол энэ эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд оруулсан явдал байгаа.

Тэгэхээр гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд ороод ирэхээр гүйцэтгэл бич бичиж, ЭМД-ын

Ерөнхий газар хяналтаа тавьж, ЭМД-ын сангаас мөнгө нь төлөгддөг маш олон том боломжуудыг нээж өгсөн байгаа. Тэгэхээр эргээд иргэн маань өөрөө ЭМД-даа заавал хамрагдах гэдэг ийм нөхцөл үүсэж байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн байдлаар албан журмын даатгал 2016 оноос гарсан. Өнөөдрийг хүртэл 6 жил орчим төлөгдөх байсныг Засгийн газраас хөнгөлөөд 2 жилийг нь хөнгөлөөд сүүлийн 4 жил дээр 190 орчим мянган төгрөгийн ЭМД-ын шимтгэлийг бөөнөөр нь төлж байж ЭМД-ын сангаас үйлчилгээ авах эрх нь үүсээд байгаа юм.

Тэгэхээр он гараад явчихвал энэ жил хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулаад бас 60 гаран мянган төгрөг ингээд нийтдээ 250 гаруй мянган төгрөг бас төлөх ийм нөхцөл үүсэж байгаа юм.

Тэгэхээр энэ урамшууллаас нь иргэн өөрсдөөр нь сайн дураараа энэ нийгмийн даатгал, ЭМД-ын шимтгэлүүдээ төлөөд явчихвал хуримтлагдаж ингэж олон жилийнх үүсэхгүй гэдгийг бас энд хэлье. Ер нь бол албан журмын даатгалтай, дээрээс нь мөнгөн дүн нь бага байгаа учраас эхлээд бол ЭМД-ын шимтгэлүүдээ бол энэ урамшууллаудаасаа төлөх байх. Ньюанс нь бол өөрөө ЭМД-ын энэ шимтгэл төлөлт маань албан журмынх тэрийгээ эндээсээ төлөх үү, карманаасаа төлөх үү гэдэг малчид, тариаланчдын хувийн сонголтын асуудал болчхож байгаа юм.

Дээрээс нь энэ хууль өргөн барьснаас хойш Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны шийдвэр гараад Засгийн газар тогтоолоо гаргаад хүнсний ногоонд урамшуулал олгохоор заасан. Тэгэхээр бид нар бас энэ хэлэлцэх эсэх нь шийдсэний дараагаар хэлэлцүүлгийн явцад энэ ногоочдыг бас оруулж ирэх ийм зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирэх асуудал бол энэ Байнгын хороон дээр бас яригдсан.

Тэгэхээр ер нь бол энэ хүмүүс маань өөрсдөө ямар нэгэн төвөг чирэгдэлгүйгээр цахим болчихсон, эрүүл мэнд, НДШ-ээ ингээд автоматаар төлөгдөөд явах нь эмнэлэгт шууд үзүүлэх яаралтай нөхцөл үүссэн үед, малчдын хувьд бол бүр эрэгтэй 55 эмэгтэй 50 нас хүрээд шууд нийгмийн даатгалын тэтгэвэр тогтоолгох, насанд хүрсэн үед нь бол энэ ямар нэгэн хүндрэлгүй ийм маш чухал зүйл гэж ингэж харж байгаа. Тэгээд дээрээс нь энэ НДШ-ээ ингээд төлөөд явснаар бол бас энэ нийгмийн халамж, ажилгүйдлийн энэ тэргээд ийм тэтгэмжүүдийг бас давхар хүртээд явах гээд иргэн талдаа бол энэ маш эерэг хууль болж байгаа гэж ингэж хууль санаачлагчийн зүгээс үзэж байгаа юм.

Ажлын хэсгээс нэмэх үү?

Г.Занданишатар: Аубакир гишүүн тодруулъя, нэг минут.

Т.Аубакир: Энэ төрөөс үзүүлж байгаа урамшуулал гэж жилдээ ХААЯ-наас жилдээ хэчнээн төгрөгийн урамшуулал үзүүлдэг юм бэ? Яг төрөөс үзүүлж байгаа урамшуулал гэж. Энэ асуултад хариулаад өгөөч.

Г.Занданишатар: Болорчулуун дарга хариулъя. 83.

Х.Болорчулуун: Аубакир гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас үндсэндээ нэг 5 төрлийн урамшуулал явж байгаа. Тухайлах юм бол ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал, хүнсний ногооны урамшуулал, улаан буудайн урамшуулал, сүүний урамшуулал гээд. Өнгөрсөн жил бид нар өнгөрсөн жилийн суурь түвшнийг авч үзэх юм бол нэг 60 гаруй тэрбум төгрөгийн урамшууллыг бол энэ 5 чиглэлд олгосон байгаа. Ер нь бол бас сүүлийн 10 жилээр нь аваад үзэх юм бол 2011 оноос ноосны урамшууллыг олгож эхэлсэн. 2021 оны энэ 10 жилийн хугацаанд бол нийтдээ

225.4 тэрбум төгрөгийг олгосон байгаа. Арьс ширний урамшуулал дээр бол 2013 оноос эхэлж олгосон энэ 8 жилийн хугацаанд бол нийтдээ 75.8 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байж байгаа.

Г.Занданшатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Баярлалаа.

Т.Энхтүвшин: Энэ малчдад 1 он дамнаад нэг урамшуулал олгодог ноос, сүү, арьс ширний урамшуулал олгодог он дамнаж олгодог байж байгаа. Тэгээд энүүгээр орж ирсэн мөнгөөр нь НДШ-ийг, ЭМД-ыг л суутгаад авах л ийм хууль орж ирж байна л даа. Тэгээд энийг бол дэмжихгүй ээ. Яагаад ч дэмжиж болохгүй. Цаг өөрөө хүнд байна шүү дээ. Хүнд байна. Энийг малчид сонсох юм бол ямар байдалтай хүлээж авах вэ гэдгийг та эдэнд ойлгох хэрэгтэй. Хамгийн гол нь НДЕГ гэж байгаа шүү, ЭМД-ын ерөнхий газар гэж байгаа шүү. Өөрсдөө ажлаа хийх хэрэгтэй, төр ажлаа хийх хэрэгтэй шүү дээ. Нийгмийн даатгалын багц хууль дээр сайн дурын гэж бичээтэй байхад заавал энэ хууль дээр дахиж сайн дурын гэж оруулж ирдэг нь яаж байгаа юм бэ дээ. Та хэд юу гэдэг юм суман дээр очиж ажиллах хэрэгтэй. Тэр баг дээр очиж ажиллах хэрэгтэй, малчин өрхүүд дээр очиж хуучин энэ Нийгмийн даатгалынхаа багц хуулиудыг сайн ойлгуулах хэрэгтэй. Малчид бол сайн ойлгох юм бол энэ ЭМД ч бай, НДШ-ийг ч бай бүгдийг нь төлнө өө.

Бүгдийг нь юу гэдэг юм парламентаар оруулж ирж ингэж хууль гаргаж ингэж юу гэдэг юм малчин өрх тариаланчдыг дарамталж болохгүй та хэд.

Тийм учраас бол би нэгдүгээрт дэмжихгүй.

Хоёр дахь асуудал бол ерөөсөө малчид урамшууллаа аваад төлөх эсэх нь бол өөрсдийнх нь л асуудал шүү дээ. Тэр

төлдөг ийм механизмын тэр арга барилыг нь та хэд хуулиа тайлбарлаж суулгаж өгөх ёстой шүү дээ. Заавал юу гэдэг юм Хүнс ХААЯ-наас нийгмийн даатгалыг нь авч байдаг ЭМД-ыг нь авч байдаг ийм системийг хийж болохгүй шүү. Тэр хүмүүс чинь бас хүн. Малчдыг дагаад энэ сайн дурын юу гэдэг юм туслах малчдын асуудал байж байна. Энэ туслах малчдын асуудлыг яаж шийдэх нь та хэд. Энэ хууль дээр чинь туслах малчин гэдэг ганц ч үг үсэг алга байна.

Хоёрдугаарт, нийгмийн даатгал гэдэг бол өөрөө сайн дурын даатгал, ЭМД бол албан журмын даатгал.

Та хэд энэ хуулийнхаа үг үсгийг хараад үз. Нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл сайн дураараа төлөх тухай гэрээ байгуулсан гэж. ЭМД-ыг сайн дураараа ингэж төлнө гэж гэрээ байгуулж болдог юм уу? Ингэж хуульд орж болдог юм уу?

Тийм учраас энийг бас дэмжихгүй ээ. Дэмжихгүй. Тэгээд малчдын малчин өрхөөр явах хэрэгтэй, туслах малчингуудтай уулзах хэрэгтэй, санал асуулга явуулах хэрэгтэй. Ингэж байж энэ хууль цаашаа гарах уу, гарахгүй юу гэдэг асуудал яригдана. Өөрсдөө ажлаа хийхгүй, Нийгмийн даатгалын Ерөнхий газар гээд аймагт НДЕГ гээд бас байж байгаа шүү дээ. Сум болгон дээр нийгмийн даатгалын тэр мэргэжилтэн гээд байцаагч чинь байж л байгаа шүү дээ. Үгүй ээ, энэ хүмүүсийн ажлыг нь хийлгэ л дээ. НДЕГ өөрөө бас ярих юм бол энэ нийгмийн даатгалаас орж ирж байгаа мөнгийг нь 4 хувиар хувиараа та хэд санхүүжиж байгаа шүү. Өөрийнхөө санхүүжилтийг хууль гаргаж бүрдүүлнэ гэж байгаа бол энэ бол болохгүй асуудал шүү. 3 өрхтэй айлыг л жилээр бодоход л хоёр сая төгрөг төлөхөөр байна шүү дээ. Хөдөлмөр хөлсний доод хэмжээг 550000 гэж бодоод нийгмийн даатгал нь 11, ЭМД нь 1 гээд бодоход үндсэндээ 1 сард 66000 төгрөг, 3 өрхөөр бодоход нэг 2 сая төгрөгийн л ингээд төлөх асуудал байж байна. Хуулиа

сайн ойлгуулъя л даа. Хууль гаргах шаардлага бол байхгүй. Малчид бол энийг маш хүндээр хүлээж авна шүү, маш хүндээр хүлээж авна. Энэ малчид руу дайрсан энэ цаг энэ цас зудтай үед ийм хууль гаргаж болохгүй л гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Үг хэллээ дээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энхтүвшин гишүүн дэмжихгүй гэж санал хэлж байна. Тэгээд бас тодорхой дотор нь асуултууд явж байна. Юу гэхээр бид бүхэн хуульдаа малчин хүний тэтгэврийн нас эрэгтэй 55, эмэгтэй 50 байгаа юм. Тэгээд үүнээсээ НДШ-ийг 20 жил төлж байж эрх нь үүсдэг. Энэ 20 жилээсээ 12.5 жилээс багагүй хугацаанд малчнаар ажилласан байх ёстой. Ийм хүмүүст энэ 55, 50 насандаа тэтгэвэрт гараад байгаа юм. Тэгэхээр энэ одоо бэлэн хуулийн энэ малчдын хувьд бол би энийг бас таатай нөхцөл гэж харж байгаа. Энэ таатай нөхцөлийг үнэхээр ашиглаж чадахгүй байна. 5 малчин тутмын 4 нь ашиглаж чадахгүй байгаа учраас энэ асуудалд нь дэмжлэг болж, энэ асуудалд нь гарц гаргалгаа хайж тэгээд дээрээс нь маш олон малчидтай уулзаж байж энэ асуудлыг тавьж байгаа гэдгийг бас хэлье.

Тэгээд гишүүнд бас нэмэлт тайлбар бас нэлээн мэдээллийн холбогдолтой нэмэлт зүйлүүдийг өгье гэж бодож байна. Туслах малчны асуудал бол ер нь маш хүнд явж ирсэн. Юу вэ гэхээр туслах малчин гэдэг хүн нөгөө үндсэн мал маллуулж байгаа хүнээсээ цалин цавуу авах, тэр хүний нийгмийн баталгаа хөлс хүчээ авах энэ тэр дээр нэлээн хүнд байсан. Тэгээд өнгөрсөн онд бид нар бас Хөдөлмөрийн тухай хууль батлаад энэ Хөдөлмөрийн хууль тухай хууль дотор энэ туслах малчинтай холбоотой маш нарийн заалтуудыг оруулж өгсөн. Тэгээд үүнтэй холбогдуулаад бас энэ асуудлыг авч үзэх хэлэлцүүлгийн шатанд авч үзье гэдэг ийм саналыг бол Мөнх-Оргил гишүүн хэлсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр бол Байнгын хороон дээр би ч бас манай хууль санаачлагчид энэ дээр бол гишүүдийн бүрэн эрх учраас нээлттэй байгаа гэдгийг бас сайн хэлсэн. Яг ний нуугүй хэлэхэд манай малчид орлого бэлэн мөнгөний орлогыг байнга олдоггүй, жилдээ хоёрхон удаа олдог. Тэгээд бэлэн мөнгөний хомсдолд байдаг ийм хүмүүс. Тэгэхээр тэр болгон дээрээс нь төвд суугаад байдаггүй. Тэгэхээр сумын төвөөсөө 50-100 километр, түүнээс цааш алслагдсан ийм хүмүүс байдаг. Тэгэхээр гэнэт нэг малаа зараад юм уу ноолуураа зараад бэлэн мөнгөтэй болчихоод суман дээр очоод НДШ-ээ төлье гэхэд ажлын бус цаг ч таарах салхи шуургатай хүнд хэцүү цаг таарах ийм үеүд байдаг учраас тэр болгон энэ харилцаандаа орж чаддаггүй.

Тэгэхээр энийг хамрагдах хувийг нь нэмэгдүүлье л гэсэн ийм санаатай байвал. Яагаад вэ гэхээр энэ НДШ төлөх нь өөрөө нэг хөдөлмөрийн чадамжаа алдчихсан, өндөр насанд очсон үедээ орлого нь баталгаатай байх гэсэн ийм маш том асуудлыг малчдынхаа хувьд шийдээд өгчих юм бол тэр хүмүүс бас амьжиргаа нь баталгаатай ийм болно дээрээс нь түрүүн хэлсэн ЭМД дээр бол тэр миний танилцуулга дотор бас нэг Энхтүвшин гишүүн зөв харсан нэг юм байна. Тэр нь юу вэ гэхээр танилцуулга үгэн дотор тэр сайн дурын гэдэг ЭМД, нийгмийн даатгал хоёулангийнх нь урд талд сайн дурын гэдэг үг орсон дээр бол бас нэг юуны л танилцуулга дээр хэлэх алдаа гарсан байна. ЭМД бол албан журмынх нөгөөдөх нь сайн дурынх. Тэгэхээр юу хэлж байна вэ гэхлээр хүнд сонголтыг нь өгч байгаа л ийм хууль байна. Хүн кармандаа бэлэн мөнгөгүй байгаа хүнд та тэртээ тэргүй төрөөсөө аваад данс руугаа авч байгаа энэ урамшуулаасаа эрүүл мэнд, НДШ-ээ суутгуулах уу, үгүй юу гэдэг сонголтыг л өгч байгаа ийм хууль байгаа юм гэдгийг танд бас энэ таирамд хэлье ээ.

Тэгээд нэмэлт мэдээллийг бас дахин хүргүүлье.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Яах вэ? Энэ хуулийг бид нар бас уржчигдар Байнгын хороон дээр нэлээд ярьсан юм. Уг нь бол малчин хүнд өөрөө нийгмийн даатгалынхаа байцаагчтай гэрээ хийгээд сайн дурын даатгалд хамрагдаад шимтгэлээ төлөх боломж нь байгаа юм. Ноос арьс ширнийхээ урамшууллыг аваад тэгээд нийгмийн даатгалынхаа байцаагчдаа шимтгэлээ төлөх ийм боломж нь байгаа юм. Гэхдээ яах вэ малчид орлого бага байна гээд цаг цас зудтай гээд отор нүүдэл ихтэй байх үед тэгээд манайхан яах вэ дээ нөгөө өнөөдрийн өөхнөөс маргаашийн уушиг гэдэг ч билүү. Тэгээд нөгөө орсон урамшууллынхаа мөнгийг бензин тосондоо өвс тэжээлдээ өгчхөөд, нөгөө шимтгэлийг нь тэгээд л хойш нь тавиад л яваад байгаа юм л даа. Одоогийн байдлаар бол малчдын нэг 20 гаруй хувь нь л НДШ бол төлөгдөж байгаа юм. Малчид өөрөө орлого тогтмол орлогогүйн улмаас сар тутам НДШ-ээ төлж чадахгүй байна гэдэг асуудал маш их ярьдаг юм. Тэгээд өмнө нь бид нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт ороод малчид сар тутам биш орлого олж байгаа боломжтой үедээ сумынхаа нийгмийн даатгалын байцаагчтай гэрээгээ хийгээд тэгээд орлоготой болж байгаа үедээ шимтгэлээ сараараа юм уу, улирлаараа юм уу, хагас, бүтэн жилээрээ юм уу төлнө өө гээд гэрээгээ хийгээд графикаа тогтчих юм бол хавар ноос, ноолуурын үед, намар мах бэлтгэлийн үед мөнгөтэй болж байгаа үедээ шимтгэлээ улирлаар нь, хагас, бүтэн жилээрээ төлөх ийм боломж нь байгаа юм.

Тэгээд энийг манай нийгмийн даатгалын байгууллагынхан хэр бас малчдад ойлгуулж мэдээлэл өгдөг юм бол. Тийм учраас уг нь бол энэ заавал ийм бие даасан хууль гаргахгүйгээр малчдын өөрсдийнх нь л эрх л дээ. Тэгээд орлого олж байгаа үедээ энэ нийгмийн даатгал, шимтгэлээ сар, улирлаар нь төлөх

хувиараа гэрээгээ хийгээд тогтчихвол тэгээд орлоготой үедээ төлчих боломжтой байх юм. Би бол ийм бие даасан хууль гаргахгүйгээр нийгмийн даатгалынхаа хуулиар нь явуулбал яасан юм бэ?

Ер нь бол бид нар аливаа асуудлыг шийдэхдээ яг тэр суурь харилцааг нь зохицуулж байгаа хуулиар л уг нь зохицуулж баймаар байгаа юм. Нийгмийн даатгалын шимтгэл цуглуулах, хуримтлуулах тэрүүгээрээ явуулахаас бол Нийгмийн даатгалын хуулиар зохицуулж байгаа учраас ийм буцаан суутган тооцох тухай гэж хууль гаргаж ингээж хийхгүй, Нийгмийн даатгалын хуульд нь өөрчлөлтөө нэмэлт, өөрчлөлт оруулаад л тэртээ тэргүй тэр орлоготой үедээ гэрээгээ байгуулаад улирал хагас, бүтэн жилээр төлөх асуудал нээлттэй байгаа юм чинь ингээд явчхаж уг нь нэг болмоор байгаа юм. Нэг дэх асуудал нь.

Хоёр дахь асуудал нь ерөөсөө энэ нийгмийн даатгалтай холбоотой НДШ төлөлттэй холбоотой асуудлыг ер нь тэр суурь Нийгмийн даатгалын хуулиар нь зохицуулбал уг нь их зөв байгаа юм гэж. Засгийн газраас ирэх он сайдын ярьж байгаагаар ирэх он гарангуут Нийгмийн даатгалын хуулийг хэлэлцэх эсэхийг нь Засгийн газар хэлэлцээд ингээд оруулж ирнэ гэж байгаа юм байна лээ. Тэгээд ингээд гишүүд дэмжье гэвэл тэгээд дэмжчихээд тэгээд тэр Нийгмийн даатгалын багц хууль нь Засгийн газраас ороод ирвэл тэр хуулийг нь хэлэлцэхэд нь хамтраад нөгөө Пүрэвдорж нарын өргөн барьсан 7 жилийн цалингийн дунджаар тэтгэвэр бодуулах, энэ малчдын НДШ-д ноос, арьс ширний урамшууллыг нь суутган тооцуулах асуудлуудыг шийдүүлэх асуудлыг хамтад нь хэлэлцээд явбал яасан юм гэсэн, би бол ийм нэг бодолтой байгаа юм.

Хэрэгжүүлэхтэй холбоотой нэг асуудал байна. Ялангуяа ЭМД чинь бол бас л албан журмын даатгал. Эрүүл мэндийн үйлчилгээ авъя гэвэл заавал нөгөө ЭМД-

ынхаа шимтгэлийг төлсөн иргэн л шимтгэлээ авна, үйлчилгээгээ авна. Гэтэл энэ урамшууллын мөнгө чинь жилд нэг удаа ордог. Бараг л жилийн эцсээр, тэгээд голдуу дандаа р он дамжиж ордог шүү дээ. Тэгэхээр нөгөө хүн чинь миний нөгөө мөнгийг тэр арьс ширний ноосны урамшууллаас суутган тооцоод авчихсан гэж ойлгоод ЭМД-ын шимтгэлээ өөрөө төлөхгүй, НДШ-ээ төлөхгүй яваад, тэгээд иргэн хүн бас энэ төрөөс болоод хохирох вий. Нийгмийн даатгалын үйлчилгээгээ авч чадахгүй, ЭМД-ын үйлчилгээ авч чадахгүй байх, хохирох юм гэсэн ийм асуудал. Энийг бас нэлээн.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн. Хууль санаачлагч.

Ц.Туваан: Хууль санаачлагчид бас энэ асуудлыг нэлээн нухацтай ярьсан. Тэгээд ер нь энэ заавал тусдаа хууль байгаад яах юм бэ. Энэ нөгөө суурь хуульдаа оруулъя гээд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, түүнийг дагасан 5 багц хууль гээд. ЭМД-ын тухай хууль гээд энэ хуулиуд байгаа. Тэгэхээр энэ дээр нэг ийм асуудал байгаа. Юу вэ гэхээр энэ өөрөө би түрүүн хэлсэн сонголтын асуудал гээд.

Хоёрдугаарт энэ өөрөө урамшуулалтай холбоотой гээд энэ тус тусдаа Засгийн газрын шийдвэрүүдтэй явж байгаа ийм урамшууллаудыг яг суурь хуульдаа хуульчлаад өгчихнө. Эргээд тэр төрлийн урамшуулал магадгүй зогсох юм уу, янз бүрийн өөрчлөлт орсон тохиолдолд дахиад суурь хууль руугаа гар хүрэх юм уу, эс үгүй бол тэр чинь Үндсэн хуульдаа юу суурь хуульдаа байгаа гээд ингээд цааши нь үргэлжлүүлэх юм уу гэдэг ийм жоохон зөрчилдөөнтэй асуудлууд гарчхаад байгаа юм. Тэгэхээр гишүүд ярилцаад хууль санаачлагчид ярилцаад, ер нь энийг бас бүрэн эрхийнхээ хүрээнд тусад нь хууль гаргаад яг энэ малчид, Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдад ийм сонголтыг л өгч байгаа сайн дурын хууль учраас гэсэн ийм үндэслэлээр өргөн бариад явж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт энэ хууль өөрөө тарган мал тал бүрийн ашигтай гэдэг шиг энэ хууль бол маш олон талын ашигтай хууль болж байгаа. Юу вэ гэхлээр нэгдүгээрт, нэгэнтээ төрөөс олгож байгаа урамшууллаас малчид энэ салбарт ажиллагсдын шимтгэлийг өөрсдийнх нь гарын үсгээр сайн дурын үндсэн дээр шийдчихвэл цаг хэмнэх ийм маш цаг, ажил хэмнэх ийм маш давуу талтай.

Хоёрдугаарт, энэ иргэн хүн, малчин хүн хөдөө явж байгаад энэ гэнэт ямар нэгэн эмнэлгийн тусламж авах шаардлага гэнэт үүслээ гэхэд энэ нь төлөгдчихсөн байвал эмнэлэг дээр яваад очиход ямар нэгэн чирэгдэл үүсэхгүйгээр үйлчилгээ авчих ийм давуу талтай.

Дээрээс нь улсын төсөв дээр ямар ч, нэг төгрөгийн ч ямар нэгэн дарамт байхгүй. Одоо бид нар энэ нийгмийн даатгалын сан багаслаа, ЭМД-ын сангийн нөөц бас багаслаа гээд ингээд нэлээн бид нар ярьдаг. Тэгэхээр энэ хуулийн бас нэг үндсэн агуулга нь иргэд рүүгээ хандсан нийгмийн баталгааг нь хангахаас гадна бас энэ сангууд руу орох мөнгөн урсгалыг дэмжих юм гэдэг ийм зүйлийг нэлээн бодож оруулж ирсэн. Мэдээж энэ сая Чинзориг гишүүний асуултад ЭМД-ын төлбөрөө энэ хүн урамшууллаа авах эрх нь үүссэний дараа урьдчилсан байдлаар төлөгдөх юм. Ямар нэгэн байдлаар дараа нь төлөх биш, жишээлбэл малчин Туваан байлаа гэж бодоход энэ жилийн урамшуулал бодогдсоноос хойш гарын үсгээ тэр шимтгэл нь орсноос хойших харилцааг зохицуулах, төлбөрийн асуудлыг зохицуулах асуудал байгаа учраас ямар нэгэн эрсдэл үүсэхгүй гэж ингэж хууль санаачлагчид харсан байгаа гэдгийг хэлье.

Г.Занданишатар: Чинзориг гишүүн тодруулъя.

С.Чинзориг: Туваан гишүүний ярьж байгаа хамгийн сүүлийн тэр тайлбарууд бүр ойлгомжгүй болоод л явчихлаа л даа. Урамшуулал авсны

дараагаар үйлчилгээ авна гээд. Тэгэхээр энэ урамшуулал чинь тухайн ондоо өгдөггүй шүү дээ. Ихэнх нь голцуу он дамжиж өгдөг байхгүй юу. Тэгэхээр тэр малчин чинь миний НДШ-ийг тэр урамшууллын мөнгөнөөс төлчихнө өө, ЭМД-ын шимтгэлийг урамшууллын мөнгөнөөс төлчихнө гээд өөрөө шимтгэл төлөхгүй яваад байдаг. Гэтэл эрүүл мэндийн үйлчилгээ авъя гэхлээр 12 сард үйлчилгээ авах юм бол 12 сарынхаа шимтгэлийг зайлшгүй төлсөн байж байж үйлчилгээ авч байгаа шүү дээ. Жирэмсэн эх байна хүүхэд түрүүлээд нөгөө тэтгэмж авах гэхлээр эд нар чинь нөгөө шимтгэл төлөгдөөгүй байна. Сүүлийн бас юу билээ нөгөө сүүлийн 4 билүү сарын шимтгэл төлсөн байж байж нөгөө тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй юм байна шүү дээ. Тэгээд энэ асуудлуудыг чинь ингээд шимтгэл нь төлөлт нь нөгөө суутган тооцох орлого чинь тухайн жилдээ ордоггүй голцуу он дамжиж ордог учраас ингээд иргэд шимтгэлээ нь төлж чадахгүй, нийгмийн даатгалын эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй болчих вий дээ?

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн хууль санаачлагч хариулъя.

Ц.Туваан: Тодорхой хэлж өгье. Жишээлбэл энэ хууль батлагдлаа гэж бодоход тухайн одоо яг тухайн тухайн салбартаа ажиллаж байгаа хүмүүс дээр урамшууллаа одоо жишээлбэл ирэх жил тухайн иргэн хэдэн төгрөгийн урамшуулал авах нь бол тодорхойгүй. Хэдэн кг ноос тушаах, ямар хэмжээний ногоо, сүү, арьс шир тушаах гэдэг нь бол одоохондоо тодорхойгүй байгаа. Тэр түүхий эдүүдээ тушаагаад ямар нэгэн байдлаар падаан гарч ирнэ. Тэр бичиг баримтууд бүгд ХААЯ-ан дээр эцэслэгдээд, данс тооцоо нь бодогдоод, тэгээд Монголбанк руу явуулж байж тэр гүйлгээнүүд малчин данс руу ордог. Тэгэхээр тэр мөнгө авснаас хойш төлөгдөнө. Тэрнийхээ өмнө энэ асуудлуудаа бол иргэд өөрсдөө хуучнаараа төлөөд явна л гэсэн үг. Тэгэхээр яах вэ одоо жишээлбэл энэ 2023 оны урамшуулал

улсын төсөв дээр энэ жил 45 тэрбум төгрөг батлагдчихсан. Энэ урамшуулал нь.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Ийм асуудал дээр ингээд хууль яриад л, хууль санаачлаад л хууль батлаад явах нь зөв юм уу? Шаардлагагүй л юм байна шүү дээ. Тэгээд Улсын Их Хурал иймэрхүү асуудал яриад сууж байна гэдэг чинь улс орон өөдлөхгүй л юм байна л даа. Үгүй ээ хүний өөрт нь орж ирж байгаа орлогыг нь хуулиар зохицуулаад, хэзээ, яаж өгөхийг нь зохицуулж байдаг тийм хачин юм ярьж болохгүй шүү дээ энэ чинь. Тэгээд тэр малчныг тэр иргэнийг юу гэж бодоод байгаа юм бэ? Нэг гандангийн тагтаа шиг л юм бодоод байгаа юм уу? Тэр хүн өөртөө өөрсдөө орж ирж байгаа орлогыг өөрөө зарцуулж чадахгүй юу? Тэр хүний малаас гарч байгаа бүтээгдэхүүн тэрийг нь үнэтэй болгох, үйлдвэр завод барих ёстой л юм ярих ёстой шүү дээ. Хил, гаалиар яах юм. Тэр асуудлыг ярих ёстой. Тэр туслах малчин 30 хувь нь даатгалаа хийдэг юм байна. Нэг нь албан журмынх, ЭМД нь. Нөгөөдөх сайн дурын үндэстэй. Тэгээд 2 юмыг хооронд нь хутгаад оруулаад ирчихсэн. Тэгээд энэ урамшуулал чинь дандаа ороод байхгүй, жил болгон янз янз байна. Сайн дураа хүрвэл засаг өгнө, сайн дураа хүрэхгүй бол өгөхгүй. Ер нь энэний иргэдээс нэг иргэнээс татвар аваад нөгөө юманд л зохицуулж өгч байгаа л ийм л мөнгө шүү дээ.

Ийм маягаар ингэж явж болохгүй ээ. Татвараа багасгаад тэр гарч байгаа бүтээгдэхүүнийг нь өндөр болгох ийм л юм ярихгүй бол энэ дээр төсвөөс мөнгө гаргахгүй энэ тэр гээд л тиймэрхүү маягаар ингээд попорсон юм яриад л. Ингээд попроод л сууж байх нь бол буруу л гэж үзэж байна.

Нөгөө зах зээлийн суурь зарчмыг нурааж байна. Хувь хүн хариуцлагатай байх энэ асуудлыг байхгүй болгож байна.

Цаагуураа аягүй хорлосон үйлдэл байхгүй юу. Хувь хүнийг ч гэсэн энэ улс орныг ч гэсэн. Бид нар чинь зах зээлийн системд шилжчихсэн. Хувь хүн хариуцлагатай байх ёстой. Үгүй ээ одоо юм хөгжчихсөн шүү дээ. Бүр 50, 60 оны үеийн юм яриад байх юм. Бүгд гар утастай болчихсон, ухаалаг утастай болчихсон. Мөнгө төгрөгөө дуртай үедээ хаашаа л бол хаашаа шилжүүлдэг болчихсон. Унаа мал сайтай болчихсон, хаашаа л бол хаашаа юманд хүрчихдэг болсон. Бүгдээрээ л машинтай тэрэгтэй болчихсон шүү дээ. Тэгсэн чинь бараг нэг хүй нэгдлийн үеийн ч юм уу, социализмын үеийн ч юм уу, социализм руугаа ухарч байгаа, коммунизм руугаа ухарч байгаа ийм л ажил байна шүү дээ. Тэгээд бүгдийг нь нийгмийн даатгал, ЭМД-ыг нь чаддаг юм бол дээрээс нь төлөөд өчих л дөө. Тэгэхгүй байж байж л хувь хүний өөрт нь орж ирж байгаа орлогыг нь хууль гаргаж захиран зарцуулдаг тийм ийм юм гэж юу байдаг юм бэ? Төсвийг болохоор холбоотой асуудлыг болохоор гишүүд татвар төсөвтэй холбоотой асуудлыг гишүүд орж ирж батлуулж болдоггүй шүү дээ. Гэтэл иргэнд өөрт нь орж ирж байгаа орлогыг тэр иргэний өмнөөс шийдээд ингээд хууль хэлэлцээд сууж байна гэдэг чинь бол үнэхээр утгагүй асуудал. Хийх юм ерөөсөө алга байна уу, энэ Их Хуралд. Энэ Улсын Их Хурлын гишүүдэд хийх юм алга уу? Зах зээлийг эвдэж байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт хувь хүнийг доромжилж байна, малчдыг. Танд өөрт чинь орж ирж байгаа орлогыг хэн нэгэн нь ингэж зарцуулна гээд хууль гаргаж байвал ямар байх вэ? Та нарын нөгөө сэтгэдэг ард түмнийг малчдаа улныхан гэж боддог энэ сэтгэлгээнээс л ийм хууль гарч байна шүү дээ. Тэгээд нэг гийгүүлчихсэн юм шиг юм яриад л. Энэ аягүй харамсалтай байна. Ийм юм болохгүй байх аа. Энийгээ боль боль зүгээр. Ийм юм чинь явцгүй. Одоо энд Улсын Их Хурал дээр аятайхан зөв юм ярьчихъя, хэдүүлээ. Хүмүүст ойлгогдохоор.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн, хууль санаачлагч.

Ц.Туваан: Ерөнхийдөө энийг бас хууль санаачлагчид Улсын Их Хурлын гишүүнд олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллаж байгаа маш олон тооцоо судалгаан дээр нэлээн олон явж, нэлээн олон малчдаас санал сэтгэгдлийг нь авч хэлэлцүүлж байж ингэж оруулж ирж байгаа.

Тэгэхээр манай Улсын Их Хурлын гишүүд бас удахгүй Улсын Их Хурлын чуулган завсарлана. Тэгээд энэ завсарлагааны үеэр бас ялангуяа хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд, Хөдөө аж ахуйн салбар эрхэлж байгаа тэр хүмүүстэй гишүүд маань очоод уулзаад энэ хуулийн талаар ярих юм бол тэр хүмүүс маань маш өндөр хувьтайгаар талархан дэмжиж хүлээж авч байгаа ийм хууль байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт энэ бол би хэлсэн сонголтын асуудал байгаа. Эндээс ямар нэгэн хүмүүсээс татвар нэмж авах гэж байгаа ийм асуудал байхгүй. Сайн дурын үндсэн дээр тэр хүмүүс өөрсдөө зөвшөөрвөл энэ нийгмийн даатгал, ЭМД-аа төлөх ийм сонголтыг л иргэдэд өгч байгаа ийм л хуулийн төсөл гэдгийг бас энэ даширамд хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна. 1 минут.

Д.Ганбат: Ямар юмны сайн дурын байдаг юм? Тэр ЭМД чинь албан журмынх шүү дээ. Тийм нийгмийн даатгал чинь сайн дурын үндсэн дээр. Үгүй ээ ер нь та нар ойлгуулах ёстой байхгүй юу. ЭМД төлөөд тэр үйлчилгээгээ авч чадаж байна уу? Нийгмийн даатгал төлөөд тэр тэтгэврээ авч чадаж байна уу? Үгүй ээ. Тэтгэврийг тэгшитгэдэг шүү дээ. Бүгдээрээ л ийм байх ёстой гээд л. Малчдын орлогыг сайжруулах ёстой байхгүй юу? ЭМД нь үйлчилдэг байх ёстой байхгүй юу? Үгүй ээ зайлуул, малчид маань ядарсан үедээ

Улаанбаатар ба аймгийн төв ороод ирэхээр тэр болгон үйлчилдэггүй шүү дээ. Бүх эм тариагаа гаднаас худалдаж авдаг. Хүлээж авдаггүй шүү дээ. Тийм болоод л хүмүүс төлөхгүй байхгүй юу даа. Тэрнээс биш, тэр нь хэрэг болдог бол хүмүүс өөрсдөө төлөөд л явна шүү дээ. Тэр нь хэрэгтэй гэдгийг ойлгуул. Тэрнээс биш энэ хүмүүс чинь өөрөө өөрийгөө аваад явах чадваргүй ийм хүмүүс биш ээ. Наад бүгд нас биед хүрчихсэн улсууд.

Г.Занданишатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Нэг талаасаа нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангийн орлогыг нэмэгдүүлэх гээд байгаа юм шиг, нөгөө талаасаа бас малчдын бас нийгмийн асуудалд бас тус нэмэр болох гээд байгаа юм шиг. Нөгөө талаасаа ЭМД, НДШ төлнө гэдэг бол хувь хүний бас үүрэг шүү дээ. Хариуцлага.

НДШ төлснөөрөө ЭМД-ын шимтгэл төлснөөрөө бас нийгэмдээ оруулж бусдын сайн сайхны төлөө эргээд бас өөрөө тэр сангаасаа үйлчилгээ авна гээд. Тэгээд энэ шимтгэл юмаа төлөөгүйнх нь төлөө, бас энэ байдлыг өөгшүүлж байгаа юм шиг бас харагдах тал харагдаж байна шүү. Өөгшүүлж байгаа. Буцаад нийгмийн даатгалын сангаасаа тэтгэвэр тэтгэмжээ авна шүү дээ тухайн иргэн төлснийхөө төлөө. ЭМД шимтгэл төлснөөрөө буцаад өвдөж хавдахгүй хүн гэж байхгүй л байх, буцаад эрүүл мэндийн байгууллагаас үйлчилгээ авна. Тэгээд төлөөгүй явж байгаад гэв гэнэтхэн нэг өдөр өвдөхөөрөө эмнэлэг дээр очоод үйлчилгээ авъя гэдэг, тэгээд шимтгэлээ төлөөгүйнхээ төлөө эргээд буцаад малчдын өөрсдийнх нь асуудал үүсэж байгаа байхгүй юу. Нэг дор олон төгрөг төлөх. Тийм учраас ийм байдлыг бас нэг талаар өөгшүүлж байна шүү гэдгийг нэгт хэлье.

Хоёрт нөгөө талаар энэ төрөөс олгож байгаа урамшуулал чинь би бас

Байнгын хорооны хурал дээр хэлж байсан цаг хугацааны хувьд дандаа он дамжиж ордог. Он дамнаж. Дараагийн оны нэгдүгээр улиралд ч чадахгүй.

2, 3 дугаар улирлуудад орж байвал их юм болдог. Тэгээд цаг хугацааны асуудал гараад байгаа юм. Эрүүл мэндийн үйлчилгээ авъя гэвэл эрүүл мэндийн дэвтэр нь төлөгдчихсөн, шимтгэл нь төлөгдчихсөн гэж эмнэлэг дээр очиж үзүүлэхэд байж байж үйлчилгээгээ авах эрх нь үүснэ. Тэгвэл дараа ондоо төлөгдөж байгаа нөхцөлийг энэ эрүүл мэндийн байгууллага. Энэ Сангийн яам энэ малчдын төрөөс олгох урамшууллыг өгч байгаа улсуудын энэ хоорондын уялдаа холбоог яаж ойлгох юм. Яаж мэдэх юм. Яг үйлчилгээ авъя гэхэд нь бол тэр шимтгэл нь ороогүй байна гэсэн үг шүү дээ. Дараа ондоо ордог учраас. Тэгэхээр нөгөө талаараа тэгээд дараа онд нь орох юм байна гээд эрүүл мэндийн байгууллага үйлчилгээгээ үзүүлчихдэг, ирэх жил таны төлсөн урамшуулал орох юм байна аа ингээд тэрнээс чинь нөхөөд суутгачихъя гэдэг ийм асуудал үүсэх юм байна. Тэгээд нэг талаасаа эрүүл мэндийн байгууллага ЭМД-ын сан чинь бас хохирох асуудал гарах вий дээ.

Нэг талаас орлого нь нэмэгдэнэ гэж бодож байгаа боловч энэ дээр бас би эртээд Байнгын хороон дээр бас асуулт асуугаад л олигтой бас дорвитой хариулт авч чадаагүй. Энэ дээр Даатгалын ерөнхий газраас хариулт өгөөч, хууль санаачлагч нар бас хариулт өгөөч ийм байдал үүсэх үү, үгүй юу? Би зүгээр энийг хууль батлагдлаа гэж харахаар амьдрал дээр яг яаж буух бол, хоорондоо ямар асуудал үүсэх бол гэдэг талаас нь л хараад байна л даа. Баярлалаа.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн хууль санаачлагч.

Ц.Туваан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ дээр эхнийх нь тэр НДШ, ЭМД-ын шимтгэлийг одоо ингээд хүмүүс ингээд эндээс суутгуулаад төлөөд

ирэхээр төлөлтийн хувь бол өгсөн үү? Ялангуяа энэ албан журмаар даатгагддаг ЭМД дээр бол урамшуулал авч байгаа хүн болгон энийгээ бараг эндээсээ төлөх байх гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ нэгдүгээрт, тэр төрөөс нэгэнтээ олгож байгаа урамшууллаас нь нөгөө ЭМД-аа төлөөд явах нь сангийн орлого бол нэмэгдэнэ. Тэгэхдээ энэ дээр бол эргээд энэ нь санд, 2 санд эрсдэл үүсэх вий, маш олон иргэд үйлчилгээ авахаар эрсдэл үүсэх вий гэж бодож байна. Тэгэхээр нэгэнтээ Монгол Улсад хууль ийм байгаа.

Хоёрдугаарт, мэдээж төр үү, иргэн үү гэдэг дарааллын асуудал үүсэх юм бол бид нар бол бас Монгол Улсын төрийг төлөөлж байгаа учраас иргэд маань ямар нэгэн эрсдэлгүй, амар байдлаар эрүүл мэндийн үйлчилгээ тэр нийгмийн баталгаа нь хангагдах, тэтгэвэртэй болох гэдэг асуудал нь бол нэг номерт байх ёстой. Тэгэхээр бид бүхэн ер нь хууль гаргаад ч тэр сурталчлаад тэр нэмэгдэхгүй байгаа энэ процентыг л яаж нэмэх вэ гэдэг дээр л бас яг нэг талаараа бол нэлээн тийм жаахан аргаа барсан л юм явагдаж байгаа юм. Бид нар мэдээж байгаа шүү дээ. нөгөө малчдын нийгмийн даатгалыг бөөнөөр нь бөөнтүүлж, нөхөн төлүүлэх хууль гаргаад 1 жил хэрэгжүүлсэн олигтой үр дүн гараагүй. Гарахгүй болохоор нь дахиад 1 жилээр сунгасан. Тэгээд миний түрүүний хэлсэн ингээд ингээд байхад л НДШ төлөлт энэ тэр ингээд л 2 хувь энэ тэр л нэмэгдэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь бол дор хаяж нэгэнт малчин 50, 55-тай тэр хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж байгаа гээд тэтгэвэрт гарах нас нь байгаа юм чинь тэр хүмүүсийн хамрагдах хувийг нь л жоохон нэмэгдүүлье, мэдээлэлжүүлье, амар болгоё гэдэг ийм үндсэн дээр л хууль санаачлагчид энэ хуулийг баталсан.

Дээр нь нэмж нэг зүйл хэлэхэд юм хөгжөөд бас сайхан болж байгаа. Юу вэ гэхээр цахим орчин нэлээн хөгжиж байгаа. Тэгэхээр ЭМД-ын дэвтэр гэдэг

дэвтэр байхгүй болсон. Хүн өөрөө эмнэлэг дээр очлоо, овог нэр, регистрийн дугаараа хэллээ. Компьютер руу орлоо, нэгдсэн ийм программ дээр таны ЭМД-ын шимтгэл төлөгдсөн байна гээд л шууд үйлчилгээгээ аваад явчихна. Нөгөө очоод л тамгаа даруулаад ингээд явдаг юм байхгүй.

Хоёрдугаарт малчид эрэгтэй 55 хүрлээ гэнэт 55 насныхаа төрсөн өдрөө тэмдэглэж нэг мэдээд би чинь нээрээ малчин хүн байна тэтгэвэр төлөх насан дээрээ ирчихлээ гээд нийгмийн даатгалын байцаагч дээр яваад очиход бас л цахим учраас, өөрөөр хэлбэл хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр гэдэг чинь байхгүй цахим болчихсон үед энэ мөнгө нь төлөгдөөд явж байгаа нь бол тэр хүнд нэг их сонин биш, яг эрх нь үүссэн өдрөө яваад очиход л таны бүх шимтгэл төлөгдсөн байна та тэтгэвэртээ гарч болно оо гээд ийм байдалд нь л дэм өгөх сонголт өгөх сайн дурын үндсэн дээр нэг ийм л зүйлүүд ингээд амьдралаас урган гарсан учраас малчид, тариаланчид, фермер эрхлэгчид, газар тариалангийнхан, дээрээс нь одоо Монголд хамгийн түрүүн гар хүрч дэмжиж чадаагүй салбар болох энэ хүнсний ногоо тариалж байгаад ногоочид маань энэ жилээс анх анх удаагаа урамшуулал авах ийм боломжтой болж байгаа.

Тэгэхээр энэ жилийн төсөв дээр нэг 8 орчим тэрбум төгрөгийн хүнсний ногооны урамшуулал авах ийм боломжтой болсон энэ ногоочид маань хүртэл энд хамрагдаад НДШ-ээ төлөөд ЭМД-ын шимтгэлээ төлөөд төрийн энэ өгч байгаа үйлчилгээг ямар нэгэн саадгүйгээр түргэн авах ийм боломжийг нээж өгөх сонголтын хууль л гэж ингэж харж байгаа. Төлөхдөө бол яг тэр харилцаа нь үүсээд, тэр хүний нэр дээр урамшууллын мөнгө гарснаас хойш төлөх учраас өмнөхөө бол тэр иргэн өөрөө хариуцаад явна.

Г.Занданишатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Энэ хуулийг дэмжиж байна аа. Тэгэхдээ бас тодруулж асуух нь нэг хэдэн зүйл байна. Ер нь даатгал гэдэг зүйл анх 250-иад жилийн өмнө Испанид анх үүссэн юм байна. Маши том үер болж 2000 хүн нас барж, үхлийн өмнө ер нь би ганцаардахгүй байж болох уу гэж нэг ийм философийн асуулт үүсээд, тэгээд ер нь хүнд нөхцөл байдал үүсвэл бие биеэ хамгаалж байя, бие биеийнхээ төлөө мөнгө хураая гэдэг л санаагаар үүссэн. Өөрөөр хэлбэл хийсэж ирдэг, хэлж ирдэггүй тэр өвчин зовлон болоход арыг нь даана л гэсэн санаа шүү дээ ЭМД, нийгмийн даатгал ер нь.

Өнөөдөр манай ЭМД яг энэ өвчин тусгаад хүнд бэрхшээлтэй болчихсон улсуудын арыг дааж чадаж байна уу, өвчин тусгаад л, тэгээд л байр хунараа хашаа хороогоо зараад л, аргаа бараад л, ах дүүсийгээ бүгдийг нь хэцүү байдалд оруулаад л, дараа нь тэр хүнээ ч бид заримдаа хүнд байдалд оруулж өвчнийг нь эдгээнэ. Зарим нь эдгээхгүй. Яг энэ дээр ЭМД-д Монголын ард түмэн итгэж байна уу, үгүй юу гэдэг дээр үзэх цаг болсон. Яагаад төлөх дургүй байна. Яг ар нь түүз үү, үгүй юу гэдэг.

Тэгэхээр миний энэ яагаад дэмжиж байгаа вэ гэвэл аргаа барсан яг үнэн, даатгал төлөлт муу байгаа. ЭМД төлөлт муу байгаа. Энийг нь ингээд хүчээр ингээд инжекшин хийгээд төрийн мөнгөөр жоохон нэмэгдүүлээд энэ шимтгэл төлөлт арай гайгүй болохын алдад ЭМД-ын үйлчилгээ сайжрах уу? Энэ чинь ЭМД-аас санхүүжилт авдаг эмч, эмнэлгийн ажилтнууд чинь ер нь бараг л ЭМЯ, даатгалын байгууллага 2 т л бөхөлзөөд байна уу гэхээс орж ирж байгаа яг даатгал төлөгч эзэнд үйлчлэхдээ хойрго байх вий гэж би санаа зовж байна. Энэ дээр сайн үр дүн гарах уу? Яагаад энийг асууж байна вэ гэвэл дунджаар нэг 60000 төгрөгийн ЭМД, нөгөөдөх нь 600000 гээд, ингээд 184 тэрбум төгрөгийн санхүүжилт ойролцоогоор хийх гээд байгаа тухай ярьж байна. Энэ ингээд гэнэтхэн та нар ингээд араас нь

хөөцөлдөхгүйгээр орж ирэх юм бол үйлчилгээ сайжрах уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, энэ мөнгөний чинь 4 хувиар та нар санхүүждэг. Та нар татвараар санхүүждэггүй. Та нар бараг төрийн байгууллага биш шүү дээ. Ер нь шимтгэлээс санхүүждэг 4 хувиар. Тэгэхээр энэ нэг ойролцоогоор 7-8 тэрбум төгрөг миний тооцоогоор гарч байна. Энэ мөнгийг та нар ерөөсөө хуруугаа ч хөдөлгөхгүйгээр төр нэг карманаас аваад нөгөө кармандаа хийгээд өгчихнө гэдэг бол энэ мөнгөөр малчдыг урамшуулах уу, эсвэл тэр төрд нь буцаагаад өгөх юм уу? Энэ талаар тооцоо судалгаа байгаа юу? Эсвэл даатгалын байгууллагуудаа урамшуулал өгнө гэвэл давай болж байна. Энэ хамгийн гол нь тодорхой байх ёстой.

3 дугаар асуулт энэ ноос, ноолуурын урамшуулал гээд байгаа энэ ХАА-гаас орж ирж байгаа мөнгө, татвараар өгсөн мөнгийг л буцаагаад ард түмэнд өгдөг мөнгө шүү дээ. Энэ татварын мөнгө мөнх биш. Энэ ноосны урамшуулал мөнх биш. Тэгэхээр нэг өдөр тэглэхэд уснаас гарсан загас шиг энэ малчид яг энэ нийгмийн даатгалд ЭМД төлдөг энэ зуршил улам байхгүй болчих вий гэдэг тал дээр ямар сургалт, ямар хөтөлбөрүүд байгаа вэ? Ер нь бол баруунд бол малчид, тариаланчид тэртээ тэргүй даатгалд маш муу хамрагддаг. Тэрэн дээр анхаардаг ажил нь үйлдвэрчний эвлэл, хоршоод, тэр малчдын тэр бэлчээр ашиглалтын холбоодууд нь ажилладаг. Тэрэнд нь сургалт хийдэг. Засгийн газар тэдэнтэй хамт гэрээтэй ажилладаг. Манайд тийм юм байдаг л байх, бодвол.

Тэгэхээр энэ ингээд ноьлсон тохиолдолд Б төлөвлөгөө байгаа юу? Би 4 асуулт асуулаа. Хариултаа авъя.

Г.Занданишатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн, хууль санаачлагч хариулъя. 4 асуулт.

Ц.Туваан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Ганбаатар гишүүн бас мэдээлэл сайтай байна. Тэр нь юу вэ гэхлээр ер нь ямар хэмжээний мөнгөний тухай яриад байгаа вэ гэхлээр ер нь бол өнгөрсөн жилүүдэд ХААЯ-наас улсын төсөв дээр Хөдөө аж ахуйн сайдын багцад улсын төсвөөс 66 орчим тэрбум төгрөгийг төсөвлөөд өгөөд урамшуулалд олгоод явж байсан. 2023 оны төсөв дээр 45 тэрбум төгрөгийн мөнгө орчихсон явж байгаа. Тэгэхээр юу хэлж байна гэхээр ямар ч улсад дэлхий дээр Америк ч тэр, Герман ч тэр, Австрали ч тэр, өндөр хөгжилтэй дунд хөгжилтэй ч улсад ер нь хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа энэ иргэдийнхээ хүнсний хангамжийг бүрдүүлж байгаа хүнс үйлдвэрлэж байгаа хөнгөн үйлдвэрүүдийг түүхий эдээр хангаж байгаа энэ хөдөө аж ахуйн салбар бол татаастай явдаг. Урамшуулалтай явдаг. Энэ бол зайлшгүй ганцхан Монголд энэ халамж маягтай ийм урамшуулал өгөөд байгаа зүйл биш ээ.

Тэгэхээр энэ бол улс орнуудын иргэдийнхээ хүнсний найдвартай хангамж, хөнгөн үйлдвэрийн найдвартай түүхий эд бэлтгэлийг бодож хийдэг ийм алхам байгаа. Саяхан бас та бүхэн мэдэж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хүнсний хангамж, аюулгүй байдлын хөтөлбөр орж ирээд бид нар 36 дугаар тогтоолоор дэмжээд явсан. Энэ дээр дотооддоо хүнсээ 100 хувь 19 нэр төрлийн хүнсээ хангая л гээд байна шүү дээ. Яаж хангах вэ гэхээр дэмжлэг, зээл, урамшуулал, тэгээд л техник тоног төхөөрөмжийг санхүүгээр дэмжих л ийм асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ урамшууллыг бол би хувьдаа зогсохгүй гэж харж байгаа.

Дээрээс нь урамшуулал бол Хөдөө аж ахуйн салбарт байх ёстой. Ингэж байж хүнсний хангамж, аюулгүй байдлаа хангана гэж үзэж байгаа юм. НДШ энэ оны 1 сарын 1-нээс 2023 оны 1 сарын 1-нээс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550000 болж байгаа. Ингээд эндээс ингээд бодоод үзэхээр сардаа сайн дураар 74250

төгрөгийн шимтгэл төлнө. Жилээр нь бодвол 891 мянган төгрөгийн шимтгэл сайн дураар төлөхөөр гарч байгаа юм. Мөн үүнтэй уялдаж ЭМД-ын шимтгэл бас нэмэгдэж байгаа. Сардаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэг хувь буюу 5500 төгрөг жилдээ 66000 төгрөг төлөхөөр ингээд гарч байгаа юм.

Тэгэхээр нийтдээ бол нэг есөн тавин хэдэн мянган төгрөгийн төлбөр хүн төлөхөөр байгаа юм. Тэгэхээр юу хэлж байна гэхээр ийм төлбөр төлөх хүмүүс маань тэр болгон төлж чадахгүй, ингээд хувь бага байгаад байгаа чинь энэнтэй холбоотой. Тэгэхээр танд та урамшууллаасаа бэлэн биш, таны нэгэнт бүтээчихсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд төрөөс олгож байгаа урамшууллаас энэ мөнгөө төлөх үү гэхээр манай ХАА-нхан дуртай зөвшөөрнө өө, малчид бол карманаасаа бэлэн мөнгө гаргаж өгөх дээр бол үнэхээр харам байдаг. Яагаад гэхээр бэлэн мөнгө тэнд ховор байдаг. Одоо бол бүр ховор болж байгаа. Тэгэхээр тэнд нь юуны энэ урамшууллаасаа төлөх үү гэвэл Өө тэгье, тэгье, ашгүй гээд л шууд гарын үсгээ сайн дураар төлнө гэдэгт бол би өндөр итгэлтэй байгаа.

Тэгэхээр энэ бол үр дүнгээ өгнө гэж харж байгаа. Энэ эрүүл мэндийн даатгалын тогтолцооны хуулийн өөрчлөлтөд орсноос хойш иргэдэд бол хэрвээ ашиглаж чадвал маш сайн болж байгаа. Юу вэ гэхээр эмнэлгийн үйлчилгээ бол маш олон эмнэлгийн үйлчилгээнүүд үнэгүй. Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөгдөж байгаа. Маш олон өдөр төлбөртэй хагалгаанууд, маш өндөр хувиар хөнгөлөгдөж байгаа. Нөгөө 350, 360 мянгаар хийлгэдэг нарийн мэргэжлийн имрай, зүрх, тархины цахилгаан бичлэгүүд гээд энэ ажилбарууд хүртэл 70 орчим хувийн хөнгөлөлттэй. Иргэд рүү бол маш сайн ийм хөнгөлөлтүүд болж байгаа. НДШ-ээ төлснөөр түрүүн би хэлсэн ажилгүйдлийн тэтгэмжээс бусад 3 төрлийн тэтгэмжийг нэмээд авах эрх нь иргэд дээр үүсэж байгаа.

Тэгэхээр иргэдэд бол малчдад бол маш их өгөөжтэй ийм хуулийн төсөл болж байгаа гэдгийг.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Аан за Буланы Бейсен гишүүнээр тасаллаа.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

Б.Бейсен: Энэ хууль санаачлагч бөгөөд дэмжигчийн нэг нь байгаа юм аа. Энэ та бүгд ерөөсөө сайн ойлгохгүй байна. Эмнэлгээр яваагүй болохоор та бүгд ойлгохгүй байгаа байх. Ерөөсөө хөдөө дээрээс энэ эмнэлгээр явж байгаа улсууд, тэр даатгал төлөөгүй хүн зөндөө байна. Энэ ЭМД-ын газар нийгмийн даатгалын газраас яваад мөнгө цуглуулах юм бодож байна. Эд нарт хийж байгаа ажил зөндөө байгаа. ЭМД-ын нийгмийн даатгалын газрынхны ажил хангалттай. Хийж байгаа ажил маш их байна шүү дээ. Тийм учраас энийг ингээд оруулчихвал бэлэн мөнгө төлөх чадвар муу шүү дээ ерөөсөө. Тухайн юмандаа зарцуулчихдаг, яг энэний суутгаад төлбөл бас тэгье, гээд дуртай зөвшөөрнө цаадуул чинь.

Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжих нь зөв байх гэж бодож байна. Тэгээд эмнэлгээр хот руу явж байгаа аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэх гээд ирж байгаа хөдөөний малчид, тариаланчид, туслах малчнаар ерөөсөө даатгал төлөгдөөгүй, хэвтэхэд бас хэцүү, хөнгөлөлттэй эм авч чадахгүй. Хөнгөлөлттэй эмнэлгийн тусламж авч чадахгүй тийм асуудал байгаа байхгүй юу. Та бүгд зөвхөн ЭМД-ыг нь цуглуулдаг юм шиг бодож байна. Энийг чинь жилийн эцсээр энэ багийн дарга нар явж байж нэг тооллогын комисстой хамт бүгдийг нь цуглуулдаг байхгүй юу. Энэ урамшууллаас төлчихвөл бас хаа хаанаа ч гэсэн төрийн ажил явах ер нь сайн байх гэж бодож байна.

Тийм учраас энэ хуулийг дэмжиж үг хэлж байгаа юм аа би.

Г.Занданишатар: Одоо эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Төрөөс олгох урамшууллыг нийгмийн даатгалын болоод ЭМД-д суутган тооцож болох тухай гэдэг энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Яагаад гэвэл ер нь бид нарын ба зүглэж, чиглэж байгаа энэ нээлттэй нийгэм, чөлөөт эдийн засгийн харилцаа гэдэг чинь эрх чөлөө гэдэг нэг үгэн дээр суурилж байгаа. Эрх чөлөө гэдэг чинь эцсийн дүндээ сонголт олон болохыг л хэлж байгаа. Иргэн хүнд сонголт нэмэгдэж байна уу. Тэгвэл иргэн хүн тэр нийгмийн даатгалаа, ЭМД-аа сонгох сонголт нь энэ хуулиар нэмэгдэх юм байна.

Тэр сонголт нь сайн дураараа нэмэгдэх юм байна. Хэн нэгний хуулийн шахалт дарамтаар биш, өөрийнх нь сайн дураар итгэл үнэмшилээр тэр сонголт нь 2 биш, 3 дахь сонголт нэмэгдэж байгаа учраас энэ зарчмын хувьд энэ хуулийн төсөл өөрөө яг энэ бид нарын энэ чөлөөт нийгмийн үзэл санаатай илүү нийцэж байгаа болохоор энэ хуулийн төслийг зарчмын хувьд нь бас ингэж дэмжиж байгаа юм аа.

Г.Занданишатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд, гишүүд үг хэлж дууссан, санал хураалт явуулна. Асуулт хариултын цаг дууссан учраас чуулганы танхимд цуглаж, санал хураалтдаа бэлдэцгээнэ үү.

Байнгын хорооны саналаар төрөөс олох урамшууллаас Нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт.

23 гишүүн дэмжиж 57.5 хувийн саналаар санал дэмжигдэж байна. Гишүүдийн олонх хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна аа.

Дараагийн асуудалд орно.

Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл танилцуулна аа. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: *Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,*

1992 онд байгуулагдсан шинэ Үндсэн хуульд Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэж. 2 дугаар хэсэгт нь төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж хувийн өмчийг эрхэмлэсэн олон хэвшил бүхий эдийн засагтай улс байх нийгмийн гэрээг батлан нийтээрээ дагаж эхэлсэн.

Ингэснээр төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх олон улсын нийтлэг зарчим руу шилжсэн. Мөн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан шинэ сэргэлтийн бодлогын тогтоолын нэгдүгээр хавсралтад шинэ сэргэлтийн бодлого нь төрийн өмчит ААН-үүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна гэж уг баримт бичгийн 2

дугаар хавсралтад шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжүүлэх эхний үе шатны хөтөлбөрийн хөтөлбөрийн 6.4.5-д төр, хувийн хэвшилтэй өрсөлдөж үйл ажиллагаа эрхлэхгүй ээ.

Зөвхөн стратегийн ач холбогдол бүхий салбарт эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор, мөн төрөөс үнэ тарифын зохицуулалт хийдэг. Хувийн салбар дангаараа эрхлэх боломжгүй. Нийтийн ашиг сонирхлын ашиг сонирхлын үүднээс зайлиггүй эрхлэх үйл ажиллагааны чиглэлд компани байгуулдаг байх, бизнесийн үйл ажиллагааны удирдлагад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх байдлыг хязгаарлаж, бизнесийн шийдвэр нь улс төрийн нөлөөллөөс ангид байх, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй ХК болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх гэж зааж өгчээ.

Эдийн засгийн зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд харьяандаа аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдийг олноор үүсгэх, үүсгэн байгуулах явдал хавтгайрсан. Үндэсний статистикийн газрын мэдээлж байгаа бизнес регистр бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн тоо 2013 онд 4530 байсан бол 2021 онд 5400. Үүнээс төрийн өмчит үйлдвэрийн газар ОНӨҮГ-ын тоо 261 байсан бол 386, төсвийн байгууллага 3900 байсан бол 4700 болж өсжээ. Хувийн хэвшлийн гүйцэтгэх бүрэн боломжтой ажил, үйлчилгээг явуулахаар төрийн зүгээс аж ахуйн үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийг үүсгэн байгуулж буй нь өөртөө илт давуу байдлыг бий болгон дангаар гүйцэтгэх, өрсөлдөөний тэгш байдлыг үүсгэх зүй бус үр дагавруудтай.

Гэвч эдгээр төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын дийлэнх олонх нь алдагдалтай ажиллаж буй нь үнэ эргээд улсын төсөвт дарамт үзүүлж байна аа. Эдгээр үндэслэл, шаардлагын

улмаас аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай тогтоолын төслийг боловсруулсан.

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэх бүгд Засгийн газрын санаачилгаар Улсын Их Хурлаас батлагдсан шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлал, зорилго болоод өрнөж буй үйл явдлууд, ард иргэдийн хүсэл сонирхолд нийцэж буй билээ. Иймд уг тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданишатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Баттөмөр гишүүнийг индэрт урьж байна аа.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэлээс 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ААН үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь төрийн болон ОНӨҮГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийг шинээр болон өөрчлөн байгуулах, эс үгүй бол хувьцаа худалдан авах, өрийг хувьцаагаар солих замаар нэмж байгуулахыг хориглох, эдгээрийн тооны хязгаарыг 400 байхаар тогтоох, шинээр болон өөрчлөн байгуулах шаардлага бий болсон тохиолдолд хувьчлах, шилжүүлэх, татан буулгах зарчмыг баримтлах зорилгоор тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн байна.

Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал гарахгүй бөгөөд төсөл санаачлагч гэж үзсэн тогтоолын төслийг *dparliament.mn* цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Байнгын хороо хуралдааны тогтоолыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлээгүй болно оо.

Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух л цаг Улсын Их Хурлын гишүүн байна уу? Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Ингээд энэ ижил утгатай 2 тогтоолын төсөл орж ирж байна л даа. Түрүүн манай Цогтбаатар гишүүнээс бас нэг иймэрхүү, одоо дараагийнх нь ингэж орж ирж байна. Би Эдийн засгийн байнгын хорооны хуралд байгаагүй учраас энийг нэг хэд хэдэн асуулт асууя гэж бодож байгаа юм. Ер нь бол энэ Үндсэн хуульд бол олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа

хэлбэрийг хүлээн зөвшөөрнө гэсэн ийм заалтуудыг дурдсан байна л даа. Үндсэн хуулийн 5.4-т төр нь үндэсний аюулгүй байдал болон аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгоор нийцүүлнэ. Төр нь эдийн засгийг зохицуулна гэсэн заалт бас байгаа юм.

Энэ утгаар бол юу гэхээр зэрэг өнөөдрийн энэ манай хөгжлийн мухардал энэ бол юу вэ гэхээр төр нь эдийн засгийг зохицуулж чадаагүй. Төрийн бодлого оновчтой байгаагүйтэй холбоотой гэж ингэж үздэг. Хамгийн сүүлд бид нар нүүрсний хулгай гээд л ярьж байна. Төр хяналт тавьж чадаагүй шүү дээ. ТУЗ байсан, харьяалдаг байгууллагууд нь байсан. Тэгэхээр төр энэ аж ахуйн ажиллагаанд их оролцоод саад хийгээд байсан юм бол байхгүй. Харин оролцож чадахгүй байсан юм биш үү гэсэн ийм асуулт гарч байгаа юм л даа. Ер нь бол энэний цаад талд бол юу вэ гэхээр энэ Монгол Улсын хөгжлийн загварын асуудал байгаа юм. 30 жилийн хугацаанд хөгжлөө өнөөдөр эдийн засгийн үзүүлэлтүүдийг аваад үзэхээр нэг ч нааштай үзүүлэлт байхгүй байхгүй юу. Энэ хугацаанд Монгол Улсын хүн ам 1.2 саяар нэмэгдсэн байгаа. Нэг нааштай үзүүлэлт, өөр нааштай үзүүлэлт байхгүй. Өөр тэр балансын алдагдал, тэр төлбөрийн тэнцэл, урсгал, дансны алдагдал гээд ингээд энэ бүх үзүүлэлтүүд хасах байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бид ер нь энэ хөгжлийн загвар ер нь ямар байх ёстой юм бэ. Энүүгээр ингээд энэ түрүүн санаачилсан санаачилга одоо энэ санаачилгаар болоод төр оролцохгүй, дахиад ААН байгуулахгүй л юм байна л даа. Нөгөө энэ төрд байж байгаа энэ Салхитын мөнгөний орд, тэр нөгөө Хармагтай энэ тэр гээд том ордууд байж байгаа шүү дээ. Тэр ордууд дээр төрийн өмчтэй том компани байгуулахгүй юм уу, хувьд өгчих юм уу, төрийн энэ бодлого зохицуулалтуудыг их зөв хийе гэсэн юмыг яривал яасан юм бэ гэсэн ийм санаа байгаа юм аа.

Энэ 400 гээд нэг тоо явж байгаа. Энэ тоог хаанаас гаргасан юм бэ? 400 гэсэн тоо. Энийг асууж байгаа юм.

Дараагийн асуулт бол юу вэ гэхээр энэ яг ингээд энэ эдийн засгийн бүтэц, ингээд цаашид бид яаж хөгжих вэ гээд ингээд аваад үзэхээр зэрэг татвар хураагаад Монгол Улсын татварын орлого бол жилд нэг 2-3 их наяд төгрөгөөр нэмэгдэнэ. Тэр нь бол юу вэ гэхээр ханшийнхаа уналтаар дамжаад л нөгөө л нэг 5-6 тэрбум доллар, төсвийн орлого. Яаж одоо мөнгөтэй болох юм бэ? Төр энэ төсөв мөнгөтэй байж байж энэ нийгмийн асуудлуудыг шийднэ шүү дээ. Энэ том хувийн хэвшилд үр ашиггүй энэ том бүтээн байгуулалтуудыг хийнэ шүү дээ.

Тэгэхээр энэ төрийн оролцоог ингэж хумиад байдаг нь ер нь хэр зэрэг байдаг юм? Төрийн оновчтой зөв зохицуулалтууд хэрэгтэй юм биш үү? Энийг ер нь юу гэж харж байгаа вэ?

Энэ бол мэдээж яах вэ дээ нөгөө хуультайгаа нийлээд л цаашаагаа нийлээд л яваад л, хэлэлцээр явагдах л байх л даа. Ер нь бол энэ бид нарын явж ирсэн зам цаашаа явах гээд байгаа зам болохгүй байгаа шүү дээ. Бодлогоо өөрчилбөл яадаг юм.

Хөгжлийн загвараа маш тодорхой болговол яадаг юм? Яг ийм байдлаар яваад цаашидаа үр дүнд хүрэхгүй. Монгол Улс хөгжихгүй, Монголын ард түмний амьдралд өөрчлөлт гарахгүй. Тийм учраас бол энийг ултай суурьтай ингэж авч үзэх нь зүйтэй байх. Гэхдээ би энийг эсэргүүцээгүй.

Г.Занданшатар: Хууль санаачлагч Одонгийн Цогтгэрэл гишүүн хариулна.

О.Цогтгэрэл: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Баттөмөр гишүүн ер нь төрийн оролцоо гэдэг зүйл цаашидаа яаж явах вэ гэдэг бас онолын шинжтэй ч бас асуулт

бас байх шиг байна. Ер нь төрийн оролцоо гэдэг зүйл явсаар байгаад 2 зүйл дээр л очих ёстой байх. Төрийн зохицуулах оролцоо, төрийн тийм өмчлөлийн бодлого гэдэг зүйл. Бид бүгд төрийн оролцоо гэхээр өмч хөрөнгөтэй, өмчлөх ёстой гэдэг зохицуулах тэр бодлогын зохицуулалт гэдэг 2 зүйлээ бид нар бас ер нь өнгөрсөн хугацаанд нэлээн тийм ялгаж салгахгүйгээр өнгөрсөн хугацаанд яваад ирчихжээ.

Бизнесийн үйл ажиллагаа. Өмчтэй холбоотой олон зүйл дээр төр зохицуулалтын үүргээ давамгайлж авч явсан бол тэр орлого болоод олон зүйлийг ч гэсэн заавал өмчлөхгүйгээр зохицуулах тэр зааг ялгааг бид нар өнгөрсөн хугацаанд барьж ирээгүй юм уу гэж. Тэгээд энэ өнгөрсөн 7 хоногт хэлэлцэж хэлэлцэх эсэхийг нь шийдэгдсэн Цогтбаатар нарын гишүүдийн хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн тогтоолын төсөлтэй утга санаа их ойролцоо. Зүгээр тэнд бол шинээр тодорхой хугацааны дотор заагаад шинээр төрийн өмчит ААН байгуулах уу гэсэн бол энэ тогтоолын төсөл дээр тодорхой тооны хязгаарыг тавьчихъя аа.

Магадгүй тэр түрүүн 400 гэдэг тоо гарч байгаа нь бол одоо байгаа төрийн болоод орон нутгийн өмчит ААН-ийн тоо 390 орчим байгаа юм байна лээ.

Статистик тоог харахаар өнгөрсөн 9 жилийн хугацаанд төрийн өмчит үйлдвэрийн газар ОНӨҮГ болоод төсөвт байгууллага нийлээд 900 орчмоор нэмэгдсэн байна лээ. 900 орчмоор. Үндсэндээ энэ 9 жилд 900 орчмоор нэмэгдсэн ийм байдалтай. Тэгэхээр тодорхой хугацаанд энэ 400 гэдэг тоог одоо 300 тодорхой хугацаанд тавьчихъя. Тэгэхдээ энд мэдээж тооны асуудлыг нэлээн дараагийн хэлэлцүүлэг дээр нэлээн ингээд ярилцаад явна биз? Ер нь бол яг одоо аж ахуйн үйл ажиллагаанд гэдэг нь тэр түрүүн Үндсэн хуулийн ч үзэл санаа болоод төрийн бодлого, зохицуулалт, өмчлөлийн бодлого гэдгийг зааглаж

байгаа энэ өмчлөлийн бодлогоосоо аль болох татгалзаад төрийн бодлого, зохицуулалт тал руугаа илүү энэ төрийн бодлого явъя гэдэг л утга санаатай тогтоолын төсөл, бусад зүйл заалтууд нь бас түрүүний тогтоолын төсөлтэй бас ойролцоо болохоор хэлэлцэх эсэх нь дэмжигдчихвэл цаашидаа ингээд нэгтгээд хэлэлцүүлээд явах боломжтой гэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Санал хураалт явуулна аа. Гишүүд чуулганы танхимд. Асуулт хариултын цаг дууссан учраас санал хураалт явуулъя.

Санал хураалт явуулъя.

Энэ тогтоолын төслийг дэмжчихээд Цогтбаатар гишүүний санаачилсан хуулийн төсөлтэй агуулга нэг учраас нэгтгээд хэлэлцээд явчих юм байна лээ Байнгын хороон дээр. Ингээд гишүүд санал хураалтад бэлэн үү? Гишүүд үг хэлж дууссан.

Асуулт хариултын цаг дууссан. Одоо санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Бат-Эрдэнэ гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Амгалангийн Адьяасүрэн гишүүн үг хэлнэ.

А.Адьяасүрэн: Их Хурлын дарга аа миний энэ кноп ажилласангүй учраас

дахин санал хурааж өгнө үү? Санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

Г.Занданшатар: Хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү гэсэн саналыг Адьяасүрэн гишүүн гаргалаа.

Адьяасүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

60 хувийн саналаар Адьяасүрэн гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас Байнгын хорооны саналаар төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Цогтгэрэл гишүүн 12 сарын 31-нд 1974 оны 12 сарын 31-нд эхээс мэндэлсэн.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх удсан тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

Цогтгэрэл гишүүнээ төрсөн өдрийн мэнд хүргэсэн. Баталсан хуулиудын эцсийн найруулгыг сонсьё оо.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга салсанд тооцлоо.

Дагалдан гарсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гэх шиг байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонсон тооцлоо.

18 цаг өнгөрсөн байна.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан байна.

Нэг асуудлаа хойшлуулъя. Пүрэвдорж гишүүний саналаар.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Нийт ард иргэд ээ,

Монгол Улсын Их Хурал 2022 оны отгон хуралдаанаа ийнхүү өндөрлөж байна.

Улирч байгаа 2022 он маань дотоод, гадаад нөхцөл байдлаас үүдэлтэй сорилт, бэрхшээл дүүрэн энэ нэрээрээ өөрчлөлт, шинэчлэлт хийх боломж, ухаарал эргэцүүлэл, туршилага сургамж

үлдээсэн, хар цагаан ялгарсан шударга үнэний төлөөх Монгол түүхийн I онцлог хуудас болон түүхнээ үлдэж байна аа.

Монгол Улсын Их Хурал бол 2022 оныг хяналт шалгалтын чиг үүргээ шинэ шатанд гаргахыг зорилгоо болгосон жил болгосон гэж хэлж болно оо. Монгол Улсын Их Хурал 2021 оны эцсээр Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийг баталсан. 2020 онд хэрэгжүүлж эхэлснээр хяналт шалгалтын чиг үүргээ үндсэн гол зорилгоо болгож ажиллахыг эрхэмлэж эрмэлзэж, ийм ч учраас хяналт шалгалтын 24 ажлын хэсэг, хяналт шалгалтын 3 түр хороо ажиллаж нийт 8 удаагийн нээлттэй сонсгол зохион байгуулж, энэ хэрээрээ ард түмний мэдэх эрхийг хангаж, Хөгжлийн банкны асуудлаар хилийн боомт, нүүрсний хулгайн асуудлаар, эмийн зэрэг асуудлаар хянан шалгах түр хороо байгуулж ажиллууллаа.

Шинжээч хянагч томилж, хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулснаар олон жил бугисан асуудлууд бас ил гарч эхэлсэн. Ард иргэдийн бухимдлыг төрүүлж байгаа авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх ялын бодлогыг чангатгах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Уул уурхайн салбарын олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, үнэ ханил тод, нээлттэй байх тогтолцоог төлөвшүүлэх зорилгоор Уул уур уурхайн биржийн бүтээгдэхүүний тухай хуулийг баталлаа.

Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, 1600 гаруй тусгай зөвшөөрлийг хялбаршуулж, цөөлж, 362 зөвшөөрөлтэй болголоо.

Цахим парламент болж парламентын ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоотой хууль тогтоох тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Ди парламент системийг анх удаа энэ 2022 онд нэвтрүүлээ.

Монгол Улсад анх удаа төсвөө энэхүү системээр дамжуулж олон нийтээр нээлттэй хэлэлцүүлээ. Ирэх 2023 он Монгол Улсын хувьд бас нийгмийн зөвшилцлийг хангаж, бугимал асуудлуудаа даван туулах, алдаа гажуудлыг засах, тогтолцооны шинэчлэл хийх, үнийн өсөлтийг зогсоож, эдийн засгаа тогтворжуулах, экспорт, үйлдвэржилтийг идэвхжүүлэх зэрэг томоохон сорилтуудыг шийдэх жил байх болно.

Энэ зорилгоор эдийн засаг, нийгэм, улс төрийн засаглалын реформ хийх эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийг Улсын Их Хурлаас дэвшүүлж ажиллана.

Нийгэмд нэгэнт үүссэн бухимдал, ард олны тавьж буй шударга ёсны шаардлага биелүүлэх нь ирэх оны хамгийн чухал зорилтууд байх болно.

Нийгмийн бухимдлын шалтгаан болж байгаа суурь асуудал нь шударга ёс, авлига, тэгш бус байдал, орлогын ялгаа, эдийн засгийн хүндрэл, амьдралын чанарын асуудал байгаа бол ажилгүйдэл, ядуурал, гадаад өр, шударга ёс, хүний эрх, төвлөрөл, түгжрэл, архидалт, боловсрол, эрүүл мэндийн ялгавартай үйлчилгээ зэрэг дагавар асуудлууд иргэдийг ихээхэн бухимдуулж байна.

Эдийн засгийн хүрээнд тогтвортой бус, оновчгүй бодлого, үнийн өсөлт, татвар, гадаад өр, валютын ханшийн өсөлтийн суурь шалтгаан болж байна.

Улс төр, Засаглалын түвшин дэх тогтолцооны гажуудал, популизм төрийн албан дахь ёс зүйгүй байдал, баялгийн хулгай, хүний эрхийн зөрчил, хууль зөрчих үзэгдэл нь авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлж, Үндсэн хуульт ёс, ард түмний засаглах, эргэх ноцтой гажуудахад хүргэж байна.

Иймээс эдгээр суурь болон дагавар асуудлуудыг тус тусад нь ангилж, цаг цаг

үеийн асуудлаа ч гэсэн тодорхойлж, алдаг оног хэлбэрээр биш, өнөө маргаашийг аргацаах хэлбэрээр биш хамтад нь нэг бүр яаралтай шийдэх шаардлагатай болсон байна. Хөгжлийг гацааж, иргэдээ бухимдуулж байгаа эдгээр хог буртаг болсон үзэгдлээс ангижрах их цэвэрлэгээ хийх шаардлагатай болсон байна.

Тиймээс эдгээр нийгмийн эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг иргэдийн туслалцаатайгаар олж тодорхойлох, асуудлын эрэмбэ, шийдвэрлэх арга зам, гарц шийдэл, шийдвэрийн талаар иргэдтэйгээ зөвлөлдөх, үндэсний зөвшилцлийг хангах зорилгоор Улсын Их Хурлаас тогтоол баталж, Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Үүний тулд эхлээд эрдэмтэн мэргэдийнхээ үгийг сонсоно, ард иргэдтэйгээ улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудтайгаа зөвшилцөж хамтран чуулна. Ард иргэдийн төлөөлөлтэйгөө зөвлөлдөнө, өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуульд заасан ард түмний засаглах эрхийг эдлүүлж, бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэсэн зарчмаар иргэдийн оролцоог хангах нь бурууг засах, зөвийг олох хамгийн оновчтой арга гэж үзэж байна аа.

Эрхэм гишүүд, хүндэт иргэд ээ,

Цар тахлын дараах сэргэлтийн төлөө төр засаг, түмэн олон хамтдаа хичээсний үр дүн бас эхнээсээ гарч байна.

2021 оны дүнгээр дөнгөж 1.4 хувь өсөж байсан Монгол Улсын эдийн засаг 2022 оны гүйцэтгэлээр 4-өөс дээш хувийн өсөлттэй гарах хүлээлттэй байна. Гадаад худалдааны тэнцэл 3.3 сая долларын ашигтай гарч, Монгол Улсын экспорт түүхэндээ анх удаа 11 тэрбум долларт хүрлээ.

Төлбөрийн тэнцлийн алдагдал багасаж, тасралтгүй буурч байсан валютын нөөц эргэн сэргээж, 3.3 тэрбум

долларт хүрлээ. Мал сүргийн тоо 2022 оны урьдчилсан дүнгээр 71.1 сая болж түүхэн дээд хэмжээндээ хүрч байна. Гэхдээ энэ бүхэн маань бол бүх зүйл болж бүтэж байна гэсэн үг биш ээ.

Монгол Улсын нийгэм, эдийн засагт үүссэн сорилт, хүндрэл бэрхшээл арилаагүй байна. Төгрөгийн америк долларт харьцах хани суларч, хэрэглээний үнийн өсөлт, амьжиргааг доройтуулж, ард иргэдийн амьдралд хүнд цохилт өгч байна. Үнийн өсөлтөөс шалтгаалж өрхийн бодит орлого ахисан нь ядуурал, нийгмийн эмзэг байдал гүнзгийрэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үүнээс сэргийлэх, нэгэнт үүссэн асуудлыг оновчтой бодлого, үйл ажиллагаагаар давахын тулд Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг тогтворжуулах тоймтой шийдвэртэй арга хэмжээг Улсын Их Хуралд оруулж ирж, энэ оны эхэнд хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Тэгэхдээ энэ бүхнийг хамтдаа шийдвэрлэхийн тулд Монгол хүн бүхний Монголоо гэсэн сэтгэл, эвийн хүчээр шийдвэрлэхийн төлөө бас хамтран зүтгэхийг Та бүхэндээ уриалъя аа. Бурууг засах, зөвийг зорих шинэ эрчим давлагаа нийт Монгол Улсыг хамарч байна. Энэ бол сэргэн мандсан шинэ Монголын түүхийг эхлүүлж, хөгжил дэвшлийн гэгээн ирээдүйг зорих нийт Монгол түмний хүсэл эрмэлзэл юм аа. Энэ эрмэлзлийг ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал тууштай дэмжиж, ард түмэнтэйгээ ямагт хамт байх болно оо.

Монгол эх орон маань сэргэн мандлын замдаа тууштай орж, Монгол түмний маань золбоо хийморь бадран мандах болтугай.

Шинэ 2023 оноо айл өрх, ахан дүүсээрээ урам зориг дүүрэн сайхан угтаарай. Та бүхэндээ шинэ оны мэндчилгээ дэвшүүлье ээ.

*Ингээд Улсын Их Хурлын 2022 оны
отгон чуулган өндөрлөж байна аа.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*